



17 • 23

ДОЛООН ӨДРИЙН ХҮЛЭЭЛТ

Зохиолч Юй Си

Цаасан шувуу



Жүжиг

ГАРЧИГ

【Шаантаг】

Абогийн цаасан шувуу — Шидө — 7

• Арван долооны өдөр. Тутраган чих

Тутраган чихний сэтгэлийн дуудлага — 21

44 — 【Эхний шөнө】 Галд автсан байшин ба гурван тэрэг

• Арван наймны өдөр. Цэцгийн хүйс

Цэцгийн хүйсийн нууц санаа — 61

84 — 【Хоёрдахь шөнө】 Хэрмэл хунтайз

• Арван есний өдөр. Эрдэнэсийн сан

Эрдэнийн газрын таван давхарлиг — 109

129 — 【Гуравдахь шөнө】 Бороон дундахь газар хагалалт

• Хорины өдөр. Горхийн урсгал

Горхийн усны хүүрнэл — 143

165 — 【Дөрөвдөх шөнө】 Нандин эрдэнийн гайхамшиг

• Хорин нэгний өдөр. Улбар туяа

Хүжчин эмгэн — 181

205 — 【Тавдахь шөнө】 Өмсгөл доторх гэгээн сувд

• Хорин хоёрны өдөр. Салхины бүжиг

Амгалан зүүдний амирлангуй сэнтий — 223

249 — 【Зургаа дахь шөнө】 Гэгээн ариун улс

• Хорин гуравны өдөр. Алтны дархан

Арван жин алт — 267

290 — 【Долоо дахь шөнө】 Отчийн хаан Сянхө

17  23

17 · 23 ДОЛООН ШӨНИЙН ХҮЛЭЭЛТ

ШААНТАГ

АБОГИЙН ЦААСАН ШУВУУ ШИДӨ

Хөхрөх уулын энгэрт хэн нэгэн цаасан шувуугаа унагаж орхижээ.

Түүний хас лимбэ мэт голшиг бие болоод уян зөөлөн араг яс үл мэдэг тахийгаад, ялимгүй салбарсныг эс тооцвол, урьдын өнгө жавхаагаа өчүүхэн ч гээгүй үзэгдэнэ.

Торго шиг зөөлөн зүлгэн дээр хэвтчихээд, урьд нь өөрөө дураар сэлгүүцэн зорчдог байсан зах хязгааргүй тэнгэрийн энг ширтнэм. Цэлмэг огторгуйд хааяа нэг хөвөн зөөлөн үүлс хөглөрөн хөвж, сүрэг шувууд юу эсийг шулганан дэггүй бяцхан анахай нар шиг хөөцөлдөн нисэх ажээ. Сонор мялаасан сонсголонтой энэхүү аялгууг сонсох тусам цаасан шувууны уйдсан сэтгэлд атаархлын оч бадрана.

Алсын уулсын тэртээд сэвэлзэх салхин сэрчигнэн үлээхэд, хавь ойрын өвс ногоо ханаран найгаад, цаасан шувууны урт нарийхан бие тэднээс хоцрохгүй гэсэн шиг дэгдэн хөвсгөнөх нь аясын салхийг хөлөглөн асар тэнгэрийнхээ энгээр хөөрөн нисэх боломжтой боллоо гэж найдсан болов уу.

Гэвч салхины хүч дэндүү сул байсан болохоор цаасан шувуу ханцуйгаа хэд сэгсэрсэн болоод зүлгэн дээрээ эргэн хэвтлээ. Тэр голдоо ортол гонсойн хэвтэж байтал хажуу дэргэд нь зөөлөн яруу дуу гараад:

“Хүүе ! Салхи ах аа, өөрийг чинь ингэж дуудахад гомдохгүй буй за? Таны биенээс далайн исгэлэн шорвог амт үнэртэж байхыг бодоход та лав тэр зүгээс ирсэн байлгүй.” хэмээн хэлэв.

Цаасан шувуу эргэн тойрныг гүйлгэн үзвээс түүнээс холгүй нэгэн сугсалзсан хээрийн өвс тэнгэрийг ширтэнгээ түүнээс яриа өдөн ийн өгүүлжээ.

“Тийм ээ ! Хэнз ногоо чи мөн ажигч гярхай байна шүү ! Би үнэхээр их далайн тэртээгээс аялсаар энэ газар хүрч ирсэн билээ.” Чийгтэй зөөлөн агаарт хаанаас ийм ялдам сайхан дуу гарав гэж бодлоо шүү.

“Тэгвэл салхи ах та бидэнд их далайн сонин хачнаас хуучлан сонсгохгүй юу ! ” хэмээн хээрийн өвснөөс гадна, цэцэгс дохилзон мэхэлзэн гуйхад, холгүй сүүхэлзэх хөгшин заарт мод ч тэднээс хоцрохгүй сэрчигнэн дуугарав.

“Түүнийг дуртайяа зөвшөөрөлгүй яахав ! ”

Тэгээд салхи талын энгээр найгалзан бүжиглэх зуур, шинэ танилцсан олон нөхдөдөө алс холын шинэ ертөнцийн сонин сайхан болох хөлөг онгоц, далайчин, тэнгисийн шувууд болон аварга загасны тухай хүүрнэн өгүүлж эхлэлээ.

“Хичнээн гайхамшигтай их мянган ертөнц вэ?” хэмээн цаасан шувуу түүний ярианд бүр алмайрч гүйцжээ. Тэр хэдийгээр салхи хөлөглөн агаарт нисэж байсан боловч салхины ийн

өгүүлэхийг урьд нь огт сонсож байгаагүй юм. Тэрбээр салхи халим загасны уянгалаг дууг шивтнэн хүүрнэхийг чих тавин сонсох зуур, далайн мандлын дээгүүр үзэгдэх саран авхай, одон мичдийг харахсан гэж мөрөөдөж байв.

Тал нутгийн талархлын дуун дунд, салхи аян замын сонин хачныг хүүрнэж гүйцээд, цаашаа аялалаа үргэлжлүүлэхээр сэвхийн явж одлоо.

Өргөн тал дахиад л нам гүм байдалд автжээ.

Уулын энгэр дэрлэн хоцорсон цаасан шувуу хэдийгээр салхи даган нисэж чадаагүй боловч түрүүчийнхтэй адил уйтгар гунигт автахаа байжээ. Дор нь нэлийх ширэг ногоон хамба хилэн мэт зөөлөн, өвс болгон эрч хүчээр дүүрэн агаад, талын өнгө тэр чигээрээ амьдралын баяр баясгаланг илтгэн харуулж буй мэт түүнд анх удаа санагдах болов. Харин өнгө алагласан цэцгүүд эх байгалийн үзэсгэлэнд чимэг нэмнэ. Эх газар тэр аяараа цоглог хөгжмийн аялгуу эс бөгөөс зөөлөн яруу хэмнэлт шүлэг мэт нэг л ялдам үзэсгэлэнтэй.

Саяхан л тэр нисэж чадахаа болилоо гэж гуниглан гутардаг байж билээ. Одоо харин огторгуй тэнгэрт цойлон нисэхийн мөрөөсөлд автахаа байжээ. Цаасан шувуу эргэн тойрны бүх юмсын дуу авиаг сонсох дуртай болчихов.

Хэдэн ч удаа наран шингэж, саран мандаад, хэдэн ч өдрийн үүрийн туяа үдшийн бүрий өнгөрснийг бүү мэд, яваандаа цаасан шувуу нүдэнд тэр бүр тусаад байдаггүй өвс ногоо,

цэцэг хуар бүхэн амьдралын оргилуун эрч хүчийг биедээ шингээсэн байдаг болохыг ойлгов. Түүнчлэн заарт модны намба төрх, салхинаа исгэрэх чимээ, од гялалзсан шөнө хорхой шавьжнууд шороо ухаж төнхөх авиа зэргийг ч ялгадаг болжээ. Тэр байгаль эхийн хөвүүдтэй ойртон дасаж, ярилцах арга ухаанд яваандаа суралцав.

Далайн салхи нааш цааш ирж очин, уулын салхи ч хөндий талын амьдралын сураг зангийг дуулган, өдөр хоногууд хэрхэндээ л сонин хачнаар дүүрэн өнгөрөх боловч, бяцхан цаасан шувуу салхи хөлөглөн агаарт дүүлэн нисэх хүслээ яахин үлдэн хөөж чадах билээ.

Нэгэн жаргах нарны шаргал туяатай шар бүрийгээр хөхрөх уулсын хормойтой залгаа хөндий талд хэд гурван хүүхдийн хөөцөлдөн инээх дуу сонсогдов. Хавьд ойрд дуулдаж сонсогдоогүй энэ дуу чимээ цаасан шувууны хувьд ихээхэн дотно санагдах төдийгүй сэтгэлд нь итгэл найдварын оч улалзлаа.

“Хүүе, та нар хар даа ! Тэр уулан дээр нэг цаасан шувуу байх шиг байна.”

Хүүхдүүд тэгж тэгсээр цаасан шувууг олж хараад, бие биеэсээ өрсөлдөн уулын энгэрийг чиглэн гүйцгээв. Хүүхдүүд дор бүрдээ л цаасан шувуутай болчихъё гэж бодсон бололтой өөд уруугүй сонжиж байснаа сүүлдээ юунаас ч болсон юм бүү мэд, маргалдаж гарчээ. Эцэс

сүүлд нь насаар хамгийн бага, уйлах дуу нь хамгийн чанга агаад үг сөрөн мэтгэлцэж ч сураагүй нэг жаалхүү цаасан шувууны эзэн болоодохов.

Цаасан шувууны эзэн болсон жаалхүү нулимстай нүдэндээ инээмсэглэл тодруулаад, утасны үзүүрээс дээш доош угзран татваас дээшээ дэгдэн хөөрчээ.

“Нислээ шүү ! Нислээ! Бүр өндөрт хөөрөн нисэж байна ! Хүүе, би дахиад хөөрөн нисэж чадлаа ! ” Балчир жаалын гарын дэмээр салхи хөлөглөн хөөрөн ниссээр үүлэн цацаг шүргэх үедээ, цаасан шувуу тэсгэлгүй баярлаж, хамаг чадлаараа ийн хашгирчээ.

Уулын энгэрийг бараадан ургасан өвс ногоо, алаг цэцэгс бүгд түүний төлөө баярлацгаан:

“Нисчихлээ ! Нисчихлээ шүү ! ” хэмээн хашгиралдав.

“Уухайс чи хувцас чимгээ зүүгээд нисэж байгаа чинь ямар жавхаалаг харагдаж байна вэ?”

“Бяцхан цаасан шувуу чиний хүсэл ингээд гүйцэлддэг байжээ.” гэж өвгөн заарт мод хүртэл тэднээс хоцрохгүй гэсэн шиг сахал үсээ намируулан инээмсэглэжээ.

“Тийм ээ, үнэхээр гайхалтай сайхан байна. Хамгийн гол нь та бүхэн миний баяр баясгалангаас хуваалцаж байгаа нь юутай сайхан хэрэг билээ?” хэмээн цаасан шувуу агаар тэнгэрт зоргоор нисэж явахдаа бодож байлаа.

Цаасан шувуу улам өндөрт дүүлэн нисэх тусам балчир

жаалын сэтгэл ч түүнээс дутуугүй хөөрөн догдлож, атаархангуй нүдээр түүнийг ширтэх бусад хүүхдүүдэд хандан ийн хашгирлаа:

“Миний цаасан шувуу дээшээ хөөрөн нисэж чадлаа. Тийм болохоор түүнийг би авах ёстой.”

Харин өндрөө аван элин халин нисэж байгаа цаасан шувуу жаалхүү рүү ширтэн хараад:

“Жаалхүү минь чи л харин минийх болсон байх шүү ! ” гэв.

Түүнтэй шүргэлцэн өнгөрөх хөвөн цагаан үүл цаасан шувуу болон жаалхүү хоёрыг хараад сониуч зан нь хөдлөв бололтой жолоо татан зогсоод тэднийг ажиглана.

Тал дээр торойн хоцорсон жаалууд өөрийн мэдэлгүй цаасан шувууны эзэн болсон жаалын араас гүйлдэх зуураа агаарт байгаа цаасан шувууг өлийн харсаар байх ажээ.

Жаалхүүгийн утсаар хөтлөх цаасан шувуу улам бүр дээшээ хөөрсөөр цэгийн төдий харагдах үед бусад хүүхдүүд түүн рүү хандан:

“Чи наад цаасан шувуугаа битгий алдчихаарай даа ! ” хэмээн сануулахаа мартсангүй.

“Би цаасан шувуугаа яасан ч алдахгүй, түүнийг хичнээн сайн барьж байгааг та нар харж байгаа биз дээ ! ” гэж жаалхүү их л итгэл төгс өгүүлэв.

Газар үлдчихээд одоо мөөгөн чинээ жаахан харагдах

хүүхдүүд рүү цаасан шувуу их л бахдалтай хариу өгүүлрүүн: “Ха, ха ! Би л чиний гар хөлийг утсаараа агдлан хүлсэн болохыг чи яахин мэдэх билээ дээ ! ” гэжээ.

Түүнийг ийнхүү өгүүлж амжаагүй шахам байтал гэнэт хэсэг ширүүн салхи үлээхэд цаасан шувууны бие хавьгүй хөнгөрөөд бүр тэнгэр огторгуйн чанад хүртэл дүүлэн нисчээ.

Өөрөө харагдаж үзэгдэхгүй болчихоос өмнө завдан цаасан шувуу өөрт нь хэсэг хугацаанд амьдралын баяр баясгалан бэлэглэж байсан өвгөн заарт мод, өвс ногоо болон өнгийн олон цэцэгстэй салах ёс гүйцэтгэлээ.

“Сайн андууд минь ! Баяртай ! Би салхи ахыг даган холын аялалд гарлаа. Харин би та бүхнийгээ хэзээ ч мартахгүй байх болно.”

Уудам талд өвгөн заарт модны бахим мөчрүүд салхины аясаар сэрчигнэн найгаж цаасан шувууны аян зам өлзийтэй байхын ерөөлийг талбина. Өвс ногоо, өнгийн цэцэгс ч бүгд жижигхэн гараараа тэнгэр өөд дохицгоон дотны андаа үдэн гаргах ажгуу. Тэр ч байтугай хорхой шавьж нар хүртэл жиг жуг дуугаралдан үдэлтийн дууг эгшиглүүлэвэй.

Олон нөхдийн ерөөлд булагдаж гүйцсэн цаасан шувуу хүчтэй салхинд туугдсаар алсын уулсын бараан хөшгийн цаагуур далд орлоо. Хорхой шавьжийн царгиа, хүүхдүүдийн харуусангуй уулга алдалт болон балчир эзнийх нь уйлах

чимээ бүгд ард хоцорчээ.

Тэнгэрт түүнийг ажиглан зогссон цагаан үүлс
бодлогоширолд автаад аян замаа үргэлжлүүлэв.

Салхины мэдрэмжийг даган яваад өгчихлөө !

Ийнхүү хөвөн цагаан үүл, хөгжилтэй бяцхан шувуу лугаа
адил түмэн газар үргэлжлэх хөх тэнгэрт чөлөөтэй хөөрөн
нисэж чадсандаа цаасан шувуу туйлын маадгар байх нь
аргагүй юм.

Тэр зам зуур цагаан үүлс лүгээ хуучилж, уул далайг
зорин холын аянд гарахдаа тэдний үзэж туулсан гайхам
сонин хачныг сонсож, галуун сүрэг лүгээ тэнгэр огторгуйд
хөөцөлдөн бүжиглэхээс гадна, орчлон хорвоо эх дэлхийнхээ
үзэсгэлэн гоог магтан дуулахаа яахин мартах билээ. Жаргах
нарны үлдэл туяаг дайран өнгөрөхдөө үүлсийн өнгө гайхам
үзэмжээр солигдохыг бахдан бишрэв. Түүнчлэн тунгалаг
нуурын мандалд өөрийн дүрсийг тольдон, тунамал ариун
горхийн усан хоржигнон урсахыг ч бахдан ажиглажээ. . . .
. Эдгээр үзэж өнгөрүүлсэн бүхэн нь үнэхээр үгээр хэлж
барамгүй үзэсгэлэн гоогийн туйл байлаа.

Үүр цүүрээр тэр өргөн тал, өндөр уулын дээгүүр нисэхдээ
эх газрын дээгүүр өглөө нарны гэрэл зугуухан урагшлан
мөлхөж байхыг харжээ. Мянга түмэн амьдрал бэлэглэгч
алтан цацраг гялтганах бүрт түүний сэтгэл учиргүй
догдлов. Тариан талбайд эртэч тариачин эр үхрээ хөтлөн

газраа хагалдаг бол орой нарны туяан дор хоёулаа ханьсан гэр рүүгээ харьдаг ажээ. Шувууд бөртөгөнөн нисэлдэхдээ ангаахай үрсээ хооллодог болохыг үзэж улам ихээр уясан хайлжээ.

Салхи хөлөглөн дөрвөн зүгээр зоргоор хэсүүчлэн нисэхдээ байгалийн олон өнгө үзэмж, хамаг амьтдын амьдралын хэв шинжийг ханатал үзэж сонирхсон боловч цаасан шувууны сэтгэлд үл ялиг харамсал хургана. Учир нь тэр зөвхөн салхины аяг аашийг даган нисэхээс биш, өөрийн дураар зогсож энэ тэрийг сонирхох аргагүй билээ. Заримдаа цагаан үүлстэй хөөцөлдөн ой шугуйн дээгүүр өнгөрнө. Харин үүл ах нь өндөр уулын оргилд саатан морилж, өөрийн хуучин анд өвгөн нарс лугаа хууч хөөрөхөд, өөрийн эрх байхгүй тул тэдний амттай ярианд оролцох боломжгүй хоцорчээ. Хааяа бас шувууд бяцхан дэгдээхэйгээ очиж үзээч гэж урих боловч цаг давчуугийн улмаас үлдэж болохгүй тул тэр бяцхан амьтдын хэрхэн нисэж сурч байгааг үзэх боломжийг алдсан юм.

Тэр зөвхөн салхины ааш аягийг даган нисэх боломжтой.

Мандах нарны араас мацан хөөцөлдөж, шөнийн тэнгэрт од сарны нандин нууцыг сурвалжлах санаа өвөрлөх боловч замын турш гагц салхины аягт захирагдан явсаар байв. Ой тайга, хээр тал, хот балгадыг дайран ниссээр. хичнээн ч мянган бээрийг ардаа орхисон юм бүү мэд. Чухам хэдийд

жаалхүүгийн гараас алдууран ниссэнээ ч одоо санахаа байжээ. Ийнхүү ниссээр тоо томшгүй олон өглөөний манан үдшийн шүүдрийг үзэж, хувцас хунар нь урагдан салбараад эцэж ядрахын туйлд хүрэв.

Бас л нэгэн жаргах нарны туяанд тэнгэрийн хаяа нэлэнхүйдээ улайсан шар бүрийн цагаар, цаасан шувуу үүрээ зорин нисэх сүрэг тагтаатай хамт, сүглэгэр бараан уулын дээгүүр даваад, өргөн уужим тариан талбайд хүрэлцэн иржээ.

Түм гаруй хүнтэй багахан хотын эргэн тойронд ногоон чих зайгүй цухуйсан тариан талбай үргэлжилнэ. Харин тариан талбайгаас цааш үелж сүндэрлэсэн хөглөгөр хөх уулс хотыг тойрон ороожээ. Хотын зүүн талын уулын оройгоос нэгэн тунгалаг горхи суналзан урссаар өргөн талыг зүсэн одно. Горхийн ус болор мэт тунгалаг болохоор дунд нь хөвөх загас жараахайг тодхон харж болох ажээ. Горхийн хөвөөг даган зэрлэг тоор, гүйлс, алим, лийр жимсний модод холилдон ургасан нь хаврын түрүү сард гөлөглөн нахиалж, мөчир даган сагсайх өнгө өнгийн цэцэгс оройн нарны үлдэл туяан дор хайрын харцаар талимаарах ажгуу. Нэлээд өргөсч ирсэн уулын горхи тариан талбай хүрээд хэдэн хэсэг услалтын сувагт хуваагдан оржээ. Эрэг дагуу ургасан унжгар уд модны саглагар мөчир үдшийн салхинд үл мэдэг найгалзана.

Үдшийн нарны туяа тэнгэрийн хаяаг хэдэн мянган бээрийн

улайлган чимээд, эргэж уул хөндийн даруухан ногоон өнгөн дээр тусчээ. Оройн салхинд хотын энд тэндгүй цагаан утаа суунаглан, амтат хоолны арааны шүлс асгаруулам үнэрийг тархаана.

“Ямар сайхан газар вэ?” хэмээн агаар тэнгэрт элин халин нисэхдээ энэхүү зураг мэт үзэмж төгөлдрийг олж хараад цаасан шувуу тэсгэлгүй дуу алдав.

“Тэгэлгүй яахав манай гэр оронд тавтай морилогтун ! ” гэж цаасан шувууны магтаалыг сонсоод сэтгэл нь хөөрсөн тагтаа шувууд өгүүлээд хотын зүг хурд нэмэн нисэлдлээ.

Цаасан шувуу ч тэднээс хоцорсонгүй хотын дээрх агаарт нисэн оров. Гудамж өргөн чөлөөг эмх цэгцтэй байгуулж хүн хар, машин тэрэг хөлхсөн газар ажээ.

“Үнэхээр хөл хөдөлгөөнтэй том хот юм гээч ! ” хэмээн цаасан шувуу агаар тэнгэрт дуугүй ажиглан ниснэ.

Хотын өндөр сүрлэг байшингуудаас гадна, уулын хаяа дэрлэсэн зүүн дүүргийн ойролцоо нэгэн номин ногоон хулсан шугуй байх нь том хотын нүргээнд хавьгүй намуун зөөлөн өнгө аяс нэмэрлэх нь хүмүүний сэтгэлийг өөрийн эрхгүй татмаар. Цаасан шувуу энэ бүхэнд татагдан байтал түрүүлэн нисэж явсан тагтаанууд бүгд хулсан шугуй руу нисэн ороод түүн рүү их л нөхөрсгөөр өгүүлрүүн:

“Бид бүгд Абогийн ногоон хулст хаданд амьдардаг юм даа ! ” гэлээ.

Оройн салхи орчлонгийн диваажин болсон энэхүү газрын нам гүмд автав уу гэлтэй хавьгүй аядуу зөөлөн болоод эхлэв. Тэр хэрээр цаасан шувуу маань ч доош зөөлөн газарджээ.

Өглөөгүүр Або өөрийн бяцхан анд нар болох тагтаануудыг эргэж тойрохоор номин хулст хадандаа алхсаар хүрч ирлээ. Тэр хэдэн удаа тасхийтэл шүгэлдэхэд ой шугуйгаар нэг цууриатаад, баярлаж хөөрсөн тагтаанууд далавчаа дэвэн нисэлдэх газраас Або нэгэн нэлээд эвдэрч муудсан цаасан шувуу хулсны мөчир дээр тоhogдсон байхыг олж үзжээ.

Або цаасан шувууг олж аваад, засаж сэлбэн “Шидө” гэсэн нэр хайрлажээ.

17 23

АРВАН ДОЛООНЫ ӨДӨР

ТУТАРГАН ЧИХ

*Амуу будаа боловсорч намрын хонгор салхи үлээх бүр, үелэн
тариалсан тутаргын талбайд тоо томшигүй олон алтан
түрүү шаагин ганхаад, болц гүйцсэн мөхлөгүүдээ дааж
ядан дохилзох буюу.*

ТУТАРГАН ЧИХНИЙ СЭТГЭЛИЙН ДУУДЛАГА

Тунгалаг өглөөний урин салхи зөөлөн илбэхэд, хот тэр аяараа гүн нойрондоо умбасан хэвээр, өчигдөр оройн хөл хөдөлгөөнтэй харьцуулах юм бол гудамж зээл нь эзгүйрээд ер бусын нам гүмхэн харагдана. Дээвэр дээр үүрлэсэн бяцхан шувуухайнууд ямар нэгэн юм хүүрнэн шулганах өглөө эрт Або өөрийн цаасан шувуугаа аваад хотын захын тутаргын талбайг чиглэн алхав.

Номин хулсан шугуйд шинэ эзэнтэйгээ учирснаас хойш цаасан шувуу өвч биеийн хувцас заслыг иж бүрэн сольжээ. Або үнэхээр уран гартай нэгэн ажээ. Тэр цаасан шувууны араг ясыг хэдэнтээ засаж тэгшлээд, хувцсыг халж өгснөөр тэр одоо агаар тэнгэрт дураар хөөрөн нисэж, салхины аясаар тонгорцоглон эргэж ч чаддаг болов. Өвч биеийн хөнгөн зөөлөн өмсгөл нь түүнийг урьд өмнөхөөс ч илүү өндөрт аваачин, тэр хэрээр алс холын юмс үзэгдлийг харах боломжтой болсон төдийгүй, өөрт нь бас нэр хайрлажээ. Энэ бүхэнд цаасан шувуу Шидө сэтгэл маш хангалуун байлаа.

Хэд хоног цуг байх явцдаа Або үнэхээр билиг оюун төгс өвгөн болохыг тэр олж мэджээ.

Наян насны босго гэдэг хүн төрөлхтний хувьд тун амаргүй

даваа боловч, хөл гар нь хөнгөн шингэн хэвээр, эрч хүч дүүрэн Абогийн нүд хурц чих сонор төдийгүй, хүүхэд мэт хөнгөн дэврүүн сэтгэлтэй нь Шидөгийн хувьд хамгийн хайр татам атлаа ойртож дотносмоор шинж санагдана. Өөрийг нь засаж сэлбэсэн цагаас хойш Або эгээ л дэггүй жаахан хүүхэд мэт цаасан шувуугаа хаа сайгүй авч явдаг болов. Өргөн чөлөө нарийн гудамж хаана ч явсан эр эм, хөгшин залуу гэлтгүй бүгд түүнтэй танимхайрч, “Або ! Або ! ” хэмээн дуудна. Хүн болгон ийн дуудах болохоор цаасан шувуу ч мөн энэ л нэрээр түүнийг дууддаг болов.

Өглөө бүрийн ургахын улаан нартай уралдан, Або Шидөгөө аваад хотоос гарч, хөдөө тосгоны хаяан дахь ойн чөлөөнд мандах нарны эхний туяаг харуулах нь цаасан шувууны хувьд ханашгүй баяр жаргалтай мөчүүд байдаг байлаа. Цэлмэг тэнгэрийн цэнгэг агаарт дураар нисэн, шувуудын хөгжилтэй жиргээг сонсонгоо, урин салхи чанадын цагаан үүлсийн тээж авчирсан алс холын сонин хачныг дуулна. Эсвэл горхийн хөвөөгөөр доогуур нисэхдээ, тоор, лийрийн цэцэгс болон унжгар уд мод горхи булагтай хоршин дуулахыг хардаг. . . . Энэ бүхэн болвоос эх болсон байгаль дэлхийн хамгийн цэвэр ариун атлаа үзэсгэлэн төгс дуугүй мөргөл мэт Шидөд бодогдоно. Өдөр болгон цаг тутам энэхүү яруу зохиролт аялгуу эгшиг хүмүүний сэтгэлийг хөвсөлзүүлдэг бус уу.

Хөдөө хээрийн энэхүү эгшиг дууг сонсоод өнгөрөлгүй Шидө ч өөрөө тэдэнтэй санал бодлоо хүүрнэдэг байлаа. Яагаад гэвэл өглөөний нарнаар учран золгодог тэдгээр анд нөхөд нь түүний агаар тэнгэрт дүүлэн нисэх хийморь жавхааг бадраадаг юм.

Тэр номин хулст шугуйгаас анх олдоод нэлээд хэд хоносны эцэст хөдөө хээр хөвс ногоон шугуйд эргэн иржээ. Учир нь хаврын бороо өдөр алгасахгүй нөрүүхэн орсоор байсан тул Або цаасан шувуугаа гэрийнхээ хананд өлгөчихөөд гаргах аргагүй байсан юм. Харин хэд хоногийн дараа удтал барааг нь хараагүй мөнх хөх тэнгэртэйгээ учран золгох үед Шидө баярласан гэж жигтэйхэн. Тэр тэсгэлгүй баяр хөөрөө нууж эс чадан салхи, үүлс, шувуухай зэрэг хуучин андуудтайгаа инээж хөхрөн хуучилж байтал нэгэн санаандгүй хэрэг тохиолджээ.

Тэр нь Аботой холбоотой юм. Цаасан шувуу шувуухай нартай хослон дуулж, уулын салхи, цагаан үүлстэй хуучлан ярилцаж байхыг сонсож үзсэн төдийгүй, хамгийн хачирхалтай нь Або өөрөө түүн лүгээ үг хэлээ ололцон ярьж эхлэсэн явдал юм. Шидө өөрийн үзэж өнгөрүүлсэн сонин хачныг түүнд хүүрнэхэд, Або ч хариуд нь хүний орчлонгийн учир жанцанг түүнд тайлбарлаж өгдөг болжээ. .

. . . .

Намрын жихүүн өглөө хөндийн салхин хүүс хүүс үлээхэд

үелэн тариалсан тутаргын түрүү намс намс найгаад, мандах нарны үзэмжит туяанд болц нь гүйцсэн мөхлөгүүд тааламжтай мишээнэ. Хураах цагаа хүлээн буй тутрагын түрүүнүүд салхины аясаар бөхөлзөөд, салхины сэвшээнд шуугин исгэрэх нь байгаль дэлхийн үзэмжинд ер бусын эрхэмсэг өнгө аясыг нэмэрлэх бөлгөө.

Алтан нарны эхний туяа алсын уулын оройд тусах үеэр Або Шидөгөө барьсаар энэхүү үзэсгэлэнтэй тутаргын талбайн захад ирсэн байлаа.

“Эх байгалийн хувирал болон сүр хүчин цаг ямагт ийм үзэсгэлэнтэй агаад сэтгэхийн аргагүй байдаг юм даа ! ” хэмээн уулын салхины сэвшээн дунд доош тонгойн тутрагын болцыг ажиглах зуур өгүүлэв. Тутрагын үнэрийг биедээ шингээсэн өглөөний шүүдэр хамаг хувцсыг нь норгоод, тутраган түрүү намалзан шуугих чимээг сонсож, тэрбээр тэсгэлгүй сэтгэл ханамжтай урт амьсгал авав.

Агаар тэнгэрийн дээгүүр дүүлэн нисэж явахдаа хөдөө хээрийн энэхүү бахдам үзэмжийг харж, Абогийн тэсгэлгүй бахдан дуу алдахыг сонсоод, цаасан шувуу Шидө үүлсэд хандан ийн өгүүлрүүн:

“Тутрагын боловсорсон түрүү ямар гоё харагдана вэ? Сэвшээ хонгор салхины аясаар намалзан шуугих энэ тутаргын чимээ орчлон хорвоогийн хосгүй яруу эгшгийн нэг яах аргагүй мөн дөө ! ” гэв.

Агаар тэнгэрийн өндрөөс боловч алтан шаргал тутрагын талбайн дундахь хоёр боловсорсон түрүүг Шидө тодоос тод ялган харж байлаа. Тэр хоёр болвоос түүнтэй бүр жаахан тутарган чих байхдаа л танил дасал болсон юм. Тэд одоо анд нөхдийнхөө хамтаар аясын салхины сэвшээнд хоолой нийлүүлэн эгшиг өргөж байна.

Халиуран найгах тутрагын голшиг нарийн ишийг хараад, Шидө улирлын нууцхан хувьслыг улам тод мэдрэхийн ялдамд, нялх ногоон чихтэй анх учирч байсан үеийг эргэн санажээ.

Тэр болвоос хаврын наран тааламжтай сайхнаар ээсэн тунгалаг өглөөний цаг байсан бөгөөд урин салхи эх газар сэргэж боссоныг илтгэх тааламжтай амьсгалыг нэвт шингээсэн байлаа. Хотын захын тутрагын талбайг нэлэнхүйд нь усаар дүүргээд, ажилч хичээнгүй тариачид урьдаас үрслүүлж бэлдсэн тариан чихийг талбайд суулгаж байв. Үелэн шатласан тутрагын талбайнууд тэнгэрийн өнгө уулын үзэмжийг тольдсон нь үнэхээр бахдалтай.

Нэгэн өдрийн өглөөгүүр Або өөрийн цаасан шувуу Шидөгөө аваад тутрагын талбайн захаар алхангаа, бяцхан чихүүдийг анхааралтай ажиглаж явлаа. Абогийн царайд үе үе тааламжтай инээмсэглэл тодрох тул Шидө түүнээс тэсгэлгүй ийн асуулаа.

“Або чи ямар нэгэн сонирхолтой зүйл олж үзээ юу? Их л

тааламжтай инээмсэглэж байх чинь ! ”

“Хэ хэ ! Тийм байна уу?” Шидөгийн үгийг сонсоод Або сэтгэл тэнүүн инээхэд, тэр ялдам инээд нь Шидөг ч мөн хөөргөн догдлуулав.

“Чухам юунд ингэтлээ сэтгэл тэнүүн байна вэ?” гэж Шидө түүнээс шалгаав.

“Энэ талбай дахь тутрагын чихүүд их л тааламжтай хурдан ургаж байгааг хараад.”

“Тутрагын чих гэнэ ээ? Юу байдаг юм бэ?” гэж эрх бяцхан жаалхүү мэт Шидө тэсгэлгүй асуулаа.

“Чи хар даа, талбайд ургасан эдгээр ногоохон нахиануудыг тутрагын чих гэдэг юм. Тутрагын үр мөхлөгөөс салаалан ургаад байгаа нь энэ юм л даа ! Хавар тариачид эднийг талбайд суулгаад, ургаж боловсрохоороо алтан шаргал тутрага болон хувирдаг. Энэ чинь л манай хотын хүмүүсийн гол хүнс юм шүү дээ ! ”

“Аа тийм бий ! Хүмүүс яахаараа энэ жижигхэн өвснүүдийг ийм жигд суулгана вэ гэж би бүр гайхаад байсан юм. Гэтэл эд чинь жирийн өвс биш байсан байх нь л дээ ! ”

“Ха ха ха ! ” хэмээн Або тас тас хөхрөх нь Шидөгийн үг түүнд их л хөгжилтэй санагдсан бололтой.

Абогийн хөгжилтэй инээдэнд Шидөгийн хийморь золбоо сэргээд, тутрагын талбайд жигд суулгасан жижиг өвснүүдийг гярхай ажиглаж эхлэв. Үгүй ээ, нээрэн

тутаргын чих гэх учиртай шүү дээ. Тэгсээр тэр сэвшээ салхинд нялх чихнүүдийн ийн шивтнэлдэхийг олж сонсчээ. .

. . . .

“Өглөөний шүүдэр ямар гоё юм бэ?”

“Хэлээд яах билээ ! Хаврын салхи хамаг биеийг тааламжтай сайхнаар үлээж байна ! ”

“Товчоор хэлбэл энэ хорвоо үнэхээр сайхан юм аа. Чи хар л даа ! Доош тонгойн харвал усанд хөх тэнгэр, хөвөн цагаан үүл, номин ногоон уулын дүрс тусах нь хичнээн үзэмжтэй сайхан байна вэ ! ”

“Яриа байхгүй сайхан байна ! Нарны туяа намуун байгалийг тольдож, шимтэй хөрсний ачаар бид бүхэн бодож санах юмгүй ийм хурдан ургаж байгаа хэрэг ! ”

Салхины аясаар бодлогоширон нисэх Шидө үелсэн олон чихэн дундаас Абогийн хөлд арай ойрхон ургасан хоёр нялх чих хоорондоо шивнэлдэх нь Шидөгийн анхаарлыг татсан тул тэдний сэтгэлийн үгсийг чих тавин сонслоо.

“Чи бид ямар учир шалтгаанаар энд ургана вэ? Яадаг ч байсан хоёр чих болчихоод энэхүү нүргэлсэн их мянган ертөнцөд ирнэ гэдэг үнэхээр сонирхолтой шүү ! ”

“Хэ хэ ! Чамд нэг бяцхан нууц задлая л даа ! Эхлээд үр арван тав хонож байж хөрснөөсөө цухуйдаг юм. Дахин арван тав хоноход бидэн шиг чих болон хувирна. Тэгээд бид хэзээ нэгэн өдөр түрүү болон сугсайгаад аясын салхинд найгалзан

байна гээд бодохоор ямархуу санагдаж байна даа?”

“Ай ! Үнэхээр сайхан санагдаж байна ! ”

“Хүүе, тутрагын талбайн хоёр жаахан чих сонсож байна уу? Би болвоос Абогийн цаасан шувуу Шидө байна.” Хоёр бяцхан чихийн яриа түүнд үнэхээр сонирхолтой санагдсан тул Шидө тэдэнтэй ийнхүү мэндчилэв.

Энэхүү халуун дулаан мэндчилгээ тэр дарай тутрагын чих болон Абогийн анхаарлыг татав.

Хоёр тутаргын чих дээш өлийн харвал хөх тэнгэрт хөнгөн гоёмсог хувцсаа өмссөн Шидө хөөрөн нисэх нь үнэхээр нүд баясгам. Хамгийн хачирхалтай нь цаасан шувуу тэдний үгийг сонсож амжсанд байлаа.

“Яриа ойлгодог цаасан шувуу байх нь ээ ! ” гэснээ зүүн талын тутарган чих бяцхан ногоон гараа даллан цаасан шувуу Шидөд хандан ийн өгүүлрүүн “Хүүе, сайн байна уу? Чамтай найз болсондоо баяртай байна. Тэнгэрийн дорх, дөрвөн далайн хоорондох түмэн бодис бүгд нягт барилдлагатай ахан дүүс гэдэг биз дээ ! ”

“Тийм шүү ! Бид тэнгэрийн салхи, үүлс, шувууд болон газрын чийгийн хорхой, том мод, хэнз өвс, цэцэгс зэрэгтэй сайн найзууд бололцоод байнга ярьж хөөрч байдаг юм.” гэж баруун талын тутарган чих ч гэсэн их л хэвлүүхэн ярианд оролцож эхлэв.

“Шидө минь, чи хэнтэйгээ юугаа яриад байна даа?” хэмээн

Шидөг ам нээж завдаагүй байтал Абогийн хашгирах дуу сонсогдлоо.

“Би хоёр жижиг тутарган чихтэй ярьж байна л даа. Би тэдэнтэй сая найз болчихлоо.” гэж Шидө баясгалантай өгүүлэв.

“Хоёр тутарган чих гэнэ ээ?”

“Тийм ээ, тэр хоёр таны хөлийн ойролцоо байна шүү дээ !”

Шидөгийн ийн хэлэхэд Або яаран доош тонгойгоод ус мэлийсэн талбай дүүрэн ургасан чихүүдийг хараад ийн бодруун “Чухам аль хоёр чих юм бол доо? Энэ олон ижил золигнуудын алийг нь аль гэж таних билээ? Бүгд л тос даасан ижил юмнууд байна шүү дээ !”

Або ийн бодох зуур нүүрэнд нь тэсгэлгүй инээмсэглэл тодров. Өглөөний салхинд тутарган чихнүүд бүгд түүн рүү гараа даллан, толгой дохин мишээж байх шиг санагдахад тэр бас л ийнхүү бодлоо: “Хаврын уур орж үр суулгаад, чих хатгаж, удалгүй бороо хуртай залгаад, эдгээр тутарган чихүүд үнэхээр хурдан ургажээ. Өнөө жил ч арвин ургац хураах юм байна даа !”

Або ийнхүү бодлогоширох зуур бяцхан чихүүдэд хандан: “Булбарай хөөрхөн чихүүд та нар юундаа ингэтэл хөөр баярт автана вэ?” хэмээн асуулаа.

Цэнгэг салхины аясаар дохилзох зулзаган чихүүд дуулж бүжиглэнгээ Абод ийнх хариулж байх шиг санагдана.

“Або, Або, тутарган чихнүүд өөртэй чинь яриад эхлэлээ шүү дээ ! ” гэх Шидөгийн дуу сонсогдов.

“Нээрэн гэж үү? Тэд нар юу гэж байна вэ?” гэж тутрагын талбайн захын ус соруулах хөөргийг ширтэнгээ Або асуужээ.

Тэгээд Шидө хоёр зулзаган чихийн юу өгүүлж байгааг нэг нэгээр нь Абод хэлж өгөв.

“Тэд тутарган чих болон төлжсөн цагаас хойш маш их баяр баясгалантай ургаж байгаа гэнэ ээ. Яагаад гэвэл тэдний туйлын хүслэн нь сайн сайхан амьдрах явдал юм.”

“Ялангуяа тариачин эр хүнд бэрх суулгацын ажлаа дуусчихаад баяр баясгалантай инээж байгааг хараад бид бүхэн олон олон хүмүүсийн гэдсийг цатгах болсондоо их баяртай байна.”

“Энэ болвоос бидний хорвоо ертөнцөд хүрэлцэн ирсэн гол зорилго болохоор бид түүнийгээ гүйцэлдүүлэхийн тулд хичээх болно.”

“Тийм болохоор бид эрх чөлөөтэй, дур зоргоор сайхан амьдраад авах хэрэгтэй.”

Шидөгийн ийн хүүрнэн өгүүлэх зуур үелж шатласан тутрагын талбайн гүнд үй олон тариан чих түүн рүү харан мишээж байхыг Або олж харах шиг санагджээ. Тутраган чихийн эгэл даруухан хүсэл мөрөөдөл Абогийн сэтгэлийг ихэд уясган хайлуулав.

Нэг л мэдсэн Або ч гэсэн тэдэнтэй салшгүй андууд болон хувирчээ. Чухам тэр цагаас хойш Або өдөр болгоны өглөө эрт тутрагын талбайн захаар явах бүртээ зулзаган чихнүүд хэрхэн ургаж байгааг ажиглан харах дуртай болсон юм. Ийнхүү ажиглан харах бүрт нялх чихнүүд өдрөөс өдөрт өтгөрөн ногоорч, өндөрсөн байргашсан нь мэдэгдэнэ. Ялангуяа түүний танил дотно хоёр чих өөрсдийн амьдрал болоод эргэн тойрны бүхий л юмс үзэгдэлд халуун хайртай агаад ганц дусал шүүдэр борооны дусал ч байсан үнэхээр сэтгэлийн угаас бахдан биширч, ямар ч гомдмоор хатуу бэрх зүйл тохиолдсон гоншгонож гонгинохгүй ажээ.

Нэгэн удаа хар салхи дайран ирээд хоёр хоногийн турш талбайн тутарган чихнүүдийг хайр найргүй балбаж, газарт элэглэн мөлхүүлсэний зэрэгцээ хур борооны ус шавар шавхайтай хутгаж хаяад босох тэнхээгүй болчихоод байжээ. Гэтэл ашгүй тариачид хүрч ирээд түшиж тулсаны хүчинд тэнхрэн босоод салхины аясаар дохилзон найгах боломжтой болов. Энэ үеэр хатуу хүтүүг хангалттай амссан хоёр бяцхан чих харин ч их баясгалантай дуугаар:

“Эх байгалийн дотоод эрч хүч гэдэг ч үнэхээр их юм даа ! Энэ айхтар ширүүн салхи борооны догшин ширүүн авир, хүч чадлыг хэлэх юм биш ! ”

“Үнэхээр сонин юм гээч ! Салхи цаг ямагт ялдам охин шиг мишээж байдаггүй, догшин ширүүн өөр төрхөөр ч илэрдэг

ажгуу. Хорвоо дэлхийн хувирал өөрчлөлтийг үнэхээр яндаж болшгүйг мэдлээ ! ”

“Хамгийн гол нь бид бас нэгэн удаагийн сорилтыг амжилттай даван туулж чадлаа”

Салхины борооны их омгийн өмнө өвдөг нугаралгүй өндийн босож чадсан хоёр зулзаган чихийн ийн баяр хөөртэй дууг сонсоод, Або тэдний эр зоригийг тэсгэлгүй бахдаж байлаа.

Нэг удаа тариачин эр өвдсөний улмаас талбайдаа хэдэн ч өдөр гараагүй тул тэр сиймхийгээр зэрлэг өвсөнд бариулах шахжээ. Ялангуяа төрх байдлын хувьд тутарган чихнээс өөрцгүй шахам усан хоног хэмээх ургамал тэдний дунд хутгалдан ороод тэдэнд ногдох учиртай хөрсний үржил шимийг булаан, нарны гэрлийг хаах болов. Хэдийгээр усан хоног ийнхүү дураар авирлах боловч бүгд шүд зуун тэвчицгээхийн зэрэгцээ, улам илүү үржил шимийг өөртөө шингээн, нарны гэрлийн хайр ивээлийг хүртэхээр хичээлээ.

Тутраган чихнүүд баяр хөөртэй урган төлжиж, урин салхины аясаар баясгалантай дуугаа хавь ойрд хадаахаас биш, ямар ч гомдол гутралын үг унагахгүй байгааг Шидө үзжээ. Удалгүй тариачин эзэн нь илааршин босоод, тутрагын талбайдаа эргэн ирж, хогийн зэрлэг ургамлыг түүж хаяад, ахиухан бордоод өгөв.

“Ёстой сохорсон биш завшив гэдэг л энэ байх даа ! Одоо бид улам ч бахим чийрэг болсон болохоор хэр баргийн сорилтод

алзахгүй, найман зүгийн салхинд налахгүй боллоо ! ”

“Хэлээд яахав ! Тэдгээр зэрлэг өвс ургамлууд л бидний амьдрах эрчийг улам ихээр өдөөлөө шүү дээ ! ”

Тутраган чих, усан хоног хоёрын тулалдаан хэрхэн өрнөсөн тухай Шидөгийн өгүүлэхийг сонсоод, өөрөө тэр тулалдаанд ялан дийлсэн мэт Абогийн сэтгэл ч маш их тэнүүн байлаа.

Ийнхүү хавраас намар хүртэл Або, Шидө хоёр зулзаган чихнүүдийн зугаатай өсөж ургахыг харсаар өдий хүрчээ. . .

. . .

Сэр сэр салхины аясаар алтан шаргал тутраган түрүү намалзан найгах нь ер бусын үзэсгэлэнтэй, шуугин ганхах тутраган долгисоор дамжин амуу будааны анхилуун үнэр сэнхийлээ.

“Бидний өвөг дээдэс нэгэн мөхлөг үрээс үүдэлтэй юм гэнэ лээ шүү дээ ! ”

Доош харан нисэж байгаа Шидө нэгэнт том түрүү болон хувирсан зулзаган чих толгойгоо бөхийлгөн ийн асуухыг олж сонсчээ.

“Тийм гэсэн. Түүгээр ч үл барам тэрхүү ганц хатуу мөхлөг, дэлхий ертөнц бүрэлдэхийн цагт эрт балрын мөсөн хананд хадгалагдан үлдсэн юм гэнэ лээ.”

Хоёр ахан дүүс ийнхүү хөгжилтэй яриа өрнүүлж байгааг Шидө Абод дамжуулан хүүрнэв.

“Тэр хатуу мөхлөг үрийн ариун нандин үүрэг гүйцэтгэхээр

гарч ирсэн юм гэнэ лээ ! ”

“Ариун үүрэг гэв үү?” хэмээн гагц Або төдийгүй талбайд ургах бүхий л тутарган түрүүнүүд бүгд чухам ямар үүрэг болохыг мэдэх гэж маш их шүлэнгэтэв.

“Тийм ээ, түүнээс ариун нандин үүрэг гэж өөр хаана байх билээ дээ? Бид тэрхүү хатуу мөхлөг үрээс эхлэн амьдралын тасралтгүй, дуусашгүй аялалаа эхлэдэг нь дэлхий ертөнц дээр хүн төрөлхтөн үүсэн буй болоход тэдний амьдран оршиход зайлшгүй чухал хоол хүнс нь болох зорилготой байсан юм ! ”

“Тийм болохоор бид бүхэн өрөөлийн тулд өөрийгөө зориулах гэж өсөж ургасан хэрэг байх нь ! ”

“Бидний өсөж ургахад нөлөөтэй орчин нөхцлийг эргээд нэг харъя л даа ! Хавар ганц мөхлөг үр соёолон, нялх нахиа болон хувирдаг. Тэгээд дараа нь нарны гэрэл, шимт хөрс, рашаан хур, урин салхи гээд энэ олон нөхдийн дэмжлэг туслалцаатай ургаж төлжсөөр эцэс сүүлдээ үр шим нь боловсорсоор өдий дайтай мөхлөгүүд болсон байна шүү дээ ! Одоо алтан шаргал тутраган түрүү бид нар бусдын төлөө өөрийгөө зориулах цаг ирчихээд байна ! ”

Ах дүү хоёрын энэхүү харилцан яриа нэгээс зууд, зуугаас мянгад дамжин тархсаар удаж төдөлгүй талбайн бүхий л тутаргууд энэ тухай сонсож мэдээд их л догдлонгуй байдалтай асууруун:

“Нээрэн гэж үү дээ? Бидний өрөөлийн төлөө өөрийгөө зориулах цаг үнэхээр болсон гэж үү? Тэгвэл бид нар тэрхүү ариун үүргийг хэрхэн биелүүлэх болж байна даа?”

Өглөөний салхинд үелсэн тутрагын долгис үзэсгэлэн төгөлдөр мяралзана. Алтан тутаргаар дүүрсэн талбай тэр аяараа амсраа дүүрэн мэлтэлзэж байх шиг Шидөд санагдав. Або ч гэсэн тутарган түрүүнүүдийн баяр догдлолыг бүх бие сэтгэлээрээ мэдрэх шиг болжээ.

“Бүрэн боловсорч гүйцэхээр бидний зарим нь шаргал хувцсаа тайлж, цасан цагаан өмсгөлөө сольж өмсөөд хүн төрөлхтний зоогийн ширээн дээр залрах болно. Харин бидний зарим нь хөрс шороондоо эргэн шингэж үрийн зориулалтаар үржин олшрох учиртай юм.”

“Байгаль эхийн цаглашгүй ач энэрлийг түгээхийн тулд бид бүр эрт өвөг дээдсийнхээ үеэс эхлэн энэ маягтай өсөж үржсээр, хамгийн эрхэм нандин амь амьдралынх нь хүнс болж байдгийг хүмүүс тэр болгон анзаардаггүй л дээ. Гэвч эх байгалийн хүч гэдэг харамгүй атлаа агуу их билээ.”

“Гагцхүү өрөөлийн төлөө өөрийгөө харамгүй зориулж чадсан цагт л байгалийн сэтгэшгүй атлаа цаглашгүй их хүчтэй уусан нэгдэж, нууцхан хувьсаж байдаг байх нь ээ !”

“Тийм ээ, гагцхүү тэгэх учиртай ! ” гэж тутрагын талбай тэр аяараа шивтнэлдэв.

Тутрагын түрүүнүүдийн биеэ харамгүй зориулах хүсэл

зориг нь Абогийн сэтгэлийг дахин хөдөлгөхөд тэрбээр ийн бодлоо: “Үнэхээр гайхалтай сонин тутраган чихнүүд байжээ. Тэдний өсөж ургах үйл явц бүр байтлаа ийм хүний сэтгэлийг догдлуулам билиг оюуныг агуулж байж шүү дээ ! Энэхүү харамгүй зориулах сэтгэлээрээ байгаль эхийнхээ ач энэрлийг хариулдаг байх нь ! Түүний хүчинд байгаль эхийн өөр нэгэн үр хүүхэд болсон хүмүүс бид нар ийнхүү аз жаргалтай амьдрах боломжтой болжээ ! ”

Тутрагын навчис бөхөлзөх талбайн голын нарийн замаар алхан, Шидөгийн дамжуулснаар зулзаган чихнүүдийн дотоод сэтгэлийн ертөнц рүү өнгийх боломжтой болсон Абогийн сэтгэл доторх бодол тутраган далайн баяр хөөртэй уусан нэгдлээ.

“Ногоон нахиа байхаас алтан шаргал түрүү болтол боловсрохдоо, тутрагын талбай тэр аяараа хүмүүсийн сэтгэлийг хөөр баярт умбуулах өнгө үзэмжээ гайхуулсаар билээ ! ” Усан сувгуудаар холбогдсон энэхүү хязгааргүй цэлийх тутрагын талбайг хараад Або нүүрэндээ инээмсэглэл тодруулан:

“Бүр зулзаган ногоон чихнүүд байхаасаа эхлэн тэд урин салхийг угтан мэндчилж, тэнгэр рүү цойлон ургадаг байсан сан. Харин одоо алтран шижиртэх мөхлөгүүд нь өрөөлийн төлөө өөрийг зориулах, ачлал санагалзахуйн ариун сайхан сэтгэлийг илтгэнэм. Аяа Бодисатва хөмсөг буулган,

тутрагын түрүү толгой дохино гэгч энэ буй за ! Тэнгэр газрын уудам орон зайд ургахдаа тэд цаг ямагт тансаг баян амьдралын өнгө жавхааг гайхуулах ажээ.” Гэхэд

“Би ч гэсэн бас тэгж бодож байна.” хэмээн Шидө хажуугаас нь үг нэмэрлээд, цааш өгүүлрүүн: “Номин ногоон зулзаган чих харахын төдийд хамаг биеийг уужруулдаг байсан бол одоо алтан шаргал тутраган түрүү эрхэмсэг атлаа өгүүлж баршгүй зөөлөн дулаан сэтгэлийг илтгэнэм бус уу !”

Хэдэн болжмор тутрагын талбай дээгүүр хөнгөн шингэн эргэлдэн нисэж байснаа дор бүртээ хэд гурван мөхлөг зууж аваад хотыг чиглэн одоцгоов. Цаасан шувуу тэдний хэн болохыг таних бөгөөд хотын баруун талын төмрийн дархны байшингийн саравчин дор гурван хөөрхөн ангаахай төрүүлээд байгаа юм.

Салхи тосон найгах тутрагын давалгаа хөөр баярын аялгууг дуурсгасаар л

“Болжмор шувуунд хэдэн мөхлөгөө харамгүй хайрлаж чадсандаа ийм баярлаж байдаг мөн өгөөмөр юм аа ! Тутрага идсэн шувуухай, өдөр болгон яруу эгшгээр донгодон, байгаль дэлхийн үзэмжинд амьдралын өнгө гэрэл нэмдэг гэж зулзаган чих маань өгүүлж байна.” хэмээн салхинаа туугдан нисэхдээ тутрагын баяр баясалд автсан бололтой Шидө дамжуулан хэлэв.

“Хүүе, Або сайн байна уу? Хар өглөөгүүр цаасан шувуугаа

салхилуулахаар наашаа ирээ юу?” хэмээн хэдэн эртэч тариачин түүнтэй мэндчилэв.

“Та бүхэн амар байцгаана уу? Танай тутрага дахин хэд хоноход хурааж болохоор болчихож дээ ! Өнөө жил ч гайгүй ургац авах байх аа даа ! ” хэмээн бүтэн улирлын турш тариачдын хөлс хүчээр услагдсан талбайг гүйлгэн харах зуур Абогийн сэтгэл ч тариачдынхаас өөрцгүй догдлох ажгуу.

“Тийм шүү ! Өнөө жил тэнгэр хангай ивээж, нар хур тэгшхэн байсан болохоор арвин ургац хураах боломжтой боллоо ! ” хэмээн бүрх малгайн дорх хүрэн бор царайдаа инээмсэглэл тодруулаад тэд хот хүрээний сонин сайхныг Абод дуулгав. “Өнөө жил тэнгэр хангайнхаа хишигт гялайснаа илэрхийлэх гэж манай хотынхон улс даяар шуугиулаад байгаа Фэнори чуулганыхныг урьж долоон хоногийн турш жүжиг тоглуулах болсон гэнэ лээ. Өнөө оройноос тэр жүжиг эхлэх учраас бүгдээрээ очиж болох юм шүү ! ”

Або ч тариачдын баяр бахдлыг хуваалцахдаа, нөгөө хоёр хайр булаам хөөрхөн тутраган чихийг мартсангүй, сэтгэл зүрхний угаас магтан өгүүлрүүн:

“Тариачид нүүр дүүрэн сэтгэл ханамжтай инээмсэглэл тодруулж, хотынхон тэдэнтэй хамт баян ургацын баярыг тэмдэглэж байгаа хэрэг байх нь ээ ! Зулзаган чихнүүд минь ! Та бүхний өөрийгөө бусдад зориулах сэтгэл хүмүүст ийм

их баяр баясгалан урам зориг бэлэглэдэг байх нь шүү дээ ! ”

гэснээ Або ойролцоо нисэн өнгөрөх шувуудыг хараад

“Өө нээрэн үгүй л дээ, зөвхөн хүмүүсээр зогсохгүй тэнгэр газрын хоорондох олон амьтад бүгд үр шимийг чинь хүртдэг юм.” хэмээн залруулав.

Тэр хязгааргүй цэлийх тутраган талбайг байн байн баясалтайгаар эргэн харж, өөрийн хайртай цаасан шувуугаа барьсаар хот руу буцжээ.

* * *

Хүсэн хүлээсэн орой ч удаж төдөлгүй болов.

Гэрэл гэгээ гялалзсан хотын орой хүмүүс хөгшин хөвөөгөө дагуулсаар тутрага цайруулах үтрэм дээр зассан тайзыг чиглэн явцгаав. Або ч гэсэн Шидөгөө дагуулан энд ирэхэд хүмүүс түүнтэй халуун дотно угтан мэндчилээд, хамгийн урд зассан хүндтэй суудалд залан суулгав.

“Арвин ургацын баяр ! ” хэмээлдэн тэнд цугларагсад бүгд нүүрэндээ баярын инээмсэглэл тодруулаад, баяр хөөртэйгөөр өнөө оройн арга хэмжээний гол баатар болох Фэнтори чуулгын тухай ярилцана.

Хүмүүс ийнхүү догдлон шуугиж байх хооронд тайзан дээр гурван том цан хэнгэрэг нижигнэсэн нь уудам талбайн зах хүртэл дуурсав.

Энэ үеэр өтгөн бужгар үстэй, улбар шар өнгийн хувцас өмссөн нэг хүн тайзны араас сэвэлзтэл алхлан олны өмнө

хүрч ирээд зогсоход ухаалаг байрын том алаг нүд нь очтон гэрэлтэж, хурсан олны анхаарлыг өөрийн эрхгүй татаж чаджээ. Тэр хүнгэнэсэн цээлхэн хоолойгоор:

“Та бүхний энэ оройн амгаланг айлтгая ! Би Фэнтори хамтлагийн ахлагч Фухуа байна. Бид өнөөдөр та бүхэнд өөрсдийн хамгийн шилдэг бүтээлийн нэг болох “Долоон шөнийн хүлээлтийг” үзүүлэх боломжтой болсондоо туйлын баяртай байна. Хүмүүс энэ жүжигт өгүүлж байгаа үйл явдал үнэхээр болсон юм уу гэж асуух нь олонтоо байдаг л даа.”

Фухуа хэсэг зуур үгээ цэнэн инээмсэглэн зогссоноо цааш өгүүлрүүн:

“Бидний амьдран буй их мянган ертөнцийн дунд нэгэн нандин нууц дамжсаар өдий хүрсэн билээ. Түүний хариулт нь цогт зүрхэн мөнхийн амь насны тоон дунд агуулагддаг гэлцдэг.”

Ямар нэгэн хувилгаан хүчийг эрхшээсэн мэт Фухуа тайзан дээр гарч ирсэн мөчөөс эхлэн олон үзэгчдийн нүдийг өөрийн зүг соронздон татаж чадсан байлаа. Харин түүний яриагаа эхлэхэд тэдний догдлосон сэтгэл хүнгэнэн нүргэлэх хоолойны хүчинд тайвшраад, чих тавин сонсоно.

“Фэнтори хамтлагийн тоглолт зөвхөн тайзан дээр тоглогдож байгаа төдийхөн бус, амьдралын гүн гүнзгий эрэлхийллийг хүүрнэн өгүүлж байх шиг байдаг юм.

Хэрвээ та бүхэн энэ жүжгийг сэтгэл зүрхээрээ шимтэн

үзэж чадах аваас, та бүхнийг сэтгэл зүрхний гүн дэх сүмбэр уулын оргилд аваачиж чадна гэдэгт би итгэлтэй байна !

Тунгалаг ариун тэнгэрийн хязгаарыг нэвтлэн, нар саран, од мичид дураар зорчих огторгуйн чанадад, оддын бүжиглэх гишгэгдлийн аясаар 17-23-ны хооронд огторгуй тэнгэрт даяар дуурьсах яруу эгшгийг сонсох боломжтой.

Улмаар өдөр шөнийн торгон уулзварыг зааглах тэнгэрийн гэрэл газраар элэглэн мөлхөхийг дагуулан цааш харваас, гэрлэн долгисын дунд нэгэн модон лянхуа завь 17.23 сэтгэлийн аян замыг хөндлөн гатлаад, долоон өдөр шөнийн үүлэн горхийн дунд өгсөж уруудан явахыг харах буй.

Ингэснээр 17.23-ын чанад нууцад нэвтрэх боломжтой. Одоо наран жаргаж, саран мандсан энэ цаг мөчид бид бүхэн “Долоон шөнийн үлгэр” жүжгээрээ дамжуулан эрт балрын цаг хугацаа орон зайг гаталган, амьдралын хамгийн нарийн нандин нууцын тайллыг задлаж, сэтгэлийн орны алтан талбайн дундах билиг оюуны нууц дардас болох 17.23-ыг дэлгэн үзүүлэхэд бэлэн болоод байна. Энэ болвоос та бидний амьдралтай салшгүй холбоотой үйл явдал юм шүү.” хэмээн үгээ дуусгалаа.

Тайзны гэрэл зугуухан бүдэгрэн хөшиг алгуур нээгдэв.

【ЭХНИЙ ШӨНӨ】

ГАЛД АВТСАН БАЙШИН БА ГУРВАН ТЭРЭГ

Амьдралын эхлэл чухам хаана байдаг вэ? Түүний эцэс төгсгөл биднийг хаашаа хөтлөнөм буй?

Хэдэн мянган жилийн тэртээ нэгэн эртний нууцлаг улсад нэгэн чихнээ яруу үлгэр ам дамжин яригддаг байжээ.

Хэсэг хүмүүс уг үлгэрт гардаг эрдэнэс нуусан газрыг олохын тулд тоо томшгүй олон хэвцэг бэрх уулсыг даван, хөхөө өвлийн хөр цас, аагим зуны амьсгаа давчдуулам бэрхшээлийг даван туулсаар, адал явдлын ангуучид мэт тоост орчлонг эгнэгт огоорон, өөрсдийн үл мэдэх ирээдүйг чиглэн явцгаасаар.

НЭГДҮГЭЭР ҮЗЭГДЭЛ

Δ ОРЧЛОНГИЙН ДИВААЖИН

(Тайзны гэрэл зугуухан тодроход, яруу аялгуу дуурсан сонсогдоно. Нэгэн үүлс хөшиглөсөн ертөнцийн чанад дахь диваажингийн орноо гурван тэнгэрийн хүмүүн тааваараа нисэн зугаацах ажээ.)

Тэнгэрийн хүн А: (Дуулна)

Хөхрөн алсрах тэнгэр газрын
Хөвөө хязгаар эс үзэгдэнэ
Ээлжлэн хөврөх бодол зүүдэнд ч
Эцэс төгсгөл мөн л үгүй
Орчлонгийн олон амьтад минь ээ
Огторгуйн чанадад ч огторгуй бий шүү !

Тэнгэрийн хүн Б: (Яриа)
Тэр газар
Тэнгэрийн цэцэгс зулгарахдаа яруу эгшиг үүсгэж
Өнгийн шүрний мөчир дээр гэгээн саран тогтоод
Өөрөө ариусан үүл мананг төрүүлнэм

Тэнгэрийн хүн Б: (Яриа)
Тийм ээ, тэрхүү үзэсгэлэн цогцлосон цогт ертөнцөд
Төрсөн хүн бүхэн гуцагдах зүйл гэж үгүй

(Тэнгэрийн хүмүүс ийнхүү хүмүүсийн сэтгэлийн орныг
үзэгчдэд хүүрнэн өгүүлээд тайзнаас холдон одоход гэрэл
ажмаар бүдэгрэнэ.)

ЛЦЭЦЭГСНИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН МОДОН БАЙШИН

(Нэгэн гайхам сонин цэцэгс бүхий хүрээлэнгийн гол дундах
модон байшинг гэгээн саран тодорхойёо гийгүүлжээ.

Байшингийн дотор эмийн өвс, эмийн сав, эмийн хорго зэргийг их л нууцлаг байдлаар өрсөн нь элдэв зүйлийн анхилам үнэрийг ханхлуулна. Хэсэг хүүхэд уг байшинд шуугилдсаар орж ирлээ.)

Бяцхан дүү: (Их л итгэлтэй байгаа бололтой) Хэн нь түрүүлж олохыг үзье л дээ ! Би хамгийн нууцлаг газарт хайх болно !

(Ингээд тэд дор бүрнээ их л хөөр хөгжилтэйгөөр өөрийн байгаа гэж бодсон газартаа эрэл сурал болцгоосон боловч ямар нэгэн онцгой содон эм тан, судар ном олсонгүй. Энэ үеэр хамгийн ухаантай гэгддэг хоёрдугаар ах нь ийн өгүүлэв. . .)

Хоёрдугаар ах: Аавын ухаан билигийг бидэнтэй яахин харьцуулж болох билээ. Тэр болвоос “Тэнгэрийн дорхийг тэнгэрийн дор нуух” эрдэм чадалтай хүн шүү дээ. Тийм болохоор цугаараа хэсэг хэсэг газарт нөгөө зүйлийг олтол хайцгаая ! (Тэгснээр хүүхдүүд ийш тийш тараад дахин сайтар хайж эхлэлээ.)

Бяцхан дүү: Би олчихлоо. (Бүгдээрээ түүнийг тойрон бүчиж авахад дүү нь их л цогтойгоор нүдээ анивчих ажээ.)

Би энэ болор хулууг олоход гадна тал нь тоосонд дарагдсан байхаар нь ханцуйгаараа шудраад тагийг нь бага зэрэг онгойлготол, ер бусын анхилуун үнэр ханхлаад, түүнд мансууран согтож, тэнгэрт дүүлэн нисмээр санагдах үед

нүдний өмнө тэнгэрийн дагинас илрэн гарч ирлээ.

(Бүгдээрээ түүний хэлэхийг сонсоод юу болохыг үзэхээр өрсөлдөх үед дүү нь гартаа усан болор хулуу барьсаны дотор ямар ч эм тан хийгээгүй байжээ.)

Бүгдээрээ: (Шуугилдан) Надад харуул л даа ! Би нэг үзээдэхье !

Том ах: Битгий шуугилдаад байцгаа ! Аюултай байж мэднэ шүү !

(Тэр ийн хэлж завдаагүй байтал булаалдах зуур, хулууны таг бүрэн нээгдээд, агшин зуурын төдийд этгээд үнэр хөшиглөн тархахад хүүхдүүдийн зарим газар өнхрөн унаж, зарим нь ухаан самуурч дэмий балайг донгосоод, өөр бусад нь модон хөшөө мэт гөлрөн зогсох болов. Гэрэл аажмаар бүдэгрэхэд хэдэн зурвас суунаг од чавхдан унах үзэгдэнэ.)

ХОЁРДУГААР ҮЗЭГДЭЛ

Δ ЭРДЭНИЙН МОДОТ УУЛЫН ГАЦАА

Эрдэнийн модот уулын гацаа болвоос хэдэн мянган жилийн түүхтэй суурин билээ.

Нэгэн ширүүн салхитай өглөө Са Юнь, Юэгуан Тунз болон хэсэг эрдэнийн эрэлчдийг дагуулсаар хаягдан эзгүйрч байгаа гацааны хашаанд орж ирлээ. Хүмүүс бүгдээрээ гайхширан

ийш тийш харцгаалаа.

Шавь А: (Арагшаа ухрангаа) Мэдээтэй байгаарай ! Хөл дор чинь хилэнцэт хорхой байна шүү !

Шавь Б: (Цочин дуу алдаад) Хүүеэ, би баахан аалзны торон дээр гишгэчихжээ.

Шавь В: Энэ суурин ч удахгүй зэрлэг өвсөнд дарагдаж гүйцэх юм байна.

Юэгуан Тунз: Энэ ямар нэртэй газар юм бэ? Хавь ойрд хүн амьдарч байгаагүй бололтой. Хаа сайгүй аалз хөлхөлдөж, хорт могой, хилэнцэт хорхой хөл дор хөлхөлдөх юм. Урьд нь их сайхан газар байсан бололтой. Хайран юм.

Са Юнь: Энэ газрыг эрдэнийн модод уулын суурин гэдэг байсан юм. Гацааны эзэн болвоос миний олон жилийн сайн анд л даа. Урьд нь энд үнэхээр амьдрал дэгжсэн сайхан суурин байсан сан.(Ийш тийш харсанаа) Харин яахаараа одоо хаа сайгүй эвдэрч нурсан хана хэрэм үзэгдэх болсон нь ямар учиртай юм бол доо?Хичнээн сайхан үзэмжтэй газар байлаа ч он цагийн элчилгүй талхидлаас мултрана гэж үгүй юм даа !

(Холоос нэгэн өндөр сүрлэг биетэй, өнгөлөг царай зүстэй настан хүрч ирсэнээ Са Юнь байхыг үзэж маш их баярласан шинжтэй болов.)

Эрдэнийн модот гацааны эзэн: Энэ чинь Са Юнь байх шив дээ ! Яахаараа энд хүрээд ирдэг билээ? (Са Юнь лүгээ

тэврэлдэн мөрөө харилцан алгадав.) Чи хэдэн шавийгаа дагуулан энэ тэрүүгээр аялан, амьдралын үнэн мөнийг эрэлхийлэнгээ, домогт гардаг эрдэнэс нуусан газрыг хайж байгаа гэл үү?

Са Юнь: (Их л баярласан байдалтай) Тийм ээ, би энэ газраар дайран өнгөрөхдөө танай гацааг эдэнд үзүүлье гэж бодсон юм. (Байшингийн дотор хэдэн хүүхэд шуугилдах чимээ сонсогдоно.) Танай гацаа яахаараа ийм болон хувирдаг билээ?

Эрдэнийн модот гацааны эзэн: (Уртаар санаа алдаад) Ай, хүүхдүүд маань тоглохоос өөрийг мэдэхгүй, арчилж тордох хүн байхгүй болохоор энэ үзэсгэлэнтэй уулын гацаа өнгө зүсээ алдаж гүйцлээ. Би ч гэсэн үүнд шаналж гүйцээд байна.Алив, та нар эхлээд жаахан амраадах, би та бүхэнд аажуу тайвуу ярьж өгье.

(Бүгдээрээ гацааны эзнийг дагалдан явж одов. Салхи улам бүр хүүгэн үлээгээд, олон жил засаж сэлбээгүй асрын сүүдрэвч чихран ганхана. Гурван хүүхэд гүйлдсээр гарч ирлээ.)

Нэгдэх хүүхэд:

Наадам тоглоомонд би хамгаас дуртай

Намайг он жилүүд ямар хүлээх биш

Өнөө өглөө сайн тоглоод авахгүй бол

Өөр ямар өдрийг хүлээх билээ

Хоёрдахь хүүхэд:

Ханатал тоглох туйлын жаргалтай

Хязгааргүй баяслыг бидэнд авчирдаг

Гуравдахь хүүхэд: Алив цөмөөрөө сайхан тоглоцгооё !

Гурван хүүхэд: (Тайзны зүг гараа дохиод) Хайя !

(Байшингаас улам олон хүүхэд гарч ирээд бүгдээрээ нэгэн зэрэг “Хайя ! ” хэмээн хашгиралдсаны дараа хүүхдүүд зүүн талын хашаанд гүйлдэн ороод, тоглож гарцгаалаа. Тайзны арын хөшгин дээр асар ордны дүрс тодроход, гацааны эзэн олон хүмүүсийг дагуулан гарч ирэв. Энэ үеэр гэнэт тасхийх сүртэй чимээ гарахад, хөшигний цаана галын дөл улалзаж, хүмүүс бужигналдан гүйлдэв.)

Зарц нар: (Их сандралдсан байдалтай) Гал гарлаа !

Алив хүмүүс ээ, гал унтраагаарай !

Хурдан наашаа ирээд гал унтраахад туслаарай !

(Том даавуу хөшгин дээр хүмүүсийн дүрс сүүтгэнэлдэнэ. Пижигнэсэн хөлийн чимээ холоос ойртон сонсогдоно. Нэгэн хөгшин даамал хажуу талаас яаран сандрал гарч ирлээ.)

Хөгшин даамал: Болохоо байлаа шүү ! Гацааны эзэн минь !

Гал алдчихжээ. Одоо галын дөл гацааны дөрвөн зүг найман зовхисоос дүрэлзэн шатаж байна ! Гацааны эзэн та хурдан зугатаж үз !

Эрдэнийн модот гацааны эзэн: (Хүнгэнэсэн хоолойгоор)

Хурдан цаадуулдаа гал унтраа гэж хэлэхгүй юу !

Даамал: Гацааны эзэн минь уг нь ч олон хүн унтраах гэж оролдож байна л даа. Гэвч галын хүч их, дээр нь манай гацааны байшин барилгууд хуучирч муудсан болохоор бараг найдлагагүй болох шиг боллоо.

Эрдэнийн модот гацааны эзэн: (Шийдэмгий байдалтай) Бүх хүмүүсийг гал унтраахад дайчла !

Са Юнь: (Цуг яваа хүмүүстээ хандан) Цөмөөрөө ч гэсэн гал унтраахад туслая !

(Эрдэнэ хайгчид болоод хөгшин даамал ухран явцгаана.)

ДДҮРЭЛЗЭХ ХҮЧИТ ГАЛ

(Хөшигний цаад талд “Нирхийх” чимээ гараад, нэг өндөр асар галын хүчийг дийлэлгүй нурж унав. Зүүн талын хашаанд хүүхдүүд юу ч болоогүй мэт тоглосоор байх ажээ. Юэгуан Тунз хэдэн зарц нарын хамт гүйлдэн хүрч ирнэ.)

Зарц А: Сарыг бараалах өргөө нураад уначихлаа. Галын дөл баруун хороонд хүрээд одоо юу юугүй наашлах нь

Юэгуан Тунз: (Санаа зовнингуй) Са Юнь багш аа, энэ галын хүч дэндүү их болохоор унтраах арга үнэхээр алга.

Зарц Б: Гацааны эзэн минь бидний зугатаж болох ганц зам одоохон хаагдаж мэдэх тул хурдан зугатсан нь өлзийтэй боллоо.

Эрдэнийн модот гацааны эзэн: (Ийш тийш харсанаа)

Хүүхдүүд минь, миний хүүхдүүд хаана байна вэ? (Их л бачимдангуй) Хүн байна уу? Хурдан хүүхдүүдийг минь авраарай !

(Салхины хүч улам ихсэн өтгөн утаа бургилан олгойдно. Хүмүүс хахаж цацан, гацааны гарах үүдийг чиглэн гүйлдэхэд, бөөн хөл үймээн босов. Хэдэн үнэнч зарц нар нь байдал бишидсэнийг мэдээд гацааны эзний хэрхэн болгоохыг ч анзаарах сөхөөгүй түүнийг татаж чангаах нь холгүй гадагш зүглэлээ. Араас нь гэрийн бусад гишүүд болон зарц нар дагалдав. Хүмүүс бие биесээс өрсөлдөн гацааны цорын ганц үүдийг тэмцэх ажээ.

Энэ үеэр хүүхдүүдийн хөгжилтэй инээд сонсогдсон хэвээр байх тул Юэгуан Тунз алхаагаа сааруулан зогсоод, чих тавин чагнаснаа чимээ гарсан зүг ажиглан харав. Галын дөлөн дунд зүүн хашааны доторх хүүхдүүд урьдын адил хөөцөлдөн тоглож, хөхрөлдөн инээж байхыг тэр үзээд, хашгирахаар завдлаа.)

Эрдэнийн модот гацааны эзэн: (Түүнээс өрсөн хашгираад) Хүүхдүүд минь ! Манай гацаанд гал алджээ. Та бүхэн тоглоомд улайраад байлгүй хурдан гараад ирцгээ !

(Юэгуан Тунз эргэн харваас, гацааны эзэн өтгөн утааг зүсэн гацааны хашаанд эргэн ороод, дүрэлзэх галын цаанаас хүүхдүүд рүүгээ хандан чанга дуугаар ийн хашгирах боловч, цаадуул нь огт тоосон шинжгүй тоглосоор байв.)

Юэгуан Тунз: (Ихэд цочоод) Гацааны эзэн минь ! ХҮҮХДҮҮД тоглоомондоо улайраад таны дуудахыг огтхон ч тоохгүй байна !

(“Пис пас” гээд салхи улам ширүүсэхэд галын дөл хүчтэй цоролзон, энд тэндгүй багана, дам нуруу нуран унах чимээ сонсогдох нь дотор зарсхиймээр. Гэвч гацааны эзэн бачимдсан байдалтай явахгүй зогссоор байлаа.)

Эрдэнийн модот гацааны эзэн: (Их л тэвчээр заасан байдалтай) ХҮҮХДҮҮД минь ! Наад багана чинь хариугүй нуран унаад та нарыг дарах гэж байгааг харахгүй байна уу? Галын дөл та нарыг түлж, хар утаанд хахаж цацах чинь дутаа юу ! Та нар одоохон надтай цуг гацааны цорын ганц хаалгыг зүглэн зугатацгаа ! Гадаа ах эгч нар чинь та бүгдийг юу болсон бол гээд сэтгэл зовнин хүлээж байгаа !

(Энэ үеэр хоёр хамгийн балчир хоёр хүүхэд тагтан дээр гүйн гарч ирэв.)

ХҮҮХЭД А: (Эрхлэнгүй байдалтай) Аав аа ! Жаахан хүлээчих тэгэх үү? Би жаахан тоглоод авмаар байна.

ХҮҮХЭД Б: Тийм шүү ! (Их л догдлосон байдалтай галын дөлийг заагаад) Энэ улаан гал хавийн юмыг хуйхлан шатаах нь ямар зугаатай байна вэ?

(Энэ үеэр дотор өрөөнөөс шуугилдах дуу гарахад хоёр жаал юу болохыг үзэх гээд буцан гүйж оров. Тэд лав зугаатай тоглоомноос хоцрох вий гэж бодсон байж таарна.)

Юэгуан Тунз: Тэд нар галын хор хөнөөлийг огтхон ч төсөөлөхгүй байх шиг байна. Одоо байдал давчуу болсон тул шалавхан эндээс холдохгүй бол амжихаа байлаа. Хоёулаа тэднийг татаж чангаагаад ч болтугай авч гаръя.

Эрдэнийн модот гацааны эзэн: (Толгой сэгсрээд) Болохгүй ээ ! Тэгвэл тун аюултай хэрэг болно ! Чи бид хоёр хэдийгээр хүчтэй, тэдний энгэр заамаас татаад гаргаж болох боловч, хүүхдүүд нарийн учрыг ойлгохгүй болохоор тоглоомондоо хорхойсоод, тийчигнэн зугатах юм бол тэрнээс эс юм болно гэсэн үг. Тэгвэл аврахад бүр хэцүү болно.

Юэгуан Тунз: Тэгвэл одоо яадаг билээ? Төөрөлдөж гүйцсэн хүүхдүүдэд байдлыг ойлгуулахгүй бол тэд харсаар байтал түлэгдэж гүйцэх нь байна шүү дээ !

(Тэр хоёр яаж ч хашгирч дуудлаа гэсэн тоглоомондоо улайрсан хүүхдүүд огт тоохгүй байх ажээ. Харин ч дүрэлзэх улаан гал тэдний хувьд маш зугаатай байгаа бололтой. Ар араасаа гүйлдэн галын дэргэд очоод хэрхэн шатаж байгааг нь сонирхож байв. Тэр ч байтугай зарим нь гартаа тааралдсан юмыг гал руу шидээд, өрвөлзөн шатахад бүгдээрээ баясан дуу алдана.)

Эрдэнийн модот гацааны эзэн: (Арга тасрангуй) Ай ! Энэ гэнэн томоогүй хүүхдүүд тоглоомондоо бүр донтож гүйцжээ. Тийм болохоор галын аюул гамшгийг мэдрэхгүй байна. Энэрэл нигүүлслийн хүч тэднийг төөрөгдлөөс

гэтэлгэх хөг өнгөрөв бололтой.

(Хүүхдүүд тоглоомондоо автаад нүүр нь улайсан атлаа эргэн тойрондоо хүрээлэх аюулыг огт мэдрэхгүй байгааг гацааны эзэн үзэж гэнэт санаа бодлоо өөрчлөөд . . .)

Эрдэнийн модот гацааны эзэн: (Өндөр дуугаар хашгирч) Хүүхдүүд ээ ! Хурдан наашаа ирээд эцэг чинь та бүхэнд ямар зугаатай сайхан тоглоом бэлтгэснийг хараарай !

(Зугаатай сайхан тоглоом гэх үгийг сонсоод хүүхдүүд бултаараа түүнийг тойрон хүрч ирэв. Түүнд Юэгуан Тунз их л гайхширч орхив.)

Гацааны хашааны гадна одоо долоон өнгийн чимэг бүхий эрдэнэсийн зүйлс дүүрэн ачсан ямаан тэрэг, буган тэрэг, үхэр тэрэг сойлттой байна. Та нар түүнээс дуртайгаа хөлөглөн тоглож болно.(Тэр гараараа гадагш заав.)

Тэр тэргийг хөлөглөн та бүхэн хүссэн бүгдийг гүйцэлдүүлж болно.

Тэр тэргийг хөлөглөөд та бүхэн зорьсон газраа зовлонгүй хүрэх боломжтой.

Тэр тэргийг хөлөглөөд та бүхэн хүний орчлонд дураар аялан зугаацаж болно.

Та нар хурдан түүнээс сонгон аваарай ! Хүртэлгүй өнгөрсөн нэг нь хожим харамсах болно шүү !

(Хүүхдүүд тийм гайхамшигтай олон тэрэг бий гэхийг сонсоод, хашгирч шуугилдан гацааны цорын ганц аврах

хаалганы зүг гүйлдэцгээлээ. . . . Энэ үеэр Юэгуан Тунз
гацааны эзнийг гайхширсан байдалтай харан зогссоор байв.)

Эрдэнийн модот гацааны эзэн: (Хүүхдүүд бүгдээрээ
гарчихсан болохоор хоёулаа ч гэсэн гарцгаая даа !)

(Тэр хоёрыг гарч одоход тайзны гэрэл унтрана.)

(Атар хээр тал, урсгал ус, өнгийн цэцэгс халиурна)

(Яруу хөгжим эгшиглэхэд уудам талд горхи булаг ундрал,
галбинга шувуу уран хоолойгоор жиргээд, зуун цэцэгс
дэлгэрэх нь хорвоо дэлхийн үзэсгэлэнг илтгэнэ. Алсад
галын дөл дүрэлзэн харагдана.Хүүхдүүд энэ тэрүүгээр
хэсэг зуур хайлдан гүйснээ гацааны эзний гар хөлөөс
зулгаацгаалаа.)

Хүүхдүүд: Хайрт эцэг минь, долоон эрдэнийн чимэгт ямаан
тэрэг чинь хаана байгаа юм бэ?

Би буган тэргийг чинь авмаар байна.

Би үхэр тэрэг авна аа.

Би ч гэсэн үхэр тэрэг авна шүү. . . . (Хүүхдүүд ийнхүү
түүний тал бүрээс шалгааж гарав.)

Са Юнь: (Дуулна)

Алтан лянхуан мандлыг сэтгэлээ тогтоон ажваас

Арван билгүүн хутагтын үрийг бүрдүүлж буй

Нарийн нандин нууцыг нь мэдье хэмээвээс

Нэгэн навч түүнчлэн ирэгчийн чанартайг таньсугай

Эрдэнийн модот гацааны эзэн: (Хайрласан өнгөөр) Миний

эд эрдэнэс улсын сан хөмрөгтэй дүйцэхүйц тул, түүнийг улсын нийт ард иргэдэд тараан өгөвч цаана нь илүү гарах буй за. Эдгээр хүүхдүүдийг би ихэд хайрлах тул тэгш сэтгэлийн үүднээс хандаж, хамгийн сайн том үхэр тэргийг тэдэнд хүртээн олгоё. (Зарц нартаа хандан) Эрдэнэсийн санг онгойлгоод, миний хүүхдүүдэд долоон зүйл эрдэнийн чимэгт үхэр тэрэг нэжгээдийг өгсүгэй !

Хүүхдүүд минь ! Очиж үхэр тэрэгнүүдээ авцгаа ! Түүнийг олсон цагаас хойш та бүхэн жинхэнэ эрх чөлөө, аз жаргал гэж юу байдгийг мэдрэх болно.

(Хүүхдүүд догдлон хөөрөлдөөд зарцыг дагалдан явахад, алсад галын дөл аажимхан замхарна.) Юэгуан Тунз энэ бүхнийг бодлогоширон харж зогстол гэнэт түүний чихэнд Са Юньгийн цангинасан инээд сонсогдоод. . .)

Са Юнь: Юэгуан Тунз аа, Эрдэнийн модон гацааны эзэн болвоос билиг оюун цогцлосон ухаант настан билээ. Хүн болгон хүсэл бодол, нисваанис бүхий галтай сууцанд амьдарч байдгийг тэр гүнзгий сайн мэддэг юм. Мөртлөө тэр галтай сууц нь өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн орон зайд тасралтгүй шатаж байдаг гэнэм.

Эрдэнийн модон гацааны эзэн өөрийн цаглашгүй билиг оюуныг ашиглахдаа гаргуун хүн юм. Хүн өөрөө ердийн санаа бодлоо өөрчлөн билиг оюун болгон хувьсгаж чадах аваас, агшин зуурын төдийд нисваанист эзлэгдсэн махан бодь

нь алтан гэрэлт гэгээн бие болон хувилдаг болохыг тэр сайн мэддэг.

Эрдэнийн модон гацааны эзэн хэдийгээр айх, цочиж, гэлмэхийг мэдэхгүй их хүчинг эрхшээсэн боловч, гагц түүгээр хүүхдүүдээ аварч болдоггүйг бас мэдэх юм. Харин билиг билгүүнээр уран арга хэрэглэн, гэнэн томоогүй хүүхдүүдээ гал дүрэлзсэн сууцнаас нь гаргаж болох тул түр зуурын уран зүйрлэлээр тэднийг галтай сууцнаас нь эхлэж гаргаад, өөрсдийн гэгээн ариун өөрийн мөн чанараа олоход туслажээ.

(Юэгуан Тунз сая л бүх учрыг ойлгоод, тэсгэлгүй бахдан дуу алдав.)

Юэгуан Тунз: Дүрэлзсэн гал зугуухан унтарч, тэнгэрийн бараан үүлс замхарч эхлэхийг харав уу ! Баярлаж догдлосон хүүхдүүд өндөр сүрлэг агаад эрдэнийн чимэгт том цагаан үхэр тэргээ хөлөглөн, өргөн талын энгээр санаан зоргоор давхилдаж байна. Хүүхэд болгоны сэтгэл цаглашгүй их хөөр баяраар дүүрчээ.Ай ! Эрдэнийн модон гацааны эзэн чи үнэхээр билиг оюун төгс настан ажгуу !

Эрдэнийн модот гацааны эзэн: Хэрвээ хүн болгон цаглашгүй их нисваанист автсан галтай сууцнаас гаръя хэмээн хүсэх аваас, тэр даруй алтан гэрэл цацраасан гэгээн ариун номын биеийг цогцлоож, над лугаа адил болно гэсэн үг.

Са Юнь: (Дуулна)

Тэднийх гэр орны ажил ихтэй
 Тэр болгоныг хэн үүрдэг гэж санана
 Мэлмийн өмнөх тоосыг хараад
 Мэдэж байна уу, Фэнтори гэж хэн болохыг
 Алхсан мөрөө нуугаад
 Авах юмгүй шавхайтай хутгалджээ.
 Гэр орон нь гал алдахад
 Гэнэн хүүхдүүд дотор нь байлаа
 Гарах янзгүй тоглосоор байх тул
 Гацааны эзэн уран арга хэрэглэжээ.
 Эрдэнэсийн эрэлчид: (Найрал дуу)
 Гэгээн цагаан саран авхай
 Гэрэлт билгүүний үүдэнд мандлаа
 Цагаан үхэр хөллөсөн тэрэг
 Цаглашгүй олон хүмүүсийг тээлээ.

Бодь сэтгэлийн үрийн шалтгаанд
 Барамнас тоос огт нялзахгүй
 Долоон эрдэнийн үхэр тэрэг
 Дундаршгүй эрдэнэсийн хоёр хүрдтэй

Алтан лянхуан мандлыг сэтгэлээ тогтоон ажваас
 Арван билгүүн хутагтын үрийг бүрдүүлж буй
 Нарийн нандин нууцыг нь мэдь хэмээвээс
 Нэгэн навч түүнчлэн ирэгчийн чанартайг таньсугай

17 23

АРВАН НАЙМНЫ ӨДӨР

ЦЭЦГИЙН ХҮЙС

*Ханьцашигүй уудам тэнгэрийн сүүн голын дунд манай гариг
өчүүхэн жаахан цэцгийн тоосоос өөрцгүй гэлцнэм.*

*Жаргалтай дэлгэр ертөнцийг гагцхүү хир тоос халдаагүй
гэгээн ариун цэцэгсийн дуазанд сая байгуулж болдог ажгуу.*

*Энэхүү алтан өнгөт биетийн дээр, аливаа бичил жаахан
хумхууд хүртэл бүгд цэвэр ариунаа хадгалан орших бөгөөд
гагцхүү салхины аясаар гадагшилсан цагт хир тоос
халдаад, алтан элс үүний улмаас шавар болон хувирдаг
гэнэм.*

ЦЭЦГИЙН ХҮЙСИЙН НУУЦ САНАА

Тэнгэр гэгээрмэгц өмнийн цэнгэг салхин сархинаган цонхны завсар заальхайгаар цэцэгсийн анхилуун үнэрийг нэвчүүлэхэд, Або балчир хүүхэд адил орон дээрээ хөрвөөн босож сууснаа, баяр хөөртэйгөөр цонхны хөшгийг ярж, бүх цонхнуудаа нээмэгц өглөөний тунгалаг агаар шувуудын жиргээтэй хамт өрөө дүүрэх нь сэтгэл сэргэм агаад өглөөний концерт гэлтэй.

Хөнгөн угаал үйлдэж амаа зайлчихаад, Шидөгөө аван өглөөний салхийг зүссээр том том алхлан гадагшлав. Уулсын оройг эмжсэн үүлэн цацагс улаавтар, тод шаргал өнгөөр туяарах нь түүний цаана халхлагдсан нар түмэн цацрагаа дэлгэхэд бэлэн болсныг илтгэнэ.

“Уухайс ! Чи бид хоёр нарнаас эрт босоцгоосон байна шүү дээ !”

Өглөө эртлэн өөрийн үй олон байгалийн найз нөхөдтэйгөө уулзсандаа Шидө их л баяр хөөртэй, омог төгөлдөр байгаа бололтой салхины аясаар дэгж дэрвэн тэдэнтэй мэндчилнэ. Урьдын адил Шидө цэлмэг тэнгэрт чөлөөтэй элин халин нисэх зуураа байгаль дэлхийн өнгө үзэмжийг бахдан байтал өнөөдөр нэг л өөр өдөр шиг санагдаад явчихав.

Урьд нь Або хотын гудамжаар тайван алхласаар тариан

талбайн захад ирээд, энэ тэрийг сониучирхан, байгаль дэлхийн үзэмжийг таашаадаг байсан бол харин өнөөдөр тэгсэнгүй, хотоос яаравчлан гараад тариан талбайг туучин өнгөрч, өмнө зүг харсан уулын энгэрийг зүглэжээ.

Удаж төдөлгүй тэд тариан талбайн захыг өнгөрөөд өтгөн шигүү ой шугуйд ороод явчихав. Або Шидөгийн утаснаас татан бүсэндээ зүүх үед цаасан шувуу тэсгэлгүй ямар учиртайг асуулаа.

“Або бид нар өнөөдөр хаашаа явж байгаа юм бэ? Өнөөдөр чи нэг л өөр байх чинь, цаанаа л нэг нууцлаг агаад догдлосон төрхтэй байна !”

“Тийм ээ ! Өнөөдөр яахын аргагүй өөр өдөр болж байна.” хэмээн уулын мурий тахир чийгтэй замаар сурамгай нь аргагүй хөнгөн шингэн алхангаа тэр хариуллаа.

“Аанхаан !” гэчихээд Шидө замын турш хадны завсар, модны хонгил бараадан ургасан өхөөрдөм хөөрхөн бяцхан цэцэгсийг бахдан ажиглаж явлаа. Тэгсэн атлаа сониуч зангаа тавьсангүй “Тэгээд юугаараа өөр юм бэ дээ?” хэмээн асуужээ.

“Чи ажиглаагүй юм уу? Өнөө өглөө өмнийн салхинд өнгийн зуун цэцэгсийн үнэр дайгдан ирсэн байдаг шүү !”

Нэгэн өндөр довцгийн оройд гараад Або алхаагаа татан зогсоод “Хүү !” хэмээн уртаар амьсгаа авчээ. Хэдийдийг бүү мэд наран авхай үүлсийн сэжүүрийг сэмлэн

цухуйгаад, эх газар, ой шугуйг нэлд нь гийгүүлсэн байлаа. Абогийн духан дээр бурзайсан хөлс, өглөө нарны туяанд үзэсгэлэнтэйсэ гялталзана. Түүний царайд тодрох хүүхдэрхүү хөөр баяслыг хараад Шидөгийн сэтгэл ч гэсэн догдлолд автаад ирэв.

Хэсэг уулын салхи шугуйг илбэн өнгөрөв.

“Шидө чи энэ салхины үнэрийг нэг үнэртээтхээч ! ” гэснээ Або өөрөө цээж тэнүүн амьсгаа авчихаад цааш том том алхлан урагшлав.

Абогийн ингэж хэлэхийг сонсоод Шидө өөрийнх нь хамаг биеийг зөөлөн илбэх уулын салхийг амтархан шинжив. Үнэхээр ч салхин дунд ажигч хүн л биш бол тэр болгон анзаарагдамгүй тоо томшгүй олон бичил тоосонцор агуулагдсан нь амьсгал уужруулж, хамаг биеийн алжаал тайлах эрдэмтэй ажгуу.

“Энэхүү салхинаа агуулагдсан бичил тоосонцорууд баяр баяслыг бэлэглэсэн учраас л Або ийм их баяр хөөртэй байгаа юм байж л дээ ! ”

“Ай ! Хүрээд ирлээ шүү ! ”

Шидө салхины амтыг таашаан явах зуур Або уулын давааг даваад нөгөө талд нь хүрсэн байжээ.

Тэс өөр ертөнцөд хүрээд ирсэн юм шиг санагдана. Учир нь уулыг даваад өтгөн ногоон ойн хөл татарч, өргөн уудам тал залган авчээ. Халиуран сугсайсан өтгөн өвсийг өнгийн зуун

цэцэгс хараа булаам чимэглэсэн нь цэнхэр тэнгэрийн дор ер бусын үзэсгэлэнтэй сайхан харагдав.

“Аяа ! Бид нар арай Бурхадын цэцгийн хүрээлэнд хүрээд ирсэн хэрэг биш биз дээ?” хэмээн Шидө тэсгэлгүй бахдлын дуу унагалаа.

Харин Або энэ бүхнийг шимтэн ажиглах зуур амандаа ийн бувтнав.

“Ойрдоо улирлын хувьсал өөрчлөлт тогтворгүй, нэг болохоор хавар шиг, нэг болохоор намар шиг байдаг болсон. Тэр ч байтугай хотын доторх галт шувуу мод гурван сар оройтож цэцэглэсэн биш үү? Гэтэл одоо зуун цэцэгс зулаастай юм шиг дэлгэрчихээд байх юм даа. Тэнгэр газрын хооронд ямар нэгэн далдын өөрчлөлт нууц санаа явагдаад байгаа юм болов уу?”

“Хүүе, нээрэн тийм юм байна шүү. Одоо чинь хавар цаг биш байтал яахаараа өнгийн цэцэгс дэлгэрсэн байдаг билээ?” хэмээн Абогийн хэлэхийг дуулаад Шидө ч гэсэн гайхширав.

Або Шидөгөө уулын салхины аясаар хэсэг зуур зугаацуулан нисгэсний дараа, нэгэн том хавтгай хадан дээр суугаад, тэнгэрийн байдлыг ажиглан, салхи хөлөглөн тархах цэцэгсийн үнэрийг таашаав.

Өндөр уул өргөн талын дээгүүр цэлмэг хөх тэнгэр хязгааргүй мэлийгээд, эрдэнэт наран хурцаар төөнөнө. Хүний хөлийн мөр ховорхон гарсан тэнгэр газрын энэхэн

чөлөөнд санаан зоргоор дэлгэрсэн өнгийн алаг цэцэгс зөвхөн, эндхийн салхи, үүл, шувууд, зөгий, эрвээхэй зэрэгт л зориулагдсан улирлын охь дээж мэт.

“Або, чи хээрийн хэлгий сараана, хурц улаан , нэг навчит цахирмаа, хэлтгий цэцэг.зэргийн үнэрийг мэдэрч байна уу?” гэснээ Шидө эргэн тойрныг гүйлгэн харав.

Том бул чулуун дээр удтал бодлогоширон суусан Абогийн нүүрэнд инээмсэглэл тодроод:

“Урьд нь энүүгээр өнгөрөхдөө зөндөө олон цэцэгс өөр өөрийн байрыг олоод, зохиролтой сайхан ургажээ гэж боддог байсан юм. Их байгалийн далд хүчнээс өөр хэнбугай ч ийм сайхан үзэмжийг буй болгож чадахгүй л дээ. Харин би анх удаа энэ газрыг олж ирчихээд чамаас өөрцгүй Бурхадын цэцэгсийн хүрээлэнд ороод ирлээ гэж бодсон. Хэ хэ хэ!”

Ярианы явцад Або урьдын дурьтгалдаа халтиран ороод балчир хүүхэд мэт хөхин баясаж инээх дуу нь салхины аясаар тэртээ хол сонсогдов. Агаар тэнгэрийн дээрээс цэцэгсийн далай дунд суугаа Абог харахад, түүний инээмсэглэл өнгийн цэцэгсээс өөрцгүй сэтгэл татам харагдана.

“Олон жилийн турш салхины аясаар эдгээр цэцэгсийн үнэр анхилахад энд ирдэг уламжлалтай болсон юм. Мөртлөө жил болгон энэ газар өөр өөр өнгийн цэцэгсээр хувцсаа сольдог. Өмнийн салхи үлээх тоолонд зуун цэцэгс хөлгүй

их найранд оролцохоор болзсон юм шиг бараг нэгэн зэрэг шахам дэлгэрдэг юм даа. Өнөө жилийн хавар би нэг хоёр удаа горьдлого тээсээр наашаа ирсэн боловч эндхийн цэцэгс огт дэлгэрээгүй байсан. Тийм болохоор би эдгээр цэцэгсийн хаашаа алга болчихов оо гэж хэрхэндээ л бухимдаж билээ. Гэтэл өнөө жилийн цэцэгс ийнхүү оройтон дэлгэрэх байсныг хэн мэдлээ.”

Або урьдын адил чулуу сандайлан амандаа бувтнахыг чимээгүй сонсох зуур Шидө ч цэцэгсийн чуулганы нууц ордныг бүр сайн ажиглах гэж улам бүр доошлов.

“Оройтож дэлгэрсэн өнгийн цэцэгс чухам юу хүлээнэм бэ?” гэж Шидө тэднийг ажиглах зуур хэллээ.

Гэгээн наранд төөнүүлж, цэгээн салхинд илбүүлэх мянган цэцэгсийн дэлбээнээ болрын өнгө гэрэлтэх шиг санагдав. Түүнийг сайтар ажиглан харваас баахан дүрсгүй бяцхан анахай нааш цааш бүжиж ч байх шиг. Шидө ихэд гайхширан алмайраад, улам нарийвчлан ажиглаваас цэцгийн дэлбээ бүрийн дунд алтан шаргал цэцгийн хүйс цухуйн гарсан нь тэр ажээ. Гэнэт тэр яруу тунгалаг эгшиг дуу цэцэгсийн дээгүүр дуурьсан дуугарахыг олж сонсов.

“Энэ чинь зэрлэг хэлгий сараана цэцэг салхины аясаар дуулж байгаа юм байна ! ”

Өнгө булаалдан багширсан цэцэгсийн чуулган дунд, довцгийн энгэр бараадан ургах зэрлэг хэлгий сараана цэцэг бүлээн

салхины илбээнд цоморлигоо дөнгөж нээгээд, үзэсгэлэнтэй найгалзах ажээ.

Ялдам сайхан хоолойгоор яруу тунгалаг эгшгийг үүсгэхэд хол ойр нь ижилгүй өмнийн салхи, шувууд, хорхой шавьж бүгд түрлэг нэмснээр, удаж төдөлгүй өргөн тал өндөрлөг газар тэр аяараа найр хуурын аялгуунд автахад Шидө ч өөрийн мэдэлгүй тэднийг дагалдан дуулж гарлаа.

Өөрийнх нь цаасан шувуу Шидө өргөн талын дээгүүр дуулан нисэхийг Або сонсчээ. Сайтар сонсох аваас үнэхээр яруу сайхан дуулж байвай. Або дууны аялгуунд мансуураад буй биеэрээ талын энд уусан нэгдсэн мэт, эндхийн ганц цэцэг, өвсөн ширхэг, хорхой шавьж нэг бүр нь хөрс шороондоо тааваараа амьдарч, тааламжтай амьсгалж байдгийг мэдрэх шиг санагджээ.

“Уухайс ! Үнэхээр яруу дууны цогтой аялгуу гэж энэ байх даа !”

“Хэлгий сараана цэцэг эгч ээ, та үнэхээр сайхан дуулах юм аа !”

“Тийм шүү ! Би бүр дууны аялгуунд автаж орхилоо байна.”

Талын найрал дууны аялгуу татраад, тэртээ хол дуурсан сонсогдохоо байх үеэр халуун сэтгэлээр бахдан магтах чимээ сонсогдсон нь талын өвс ногоонууд ийнхүү өгүүлэлдсэн ажээ.

“Үнэхээр сайхан дуу юм гээч ! Хэлгий сараана бүсгүй минь

! Энэ дууг чи хаана хэнээр заалгасан юм бэ?” гэж Шидө түүнээс тэсгэлгүй асуулаа.

“Хаврын салхи ! Би шавартай хөрсөнд ичээд бүтэн өвлийн турш унтсан байлаа.Хаврын бороо хэдэнтээ орсоны дараах нэгэн өглөө, өд мэт энхрий зөөлөн салхи намайг илбэн сэрээхэд, хөрс шорооны чийглэг агаад тааламжтай үнэр хамар сэнгэнэв. Түүнээс улбаалан би хавар цагийн хөнгөн зөөлөн алхаа энэ дэлхий дээр эргэн ирсэн болохыг би мэдсэн юм.

Тэгээд би догдлосондоо газрын хөрснөөс цухуйн гарах үедээ нэгэн яруу тунгалаг эгшиг дуу урин салхины аясаар алсад дуурьсахыг сонсож билээТэр болвоос хаврын салхины яруу дуу хоолой хангай дэлхийг сэрээж байсан хэрэг ажээ. Түүнээс илүү сонсоход сонор мялаасан эгшиг дуу гэж хаана байх вэ? Сонсох тусам хамаг биеэр амьдралын эрч хүч дүүрээд ирсэн юм даг.

Тэр аялгуу дууны эгшиг дор хөөр баяртай, чөлөөтэй өсөж торних явцдаа өөрийн мэдэлгүй чихэнд хоногшихсон байсан. Харин үзэсгэлэнт цоморлигоо нээсний дараа өөрөө ч тэр дууг аялгуулан дуулж чадах болсноо ойлгосон юм даа.”

Зэрлэг хэлгий сараана цэцгийн ийнхүү ялдам хоолойгоор хүүрнэн өгүүлэхийг сонсох зуур Шидөгийн ухаан санаа алсран одоод, хөрс шорооны тааламжтай сайхан үнэр, урин салхины амтыг мэдрэн, өөрийн биеэр хавар цагийн дуутай

хууртай найранд очих шиг санагдав.

Талын энгээр өнгө алаглан багшрах цэцэгс алс холоос зорин ирсэн хоёр дотны андынхаа ийнхүү баахан магтаалаар шагнасны хариу болгож, хэсэг зуур хэлэлцсэний эцэст нэгэн гайхамшигтай сайхан үлгэр ярьж өгөхөөр шийджээ.

“Энэ ч гэсэн алс холын ариун орноос хаврын салхи тээж ирсэн мэдээ юм шүү.” хэмээн хийморь сүлд нь сэргэсэн хурц улаан цэцэг, ярьж эхлэснээ хоолойгоо засаад цааш өгүүлрүүн: “Мөн чанарын ирэхүй нь ариун одохуй ч мөн ариун ! ” гэхэд

“Мөн чанарын ирэхүй нь ариун одохуй ч мөн ариун ! ” хэмээн талын олон өнгийн цэцэгс нэгэн зэрэг түрлэг нэмэн өгүүлэв.

“Хаврын салхи зүйргүй цээлхэн хоолойгоор эгшиглэн дуулах нь өгүүлж барамгүй сонсголонтой.Өнөө хэр бид нар тэр яруу сайхан эгшиг дууг үггүйлэн санагалзсаар байна. Тэр нь магадгүй саяын хэлсэн өгүүлбэрийн цаана агуулагдаж байгаа гүн гүнзгий санаа үнэхээр уран яруутай холбоо бүхий байж ч мэднэ !” хэмээн хаврын салхи өнөө хэр чихэн дээр нь хангинасаар байгаа тод шаргал өнгийн уулын удвал цэцэг тэдний ярианд оролцлоо.

“Мөн чанарын ирэхүй нь ариун одохуй ч мөн ариун ! ” хэмээн Шидэ цэцэгсийн үгийг дамжуулан өгүүлж байх зуур Або амандаа бодлогоширон бувтнасаар байлаа.

“Наадхи чинь ямар учиртай үг юм бэ?” гэж Шидө асуулаа.

“Энэ өгүүлбэрийн гол санаа болвоос бидний мөн чанар ариун дагшин газраас ирсэн шигээ мөн л тэр ариун дагшин газар руугаа буцдаг гэсэн утгатай юм байна. Хаврын салхин хамгийн түрүүнд энэ үгийг бидэнд дуулгасан юм.” хэмээн хурц улаан цэцэг намуухнаар хариулжээ.

“Залгуулаад хаврын салхи бидэнд ухаан санаанд ч багтамгүй сайхан зүйлийг хүүрнэн өгүүлсэн юм. Би нар тэр тухай дуулчихаад хэд хоногийн турш шогшрон бахдаж байсан шүү ! ” гэж хэлгий сараана цэцэг хаврын салхинаас өөрцгүй яруу тунгалаг хоолойгоор хэлээд цааш нь:

“Бидний оршин амьдарч байгаа дэлхий ертөнц цаглашгүй уудам орчлонгийн далай дунд зүйрлэн хэлвээс өчүүхэн жаахан хумх төдий юм.”

“Жижигтээ бүр ширхэг элснээс ч хавьгүй жижиг гэж болно.” гэж хэлгий сарааны хажууд зогсох удвал цэцэг ярианд оролцлоо.

“Тийм ээ, жаахан гэхэд дэндүү жаахан ийм мянган дэлхий ертөнц нийлээд нэг бага мянган ертөнцийг бүрдүүлдэг гэнэм. Нэг мянган бага мянган ертөнц нийлэхээрээ нэг дунд мянган ертөнцийг бүрдүүлдэг. Харин мянган дунд мянган ертөнц нэгдэж нийлээд нэг их мянган ертөнцийг үүсгэдэг ажгуу. Харин гурван мянган их мянган ертөнц нэгэн анхилуун уст далайд багтдаг гэнэ.”

Хэлгий сараана цэцгийн дуу хоолой хэдий яруу зөөлөн боловч Шидө эцэстээ тэсгэлгүй дуу алдаад “Пөөх, би наад тоон дунд чинь хариугүй живж гүйцэх нь ээ ! ” хэмээн хашгирав.

“Хэлээд яах билээ? Би ч гэсэн анх удаа энэ тухай сонсоод бүр чамаас өөрцгүй болж байсан шүү. Гэвч цаашид өгүүлэх зүйл бол үнэхээр гайхамшигтай сонин л доо ! ” гэж уулын удвал үг нэмэрлэлээ.

“Уулын удвал чи томоотой байхгүй дандаа дүрсгүйтэж байх юм. Хэлгий сараана цэцэг эгч үлгэрээ ярьж дуустал дуугүй байгаач ! ” хэмээн хүрэн өнгийн башга цэцэг түүнийг зэмлэлээ. Гэвч уулын удвал башга цэцгийн хэлдэгчлэн тийм амархан засарчихааргүй дэггүй амьтан тул урьдын адил хээрийн салхинд томоогүйтэн найгалзах өхөөрдөм төрхийг хараад Шидө тэсгэлгүй тас тас хөхрөв. Зэрлэг сараана ялдам инээмсэглэл тодруулаад цааш залгуулан өгүүлрүүн:

“Анхилуун уст далай гэдэг бол хамаг анхилуун сайхан үнэр болгон цогцлож бүтсэн ариун далай юм гэж хаврын салхи бидэнд ярьж байсан л даа. Хаврын салхи цааш нь зөндөө олон анхилуун уст далай нийлээд, нэг ертөнцийн далайг үүсгэдэг. Тоо томшгүй олон ертөнцийн далай нийлээд нэгэн “Усан хуурайг” үүсгэнэ. Хамгийн гайхамшигтай нь арван зүгийг бүрхсэн “Усан хуурай” бүгдээрээ нэгэн асар том ариун цагаан гэрлэн биет хүйсний анхилуун үнэр дээр тогтдог гэнэ лээ ! ”

“Гэрлэн биет хүйсний анхилуун үнэр гэнэ ээ? Тэр чинь юу байдаг юм бэ?” гэж Шидө ойлгосонгүй бололтой асуулаа.

“Хаврын салхи тэр үед ингэж тайлбарлаж байсан л даа. . .” гээд хэлгий сараана цэцэг тайвуухан цааш залгуулан өгүүлрүүн “Хүйсний анхилуун гэдэг нь цэцгийн хүйсийг хэлж байгаа хэрэг. Чи бидний цэцгийн голыг нарийвчлан ажиглах юм бол зөндөө олон бичил тоосонцор байдаг биз дээ? Түүнийг цэцгийн тоос гэдэг юм. Тэр тоосонцоруудыг цэцгийн хүйс буй болгодог. Харин цэцгийн хүйс тэр тоо томшгүй олон тоосонцоруудаар дамжуулан цаглашгүй их амин хүчийг агуулж байдаг. Ингээд бодоод байвал орчлон хорвоогийн далд нууц чухам үүнд агуулагдаж байгааг ойлгоход төвөггүй. Бидний оршин амьдарч байгаа дэлхий ертөнц асар том гэгээн биет цэцгийн хүйсний нэгэн тоосонцор болохыг хаврын салхи бидэнд анх дуулгасан юм.” Шидөгийн ийнхүү дамжуулан өгүүлэхийг сонсох зуур Абогийн сэтгэлд үзэсгэлэнтэй яралжууд хөвсөлзөж эхлэв. Тэр нүүрээ цэцгэнд ойртуулаад булбарай хонгорхон хүйсийг нь ажиглалаа.

“Үнэхээр тийм юм гээч ! Тоо томшгүй олон бяцхан тоосонцорууд цэцгийн хүйснээс ялгаран гарч байна. Бас алтан шаргал гэрэл цацруулахыг яана гээч ! ” хэмээн Або балчир хүүхэд мэт хөхин баясаад дуу алдлаа.

“Хэлээд яахав ! Бидний хүйсний тоос угаас ийм алтан

шаргал өнгөтэй байдаг юм. ” хэмээн Абогийн нээлтийг олж хараад хэлгий сараана цэцэг улам ч яралзсан сайхан инээмсэглэлээ тодрууллаа.

Энэ үеэр уулын удвал цэцгийн хэл загатнав бололтой “Тэр үед хаврын салхи энэ хүртэл ярьчихаад биднийг шалгах санаатай: Та нар газрын хөрсийг хар, бохир гэж боддоггүй биз дээ хэмээн асууж билээ.” гэж хэлэв.

“Тэгэлгүй яахав, дандаа тоос тортгоос бүрдсэн юм чинь ! ” гэж Шидө бодож санах юмгүй хариуллаа.

“Уухайс, цаасан шувуу Шидө чи ч гэсэн бидэнтэй адилхан төөрөлдсөн байна шүү ! ” хэмээн бяцхан удвал цэцэг томоогүйтэн шоолоход тэр хавийн хэлгий сараана цэцгүүд бүгд баясан инээлджээ.

“Яахаараа тэгдэг билээ?” хэмээн шоолуулсандаа бантсан Шидө асуулаа.

Түүний тийнхүү бантан сандарч байхыг харсан цэцэгс улам ч хөгжилтэй инээлдсээр чимээ шуугиан сая нэг юм намсах үед хэлгий сараана зугуухан өгүүлрүүн: “Манай дэлхийн хүйс нь анхилуун цэцгэн дуазан дээр тогтсон тоосонцор юм бол, тоосонцорууд бүгд алтан шаргал өнгөтэй байгааг харж байгаа биз дээ ! Цэцгийн тоосонцрууд түмэн бодисыг төрүүлж, манай гариг гэгээн биет хүйсний анхилуунаас төрсөн алтан өнгөт тоосонцор болохыг хаврын салхи бидэнд уламжлан өгүүлсэн юм. Чамд ямар санагдаж байна вэ?

Сайхан байгаа биз дээ?”

“Тэгэхээр мөн чанарын ирэхүй нь ариун гэдэг энэ дээ !
” хэмээн бяцхан удвал цэцэг цовоо гэгч нь чанга дуугаар хэллээ.

Өглөөний салхинд, Шидөгийн ийн дамжуулан хүүрнэхийг чагнангаа Або усан долгис мэдэгдэхгүй атлаа цэцэгсийн үнэр анхилуулах оддын далайд зорчиход хаа сайгүй өнгө гэрэл солонгорно. Харин уулын удвал цэцгийн цовоо цолгин үг үзэсгэлэнтэй цахилгаан цахих мэт уужуу сэтгэлд нь харван ороход Або Шидөгөөр дамжуулан өөрийнхөө эргэлзээг ийн асууруун:

“Тэгэхээр ганц мөхлөг цэцгийн тоос маань яахаараа өнөөдрийн тоос шороогоор дүүрсэн дэлхий ертөнц болон хувирдаг билээ?”

“Аа ! Тэр ийм учиртай юм. Гэгээн биет хүйсний анхилуун алтан тоосонцор хөвөн явсаар өөрийн цэнгэг ариун эхийн биеээс холдож, хязгааргүй холд тэнүүчлэн одоод огторгуйн чанад дахь огторгуйд хүрсэний улмаас тоос тортог түүнд халдаж л дээ.”

“Тэгээд тоос тортог халдсан болохоор ердийн өнгө зүстэй болон хувирсан хэрэг.” гэж удвал цэцэг хээрийн хэлгий сараана цэцгийн үгийг таслан ярианд оролцоод “Тоос тортог халдсан цэцгийн тоосонцор тоо томшгүй олон галвыг дамжин хувьсах явцад хийн хөнгөн цэлмэг нь дээш хөөрөн

тэнгэр болон хувираад, хийн хувь хүнд нь доош сууж газар болсон ажээ. Ингээд манай дэлхий бүрэлдсэн гэдэг ! ”

Хөндийн салхи хүүгэн үлээж, өнгийн цэцэгсийн анхилуун үнэр ханхлана. Хаврын салхины хүүрнэсэн гайхамшигт үлгэрийг сонсоод, Абогийн санаа бодол алс эрт балрын дэлхий үүсэх үеийн цаг хугацаа руу хөвөрч байлаа. . . .
 . Гэтэл зэрлэг сараана цэцгийн яруу хонгор дуу дахин сонсогдоод:

“Сэтгэлийн мэлмийгээр ажиглан шинжвэл орчлон хорвоогийн хувирал хувьсал ийм гайхамшигтай гэж хаврын салхин хүүрнэн өгүүлснийг би одоо хэр тодхон санаж байна. Энэхүү өгүүлж баршгүй нарийн нандин нууцыг бэртэгчин ардын махан нүдээр яахин харж таньж болох билээ.”

“Та бүхний оршин амьдарч байгаа дэлхий ертөнц шавар шороо огт биш, харин хамгийн цэвэр нандин ариун дагшин эрдэнийн орон болохыг санаж яваарай ! Энэ л чухам огторгуйн хамгийн чухаг нууц юм шүү ! хэмээн хаврын салхи бидэнд захисан.” гэж зэрлэг хэлгий сараана цэцэг санагалзсан байдалтай өгүүлэв.

“Энэ ч үнэхээр гайхамшигтай түүх байна шүү ! Чиний ухаан санаанд багтаж байна уу? Або ! ” гэж сараана цэцгийн нууц үгсийг дамжуулан хэлсний дараа Шидө гайхширан дуу алдав.

“Хэлээд яах вэ ! Үнэхээр ухаан санаанд багтамгүй юм. Бидний оршин амьдарч байгаа газар дэлхий түмэн бодисын амь амьдралыг тэтгэн ундаалж байдаг. Харин энэ тухай тэр болгон хүмүүс анзаарч, түүнийг бахдан дуулж байдаг бил үү? Тэр ч байтугай хүмүүс газар шороог бохир заваантай зүйрлэх нь бий шүү дээ ! Гагцхүү тариачин хүмүүс л газар шорооны үнэрийг дээдлэж байх шиг байдаг.” хэмээн амандаа үглэх зуур Абогийн нүдэнд баярын оч гэрэлтэнэ. Тэр бахдан өгүүлрүүн:

“Өнөөдөр хаврын салхины хүүрнэсэн түүхийг сонсоод хөл дорх хөрст газар маань анх ариун дагшин цэцгийн хүйсийн анхилуун тоосонцор байсан гэдгийг мэдлээ. Үнэхээр хүмүүний сэтгэлийг догдлуулмаар юм байна шүү ! Шидө, чи энэ бүхнийг сайтар ойлгож байна уу ! Би балчир жаахан хүүхэд, өсөх идэр залуу байсантай адил, манай гариг ч мөн алтан гэрэл цацруулсан үе байж шүү дээ ! ” гэлээ.

Шидө Абогийн баяр хөөр чухам хэдий хэр их болохыг хэлж мэдэхгүй боловч, түүний он цагийн ор мөр тод хадгалагдан үлдсэн царайнаас ердийн өдөр тэр болгон үзэгддэггүй догдлол баярын гэрэл цацрах нь гайхалтай санагдаж түүнд өөрийн мэдэлгүй татагдаж орхив. Абогийн баясгалантай төрх байдал түүнд өөрийнх нь дотно нөхөд болох өвс, цэцэг, мод зэрэг хаврын улиралд өсөн төлжихийн баяр хөөрийг дуулж байсан үеийг өөрийн эрхгүй санагдуулна.

Або, Шидө хоёр ийнхүү догдлол баяртаа автан дуугаа хурааж орхиход гэнэт уулын удвал цэцгийн дуу хангинаад “Хүүе ! Надад өөр бас нэг сонин хэрэг санагдчихлаа. Та хоёр энэ тухай сонсвол лав их сонирхолтой санагдах байх даа ! Энэ мөн л хаврын салхи бидэнд хүүрнэсэн нууцуудын нэг юм шүү ! Хүн төрөлхтөн анх нисэж чаддаг байсан гэнэ л дээ. Тэгээд тэд өөрийн эх нутгаасаа аяарлан холдож ниссээр манай гариг дээр ирэхэд, дэлхий ертөнц дөнгөж бүрэлдээд байсан үе тул нимгэн газрын хийгээр хучигдсан байж гэнэ. Түүнийг анхны хүмүүс идээд үзтэл их амттай байсан тул шунаад ахиухан идтэл гэрэлтэй хөнгөн зөөлөн биес нь хүндэрч бохирдоод, дахин нисэж чадахаа байжээ ! ” гэв.

“Яалаа гэнэ ээ? Тэгээд тэд нар хожим яасан хэрэг вэ?” хэмээн Шидөд их л сонин санагдах тул тэдгээр тэнгэрийн хүмүүсийн цаашдын хувь заяанд санаа зовнин асуулаа.

“Тэгээд тэд нар арга буюу дэлхий дээр үлдээд амьдрахаас өөр яах билээ дээ ! ” хэмээн уулын хурц улаан цэцэг энэ үеэр удвал цэцгийн үгсийг залгуулан өгүүлрүүн: “Тэгээд тэд яваандаа газрын хийг идэж дуусгаад, арга буюу ногоо тарьж иддэг болжээ.”

Або, Шидө хоёр энэ тухай сонсоод гайхсан гэж жигтэйхэн. Тэд хэдийгээр энэ домгийг маш их хачирхан сонсож байсан боловч хэсэг зуур чухам юу хэлэхээ мэдэхгүй алмайран зогсоцгоов.

“Та бүхэн шавар шороо ямар хэрэгтэй юм бэ гэж гайхаж байж мэдэх юм.” хэмээн хэлгий сараана бусдыгаа тойруулан харсанаа инээмсэглэж: “Хамаг амьтдад жаргал цэнгэл бэлэглэхийн тулд бүрэлдсэн гэдэг юм.” гэв.

“Хүмүүс эцэс төгсгөлгүй зугаа цэнгэлийг хөөцөлдөн, элбэг дэлбэг амьдралыг эрхэмлэх болсноор зарим нь гуа тарих гэхэд, нөгөө хэсэг нь мод тарихад дуртай байх жишээтэй. . . . Тийм болохоор хүйсний анхилуун хөрс шороо болон хувирч, ногоо цагаа тарих нөхцлийг бүрдүүлжээ. Хожмын ирээдүйд энэ дэлхий дээр амьдарч байгаа хүмүүсийн хүсэл гүйцэлдэж, бүгд цэвэр ариун сэтгэлтэн болохын цагт хөрс шороо буцаж өөрийн унаган төрхөө олох учиртай юм гэж хаврын салхи бидэнд ярьж билээ.” гээд уулын хурц улаан цэцэг үгээ дуусгав.

“Цаасан шувуу Шидө чи одоо мөн чанарын ирэхүй нь ариун одохуй нь ариун гэдэг үгийн учрыг ойлгов уу? Хөрс шороог хуучин алтлаг өнгөтэй болгохын тулд бид өөрсдийн сэтгэл зүрхийг ариусгах хэрэгтэй юм байна шүү дээ ! ” хэмээн уулын удвал тэвчиж ядсан байдалтай ярианд оролцов.

“Тэгэлгүй яахав, цаасан шувуу Шидө минь ! Хэрвээ хэзээ нэгэн өдөр хүмүүс энэ гүн ёсыг ухаарч, урьд нь хүмүүсийн төдийлөн ойшоодоггүй байсан хөрс шороо, үнэндээ цаглашгүй үзэсгэлэнт цэцгийн хүйснээс хувилан төрөөд элдэв зүйлийн тунгалаг чанарт анхилам үнэр

тархааж байдаг гэдгийг ойлгох юм бол тэд газар дэлхийн ач энэрэлд талархаж сурах болно. Тэр хэрээр тэдний амьдрал өөдрөг гэгээн болох учиртай юм ! ” хэлгий сараана цэцэг туяхан биеэ найгуулан цааш өгүүлрүүн:

“Аливаа амьд биет болгон энэ хорвоод мэндлэхдээ гэрэл гэгээ цацруулж ирээд харин огторгуйн орон зай цаг хугацааны хувьслын явцад бохирдож жирийн өнгөтэй болон хувирдаг гэнэм.

Тийм болохоор хаврын салхи алс хол ертөнцийн чанадаас дээрх нууцыг бидэнд дуулгангаа мөн чанарын ирэхүй нь ариун одохуй нь мөн ариун хэмээх ёсыг хэлж өгсөн билээ. Тэгэхээр бид бүхэн төрөхдөө цэвэр ариуны туйл байсан шигээ буцаж одохдоо ч тэр л мөн чанартаа хувилдаг байх нь ! Бидний буцан очих гэгээн биет цэцгийн хүйсийн анхилмал орон болвоос бидний цаглашгүй жаргалтай төрсөн нутаг билээ ! ”

Ямар гайхамшигтай түүх, ямар гайхамшигтай захиас вэ хэмээх үгс Абогийн сэтгэлд халгилна.

Жаргах нарны шижир туяа өндөрлөг талын өвс, цэцэг бүхнийг алтан шаргал өнгөөр будлаа !

* * *

Тэр хоёр хээр талаас буцан ирэх үест хотын түм буман гэрлүүд ассан байхыг үзэж, Шидө Абог хурдан хоолоо идчихээд өнөө оройн тоглолтыг амжиж үзье хэмээн

шавдуулав.

“Шидө минь, чамайг жүжиг үзэх ийм дуртай гэж бодсонгүй шүү !”

“Тэгэлгүй яахав ! Тэр бидэнд байгаль эхийн дотоод нууцыг танихад тус болдог шүү дээ ! Тийм болохоор надад их сонин санагдаж байна !” Шидө гэнэт ямар нэгэн зүйл санасан бололтой, өгүүлрүүн: “Фухуа хамтлагийн ахлагч лав байгаль эхтэй сэтгэл зүрхээрээ холбогдсон хүн мэт санагдсан шүү !” гэлээ.

Шидөгийн үгс Абогийн сэтгэлд нэгэн гайхамшигтай онгод мэдрэмжийг өдөөв.

“Хээр талын өнгийн цэцэгс арай Фухуагийн хүрэлцэн ирэхийг хүлээсээр өдийд дэлгэрч байгаа хэрэг биш биз дээ?” хэмээн тэр бодлоо.

Шидөгөө аван, хотын гудамжаар инээмсэглэсээр Або жүжиг тоглох үтрэмийн талбай дээр очлоо.

Або ч эхний өдөр суусан суудалдаа тухлахад Шидө түүний өвдөгийг түшээд нүд бүлтийлгэн хүлээж байжээ.

Тэгсээр тайзны гэрэл гурвантаа гялалзав.

Хамтлагийн ахлагч Фухуа тайзан дээр сэвэлзтэл алхлан гарч ирээд хүнгэнэсэн хоолойгоор өгүүлрүүн:

“Тэнгэр газар хэмээгч нь түмэн бодисын урвуу аялал, цаг хугацаа хэмээгч зуун үеийн дайраад өнгөрөх зочин гэлцдэг.

Алжаасан анжис бодь модны дор хэвтээд зүүдэнд умбан,
талбай дахь тутрагын түрүү гүн нойрондоо дугжрах цагаар,
сүүн голын сарны мөнгөн туяан дор, та сэтгэл зүрхний
гүнд, тэнүүлч оддын дуудлагыг олж сонсож байсан буй за !
Тэр тэнгэрийн уудам хязгаарт гайхамшигт вивангиридийг
шивших нь нутаг руугаа буц, нутаг руугаа буц гэсэн утгатай
юм.

Хэзээ нэгэн өдөр таны гэгээн ариун сэтгэлийн хүч, энэхүү
үзэсгэлэнтэй атлаа хязгааргүй, ертөнцийн чанад дахь
диваажин мэт оддын чөлөөг олж харах буй за.

Одоо та бүхэн сэтгэлийн үүдийг нээж, хэрмэл домгийн
хуучин цэцэрлэгт орохыг урьж байна.

Яруу аялгуу эгшгийн дор, хоёр дахь шөнийн түүх ийнхүү
эхлэвэй. . . ”

【ХОЁРДАХЬ ШӨНӨ】 ХЭРМЭЛ ХУНТАЙЗ

ΔΕΡΤӨНЦИЙН ЧАНАДЫН ДИВААЖИН

(Алсад диваажингийн байдал тодрон, наад талд нь хотын дүүрэгтэй залгаа ой модон дотор хэдэн хүүхэд гүйлдэнэ. Тэдний дээгүүр тэнгэрийн хүмүүс дагалдан нисэх ажээ.)

Тэнгэрийн хүн А: (Дуулна)

Намуун салхи голын усны мандлыг илбэж

Наадхи уулын энгэр улбартах нь

Урин хаврын өдөр тэнгэрийн бүсгүй өнгийн бүсээ гээжээ

Хээнцэр шувуухай горхийн хөвөөнөө уянгалаг донгодоод

Хээрийн хулгана модны завсраар гүйлдэнэ

Хаврын өдрийн нозоором байдал

Хотын гудамжинд үзэж болохуйц тодхон

Тэнгэрийн хүн Б: (Яриа)

Хотын эргэн тойрны гайхам үзэмжинд татагдаад

Хоёр гурван дэггүй жаал

Хулгайгаар хотын гадна гарч ирлээ

Тэнгэрийн хүн В: (Дуулна)

Атар хээрийн цэцэг дэлгэрэх нь

Гоёхон

Алаг эрвээхэй цэцгэн дээр нь нисэх нь

Гуниггүй

Энэхүү гоёхон гуниггүй байдалд
 Эрхэн бяцхан хүүхдүүд татагдах нь аргагүй
 Хөнгөн зөөлөн бие
 Хөөрөн нисээд
 Зүүд нойрны цэцэгсийн ой болон
 Зайрмагтсан усны хөвөөгөөр эргэлдэнэ.
 Тэнгэрийн хүн А: (Яриа)
 Шөнийн хатан хаан хар дээлээ дэлгэж эх газрыг бүрхэхэд
 Шүлэнгэтэн хорхойссон хүүхдүүд
 Сэтгэл дүүрэн хүсэл мөрөөдөлд автсаар
 Сайхан цаг хугацааг алдаж гүйцэв.
 Хоног хугацаа ямх ямхаар багассаар
 Хуучин нутаг руугаа буцах зам мөр балрав
 Хоромхон зуур
 (Тэнгэрийн хүмүүс тайзан дээрээс аажуухан холдоход,
 шөнө ямар нэгэн зүйлийг яаран хайж байгаа хүүхдүүд
 ийнхүү дуулалдана. . .)
 Хүүхэд А: (Дуулна)
 Харанхуй шөнийн тэнгэрт одод түгээд
 Харгиа булгийн ус уулын хөндийд хоржигноно
 Хаа сайгүй занга сааль байна
 Хүүхэд Б: (Яриа)
 Хуучин нутаг руугаа буцах зам хаашаа хөтлөнө вэ
 Хаана очвол гэрэлт дэнлүү байнам бэ?

Бууринаасаа холдсон хүүхдүүд
Буцах замаасаа төөрчихлөө
Хүүхдүүд: (Хамт дуулна)
Аажуухнаас аажуухан яваад байтал
Аялгуут булгийн эгшиг тасарлаа
Алсын барааг харуулдан байтал
Алтан одны гэрэл тодорлоо
Үелсэн олон уулсыг давлаа гээд
Үүл шиг бүрхэх шөнийн бараан өнгийг арилгахгүй
Туулаад барамгүй өргөн тал сэтгэл гонсойлгоно
Туйлаадас мэт хийсэх шар навчнууд
Мөчрөөс салан доошлоно
(Одтой тэнгэрийн дор хүүхдүүд зугуухан холдон
явахад, тайз засал солигдож, уйтгартай намуухан хөгжим
эгшиглэсээр.)

ДНОМХРУУЛАГЧ ХОТЫН БАЙДАЛ

(Элсэн цөлийн хот улсын доторх нэгэн элбэг баян хүрээ
хорооны дааман хаалганы үүдэнд хоёр чулуун арслан
байрлуулжээ. Бараан шөнийн одод сийрээд, үүрийн шаргал
гэгээ тусахад нэгэн хэрмэл хунтайз алжаангуй алхсаар гарч
ирнэ. Тунгалаг өглөөний жихүүн салхи үлээхэд түүний
хамаг бие жиндэх ажээ.Хунтайз энгэрээ хумбин барьж

дорноос хаяарах үүрийн туяаг ширтлээ.)

Хунтайз: Ай ! Бараан шөнийн харанхуй эцэслэвч бас л нэг унтдаггүй шөнө залгах юм даа ! (Доош тонгойн гингэнээд) Шөнөжин нойр алдаж үзээгүй хүн орчлон хорвоогийн зовлон шаналлыг мэдэхгүй л дээ !

(Юэгуан Тунз түргэн алхлан гарч ирээд, ийш тийш юм хайж байснаа, хунтайзийг мөргөж орхиод, яаран биеэ эргүүллээ.)

Юэгуан Тунз: Өөрийг чинь мөргөөд ёстой эвгүй юм боллоо. Уучлаарай.

(Хунтайз толгой сэгсрэн гашуунаар инээвхийлээд, толгой гудайлган цааш алхах үед Юэгуан Тунз түүнийг дуудан зогсоов.)

Юэгуан Тунз: Хүүе, ах аа та түр хүлээнэ үү !

(Хунтайз зогсоод эргэж харлаа.)

Юэгуан Тунз: Та нэгэн настан баахан хүмүүс дагуулан явж байхыг хараагүй биз дээ?

(Хунтайз дув дуугүй толгой сэгсэрлээ. Юэгуан Тунз их л гонсгор байдалтай дахин нэг юм асуухаар завдсанаа хунтайзийн царайд уйтгар гуниг, алжаал ядаргаа дүүрэн байгааг үзээд, сэтгэл нь огшоод явчихав.)

Юэгуан Тунз: Ах аа, та яахаараа ийм алжаангуй атлаа уйтгар гуниг дүүрэн харагдана вэ? Гэсэн атлаа таны царай чинь нэг л танил дотно санагдах юм. Та надад

өөрийн алдар нэр хэн болох, ахуй нутаг хаагуур байдгийг
хэлж болохсон болов уу?

(Хунтайз ингэж хэлэхийг сонсоод сэтгэл нь сэрхийж, толгой
өргөн Юэгуан Тунзыг харсанаа, нүд нь гялалзаж, амандаа
ийн бувтнав.)

Хунтайз: (Гансрангуй)

Намайг хэн гэдэг, хаанаас ирсэн гэв үү?

(Тэр биеэ эргүүлж нааш холхингоо зугуухан)

Ахуй нутгаас аяарлан холдсон

Аяа чи

Аясын салхинд дайвалзах

Атгын чинээхэн жижиг завь

Хөнгөн зөөлөн явсаар

Хөглөгөр модны дор

Сэрүүцэж аваад

Сэвэлзэн ниссээр

Уулыг тойрохдоо

Сархдын аяыг даагаагүй

Саваагүй эрвээхэй

Аажуухан доош буухдаа

Ай хэмээн

Санаа алдав.

Тэнгэрийн дагины ирээдүй

Тэртээх уул намрын өнгөнд алаглана
Цэцэг мэт
Цэнгэг салхи исгэрэхэд
Хурмастын гадар тэр аяараа хувьсан
Хур болон буулаа
Орь залуу насандаа
Огт хувиралгүй
Налгар намрын улиралд
Ялдам өнгө нэмж чадах уу
Өтөл насны босго давсан ч
Өнгө алдалгүй
Жавхаа хийморьтой бүжиглэж
Жаргах нар шиг гялалздаг бил үү

Ай, толгой гудайн эргэцэх
Үл таних хүн чи
Ахуй нутаг хаана вэ
Аль газраас ирэв

Өө, сэрчигнэн үлээх
Сэрүүн намрын салхи минь
Харин би уулын тэртээгээс нисэн ирсэн
Хариугүй жаахан гунигт
Навч билээ

(хэмээн дуулж дуусаад Юэгуан Тунз руу эргэн харж)

Хунтайз: Ай, чи надад тус болж чадахгүй ээ !

Юэгуан Тунз: (Ойлгосонгүй байдалтай) Юу гэнэ ээ? Ах минь, та юу гэхивээ ээ?

Хунтайз: (Толгой гудайн санаа алдан цаашаа явах зуур)

Ай ! Хэрвээ гэнэн томоогүй зангийн эрхээр, зугаа цэнгэл хөөцөлддөггүй байсан бол тэр жил юу боллоо гэж худалдаачны аян жингийн цуваа даган хотоос нууцаар гарч явах билээ дээ. Түүний харгайгаар энэрэлт эцгээсээ хагацан хорин жилийн турш энэ тэрүүгээр тэнүүчлэн явж байна. Энэ зуур хичнээн ч олон элсэн цөлийн хот улсуудыг дайран өнгөрөв дөө. Шөнө орой хотын гудамжинд хоног төөрүүлж байхдаа уйтгар харууслын усан нулимс хацрыг минь даган урсдаг. Заримдаа өвөрт минь сохор зоос ч үгүй болсон үед хоёр гурван хоногоор ходоод хоосон явах энүүхэнд. Махан биеийн зовлон зүдгүүр чулуун сийлбэр мэт хүндрэх ч яахав, түүнийг тэсэж болно. Харин санаа сэтгэл минь цөхрөлийн гүн ангалын амсар дээр ирээд байгаа мэт санагдахыг яалтай билээ. Тэнгэр газрын хооронд надад туслаж чадах хүн нэгээхэн бээр үгүй. (Тэр биеэ эргүүлж гудамжны нөгөө булан хүртэл алхах зуур) Би чухам хэн юм бэ? Хаанаас ирсэн гэл үү? Би (хэмээн амандаа үглэсээр . . .)

Юэгуан Тунз: Хүүе, хүүе !

(Хунтайз Юэгуан Тунзийн хашгирахыг ч сонсох сөхөөгүй мөнөөх баян тансаг хашаа хорооны үүдэн дэх хоёр чулуун арслангийн дэргэд хүрэлцэн ирээд гөлрөн зогсов.)

Хунтайз: (Амандаа үглэж) Ийм баян чинээлэг айлд лав хашаа хороогоо цэвэрлүүлэх хүн хүч хэрэгтэй байж таарна. Би ч гэсэн жаахан амарч аваад дараа нь яахаа шийдье байз !

(Хунтайз чулуун арслангийн дор биеэ атираад унтахаар хэвтэв. . . . Энэ байдлыг харж зогссон Юэгуан Тунз арга тасарсан байдалтай хүмүүсээ хайж явав. Гэрэл аажмаар бүдэгрэнэ.)

(Нэгэн бүдэг хөх гэрэл атиран унтаж байгаа Хунтайзийн бие дээр тусна. Тайзны нөгөө булангаас хүүхдүүдийн цангинасан инээд тодрон ойртолоо.

Гурван шивэгчин охин нэгэн гоёмсог хувцастай жаалхүүд бараа болон гарч ирнэ. Нэг шивэгчин охин гартаа шувууны үүр барьжээ. Хажуу талд нь хэдэн хүүхэд шуугилдан хөөцөлдөнө. Гоёмсог хувцастай жаалхүү шивэгчин охиноос шувууны үүрэнд байгаа алтан бялзуухайг авъя хэмээн шалгаа ажээ. Шивэгчин охин түүнд өгөхгүй гэхэд цаадхи нь уурсан дэвхцээд. . .)

Жаалхүү: Надад өгөөдөх л дөө ! Надад өгөөдөх л дөө ! Наад алтан бялзуухайг чинь авмаар байна шүү дээ !

(Шивэгчин охин инээд алдаад шувууны үүрийг түүнд

өгөхөд цаадхи нь санаа амрав бололтой хэсэг зуур оролдож байснаа, үүрийг онгойлгон бялзуухайг барьж авахаар завдлаа.)

Жаалхүү: Өө, алтан бялзуухай нисээд явчихлаа шүү дээ ! Шувуухай битгий яв л даа, эргээд ир гэж байна шүү !

(Жаалхүү алтан бялзуухайны араас гүйхэд хүүхдүүдийн инээд зугуухан холдоод, тайзны гэрэл бүдэгрэнэ. Хөшигний цаад талд морин төвөргөөн нүргэлж, нэгэн хүний хашгирах чимээ сонсогдоно. “Хүү минь ! Чи хаана байна вэ? Би чамайг мөн олон жил хайж байна шүү ! ” Морин төвөргөөн хунтайзийг зүүд нойрноос сэрээж, хэн нэгэн хүн түүний нүүрийг илбэхийг мэдэрчээ.)

Номхруулагч хотын эзэн: (Их л энэрэнгүйгээр) Хүү минь, чи яахаараа энд унтаж байдаг билээ?

(Хунтайз сэрээд, толгой өргөн үзвээс нэгэн сүр жавхаатай өвгөн хүмүүн байх тул давхийн цочоод арагш хэд ухрана.)

Хунтайз: (Амандаа бувтнан) Энэ настан хэрвээ улсын хаан биш бол түүнээс нэг их дутахааргүй хүн байж таарна. Нээрэн ч ийм сүрлэг сайхан орд харшид над шиг дорд амьтан яаж багтаж шингэж болох билээ. Эртхэн эндээс холдож, хэр тааруу ажил олж ходоодоо борлуулъя ! Ийм эрх сүртэй хүн над шиг амьтныг барьж аваад насан туршид өөд нар харахааргүй хатуу хүтүү ажилд зүтгүүлэхийг хэн байг гэхэв !

(Хунтайз ийн бодоод тавхай гялалзуулан зугатаж одов.
Хотын эзэн энэ байдлыг үзээд зарц нартаа хандан)

Номхруулагч хотын эзэн:(Бачимдангуй) Хүн байна уу !

Одоохон тэр залууг бариад ирэгтүн !

(Зарц нар тушаалын дагуу удаж төдөлгүй хунтайзийг барьж ирнэ.)

Зарц: (Их л маадгар) Чи хаашаа зугатах гээ вэ? Манай эзэн чамтай уулзъя гэж байна.

Хунтайз: (Хирдхийн дуу алдаад) Би та нартаа угаас танил биш байтал яахаараа намайг барьдаг билээ.

(Хунтайз тийчигнэсээр хотын эзний өмнө ирэх үед, айсандаа ухаан алдав. Хотын эзэн ухаан алдсан хунтайзийг нигүүлсэнгүй харцаар ажиглана. Энэ үеэр Юэгуан Тунз буцаж ирээд, юу болж байгааг харав.)

Юэгуан Тунз: (Сандарсан байдалтай) Та нар яагаад түүнийг барьсан байдаг билээ?

Номхруулагч хотын эзэн: (Зарц нартаа хандан) Наадхиа тавьж явуулагтун ! Битгий дараа төвөг удаарай !

(Зарц нар хувинтай ус авчран түүн рүү цацахад хунтайз сэргэж босоод айсандаа дагжин чичирнэ.)

Зарц: Чи одоо явж болно. Чамд амар тайван амьдрах газар өгье гэтэл ингэж ч байх гэж дээ, ёстой өрөвдмөөр юм.

(Ухаан санаа нь бүрэг бараг хунтайз босож ирээд, хотын эзнийг цочин харснаа, ухасхийн босоод гудамж зээлээр хоол

гуйж идэхээр яваад өгөв. Хотын эзэн холдон одож байгаа хунтайзийн араас хараад, тэсгэлгүй гүн санаа алдлаа. Алсад Са Юнь эрдэнийн эрэлчдийг дагуулан ирэхийг хараад Юэгуан Тунз тэднийг угтан гүйлээ.)

Юэгуан Тунз: Ай, Са Юнь багш аа ! Би та нарыг ашгүй энд олдог байна шүү !

(Юэгуан Тунзтай учраад баяртай байсан Са Юнь гэнэт хотын эзнийг олж хараад, тэсгэлгүй баярлан гар барилцан өөд өөдөөсөө харж инээмсэглэнэ.)

Са Юнь: Өө, хотын эзэн та яахаараа энд морилж явдаг билээ? Номхруулагч хотын эзэн: Үнэхээр та байсан юм уу? Са Юнь гэгээнтэн, энд өөртэй чинь учраад их баяртай байна шүү.

Юэгуан Тунз: (Гайхсан байдалтай) Та нар танилууд байсан юм уу?

Са Юнь: Тэгэлгүй яахав ! Тэр болвоос нэгэн зүгийг эзлэсэн баян, билиг оюун төгс хотын эзэн хүн. Бид хоёр хэдэн арван жилийн турш нөхөрлөж байгаа юм. (Ийн хэлээд хотын эзэн рүү эргэж) Олон жил уулзсангүй шүү. Яагаад өнөөдөр ийм гунигтай харагдана вэ?

Номхруулагч хотын эзэн: Тэр тухай ярьвал урт түүх болно доо.

Юэгуан Тунз: (Ам өрсөн асууж) Сая чухам юу болсон юм бэ? Та нар яагаад саяын ахыг барьж ирсэнээ, буцаагаад тавиад явуулчихав аа?

Номхруулагч хотын эзэн: (Гунигтай инээвхийлээд) Ай, ярьвал урт түүх болно гэсэн шүү дээ. Са Юнь ээ, би эндхийн хүн огт биш гэдгийг чи юу эс андах билээ. Олон жилийн өмнө салж хагацсан хайртай хүүгээ хайх зорилгоор хэд хоногийн өмнө энэ газар суурьшихаар ирээд байгаа юм.

Юэгуан Тунз: Хагацаж салсан хайртай хүүгээ эрж ирсэн гэнэ ээ?

Са Юнь: (Ихэд гайхширан) Таны хайртай нөгөө хөөрхөн хунтайз алга болчихсон хэрэг үү?

Номхруулагч хотын эзэн: (Их харуусангуй байдалтай) Хэлээд яахав. Тэр жил гэнэн томоогүйн харгайгаар зугаа цэнгэл хөөгөөд ор сураггүй алга болсон. Харин хорин хэдэн жилийн турш би энэ тухай хэнд ч хэлэлгүй нуусаар өдий хүрсэн юм. Хэнхдэг дүүрэн гуниг шаналлыг хэндээ ч гэж хэлэх билээ? Сан хөмрөг дүүрэн алт мөнгө, шүр, сувд, мана эрдэнэ болон тоо томшгүй олон боол зардсангууд байгаа боловч итгэлтэй хүн тэр болгон таарахгүй юм. Би уулыг даван, усыг гатласаар хичнээн олон жил эрэл сурал болж явахдаа дайран өнгөрсөн хот балгадын тоог ч алдсан. Ганц хүсэх юм гэвэл хайртай хүүгээ олж өөрийн өв хөрөнгөнд эзэн суулгах гэсэн хэрэг.

Юэгуан Тунз: Тэгвэл саяын.

Номхруулагч хотын эзэн: Саяын энд унтаж байсан залуу болвоос миний өдрийн бодол шөнийн зүүд болсон хүү минь

мөн билээ

Юэгуан Тунз: (Эргэлзэнгүй байдалтай) Гэвч тэр таныг огт танихгүй байх шиг байсан шүү дээ ! Тэр үнэхээр таны хүү мөн юм гэж үү дээ?

Номхруулагч хотын эзэн: (Хунтайзийн явсан зүг харж) Гарцаа байхгүй мөн. Хэдийгээр олон жил тэнэж төөрсөн ч гэсэн түүний магнайд эрхэм дээдсийн гэрэл гийж байгаа тул би харангуутаа таньсан юм.

Юэгуан Тунз: Гэвч тэр яахаараа таны барааг харуутаа ухаан алдан унадаг билээ?

Са Юнь: (ээлдгээр) Тэнэгхэн минь дээ, өдий олон жил өнгөрсөн тул тэр өөрийнхөө эцгийг танихгүй байх нь аргагүй.

Номхруулагч хотын эзэн: (Их л ул суурьтайгаар) Тийм ээ, тэр хар бага наснаасаа хорин хэдэн жил тэнүүчлэн амьдарсан. Өөрийн эрхэмсэг зан чанараа гээсэн төдийгүй, намайг ч танихаа болих нь аргагүй. Ялангуяа өөрт нь оногдох хичнээн их сувд эрдэнэс байгааг ойлгохгүй байгаа. Олон жилийн турш өөрийн махан биеийн төлөө зүтгэж, хэдэн ч удаа үхэл амьдралын зааг дээр ирэв дээ. Тийм болохоор дотоод сэтгэлийн айдас нь туйлдаа хүрсэн байж таарна. Сая би түүнийг олж аваад маш их баярласан боловч, тэр дахиад л хүмүүсийн дунд ороод алга болчихлоо. Би

бачимдсандаа түүнийг олоод ир гэж зарц нартаа тушаагаад авчруултал, түүний бие сэтгэл тамирдан, айсандаа ухаан алдаад уначихсан юм.

Юэгуан Тунз: (Ойлгосонгүй бололтой) Тэр нэгэнт л таны салан хагацаад олон жил болсон хүү юм бол яахаараа түүнийг тавиад явуулчихаж байгаа юм бэ?

Номхруулагч хотын эзэн: Олон жил гадуур тэнүүчилсэн болохоор түүний санаа зориг дордсон байгаа. Тийм болохоор түүнийг хүчээр авчраад ч нэмэргүй л дээ.

Юэгуан Тунз: (Тээнэгэлзэнгүй) Тэгэхээр та түүнийг буцаан авчрах бодолгүй хэрэг үү?

Номхруулагч хотын эзэн: Яалаа гэж дээ? Би түүнийг хэзээ ч мартаж хаяна гэж үгүй. Харин ямар нэгэн уран арга бодож олоод түүнийг гэрт нь буцааж ухааруулах чухал байгаа юм.

Юэгуан Тунз: (Ойлгож ядсан байдалтай) Уран арга гэнэ ээ?

Са Юнь: Юэгуан Тунз аа, энэ бол Хотын эзний хувьд ярих юм бол тийм ч хэцүү хэрэг биш ээ.

(Хотын эзэн инээмсэглээд гараараа дохитол хоёр зарц хүрч ирэв. Тэр зарц нарт хандан)

Номхруулагч хотын эзэн: Хоёр хоногийн дараа гэхэд та нар тэр залуутай найз болох хэрэгтэй. Тэгээд цаг мөчийг анаж байгаад түүнд нэг газар хар ажлын хүн хэрэгтэй байгаа юм. Ацаг хөлс нь гадуур байдгаас гурав дахин өндөр гэж хэлээрэй. Хэрвээ тэр ирэхээр болох юм бол түүнийг арын

хаалгаар дагуулан орж ирэгтүн ! Эс бөгөөс тэр айчихаж магадгүй. Тэр ямар ажил хийх юм бэ гэж асууваас өтөг зөөнө гэж хэлээд, өөрсдөө ч гэсэн түүнд хамжилцаарай. (Хоёр зарцын зүг гараар дохин явуулчихаад, Са Юньгийн зүг эргэж) Харийн нутагт ингэж таарна гэж байх уу даа, та бүхэн ч гэсэн манай энэ түр өргөөнд хэд хоног алжаал тайлаад явцгаа !

Са Юнь: Уухайс ! Би ч гэсэн та тэр хэрмэл хунтайзийг хэрхэн ухааруулахыг харъя гэж бодож байна !

(Олон хүмүүс бүгдээрээ хотын эзнийг даган орд өргөөнд орсоны дараа, Юэгуан Тунз ганцаараа алхангаа байн байн хунтайзийн явсан зүг рүү харан бодлогоширох ажээ.)

Юэгуан Тунз: (Дуулна)

Хэрмэл хөвгүүн гэр оронгүй

Хэрхэн амьдрахаа ч мэдэхгүй

Өдөржин тоос татуулан явахдаа

Өөрт байгаа эрдэнийг харахгүй

(Өргөөн дотор хүмүүс шуугилдах чимээг сонсоод Юэгуан Тунз дотогш оров. Гэрэл унтарна.)

ЛЯДУУСЫН ГУДАМЖ

(Ядуусын гудманд хэрмэл хунтайз хоёр зарц лугаа ярилцан

зогсоно.)

Хунтайз: (Уртаар санаа алдаад) Хүний сэтгэл гэж мөн сонин юм аа. Өдөр болгон нэг юманд санаархаад, түүнийгээ олчихсон хэрнээ өөр юманд сатаараад эхлэх юм.

Зарц А: Чи тэгээд бие амар байх газраа олоогүй хэрэг үү?

Хунтайз: Тийм амар олдох юм гэж хаана байх билээ.

Зарц Б: (Зарц А руу нүдээ ирмээд) Бидний нэг танил баян хүнд туслах хүн хүч хэрэгтэй байгаа юм л даа. Ацаг хөлс нь ч их өндөр юм байна лээ шүү. Гадуур олгодгоос гурав дахин өндөр гэсэн. Дээр нь бас байр саваар хангах юм байна лээ. Хэрвээ тэнд очиж амьдар гэвэл чи зөвшөөрөх үү?

Хунтайз: (Эргэлзсэн байдалтай) Ямар ажил гэхээрээ тийм өндөр цалинтай байдаг билээ?

Зарц А: Нэг баяных баасаа зөөлгөх гэж байгаа юм л даа. Гэхдээ тийм ажлыг хийх хүн тэр болгон олдохгүй. Харин тэр газрын эзэн их өгөөмөр хүн гэдэг шүү.

Хунтайз: Хэрвээ сайн айлд зөв шудрага ажил хийх юм бол очоод үзэхэд яахав дээ !

Зарц Б: Тэгвэл цөмөөрөө одоо явцгаая !

(Хунтайз хоёр зарцын хамт явахад гэрэл унтарна.)

ДОРД ӨРГӨӨНИЙ АРЫН ХҮРЭЭ

(Арын хүрээнд уранхай хувцастай хунтайз хэсэг

хүмүүсийн хамт өтөг зөөж байна. Са Юнь, Юэгуан Тунзийн хамт хонгилын саравчин дор зогсчихоод тэднийг ажиглан харна.)

Юэгуан Тунз: Тэр энд ирээд хэд хоночихлоо. Гэтэл хотын эзэн яахаараа түүн дээр өдий болтол очиж уулздаггүй билээ?

Са Юнь: (Бодлогоширонгуй) Битгий яар даа, аливаа хэрэгт боломж завшааныг харна гэж нэг юм байдаг. Миний санахад энэ залуу өөрийн эрхэм дээд угсаа гаралтай гэдгийг хараахан олж мэдээгүй шиг байна. Номрхуулагч хотын эзэн түүний дорд муу зан авир засрахыг хүлээж байгаа нь лавтай. . .

(Хунтайз хичээнгүйлэн ажилласаар байлаа. Гэрэл аажмаар бүдгэрсэнээ дахин тодсов. Хүмүүс амрахад хунтайз үргэлжлүүлэн ус зөөнө. Биедээ бохир салбархай хувцас өмсөөд, өтөг зөөх хэрэгсэл барьсан номрхуулагч хотын эзэн гарч ирэв.)

Номрхуулагч хотын эзэн: Бүгдээрээ хичээнгүйлэн сайн ажиллах хэрэгтэй шүү. Залхуурч болохгүй. (Хунтайз руу хандан) Залуу минь, чи харин их хичээнгүй сайн хүн болохыг би харлаа. Тийм болохоор чи гадуур дотуур тэнүүчлэх хэрэггүй. Би чамд үүнээс аятайхан ажил ацаг хөлс олгож эндээ төвхнүүлье гэж бодож байна.

Хунтайз: (Их л хүндэтгэлтэй) Танд их баярлалаа. Та үнэхээр энэрэнгүй сайн хүн байна. (Дахин доош тонгойн

ажилдаа улайрлаа)

Номхруулагч хотын эзэн: (Доош бөхийн хунтайз лугаа хамт ажиллана) Чамд өөр хамаатан садан байдаггүй бололтой. Чиний гэр орон яасан юм бэ?

Хунтайз: (Харуусангуй) Ай, тэр тухай ярих ч юм биш. Би өнчин өрөөсөн хэрмэл хөвгүүн болохоор гэр орноо хаана байгааг аль хэдийн мартжээ. Гагцхүү санах нь хар бага насандаа зугаа цэнгэлд дуртайн эрхээр худалдаачны хөсөг дагаж гэрээс гараад төөрсөнөө л сайн санадаг. Тэгээд буцаж харих замаа мэдэхгүй өдий хүртэл тэнүүчлэн явдаг юм даа. (Бодолд дарагдана) Надад нэгэн энэрэнгүй сайхан эцэг байсан шиг санагддаг юм. Түүний дүр төрхийг зүүд нойрондоо л бүдэг бадаг хардаг. Харин түүний хаана амьдардаг талаар өчүүхэн ч төсөөлөл байхгүй. Түүнтэй уулзахыг ихэд хүсдэг боловч зүүд нойрондоо дуудахаас хэтэрдэггүй. Гэвч. (Толгой өргөн номхруулагч хотын эзнийг хараад нэг юм хэлэх гэснээ больчихов)

Номхруулагч хотын эзэн: (Их л дотночлон) Гэвч гээд юу хэлэх гэсэн юм бэ?

Хунтайз: (Толгой гудайлгана)

Номхруулагч хотын эзэн: Алив надад хэлчих л дээ. . . (Хотын эзэн дотночлон баруун гараа түүний мөрөн дээр тавив.)

Хунтайз: (Зоригоо чангалаад) Гэвч та миний энэрэнгүй дотно эцгийн минь дүр төрхийг эрхгүй санагдууллаа.

.(Ичингүйрэн) Өө, уучлаарай, их эвгүй юм хэлчихэв үү дээ !

Номхруулагч хотын эзэн: (Догдлосон төрх нүүрэнд нь илрээд) Яалаа гэж дээ ! Надад ч гэсэн олон жилийн өмнө орон гэрээсээ гараад одоо болтол сураг тасарсан нэг хүү байдаг юм. Би ч гэсэн түүнийгээ санаад өдрийн бодол, шөнийн зүүд болсоор өдий хүрсэн. Чи эцгийгээ яаж санадаг билээ, түүнээс огт өөрцгүй. (Хуучин хэвэндээ буцаж ороод) Хүү минь, чи түр зуур ч гэсэн намайг эцгээ гэж бодож явбал ямар вэ?

Хунтайз: (Их л баярлаж) Нээрэн үү? Би яахин чадах билээ? Номхруулагч хотын эзэн: (Шийдэмгий) Би ч гэсэн хэсэг зуур чиний эцэг болохыг үнэхээр их хүсэж байна.

Хүмүүс бүгд: Тэгвэл ямар сайн хэрэг вэ ! Тэр хүүгийн мөрөөсөл болж, харин чи эцгээ санагалздаг биз дээ, үүнээс сайн хэрэг гэж байх уу даа ! Ёстой сайн юм боллоо.

Зарц А: Чи хурдхан наад хөгшиндөө зөвшөөрчих !

Зарц Б: Чи түүнийг аав аа гэж дуудаарай !

Хунтайз: (Чичирхийлсэн хоолойгоор) Аав аа, аав аа !

Номхруулагч хотын эзэн: (Нулимс гялтгануулан) Аа ! Хонгор хүү минь ! Чи надтай байх болсонд би ямар их баяртай байна гэж бодно вэ.

Хунтайз:(Догдлонгуй) Тан шиг хүний хүү болдог ёстой буян нь дэлгэрсэн хэрэг байна даа !

Номхруулагч хотын эзэн: (Уясангуй) Хүү минь, хүү минь !
(Хүмүүс хөөрцөглөн хашгиралдах чимээнд Са Юнь нар
инээмсэглэн далд орж, гэрэл унтрана.)

ΔНОМХРУУЛАГЧ ХОТЫН ДОТООД ХҮРЭЭ

(Хүрээ хашааны голд хунтайз ганцаараа бодлогоширон
зогсоно. Номхруулагч хотын эзэн, Са Юнь хоёр лянхуат
цөөрмийн хажууд түүнийг ажиглана.)

Са Юнь: Энэ залуу таны нөлөөгөөр өдөр ирэх тусам их өөр
болж байна шүү. Тэр таныг улам бүр хүндэтгэн итгэдэг
болсон болохоор та түүнд өөрийгөө таниулах цаг болсон
биш үү?

Номхруулагч хотын эзэн: Са Юнь минь, тэр залуу өдөр ирэх
тусам надтай санаа бодол ижилсэн ээнэгшиж, элдэв буруу
бодолгүй болсон болохоор түүнд өөрийгөө таниулах цаг
болсон гэж бодож байна. (Гараараа даллан зарцаа дуудаж
ирүүлээд, чихэнд нь ямар нэг юм шивэгнэхэд, зарц толгой
дохисноо цааш явж одов.)

(Хунтайз нааш цааш холхин ямар нэгэн юм бодсоор байгаа
бололтой.)

Хунтайз: (Гүн бодолд автан) Энэ настан миний эцгээс
өөрцгүй эрхэмсэг агаад энэрэл нигүүлсэнгүй сэтгэлтэй
ажгуу. Тэгээд зогсохгүй намайг өөрийн хүүгээс өөрцгүй

хайрлах боллоо. Түүний ачлал сургаалаар орох орон оочих аягагүй би гэдэг хүн зүйрлэшгүй сайхан амьдарч байна. Гэвч. . . . Ай, за за би тэртэй тэргүй айлын гэрийн мухарт толгой хоргодож байгаа амьтан, өөрийгөө яахин түүний төрсөн хүүтэй адилтгаж болох билээ.

(Гэнэт түүний сэтгэл гуниг гутралаар дүүрээд ирэхэд тэсгэлгүй ийн дуулна)

(Гэнэт бөмбөрийн дуу нижигнэн бөөн хүмүүс цугларцгаав.)

Хунтайз: (Цочин гайхаад) Юу болов?

Зарц: Хотын эзэн чухал хэрэг зарлах болсон тул ийнхүү бөмбөр нижигнүүлэн нүдэж байна.

(Номрхуулагч хотын эзэн гоёмсог хувцсаа өмсөөд, сүр жавхаатай тайзны голд гарч ирнэ. Олон хүмүүс бүгд хүндэтгэн зогсох ажээ. Хунтайз түүнийг гэнэт олж харлаа. . .)

Хунтайз: Энэ чинь нөгөө настан байх шив дээ ! Гэтэл яахаараа хотын эзэн болон хувирдаг билээ?

Номрхуулагч хотын эзэн: (Тэнд байгсдыг тойруулан харсанаа) Өнөөдөр би та бүхэнд нэгэн чухал хэргийг зарлах гэсэн юм. Би олон жил эрэл сурал болсны эцэст өөрийн хайртай хүүгээ олж аваад байна.

(Олон хүмүүс бүгд баяр хөөртэйгөөр шивэр авир хийцгээнэ. Хотын эзэн хэсэг зуур зогсосхийснээ үргэлжлүүлэн өгүүлрүүн. . .)

Номхруулагч хотын эзэн: Өдгөө би нас дээр гарсан болохоор өөрийн асар их эд хөрөнгийг түүнд өвлүүлэн үлдээх хэрэгтэй боллоо. Тийм болохоор зарц нарт тушаан номын их хэнгэргийг дэлдүүлэн, та бүхнийг цуглуулаад байгаа юм.

(Хотын эзэн ийнхүү өгүүлж дуусаад, хунтайз руу гараараа дохив. Хунтайз их л гайхан цочирдож, юу хийхээ мэдэхгүй байтал дэргэд нь зогсож байсан Са Юнь түүнийг зоригжуулна. Хунтайз эргэн тойрныг харсанаа эмээнгүй байдалтай явж очлоо.)

Номхруулагч хотын эзэн: (Их л энэрэнгүйгээр) Хүү минь ! Чи болвоос миний олон жилийн турш эрэл сурал болж байсан хүү минь мөн шүү дээ !

Хунтайз: (Их л цочин давхийж арагш хэд ухраад) Юу???

Номхруулагч хотын эзэн: Хүү минь, чи уг нь болвоос манай номхруулагч хотын эзэн хааны хүү байсан юм. Тийм болохоор өнөөдөр би чамд өөрийн удам дамжин ирсэн хамгийн нандин өвийг өгөх гэж байна. Чи түүнийг нандигнан хайрлаж яваарай.

Хунтайз: (Итгэж ядсан байдалтай) Эцэг минь !
.Үнэхээр та мөн гэж үү дээ?

(Тэрхэн мөчид, нэгэн нүд гялбуулсан хурц гэрэл хунтайзийн дээрээс цацарч, олон жил энэ тэрүүгээр төөрөлдөж явсан хунтайз өөрийн эрхэм дээд сурвалж язгууртай болохыг мэднэ. Туулж өнгөрүүлсэн олон хэрэг явдал нүднийх нь

өмнүүр жирэлзэж, зүүд нойрноос сэрсэн мэт, тэсгэлгүй
элдэв бодол толгойд нь эргэлдлээ.)

Хунтайз: (Дуулна)

Толины нүүрэнд тогтсон

Тоос тортог хаанахынх вэ?

Сэтгэлд үүссэн зангирааг

Сэмлэж яахин тайлах вэ?

Ирвэлзэх зузаан тоосон дундаас хэн

Их мянган ертөнцийг харж чадах вэ?

Мэлмий таглах үүлийг хэн зайлуулж

Өлмий өргөн гэрээ зүглэж чадах вэ?

Алаг цэцгийн эрвээхэй

Амгалан нойронд нисэн ирлээ

Амтат цэцгийн баланд шунаад

Аяарлан холдож чадахгүй гэнэм

Хүсэл дурыг өдөөгч улаан цанхуй

Хүмүүний сэтгэлийг өөртөө татна

Улаан энгэсэг гал мэт дүрэлзэнэ

Уяхан дуут алтан бялзуухай минь

Хавийн цэцгийн үнэрт согтоод

Хаврын наранд унтаад өглөө

Алтан бялзуухай минь сэрээрэй
 Алсын уул хөхрөх усыг харав уу
 Үүлс баганадах оргилд нь
 Үзэсгэлэнт ариун цагаан лянхуа
 Өнгө гэрлээ цацруулж байна

Алтан бялзуухай минь сэрээрэй
 Алив тоосыг нэвтлэн гараарай
 Төв их номын хэнгэргийн чимээг сонс
 Түүнчлэн орны ертөнцөд
 Хол ойр алдаршсан билгүүн хүмүүн
 Хөлгөн их судрыг айлдан
 Хөнгөн тоосны дунд орж чадах ажаам
 (Ийн дуулах зуур Хунтайзийн нүүрэнд зугуухан цаглашгүй
 их баяр баяслын инээмсэглэл тодроод, догдлосондоо
 ухасхийн номхруулагч хотын эзнийг тэврэн авлаа.)
 Хунтайз: Эцэг минь ! Үнэхээр та байсан байна шүү дээ !
 Эцэг минь !
 (Энэ үеэр хүмүүс баярлан хөөрцөглөж, дуу алдацгаана. . . .
 . .)

Юэгуан Тунз: (Их л догдлонгуй) Аяа ! Тэр хэрмэл хунтайз
 одоо л өөрийн хосгүй эрхэм дээд язгууртай болохоо мэдэж
 авснаар, өөрийн төрсөн эцэгтэйгээ уулзаж чадлаа. Түүний
 хамаг бие нь баяр хөөр, гэрэл гэгээгээр бялхаж байхыг харав

уу ! Тэгснээр хамаг эд баялгийнхаа эзэн суух боломжтой
боллоо.

Олон хүмүүн:(Найрал дуу)

Махан биеийн наран уулын хөндийд шингэхэд

Магад оюуны саран зөрөөд дээшээ мандлаа

Хатавчны мухарт хоргодож хаа сайгүй тэнүүчилдэг байлаа

Харин одоо хойморт заларч эрдэнэсийн эзэн суулаа

Орчлонгийн хүрдэнд уранхай хувцастай тэнүүчилдэг байлаа

Одоо харин Бурханы сэнтийд залран гурван сансраас
ангигжав

Махан биеийн наран уулын хөндийд шингэхэд

Магад оюуны саран зөрөөд дээшээ мандлаа

Хөшиг хаагдана

17 23

АРВАН ЕСНИЙ ӨДӨР

ЭРДЭНЭСИЙН САН

Газар болвоос түмэн бодисын түшиглэн орших орчин билээ. Хүмүүс энэхүү эх газар хэмээх тайзан дээр тоо томиггүй олон үзэгдэл юмсыг тоглон үзүүлж байдаг. Тухайлбал улсын эзэн, сайд түшимэд, аягүй бол шоргоолж ч юм уу, аль эсвэл модны навч гэх мэт. Хэдэн мянган галвын турш тасралтгүй уг тайзан дээр тоглож, цаглашигүй их өв санг үлдээсэн нь далай мэт гүн бичил хумхийн бэлгэс юм.

Хэдийгээр бичил хумхийн бэлгэс нь далай мэт гүн боловч, хамаг бүгд түмэн мод мянган цэцэгсийг төрүүлэн чадах нэгэн эрдэнийн газартай билээ л . Хамаг орон нугууд сэтгэлийг даган хувьсаж, гагц хайр болон баяр баясгалан ашид оршиж, онгод ба бүтээлч хүч бидний сэтгэлээс тасралтгүй ундрэн гардаг бус уу.

ЭРДЭНИЙН ГАЗРЫН ТАВАН ДАВХАРЛИГ

Або тутрагын талбайн тариалалт амарсан үеийн сэтгэл хөдлөм дүр төрхөнд бас л их дуртай нэгэн билээ.

Тэрээр өглөө эрт тутрагын талбайн нүцгэн талбай дээр хөл нүцгэн гишгэхэд эх газрын тааламжтай бүлээхэн мэдрэмжийг мэдрэв.

Өглөөний шүүдэр газрын гадарга руу хаваад, түүгээр ундаалсан хөрс шороо тутрагын сүрлийн үнэртэй холилдон, талбайг тэр аяар нь анхилуулна. Энэхүү өвөрмөц содон үнэрээр цээж дүүрэн амьсгалахад Шидөд ер бусын тааламжтай байдаг байлаа.

Або ч ийш тийш чиг зорилгогүй алхлах зуур, заримдаа доош тонгойгоод хөрс шороог үнэрлэж үзэх буюу эс бөгөөс хөрсөн дээр ил гарч ирсэн чийгийн улаан хорхой, хүрэлзгэнэ зэргийг ажиглан хардаг. Бас үүлэн чөлөө шиг ховорхон завшааныг алдахгүй гэсэн шиг хэнзлээд авсан хээрийн цэцгийг бүр ч их шохоорхдог билээ.Урьд нь тэр болгон анзаарагдамгүй эдгээр бяцхан зүйлс, одоо энэ хэсэг тутрагын талбайн гол баатрууд байгаа юм.

Үелэн хагалсан тутрагын талбай дундуур хөл нүцгэн туучиж, хөлийн ул дорх бүлээн чийглэг мэдрэмжинд автан явахдаа, Абогийн сэтгэлд элдэв зүйл бодол эргэлдэнэ.

Ургац хураалтын дараа, алтан шаргал өнгөө халсан тутрагын талбай цаанаа л нэг эзгүйрэн харагдана. Харин энэ хоосрон цэлийх уудам талбайд салхи дураар сэлгүүцэн, шувууд ганц нэгээрээ бөгтгөнөн тариачдын унагаж үлдээсэн тутрагын мөхлийг түүж идэх ажээ. Ургац хураасаны дараа талбайг амрааж орхисон болохоор эх газар нэлэнхүйдээ амгалан дүнсийж буй нь энэ юм.

“Сайтар ажиглах юм бол энэ тутрагын талбай хэзээ ямагт хүнийг уйдаахгүй шүү.” хэмээн амандаа үглэх зуур Або утасны үзүүрээс атгасан хэвээр, цаасан шувуу Шидөгөө өглөөний салхинд дураар сэлгүүцүүлнэ.

“Або тариачид дахиад хэр зэрэг удсаны эцэст тариан талбайдаа гардаг юм бэ?” гэж тариачдын хичээнгүйлэн ажиллахыг харсаар дассан Шидөд тутрагын талбайн энэхүү эл хуль байдал уйтгартай санагдсан тул тэр тэсгэлгүй ийн асуулаа.

“Дахиад нэлээд хугацаа байгаа байх аа ! Талбайн зэрлэг өвсийг зулгааж, газар хагалаад, усласны эцэст үр суулгана гээд тэр үед ч эргээд л нүргээн тасрахгүй шүү.”

“Тийм их удах хэрэг үү? Тэд нар арай залхуураад суучихсан юм биш биз дээ?”

“Хаанаас даа ! ” гээд Або тэсгэлгүй инээд алдав. “Тэд нар гол нь талбайгаа амрааж байгаа юм. Тэд нар ургацаа хурааж дууссаны дараа газрын шим нөхөгдөг гээд талбайг

амраадаг уламжлалтай. Тэгээд ч нарны илчинд хортон хорхой шавьжийн өндөг авгалдай устаад, дараа тариалахад хангалттай үржил шим бүрдсэн байдаг юм. Хэрвээ ингэж амраахгүй тасралтгүй тариалдаг байсан бол тачир хөрс үүсээд арвин ургац хураана гэж саналтгүй.”

“Аа, тийм юм байна шүү дээ ! Талбайгаа амраана гэдэг чинь хөрсөө хамгаалж байгаа ухаан байх нь ! ” гэж Шидө гайхан дуу алдлаа.

“Энэ дэлхий дээр тариачид шиг тэнгэрийн ёсыг дээдлэдэг хүмүүс өөр үгүй байх аа. Тэд газрын шимэнд дулдуйдан арвин ургац хүмүүст бэлдэж өгдөг. Газартай шууд харьцсан туршлага нь тэдэнд эх байгалийн үг яриагүй амин судлын лугшилтыг ойлгуулсан байж таарна. Тийм болохоор газар эхдээ элэгтэй тариачин болгон түүний шимийг ховх сорчихож болохгүй, эс бөгөөс газрын амийг таслана гэдгийг мэддэг.”

Абогийн энэ үгийг сонсоод агаарт дураар хөөрөх Шидө үелэн залгалдсан тутрагын талбайг өөрийн эрхгүй гүйлгэн харлаа.

Өглөөний нарны гэрэлд талбайг нэлэнхүйд нь бүрхсэн шүүдрийн дуслууд гялтганаж, сэтгэлд бүлээхэн гэгээ цацруулахад эх газар бүдэг бүдэг шаргал өнгөнд умбах ажээ. Тэгснээр амрааж орхисон талбай цаанаа л нэг өвөрмөц, амьд эрч хүчийг илтгэн харуулна. Шидө тэсгэлгүй ийн асуулаа:

“Эх газар минь ! Та яахаараа өөрийн үр шимийг тасралтгүй хайрлах атлаа хариу нэхдэггүй юм бэ?”

Өргөн уудам тутрагын талбай дээгүүр гагцхүү цаасан шувуу Шидө л ийнхүү дураар зорчин ниснэ. Харин эх газар урьдын адил нам гүмийн гэрлэн агаарт умбасаар байвай.

Або талбайн голыг чиглэн алхсаар урьд нь тариачид сүүдэрт нь хуучлан суудаг байсан хөгшин заарт модны дор ирлээ.

Мөчир навч нь саглайсан заарт модны сүүдэр дор суугаад, өглөө нарны цацрагийг нэлэнхүйдээ дэвссэн тариан талбайг тойруулан харахад, өндөрлөг талын зуун цэцэгс түүний чихэнд шивэгнэсэн нууц үгс санагдаж, тэр өөрийн эрхгүй гүн бодолд дарагджээ.

“Үнэхээр сэтгэшгүй гайхамшигтай ажгуу ! Энэхүү хамаг амьтны амийг тэтгэх эх дэлхий нэгэн үзэсгэлэн төгс алтан өнгөт цэцгийн тоосонцор гэж бодохоор.” хэмээн Або өөрийн эрхгүй амандаа шогширов.

Модны дээрх шувууд есөн хэлээр шулганалдаж, жирхрээ далавчаа зөөлөн дэвээд, өвсөн дунд дэвхрэг үсчин, хараа сунган үзэхүйеэ алсын уулын хад асганд манан будан хөшилдөнө.

Сэтгэл санаа тайвуухан үедээ Або эргэн тойрны амьдралын намуухан хэмнэлийг ажиглан суух дуртай. Ойрын өдрүүдэд тэр цаасан шувуу Шидөгөөр дамжуулан нам гүмхэн дүмбийх эх газрыг илүү сайн мэдэх болсон билээ. Ялангуяа

сансар огторгуйн юмс үзэгдэл харахад чимээ аниргүй шиг атлаа, үнэн чанартаа үргэлж оволзох сэтгэлийн дуу, түүний оюун санааны гүнд битүүмжлэгдчихээд байсан амин лугшилтыг өдөөн сэрээж өгсөн сөн. Яваандаа санаа сэтгэл тайван амгалан болох үед, салхины дунд агуулагдсан эх байгалийн яруу эгшиг дуу түүний сэтгэлийн утсыг сэм сэмхэн хөглөдөг болов. Одоо ч гэсэн эх байгалийн тэрхүү өдөөлт түүний сэтгэлийг доглуулах ажээ.

Өглөөний салхи илбэн өнгөрөхөд эх газрын агаар соргог анхилуун үнэр анхилууллаа. Заарт модын мөчир намаа хөнгөн санаа алдаж, хээрийн өвс нэлдээ халиуран ганхаад, тэртээ хол хүдэн будан хөшилдөн хөвсөлзөнө. . . . Тэрхэн мөчид Абогийн нүдний хараа гийгээд явчих шиг санагдав. . . .

Нүдний өмнө эх газрын түмэн үзэгдэл жирэлзэнэ. Тоо томшгүй олон мод, цэцэгс дураар дэлгэрч, есөн зүйлийн жигүүртэн, араатан түүний дундуур сүлжидэхэд, хүмүүс ч тэднээс хоцрохгүй гэсэн шиг тариа ногоо тарьж, байшин барилгаа бариад, номын үйлд шамдан, бизнес эрхлэж, аяллаар явах гэх мэт. . . . гэсэн атлаа түмэн бодис бүгд ганц эх дэлхийдээ багталцан амьдрах ажээ.

Ийн тайван ажиглах зуур, Абогийн гэгээн мэлмий амь амьдралын элдэв зүйл байдлыг таньж ухаарав.

Моддын ногоон амь өөр өөр мөчир, навчны хэлбэртэй,

шувуудын чуулган өөр өөрийн өнгө хэлбэр бүхий өд сөд, дуу хоолойтой, далай тэнгисийн ургамал ч мөн өөрцгүй түмэн янзын хэлбэр дүрстэй, тэр ч байтугай өчүүхэн жаахан өнгийн эрвээхэйн төрөл зүйлийг түүний нүд бүрэн дүүрэн таньж мэдэх аргагүй санагдана. Ой тайгын мөөгний төрөл зүйл ч гэсэн тоо томшгүй, урсах усны түмэн янзын яралжийг төсөөлөн зураглана гэдэг бас л бүтэшгүй хэрэг.Өдөр болгон зав чөлөөгүй ажиллах хүмүүс амьдралын түг түмэн янзын хэвшилтэй. Або тэр болгонд баяр хөөр, уйтгар гуниг, эргэлзээ, мөрөөдөл зэрэг сэтгэлийн өөр өөр орон ертөнцийг олж хардаг байв.

“Або нэг л дэлхий ертөнц дээр байгаа хэр нь яахаараа амь амьдрал болгон ийм өөр өөр байдаг байна вэ?” хэмээн Шидө тэсгэлгүй гайхан асуулаа.

“Туа таривал гуа хураана, буурцаг таривал буурцаг хураан гэдэг юм даа.” хэмээн хүнгэнэсэн дуу чихэн дээр нь шахам сонсогдоход Або юу болохыг мэдэж завдаагүй байтал цааш өгүүлрүүн “Нэг л амьдрал, адилхан тариалалт мөн атлаа дотоод сэтгэлийн гүн рүү нь өнгийгөөд үзвэл тэр болгон баяр хөөр, дур бахдлаар дүүрэн байдаг бил үү?”

“Баяр хөөр, дур бахдал гэнэ ээ?” хэмээн Або амандаа давтав.

“Тэр олон хувирал нэг л сэтгэлд багтдаг шүү дээ ! ” хэмээн нөгөө хүнгэнэсэн дуу элдэв үзэгдэл юмсыг өөртөө багтаах эх газрын энгээр нэг цууриатлаа. “Газар харилцан адилгүй

өөр өөр санаа сэтгэлийн байдалд түшиглэн түүнд тохирох элдэв зүйлийн өнгө хэлбэр дүрсийг буй болгож байдаг. Асар том эх газар түмэн бодисыг өөрийн дээр агуулж байдаг төдийгүй, элдэв зүйлийн амь өөрсдийн санаа зоригийн дагуу чөлөөтэй өсөн төлждөг билээ. Тийм болохоор нүдний өмнөх адилгүй, зогсолтгүй дэгжих мянган түмэн үзэгдэл юмс, бүгд амь амьдрал бүхний хүсэл зориг, урьд насанд хураасан үйл үрийн дагуу харгалзан бүтдэг байх нь ээ ! ”

“Өө ! Ёстой өнгө алагласан их мянган ертөнц гэдэг чинь энэ байх даа ! Би нааш ирэх замдаа, эх газрын өнгө аяс ямар өөр өөр юм бэ дээ хэмээн бодож байсан юм.” гэж Шидө сая л нэлээд зүйлийг ухаарсан бололтой дуу алдав.

“Яалаа гэнэ ээ? Тэгээд цааш нь. . .” хэмээн Або өөрийн цаасан шувууны бодлыг сонсох санаатай асуулаа.

“Би гол нь түүнийг залуу зандан цагийн эрч хүчтэй холбоо бүхий гэж бодсон юм. Залуу насны эрч хүчнээс илүү цог жавхаатай зүйл гэж юу байх билээ дээ?” гэж урин салхины аясаар нисэх Шидөгийн урьдын дурьдатгал сэргэв бололтой цааш өгүүлрүүн:

“Эх газар цаг ямагт залуу насны эрч хүчээр дүүрэн байдаг. Тоо томшгүй олон амь амьдралыг түүний дотор багтаадаг төдийгүй, өдөр болгон өөрийн биеэс шинэ амьдралыг төрүүлэн гаргаснаар, цаг ямагт баялаг яруу бахдам аялгууг дуурсгаж байдаг биш үү. Ганц ширхэг тутаран чихний

нахиа, аль эсвэл ногоохон жирхрэний авгалдай зуны өдөр хөрсөн дороос цухуйн гарч ирэх нь. . . .Цаг наргүй, цаглашгүй их баяр хөөрийн уур амьсгал газрын гавнаас ундрэн гарч, тэрхүү хайр бахдлын их эрчим тэднийг ундаалан тэтгэж байх шиг санагддаг.

Харин тухайн газар уйтгартай, дуу шуутай, эрхэмсэг, үзэсгэлэнтэй харагдах эсэх нь бүгд түүний дээр өсөн төлжих амьдралын өнгө аяс ямар байгаагаас шалтгаалдаг ажээ. . . .”

Шидэгийн ийнхүү уянгалуулан ярихад Або өргөн дэлгэр уул усны ертөнцийн нууцад нэвтэрч, амьдралын өөр нэгэн өнгө төрхийг ойлгож авав.

Заримдаа нуурын ус өөрийн өвөрмөц дуу хоолой, цээлхэн яруу эгшгээр газрын гадаргуугийн гүн нарийн атлаа эрхэм нандин бодролыг намуухан илтгэнэ. Заримдаа ой шугуй өөрийн номин ногоон мөчрөөрөө газар эхийн хормын төдийд ч тасалдахгүй атлаа өрнөн дэгжиж байдаг нууцлаг амин урсгалыг бидэнд харуулдаг. Өнгө алагласан цэцэгс ч мөн өөрцгүй булбарай зөөлөн дэлбээ болон анхилуун үнэрээрээ эх байгалийн уран гар, баяр баясал үзэсгэлэн гоог дэлгэн үзүүлдэг билээ. . . .

Нарны туяа нуурын торгон мандалд тусахад долгис нь бидэртэн мяралзаад, эргийн дагуух ой түүнд тусан ер бусын гайхам ногоон өнгөөр гялтганав. Алаг цэцэгсийн түмэн өнгө

түүнээс дутахгүй гэсэн шиг гоо үзэмжээрээ өрсөлдөнө. Орчлон ертөнцийн түмэн өнгө угаас зүйрлэшгүй гайхам, эгэл жирийн хөх хагд өвс хүртэл газар дэлхийн зузаан ногоон хүрмийг нэхэж байдаг байнам.

Аливаа бидэнд мэдэгдэх амь амьдралын дотоодод агуулагдах эрч хүч, эсвэл уян зөөлөн чанар, сүр жавхаабүгд л цэвэр ариун үзэсгэлэн гоог илтгэх ажээ. Тиймдээ ч эх газар өөр өөр хүсэл зоригт харгалзсан сүрлэг жавхаатай асар том модон ойг цогцлоохдоо зуун жил, бүр магадгүй хэдэн мянган жилийг ч зарцуулдаг тул анх байсан эль хуль орон зай өнөөдрийн үзэсгэлэнт ойгоор бүрхэгдэж, үүрд мөнх үзэсгэлэн гоогоо гайхуулах диваажингийн цэцэрлэг болон хувирсан байж таарна.

Шидөгийн ийн хүүрнэхийг сонсонгоо эргэн тойрон дахь эх байгалийн үзэмж төгөлдөр байдал үнэхээр ч ариун нандин, уян зөөлөн, гэрэл гэгээ цацраасан хосгүй үзэсгэлэнгийн бүрдэл болохыг Або гүнээ мэдрэв. Харсан үзсэн хүний бахдлыг төрүүлэх энэ үзэмж сэтгэлд дотно агаад хязгааргүй бахдлыг төрүүлнэ.

“Хоёр дахь давхар эрдэнийн газар дээр бүхий л үзэмж цаглашгүй үзэсгэлэнтэй агаад, хамаг амьтны сэтгэлийн төгс төгөлдөр мөрөөдлөөс үүдэлтэй бүтсэн байдаг.” хэмээн эх газар намуухан хүүрнэх нь Шидөгийн салхинаа дэрвэх хувцсыг дагалдан нисэж тутрагын талбайгаар нэг тархаж

байх шиг санагдав.

“Хүн эх газрынхаа нэгэн адил түмэн бодисын түшиг болж байхаас гадна, өөрийн биеийн дотоод дахь цаглашгүй их эрчим чадлыг илрүүлэн нээж, хайр баяр баяслаар гэрэлтэн байж чадах аваас, онгод болоод бүтээлч хүч дотоод сэтгэлийн гүнээс тасралтгүй оргилон гарч, хаана ч амьдарсан эрдэнэсийн цэцэрлэгт буй мэт санагдах болно.”

Одоо дагтаршсан хатуу газрын хөрсөн дээрээс, амьдрал хэмээгч нам гүм зүйл огт биш болохыг Або ойлгож ухаарав. Харин ч туйлын уян зөөлөн хэлбэрээр тасралтгүй үргэлжлэн явагдаж, цаг мөч он жилүүдийн турш баялаг атлаа гайхалтай сониноор хувьсан хувирч, ухаан бодолд тэр болгон ажиглагдалгүй, газрын гаваас өөрийн түмэн гайхамшигт өнгө аясыг дэлгэн ундарч, хязгааргүй халуун сэтгэлийн баясгалант эгшгийг дуурьсган, сүрлэг атлаа цаглашгүй олон хэлбэртэй амьдралын аялгуу дууг хэлхэж байдаг ажаам.

Нэгэн зурвас цахилгаан өглөөний агаарт нойрмоглох тутрагын талбай дээгүүр зурсхийн татав.

“Тэнгэрийн эрхэс эргэлдэн, цаг хугацаа хувьсан өөрчлөгдөхөд, хавар, зун, намар өвлийн ээлжлэхийг ажиглалгүй өсөж торнидог хэн ч байх билээ дээ?”

Цаг хугацааны хувирал, үрийн шимээр, зуун цэцэгс болон тутрага будаа ирэх жилийн хавар гэхэд дахин соёолон ургаж,

жилээс жилд өсөн арвижих нь гарцаагүй юм.” Аянгын нүргээнд эх газар нэлэнхүйдээ доргин чичирхийлнэ.

“Хүүе, ямар сонин юм бэ?” хэмээн аянгын нүргээн дунд өөрийнх нь хөл дор тунгалаг гэрэл гялтнахыг Або олж үзэв.

“Эх газар чухам хэр зэрэг гүн зузаан бол доо?” Тэр ийн өгүүлээд Шидөгөө дагуулан улам ч гэрэлтэй соргог газрыг эрэлхийлэн явлаа.

Тэнгэр газрын энэхэн чөлөө хязгааргүй сунан үргэлжлэх эрт балрын толь болон хувирсан юмсанжээ. Өнгө алагласан хорвоо дэлхий хэмээгч өөрөө цаг хугацаа орон зайн хувьд хязгааргүй алслалтай огторгуйн дуран байг агуулсан өрөө ажгуу.

Эргэн тойрон элчилгүй мэлцийж, Або л тэр дунд ганцаараа бөртөгөнөж байгаа болохыг олж мэдэв. Тэнгэр газартай, газар тэнгэртэй залгалдаж, тэр хоёрын уулзвар завсраар орчлонгийн хамаг юмс үзэгдэл тасралтгүй үүсэн хөгжиж байдаг байх нь. . . . Гэрэл сүүдэр солбицсон асар том дуранбайт өрөөнд хэдийгээр өөрийгөө олж харах боломжгүй боловч, хоёр талын тольтой хана өөрийг даган хөдлөхдөө түм буман харилцан адилгүй амь амьдралын дүрсүүдийг тусгадаг болохыг тэр мэдрээд тэсгэлгүй гайхав.

“Хүмүүс энэхүү эх газар хэмээх тайзан дээр тоо томшгүй олон үзэгдэл юмсыг тоглоон үзүүлж байдаг. Тухайлбал улсын эзэн, сайд түшмэд, аягүй бол шоргоолж ч юм уу,

аль эсвэл модны навч гэх мэт. . . . Хэдэн мянган галвын турш тасралтгүй уг тайзан дээр тоглож, цаглашгүй их өв санг үлдээсэн нь далай мэт гүн бичил хумхийн бэлгэс юм.” хэмээн эх газрын дуу хоолой дахин нүргэлж, бүр алсад дуурсан замхарлаа.

“Нэгэн бодлыг усны долгистой зүйрлэж болох бол тоо томшгүй олон бодлууд нийлээд сэтгэлийн далайн хэзээ ч эс тасалдах хүчит давалгаа болдог ажгуу. Салхи намжаад давалгаа тогтуун болсон үед сэтгэлийн далайн тунгалаг мандал толь адил гэрэлтэх тэр л агшинд амь амьдралын түм буман харилцан адилгүй өнгө төрх, их бага, сайн сайхан ямар нэгэн байдлаар илрэн харагдахгүй нь үгүй.”

Агшны зуур нүдний өмнүүр жирэлзэн өнгөрөх дүрсүүд сэтгэлийн гүн дэх ямар нэгэн далд мэдрэмжийг өдөөж байгаа болохыг Або мэдэрлээ.

“Ай ! Ямар хөөрхөн хүүхдүүд вэ? Тэд нар юу хийж байгаа юм бол?” гэж Шидө гэнэт гайхширан хашгирах дуу сонсогдов.

Хэзээг бүү мэд энэхүү тольтой өрөө шиг гурван давхар эрдэнийн газар дээр тоо томшгүй олон гэнэн цайлган хүүхдүүд гарч ирээд эртний толийг арчиж цэвэрлэж байх ажээ.

“Бичил хумхийн бэлгэс далай мэт гүн, тэгээд ч хэмжээлж баршгүй цаг хугацааны хувиралт дунд эртний толь тоос

тортог болохгүй байна гэж үгүй.”

Эх газрын ийн өгүүлэх ухаант үгс Абогийн сэтгэлийг гийгүүлэв.

“Гагцхүү шөнө орой хүмүүсийн хөл татарсан үед ганцаар суугаад сэтгэлээ шинжиж, түүн дээр тогтсон хир тоосыг цэвэрлэх аваас, эртний толиний өөрийн угийн мөн чанар болох гэгээн тунгалаг төрх эргэн сэргэж, тэнгэр газрын түмэн үзэгдэл юмсийн хувирал хувьслын нууцыг тольдон харах боломжтой.” Эх газрын нүргэлсэн яруу дуун гэрэлтэн цэлийсэн огторгуйн тольт өрөөнөө ийнхүү дуурсана.

“Тоос тортгоос салгаж, эртний толиний гэгээн тунгалаг байдлыг сэргээ гэнэ ээ?” хэмээн Або түүний хэлсэн санааг дахин давтан эргэцүүлэв.

“Тийм ээ, огторгуйн эртний толь зөвхөн гадна талд байдаг юм биш, бас дотоод сэтгэлд ч мөн адил байдаг юм. Түүнийг эрэгцүүлж ухаарах нь сэтгэлийн тусгалын долгионы уг мөн чанарт нэвтрэх цорын ганц арга мөн.” Або хоёр талын тольт хананууд ийн өгүүлэхийг сонсох шиг санагдав.

“Амьдралын ирээдүй, он цагийн урсгалын алинд ч сэтгэлийн ариун дагшин анхны тэр байдал руу ямагт тэмүүлж байх хэрэгтэй. Тэгж чадсан цагт цаг хугацааны хувирал хувьслын дунд хир тоос халдалгүй, огторгуйн олон юмс үзэгдлийг даяар нь таашаан үзэж болно.”

“Бид нар хэвийн сэтгэлээр түмэн бээрийн үзэмжийг туулан

өнгөрсөний дараа амь амьдралын их мөрөнгийн дундахь он цагийн ул мөрийг олж үзэж болох төдийгүй, тэр бүхэн гичийн үрийн голд багтаад их үдийн наран мэт налайж байдаг ажаам. Чухам энэхүү тодорхой тунгалаг угийн мөн чанар л бидний үеийн үед эрэлхийлж явах зорилго гарцаагүй мөн юм.”

Ийнхүү бодолхийлж байх зуур хүүхдүүд эртний толийг гялалзтал арчиж дуусчээ.

Гэнэт нэгэн зурвас гэрэл сэтгэлийн мэлмийг гийгүүллээ.

Тэрхэн зуур эртний толины дунд зүйрлэм үзэсгэлэнтэй гэрэл солонгороод, зугуухан өргөсөн тэлэв.

“Пөөх ! Ямар баян тансаг эрдэнэс вэ?” хэмээн Шидө гайхширан дуу алдах сонсогдов.

Удалгүй мөнөөх зүйрлэшгүй үзэсгэлэнтэй солонгын гэрлийн цаана газрын гүнд агуулагдах цалин цагаан мөнгө, усан болор, мана, шүргэх мэтийн тоо томшгүй олон эрдэнэсийн олон өнгө үзэмжит өнгө гэрэл харилцан солбицож, нүд хужирлав. Тэрхүү цэцэг мэт гэрэлтэх өнгө гэрэл эх газрын дотоод амины цэвэр ариун, гоо сайхан бүхнийг илтгэн харуулах ажээ. Залгуулаад нэгэн гэгээн гэрэл цахилавай.

“Хэрвээ өөрийнхөө жинхэнэ мөн чанарыг олж чадах аваас жинхэнэ билиг билгүүн тодрон гарахад бэлэн боллоо гэсэн үг ! ” хэмээн эрдэнэс агуулсан эх газрын гүнээс алтан

гэрэлт долгион ар араас ундрэн дуурьсаж, ягуухан Абогийн чихэнд хүрэх ажээ.

“Биеэ цэгнэх аргаар өөрийн сэтгэлийн дундахь тоосыг бүрэн цэвэрлэж чадсанаар, ертөнцийн түмэн үзэгдлийн дунд төөрөлдөхгүй байж, дээр өгүүлсэн өөрийн мөн чанар лугаа учирч болно !”

Эх газрын цэвэр ариун атлаа оргилсон халуун дуудлагыг мэдрээд, үе үе тодрох хөнгөн, тааламжтай гэрлийн дунд оршихдоо Абогийн бие сэтгэл өгүүлэхийн аргагүй алтан гэрлийн дунд уусан шингэж, дотоод санаа бодол нь уужран амирлах шиг санагдав.

Ийнхүү гайхширан баясаж байх үед, хий агаарт дахин эх газрын гэрэл дуу түгээд:

“Энд ямар ч эргэлзэж сандраад байх юм үгүй ! Гадаад ертөнц дотоод сэтгэл хоёр нэгэн зэрэг ариуссанаар амь нас өөрийн ноён оргил болсон билиг билгүүнийг олох болно. Энэхүү туйлын гэгээн ариун мөн чанартаа тулгуурласнаар, чи орчлонгийн түмэн үзэгдлийн далд чанар болсон гэрэл гэгээ, хамгийн анхны үүслийн уг сурвалжийг ойлгох боломжтой !

Дэлхий дээр тухайн уг сурвалжийг уудлан гаргаж чадсан гэгээрэгч л сая огторгуйн цаглашгүйгээс нааш эс эвдрэх, гэгээн гэрэл цацруулсан үнэн билигийн эрдэнийн газрыг олж чаддаг байнам.”

Энэхүү үе үе тодрох гэрлэн дуу Або, Шидө хоёрыг эх газрын гүний сэтгэшгүй орон зай руу аваачихад бүхий л гэрлүүд хоорондоо уусан нэгэн биет болон шингэвэй.

Одоо мэдэх нь ээ, орчлон хорвоо тэр аяараа цэвэр тунгалаг алтан гэрлийн мөн чанартай бөгөөд аливаа ухамсар, үзэгдэл юмс тэрхүү алтан гэрлийн дотор агуулагдаж байдаг нь зүйрлэн хэлвээс хавар, зун, намар, өвөл нарны гэрлийн тусгал харилцан адилгүй байдгийн улмаас юмс өөр өөр өнгөөр гэрэлтэж, үзэгдэж байдаг лугаа агаар нэгэн ажгуу.

“Алтан гэрэл болвоос түмэн бодисын амь амьдралын далд нууц атлаа жинхэнэ бэлгэс нь болой. Нөгөө талаар бичил хумх бол тэрхүү бэлгэсийн нөгөө тал юм.” хэмээх энэ үгс эх газрын үг юм уу гээд сайтар сонсох аваас Абогийн сэтгэлийн гүнээс ундран гарч байлаа.

Нөгөө талын ертөнцөд юм бүхэн алтан эрдэнээр хучигдсан нь цэвэр ариун, буян хишигийг илтгэдэг болохыг Або олж үзэв. Тэндхийн хүмүүс нэгэн мөхлөг бичил тоосыг нандигнан үздэг ажээ.

“Тэтэл хаа сайгүй бичил хумхаар хучигдсан манай дэлхийд хүмүүс алт алт л гэх юм даа. . . .” гэж Або нэг юм ухаарсан бололтой амандаа бувтнав.

“Цаглашгүй олон тоотой бичил хумх нь тоо томшгүй олон алтан элснээс өөрцгүй. Бичил хумхын дотор алтан өнгөт Бурханы орон агуулагдаж байдаг ! ” Або нууцаа дэлгэсэн

эх газрын дээр, зурвас зурвас алтан гэрлийн долгион ойн гэрэлтэж, өнцөг булан бүхэн нь алтан өнгөт нарны туяагаар бүрхэгдээд, газар сайгүй яруу дуут жингэнээ сонсогдохоос биш, зовлон шаналал, түүний уг сурвалж болсон нисваанис огт үгүй байлаа.

“Дээд зэргээр боловсорсон билиг оюун бусдын төлөө гэсэн сэтгэлээс үүдэлтэй ! Үүний тулд өөрийн биеийг хичээж, сэтгэлдээ буяны тариаланг өсгөн ургуулж чадваас, хувцас өмсөх, хоол идэхийн хооронд ч огторгуйд хаа сайгүй орших цэвэр ариун амьдралын амтыг мэдрэн, эргэн тойрны түмэн бодисын гайхамшигтай яруу амьдралын тоглолтыг үзэж болмуй ! ”

Энэ бүх гэрлэн дуу өөрийн биеэс үүсэн гарч буй мэт санагдахад, буй биеэрээ орчин тойрондоо бүрэн уусан нэгдэвэй.

“Або ! Або ! ” хэмээн хашгирах дуу түүнийг энэхүү гайхамшигтай сэрэл мэдрэмжийн орноос хөндийрүүлэв. Гэвч тэр хэсэг зууртаа тэр дууг жинхэнээсээ сонссон, эс бөгөөс зүүдэндээ сонсов уу гэдгийг эс ялган байтал хэдэн настай тариачид түүнд хандан: “Хүүе ! Або, чи байтлаа салхин шувуу тавьж байх зуур зүүдлэдэг болоо юу?” гэж асуулаа.

Настай тариачдын номхон дөлгөөн харц, дотно мэндчилэх дуунд, Або сая нэг жаахан ухаан сэхээ ороод, ийш тийш харсанаа тэсгэлгүй инээд алдаж:

“Хэ хэ ! Салхины тааламжтай илбэлтэнд өөрийн мэдэлгүй хэсэг зүүрмэглэсэн бололтой. . . . Та нар ч гэсэн өдий цагаар тутрагын талбай дээр юу хийж явдаг билээ?”

“Хэдийгээр одоо талбайгаа өнжөөж байгаа боловч эндээ сэтгэл татагдаад байх юм ! ” хэмээн нэгэн хөгшин тариачин хөгжилтэй хэлснээ

“Манай энэ талбай болвоос үржил шимт сайтай болохоор юу ч тариалсан сайн ургаж, биднийг өлсгөж байсан удаа огт үгүй юм шүү ! ”

“Нээрэн ч тийм дээ ! Үнэхээр эрдэнийн газар мөн ! ” хэмээн тэдний амыг дагуулан хариулахдаа, Або саяхан зүүд зөнгийн орчинд үзэж харсан бүхнээ тодхон санасаар байлаа.

Бүлээн хатуу газрын хөрсөн дээр зогсоход, бүгээн салхи хацар нүүр илбэж, мөчир дээр яруухан жиргэх шувуудын найралд намрын жирхрээ түрлэг нэмсэн байхыг тэр сая анзаарав.

Заарт модны дор үе үе давтамжтай сонсогдох жирхрээн дуу, мянган түмэн долгион гэрэл лүгээ адил, хүний бодлын давтамжтай нийлээд, санаа сэтгэл уужруулан ариусгах эрдэмтэй ажгуу.

* * *

Оддын гэрэл дор, ойн чөлөөний алтан гургалдай төрсөн нутгийн эртний дууг яруухан эгшиглүүлэхийг би сонслоо.

Эх газрын дунд нойрсож буй номин хулст хад асганы гоолиг нарийхан хулснууд, түүнийг ягуухан цууриатуулах нь цээл

яруу лимбийн аялгуу мэт, амьдралын баяр баяслын гэгээг цацруулна. Энэ газрын хүн бүхэн амьдралын хүнсээр элбэг хангалуун байх ажээ. Аяа ! Энэ дэлгэр сайхан уул хангай чухам хаанаас үүссэн юм бол?

Шөнийн агаарт, Фухуагийн дуу хоолой шүлгээ уран яруу уншиж байгаа найрагчийн хоолой мэт уянгалан дуурсахад, Абод өдрийн тохиолдсон явдал гэнэт санагдаж Шидө рүүгээ хараад мишээв.

“Аль диван галвын үеэс ч өмнө, манай дэлхий дөнгөж үүсэн бүрэлдэж байх үед. . . . хийн хөнгөн цэлмэг нь дээш хөөрөн тэнгэр болон хувираад, хийн хувь хүнд нь доош сууж газар болсон гэнэм. Тэнгэр газар бүрэлдэн буй болсноор амьдралын гайхамшигт аялал түүний завсар үргэлжлэх болжээ.” гэх Фухуагийн нүргэлсэн цээл хоолой хотын иргэдийг өөрийн эрхгүй эрт балрын үед аваачих шиг санагдана.

“Тоо томшгүй олон амьтад, чухам энэхүү өргөн уудам агаад үржил шимтэй дэлхий ертөнц дээр, эх байгалийн сэтгэл харамгүй үр шимийг хүртэн өсөж дэгжин, үеэс үед уламжлагдсаар өдий хүрсэн ажгуу.”

Фухуагийн дуу хоолой үтрэмийн цэлийсэн талбайгаас халин шөнийн салхийг хөлөглөж, хотын гаднахь уулын хөндий хүртэл цууриатав.

【ГУРАВДАХЬ ШӨНӨ】

БОРООН ДУНДАХЬ ГАЗАР ХАГАЛАЛТ

ДУУЛЫН ХӨНДИЙН ҮЗЭМЖ

Оддын дундахь саран авхайн бүгээн гэрэл шингэж, өглөөний наран зугуухан мандах гэгээн өглөө, уулын амны номин ногоон зүлэг нүд баясган гэрэлтэнэ.

Зуун цэцэгс нарны дулаан өвөрт тааламжтай нойрссоор. Навчсын чөлөөний шүүдрийн дуслууд бөнжигнөн гялтганах нь ухаант бяцхан анахай нар дүрсгүйтэн тоглож байгааг санагдуулах ажээ.

Хаврын урин амьсгал нарны гэрлийн тусламжтайгаар өвлийн амьсгалыг үлдэн хөөж, хээрийн ногоо дуу дуугаа авалцан ургахад, урамшин баяссан олон хэлийн шувууд баярлалдан шулганалдана.

Нэг л мэдсэн байгаль дэлхий өвлийн гүн нойрноосоо өндийн сэрсэн нь энэ бөлгөө.

“Нирррр. . .Нирррр” хэмээх аянгын дуу, нүд гялбам хурц цахилгаан уулын амыг нэлэнхүйд нь цочоов. Залгуулаад нөр бороо шивэрснээр хүйтэн өвөл холдон одлоо. Энэ жилийн анхны аянга байгаль дэлхийн түмэн бодист хаврын улирал хаяанд ирлээ шүү гэдэг мэдээг зарлан тунхаглалаа. Хаврын

бороо эх газрыг дэвтээн ундаалснаар, зуун цэцгийн үр соёолон ургаж байгалийн шинэ гоёлыг сольж өмсгөв.

Өглөөний наран өөдлөн мандаж, түмэн цацраг нь уул усны үзэмжийг чимэхэд, уудам хөх огторгуй санаа сэтгэл уужрам мэлтийгээд, борооны дараах солонго тэнгэр газрын хооронд долоон өнгийн гүүр байгуулж, дүрсгүй шүүдрүүд тоглож ханасан бололтой түүгээр дамжин үүлсийн ордон руу зорчжээ.

Наран мандаж саран шингэх тоолонгоор, соёолон цухуйсан өнгийн цэцэгс өдөр шөнийн алинд ч зогсолтгүй урган төлжсөөр байх ажээ.

(Тунгалаг өглөө шүүдрийн дуслууд хаврын салхийг өдөөн дуудаж, тал хээрийн өвс ногоог нойроос нь сэрээлээ.
Өвс ургамлууд бие биесийн амар мэндийг айлтган, байгаль дэлхий амилан сэргэв.)

Наран гүнтэн: Хэ хэ ! Та бүхэн сайн байна уу?

Ургамлууд: (Эвшээн суниагаад) Наран гүнтний өглөөний амгаланг айлтгая !

Ваа ! Өнөө өглөө таны илч гэрэл хичнээн тааламжтай сайхан байна вэ?

Байз ! Уулын амны тэртээгээс салхин хонгор бүсгүйн хөлийн хөнгөн алхаа ирж яваа чимээг сонсов уу?

Тэр лав бидэнд сайхан мэдээ дуулгахаар яарч байгаа нь ойлгомжтой.

(Ургамлууд бүгд чих тавин сонсоцгооно.)
 Салхин хонгор бүсгүй: (Холоос ойртон дуулах чимээ)
 Урьд шөнө ичингүй зүүдэнд умбаад
 Ургах нарнаар нулимс мэлтрүүлэн сэрлээ
 Удган уулын усан бороог яалтай
 Ужигран салахгүй нисваанисыг ч мөн яалтай

Хаврын шүүдэр шиг залуу нас богинохон
 Хагдран унах навчны гуниг гаслантай
 Үеийн үед зулгаран унах тавилантай
 Өдөр шөнөгүй түүний шалтгааныг эрэлхийлнэм

Урьдын дурсамж гэгээн сар шиг гэрэлтэй
 Усан бороонд угаагдавуу гэлтэй бүдгэрнэ
 Толинд туссан дүрсийг барья гэтэл
 Тортог шавар болон хувиргаад шаналгана.

Үзэгдэх өнгөний сайханд хууртаж бүү шанал
 Үүлгэр хаврын зүүдийг даруй түргэн дуусга
 Үзэгдэх өнгөний сайханд хууртаж бүү шанал
 Үүлгэр хаврын зүүдийг даруй түргэн дуусга

Санах бодох юмгүй буцсан нь дээр
 Салхи хөлөглөн гэртээ харьсан нь дээр

(Тал хээрийн зуун цэцэгс хаврын салхины дуулах дуунд уяран дохилзон найгахад, Юэгуан Тунз алжаасан байдалтай уулын аманд хүрч ирэв.)

Юэгуан Тунз: Хүүе, энэ уулын амны үзэмж хичнээн үзэсгэлэнтэй сайхан харагдана вэ? Энэ яруу цээлхэн дууг хэн дуулна вэ? (Ийш тийш харсанаа) Хүүе, хэн дуулаад байна вэ? Са Юнь багш аа, Са Юнь багш аа !

(Дуулах чимээ намжина) Са Юнь багш аа, та дуулсан уу? Хүүе, хүн байна уу?

(Хариулах хүн байхгүй. Юэгуан Тунз ийш тийш хайсан боловч хэнийг ч олсонгүй тул их л гонсгор байдалтай хөгшин нарсны дорх нэгэн хад чулуун дээр суугаад, ядарсан тул удалгүй унтаад өгөв. . . . Энэ үеэр эх газрын ургамал ногоо дахин амилан сэргээд ирэв.)

Наран цэцэг: (Тэсэж ядсан байдалтай) Салхин хонгор бүсгүй бидэнд шинэ ногоон торгон хувцас өмсгөчихөөд, яаруу сандруу яваад өглөө. Аягүй бол өөр газар очиж шинэ хувцас эсгэхээр яараа байлгүй дээ. Одоо түүний хөлийн чимээ бүр тасраад сонсогдохоо байлаа.

Мушгирмал арц: Тийм шүү ! Цаг агаар улам бүр халуу шатаж эхлэх нь ! Тэр нуурын мандал дээгүүр зуны лянхуа цэцэг дэлгэрсэн байгааг та бүхэн харж байна уу?

Ичингүүрт цэцэг: (Их л дуу шуутай) Тийм байна. Үзэмний мод хүртэл үрэл ногоон, хүрэн улаан жимсээ

бөнжийлгөжээ.

Хөгшин нарс: Би уг нь өвлийн хүйтэнд ажирдаггүй атал, зуны халуунд л байж ядаад байдаг юм даа ! Харин наранцэцэг чи надтай адилгүй, халуун байх тусам улам сайхан ургах юм. (Энэхүү магтаалыг сонсоод наранцэцэг их л тааламжтай байгаа бололтой. Дэргэд нь байгаа ичингүүрт цэцэг өөрийн улаан өнгийн бөмбөлгөө засаж янзлан толгойгоо өргөв)

Ичингүүрт цэцэг: Хэлээд яах билээ? Энэ айхтар халуунд дотор балартаж байтал, азаар зангууд өвс эгч л намайг овоо халхлаж сэрүүцүүлэх юм. Эс бөгөөс би хариугүй амь тавих байлаа шүү.

(Наранцэцэг доош тонгойн ичингүүрт цэцгийг харав.)

Наранцэцэг: (Гайхсан байдалтай) Нээрэн тийм байна шүү ! Ичингүүрт цэцэг дүүгийн ногоон өмсгөл хариугүй онгож гандах нь. Зангууд өвс дүү ч өөрийгөө яая гэж байгаа бололтой, тийм болохоор ичингүүрт цэцэг чи мушгирмал арцны нөмөр нөөлөгт багтсан нь дээр.

Зангууд: Би рашаан хурын амтат шимийг хичнээн их үгүйлж байна вэ?

Ургамлууд: (Нэгэн зэрэг) Бид нар ч мөн өөрцгүй.

(Ургамлуудын ийн хэлэлцэж байх зуур Юэгуан Тунз нойрноосоо сэрэв. Тэр ийн шуугилдах чимээг сонсоод их л гайхаж, сайтар ажиглан харваас ургамал ногоо ийн ярилцаж байх ажээ.)

Юэгуан Тунз: (Гайхах баярлах хослуулан) Хүүе ! Нарс мод, мушгирмал арц, наранцэцэг, зангууд өвс та нар чинь яахаараа хоорондоо ярьж байдаг билээ? (Тэгснээ нэлээд цэнэсэн байдалтай) Та нар чинь арай, аршууд биш биз дээ?

Ичингүүрт цэцэг: (Намуухнаар) Нарс өвөөгийн сүүдэрт унтаж байсан хүн сэрчихлээ.

(Тэр айсан бололтой навчаа хумихад, наранцэцэг, зангууд өвс хоёр ч их л сандарсан байдалтай үзэгдэв.)

Юэгуан Тунз: (Их л ёсорхуу) Та нар сая ярьцгааж байсан уу? Сая та нар ярьж байсан уу?

(Хөгшин нарс хоолойгоо засаад, их л тайван дөлгөөнөөр хариу өгүүлрүүн)

Нарс: Тэнгэр газрын хоорондох түмэн бодис бүгд л үг ярианы чадвартай байдаг юм шүү дээ ! Харин түүнийг ихэнх хүмүүс сонсох чадваргүй байдаг.

Юэгуан Тунз: Яахаараа сонсож чаддаггүй билээ?

Нарс: Яагаад гэвэл тэд нарын зүрх сэтгэл ертөнцийн хэрэг явдал, элдэв бодолд хучигдсан байдаг болохоор тэр юм. Харин чи бидний яриаг сонсож чадаж байгаа чинь харин их гайхалтай хэрэг байна.

Юэгуан Тунз: (Их л баяртайгаар) Өө !

Мушгирмал арц: (Намбатайгаар) Чиний үг яриа зөөлөн яруу болохыг үзвээс, цэвэр ариухан сэтгэлтэй хүн бололтой. Тийм болохоор чи бидний яриаг ойлгож байгаа хэрэг.

(Наранцэцэг зэрэг бусад ургамлууд ч тайвшраад, ичингүүрт цэцэг ч навчаа зугуухан дэлгэлээ.)

Наранцэцэг (Эрх хонгор дуугаар) Нээрэн тийм шүү ! Олонх хүмүүс бидний үзэсгэлэн гоог таашаах гэж гэртээ аваачин тавьж байгаад, удалгүй гаргаад хаячихдаг тул бид усгүйдэж гандахад хүрдэг.

Зангууд өвс: (Үгийг нь таслан) Тэд биднийг таслан гэртээ аваачихаар явахад бид ч дургүй байдаггүй л дээ.

Ичингүүрт: Яг үнэн ! Тэд нар бусдыг хүндэтгэнэ гэж огт үгүй. Бидний дээрээс хөлөөрөө хайр найргүй гишгэхэд хичнээн их өвддөг гэж санана вэ !

Юэгуан Тунз: (Ичингүйрсэн байдалтай) Нээрэн тийм байдаг гэж үү дээ? Тэгвэл үнэхээр уучлаарай ! Бид байгаль дэлхийн амьтай болгоныг нандигнан хайрлаж байх учиртай юм байна.

Нарс: (Уясангуй) Хэрвээ хүн болгон ийм бодолтой байдаг бол байгаль дэлхий маань цаг ямагт өнгөжин жавхаажиж байхсан даа !

Мушгирмал арц: Ингэхэд чи яахаараа энэ эзгүй зэлүүд уулын аманд хүрээд ирдэг билээ?

Юэгуан Тунз: Би уг нь хэсэг нөхдийн хамт Са Юнь нэрт багшийгаа дагалдан домогт өгүүлдэг амь насны нандин эрдэнийг олохоор олон он жилийн турш, газар сайгүй хэрэн хэсэж яваа хүн л дээ. Өчигдөр шөнө бид нэг том давааг

арайхийж даваад, өглөө бостол би манан дунд нөхдөөсөө төөрч орхилоо. Тэгээд явж байтал энэ газар хүрээд ирлээ. (Горьдлого төрсөн бололтой) Та нар харин манай нөхдийн хаана байгааг мэдэхгүй биз дээ?

(Ургамлууд бүгд толгой сэгсрэв)

Нарс: Манай энэ уулын ам маш нууцлаг болохоор хэр баргийн хүн олоод ирж чаддаггүй юм л даа.

Юэгуан Тунз: (Сандарсан байдалтай) Тэгвэл одоо яадаг билээ? Энд чинь өндөр оргилууд сүүхийлцэн, гол горхи сүлжилдсэн болохоор би тэднийгээ яаж шүү олно доо !

Мушгирмал арц: (Аядуу дуугаар тайвшруулан) Бүү санаа зов доо ! Бид газар сайгүй хэрэн хэсэж явдаг салхин хонгор бүсгүйгээс танай нөхдийн сураг ажгийг мэдээд өгч чадна. Тэр бидэнд цаг ямагт шинэ сонин мэдээ дуулгаж байдаг болохоор тэдний барааг харсан байж ч мэдэх юм.

Юэгуан Тунз: (Хийморь цог нь сэргэж) Ямар сайн хэрэг вэ? Тэгвэл тэр салхин хонгор бүсгүй чинь хаана байгаа юм бэ?

Наранцэцэг: Өглөөхөн манай энүүгээр дуулж бүжиглэж байгаад явсан. Харин одоо аль газар уул усны үзэмжийг таашаан явааг мэдэхгүй.

Юэгуан Тунз: Аа мэдлээ. Намайг ирэхэд хэн нэгэн яруу тунгалаг хоолойгоор дуулж байсан юм. Тэр лав нөгөө салхин хонгор бүсгүй байх нь. (Нааш цааш холхисноо) Тэр одоо дэлхийг тойрон тэнүүчлэн яваа байлгүй. Хэзээ наашаа ирэх вэ?

Нарс: Бүү бачимдагтун ! Тэр удахгүй эргэж ирэх цаг болсон. Тэр манай энд сэтгэл татагдаад байдаг юм. Яагаад гэвэл

Ичингүүрт цэцэг: (Ярианд оролцон) Яагаад гэвэл тэр эндээс холдох болгондоо гадаад ертөнцийн тоос тортогт хувцсаа муухай болгочихсон байдаг юм

Зангууд өвс: (Сүүрс алдан) Энэ айхтар халууныг ээ ! Би хариугүй амь тавих нь байна шүү !

Наранцэцэг: (Толгой бөхийлгөн) Хэлээд яахав ! Би хүртэл хэцүүдэж л байна шүү !

Ичингүүрт цэцэг: (Хоолой сөөнгөтөн навчаа хумиад) Ядаж энэ залуутай үг хэлэлцсээр ядарч гүйцлээ байна.

Зангууд өвс: (Тамирдсан байдалтай) Рашаан хурын ариун үүлс манай үүгээр хавьдаа үзэгдсэнгүй, манийгаа мартчихаагүй л байлтай !

Нарс: (Бодолхийлэн) Хачин юм даа ! Рашаан хурын ариун үүлс биднийг үгүйлэн санагалзахын зуур л үд өнгөрөлгүй хүрээд ирдэгсэн. Гэтэл өдий болтол яагаад сураг чимээ алга байна вэ?

(Нар улам бүр халуунаар төөнөхөд, уулын амны ургамал ногоо бүгд нозоорсон байдалтай дуугаа хураачихав.
 .Юэгуан Тунз өвс модод бүгдээрээ дуу шуугүй болохыг үзээд нөгөө хадан дээрээ эргэн суулаа.)

Юэгуан Тунз: (Өрөвдсөн байдалтай) Энэ халуун нар өвс ургамлыг хуйхлах нь дээ. Хэрвээ дахин хэд хоног бороо

орохгүй бол цэцэг ногоо л хамгийн түрүүнд хатаж гандах байх. (Ухасхийн босоод) Ер нь жаахан ус олж ирээд тэднийг услая байз !

(Гэнэт салхи исгэрэн шуугихад өвс ногоо бүгд халиуран ганхлаа.)

Салхин хонгор бүсгүй: (Аядуу зөөлнөөр) Алив ! Бороо ах, рашаан хур эгч наашаа ирээрэй !

(Удаж төдөлгүй уулын салхины аясаар уулын ам тэр аяараа үүл мананд хучигдан бүрхэгдлээ. Аянга нижигнэн дуугарч, түм буман бороон дуслууд асгаран орж эхлэх нь тэнгэрийн дагинасын бүжиг гэлтэй нүд баясгана. Наранцэцэг, ичингүүрт цэцэг, зангууд өвс болон бүхий л өвс цэцгүүд, рашаан хурын шимийг амтлан цэнгэж, хөхин баясаж үзэгдэв. Хөгшин нарс, мушгирмал арц зэрэг том модод энэ үеэр мөчир намаагаа дэлгэн, сүр жавхаагаа гайхуулан ханхайгаад, биедээ тогтсон тоос тортгийг угаан ариусгаж, хурын усыг үндсээрээ ханатал шимэх ажээ. Юэгуан Тунз ч гэсэн ургамал ногооны сэргэн баясахыг үзээд, борооны усанд тэсгэлгүй гар хөлөө гозолзуулан бүжив.)

Наранцэцэг: (Баясгалантайгаар) Нарс өвөө та одоо сайхан сэрүүцэж байна уу?

Нарс: Хэ хэ ! Хэлээд яахав ! Рашаан хур сэтгэлийг ариусган гийгүүлж, дахин төрсөн мэт л баяртай байна шүү. Би энэ удаа ширхэг борооны дуслыг хүртэл гарзадахгүй эрдэнийн

авдартаа нөөцлөж байгааг харж байна уу?

(Ичингүүрт цэцэг хоёр гараа дэлгэн хурын усыг хураан авах зуур, өвгөн нарс мушгирмал арц хоёр руу хараад)

Ичингүүрт цэцэг: (Уян зөөлнөөр) Мушгирмал арц ах аа, та яахаараа нарс өвөөтэй адилхан рашаан хурын шимэнд тэгтэл шүлэнгэтэж байдаг юм бэ? Зангууд өвс эгч бид хоёрт хэдхэн дусал байхад л хангалттай. Зангууд өвс эгч одоо хийморь жавхаатай болчихоод гялалзаж байгааг хар даа !

Мушгирмал арц: (Эелдгээр) Бидний үндэс харилцан адилгүй болохоор хур борооны хэрэгцээ ч өөр өөр байх нь аргагүй ээ !

Нарс: (Хөгжилтэй) Рашаан хур ариун үүлс гэдэг бидний хувьд энэрэлт эцэг, элбэрэлт эхээс өөрцгүй, цаг ямагт арвин шимээ алагчлалгүй хайрлаж байдаг болохоор бид савныхаа хэмжээгээр шингээж авахаас бус яалтай билээ.

Зангууд өвс: (Их л сүслэнгүй) Тийм шүү ! Хэн болгоны хүсэл санаа өөр өөр боловч тэр болгоныг ариун үүл ах, рашаан хур эгч нар гүйцэлдүүлж байдаг.

(Бороон дунд зогсчихоод ургамал ногооны ийн хүүрнэлдэхийг сонсож байсан Юэгуан Тунз улам ч гүнзгий ухаарал төрөх шиг санагдав.)

Юэгуан Тунз: (Аман дотроо) Аадрын үүлс ариун хурын шимээр эх газрыг тэтгэхэд түмэн бодис өөр өөрийн хэрд тааруулан хувь хишгээ хүртдэг байх нь ээ.

(Нарны гэрэл үүлэн цаанаас цухуйн эх газрыг дахин гийгүүлэхэд, түм буман шаа торгоны ширхэг шиг хурын борооны дуслууд татрав. Шимт хөрс тоо томшгүй олон амийг тэтгэснээр, түүний ачлалд гялайсан ургамал ногоо улам ч үзэсгэлэнтэй ногоон өмсгөлөөр түүнийг гоёлоо. Зуун цэцэгс өнгөө гайхуулан алаглахад, атар хээр талаар хөгжилтэй анахай нар хөөцөлдөн наадна. Энэхүү ер бусын үзэмжийг үзээд Юэгуан Тунз бахдан дуу алдлаа.)

Юэгуан Тунз: (Догдлонгуй) Аяа, төөргийн эрхээр ирж, төөргийн эрхээр буцдаг рашаан хур байгаль эхийг ийнхүү баясган цэнгээдэг байх нь ээ ! Эгээ л газар эх түүний амь амьдралын салшгүй хэсэг мэт. Тэр өдөр шөнөгүй энэ л хэсэг газрыг марталгүй тордон услаж байдаг нь ямар гайхалтай вэ? Газар дэлхий дээрх амьтай бүхэн өөр өөрийн мөн чанар, хэрэгцээтэй байдаг юм байна шүү дээ !

Мушгирмал арц: Тэгэлгүй яахав ! Тэнгэр газар, ариун хурын үүлс бүгд дув дуугүй амьтныг алагчлан үзэхгүй нигүүлсэх эрдэмтэй болохоор, бүгдэд хувь тэнцүү хишгээ харамгүй хүртээж байдаг юм.

Нарс: Харамсалтай нь тэнгэр газрын хоорондохь амьтай бүхэн бие биеэс салшгүй хамааралтай оршиж, биедээ биеийнхээ оршин байх нөхцлийг бүрдүүлж, тэр хэрээр өөрөө хөгжин дэгжих боломжтой байдгийг ойлгодог хүн маш цөөхөн байх юм даа.

(Юэгуан Тунз гүн бодолд автах зуур агаар тэнгэрээс сүрлэг
яруу хоолойн ийнхүү дуулах сонсогдов.)

Найрал дуу:

Өдгөө миний номын дууг сонссон хамаг амьтан
Өөр өөртөө тохируулан хүртэж, тус тусын оронд оршицгоо
!

Хүмүүн болон тэнгэрийн оронд орших эс бөгөөс
Хүрд эргүүлэгч Загарвардийн хаан болох нь бага эмийн өвс
болой

Ариун цуврилгүй номыг сонсож нирваанд хүрэх
Аль эсбөгөөс Брадигабудын сууринд дэвших нь дунд эмийн
өвс болой
Ялж төгс нөгцсөн сууринаа хүрч Бурхан болох
Ялгуусан хичээнгүй самадигаар явах нь дээд эмийн өвс
болой

Харилтгүй хүрднийг эргүүлэн Рид хувилгаанаа амгалан
оршиж
Хамаг амьтныг гэтэлгэх нь том модон мөн
Тэгш өгүүлэхүй Бурханы номлол рашаан хураас өөрцгүй
Тэтгэгч шимийг нь хүртэн өөрийн хүчиндээ тохируулан
суралц

Энэ нь зүйрлэвээс эмийн өвс, мод бут бүгдээрээ
Их бага харилцан адилгүй ч эрх дураар өтгөн ягч болдогтой
адил

(Ургамал ногоо, өвс цэцэг бүгд энэ дууны аялгуунд баясан
бүжиглэнэ. Юэгуан Тунз тэдний дундуур хөөрөн сүлжиж,
дууг даган дуулав.

Аялгуу дуусах үеэр, алсаас “Юэгуан Тунз аа !”, “Чи хаана
байна вэ?” хэмээн дуудах дуу сонсогдоно.)

Юэгуан Тунз: (Баясгалантайгаар) Энэ чинь Са Юнь багш уу
даа? (Дуу гарсан зүг рүү хандан) Са Юнь багш аа ! Би энд
байна аа ! Та нар хаана байна вэ?

(Юэгуан Тунз хашгирах чимээ гарсан зүг рүү гүйх гэснээ
алхаагаа татан, ямар нэгэн юм санасан бололтой, эргэж
хараад ургамал ногоонууд руу гараа даллангаа. . .)

Юэгуан Тунз: Нарс өвөө, мушгирмал арц ах болон
наранцэцэг, зангууд өвс, ичингүүрт цэцэг та бүхэн надад
ийм нарийн нандин зүйлсийг зааж ойлгуулсанд их баярлалаа.
Би одоо Са Юнь багш, бусад нөхөд дээрээ очихоор явъя даа !
Баяртай !

Ургамлууд: Баяртай ! Замдаа сайн яваарай !
Хөшиг хаагдана.

17 23

ХОРИНЫ ӨДӨР

ГОРХИЙН УРСГАЛ

Тунгалаг горхи цэлмэг тэнгэрийг тольдоод, хоржигнох ус холхи огторгуй хоёулаа гүн хөх харагдмуй. Үүлэн чанадаас нисэн ирсэн ганиц хээрийн галууны дүрс горхин цээлд тусаад хэд эргэлдэж байснаа алга болов.

Тэнгэр газрын хооронд түмэн бодис, түмэн үзэгдэл саяын горхинд тусдаг өнчин галуу лугаа адил аяндаа үүсдэг. Орчлон хорвоо, эх байгаль дэлхий гэдэг үнэн хэрэг дээрээ үсэг бичиггүй тэнгэрийн ном бөгөөд нэжгээд өвс мод, ганиц нэгхэн цэцэг ногоо гээд бүгд л түүний уран бичиглэл байдаг ажгуу.

ГОРХИЙН УСНЫ ХҮҮРНЭЛ

Хөдөөгүүр намрын ургацын дараахь тариан талбай шаргал өнгийн тост ногооны цэцэгсээр битүү хучигдаад, өргөн талыг зүсэн урсах горхи л урьдын адил амсхийх чөлөөгүй хоржигноно.

Энэхүү сэрүүн тунгалаг горхи улирлын амьсгалд зохицон урсахдаа хээр талыг ундаалж, тутрагын хөх чих хавар соёолох, зун өсөж төлжихөд ч дэм болж байдаг билээ. Тутрагын түрүү боловсорч гүйцэх үеэр ч гэсэн горхийн усны алхаа татрах шинжгүй урссаар л

Абог төрж мэндлэхээс ч бүр өмнө энэ гол эрх дураараа тахиралдан мушгиралдан урссаар л байсан байж таарна.

Ариун тунгалаг горхи арвин баян хөрс шороо тарчиг ядуу тосгоны амьдрал ахуйг өөд татан өдий зэрэгтэй болгосон юм. Або ч мөн хоржигнох булгийн устайгаа цуг хорвоо дэлхийг туулсаар өдий хүрчээ.

Өдгөө наян намрын нүүр үзсэн Або сэтгэл санаа өөдрөг үедээ горхийн эхийг өгсөн уруудан явж ойр орчмын байгалийн үзэмжийг таашаах дуртай. Учир нь тунгалаг горхийн үзэсгэлэнт долгисын дунд тэр өөрийн амьдралын зурвас үеүүдийг олж харах шиг болдог юм.

Энэ өдрийн нарлаг өглөө Або Шидөгөө аваад уд модон

төглийг дайран өнгөрөхөд, салхины сэрчигнээнд мөчрөөс гөвөгдсөн шүүдрийн дуслууд гялтганан унах нь сэтгэлд нэн тааламжтай ажээ. Өглөө нарны туяан дор тэр хоёр горхийн эх өөд өгсөн явжээ.

Хоёр талаар нь уянгат мод битүү ургасан горхийн цээлд загас жараахай наадан ус үсчүүлнэ. Энэхүү дураар наадах загасан заарцгийг хараад Або өөрийн эрхгүй бага залуугийн явдлыг саналаа.

“Би бүр хүүхэд ахуй цагтаа энэ горхийн усанд үсрэн ороод жараахайнуудтай тоглох дуртай байж билээ. Тэр үед бодож санах юмгүй яасан ч сайхан байгаа вэ дээ.” хэмээн Або амандаа бувтнах нь өөртэйгөө ярьж байгаа аль эсвэл мөрөн дээрээ тавьсан Шидөд хэлж байгаагийн аль нь болохыг бүү мэд.

Ийн явсаар уянгат модон төглийг өнгөрөн явав. Уулын байдал улам хэвцэг байц болоход эргэн харваас горхийн хажуугийн төгөл ой сэтгэлд улам ч бүгээн санагдав. Горхийн ус уулын энгэр өөд өгссөн өтгөн шигүү балар ойгоос эх авдаг ажээ. Энэ үед нар бүр дээш хөөрөн мандсан үзэгдэнэ. Бүтэн жилийн турш ой шугуйгаас эх авдаг горхийн ус ер бусын цэнгэг ариун харагдана. Хайрга чулуунд ойн цацлах цагаан хөөс агшны төдийд үзэгдээд өнгөрөх бадма лянхуа цэцгийг санагдуулав. Жалга судаг бүрээс эх авсан нарийн судлууд нийлэн нэгдсэн энэхүү үзэсгэлэнт горхи ийнхүү

үсчин тонгочсоор уулын амыг өнгөрүүт эх газрыг ундаалах амин гол болон хувирах ажээ.

“Шидө чи хар даа ! ” хэмээн Або ойролцоох нэгэн том чулуун дээр суунгаа горхийн урсгал, жараахайн сүргийг харсаар байлаа.

Жин үдийн үест хоржигнох горхийн усан торгон долгис хаялан мяралзан урсахдаа нарны туяаг ойлгох тул цэхлэж удаан харж боломгүй байдаг аж. Хэсэг хугацаанд энэ тунгалаг горхид загас жараахайн ул мөр татраад байсан бол эргээд дахин үзэгдэх болж тааваар чөлөөтэй заарцаглан хөвөхийг хараад насан багын дуртгал Абогийн сэтгэлийн мухарт тодхон санагдлаа.

“Энэ булгийн ус ямар нэгэн зүйлийг хүүрнэн өгүүлэх гээд байх шиг санагддаг юм. Хэдэн ч удаа би түүний өгүүлэхийг хариугүй ойлгох нь уу даа гэтэл сэтгэлд өөр бодол төрөөд тэр сайхан мэдрэмжийг үгүй хаячихсан юм даг.” Хэмээн Або цаасан шувуу Шидөд харамсал догдлол хослуулан хэлэв. “Або чиний мэдрэмж ямар хурц юм бэ ! Наад горхи чинь бидэнтэй үнэхээр хүүрнэн ярьж байна шүү дээ ! Чиний сэтгэлийн хэмнэл тэнгэр газрын амин лугшилт лугаа их ойр дотно болохоор эх байгалийн далд хүчийг мэдэрч чаддаг. Тийм болохоор чи түүний өгүүлсэн болгоныг ойлгоно гэдэгт итгэж байна гэнэ ээ ! ”

“Нээрэн гэж үү дээ?” Шидө, өө би нээрэн чамайг горхийн үг

хэлийг ойлгодог гэдгийг мартчихсан байна. Ямар сайн хэрэг вэ? Даруйхан наад горхийнхоо өгүүлж байгаа болгоныг надад дамжуулан хэлээдэх !” гэж Або түүнийг хүүхэд шиг шавдуулав.

Абогийн магтаалд маадайсан Шидө горхийн мандал руу ойртон ирсэнээ годройтон эргэлдэх тэрхэн агшинд горхийн мандал дээгүүр түм буман алтан долгис мяралзана.

“Або балар өтгөн шугуйгаас эх авсан горхийн ус тэнгэрийн сүүн голын хүү нь мэт санагдахгүй байна уу? Тэр хавь орчны түмэн бодисыг ундаалахын тулд өндөр уулын жалга судаг бүрийг сүлжин, сая өргөн талтай золгодог. . . .”

Үдээс хойшхи нөөлөг салхины аясаар дэрвэн нисэх Шидө горхийн намуухан хүүрнэх үгсийг Абод хөрвүүлэн ярьснаар урьд өмнө дуулж мэдээгүй олон нарийн нандин нууцсыг ойлгожээ. Түүнийг эрэг хавийн юмс дамжуулан хүүрнэнэ. . .

Хүний гар хөндөөгүй балар өтгөн ой шугуйгаас эх авсан горхийн усанд олон сүрэг загас жараахай он жилийг элээн жаргалтай сайхан амьдарцгаадаг ажээ.

Нэгэн удаа хэд гурван салтаа нь онгорхой өмдтэй бяцхан жаалууд ээж нарынхаа хамт талын энгэрийг зүсэн урсах энэ томоохон горхин дээр хүрч ирсэн гэнэ. Ёроол нь гэрэлтэн харагдах энэ тунгалаг горхийн дэргэд ээжүүд хувцас хунараа угаахад, бяцхан жаалууд загас жараахайтай

хөөцөлдөн, ус цацлан тоглож гарчээ.

Хүүхдүүдийн гэнэн томоогүй зан жараахайнуудын сониуч занг өдөөн, хөлийн шилбэ, эрээн булчинг ирвэгнүүлэн өнгөрөхөд жаалуудын гижиг хүрч баясан хөхрөлдөнө.

Тэдний наадам зугаанд эрэг дагуу ургасан мод, цэцэг ногоо атаархангуй янзтай салхинд нахилзахад, горхийн ус жишим ч үгүй тайвуу урссаар байх ажээ.

Нэгэн зуны улирал мөнөөх хөл нүцгэн жаалууд их л өсгөлүүн болсон байлаа.

Хөгжилдөн сүлжилдэх хөөрхөн загас жараахайнуудыг хараад, том жаалууд хэсэг алмайран зогсов. Бодож санах юмгүй жараахайнууд урьдын адил тэдэнтэй тоглох гээд хөлийг нь гижигдэн өнгөрөхөд, хүүхдүүд тэдний найрсаг сэтгэлийг ойшоосонгүй, гараа сунган барьж авах гэж оролдсоноо эргийн дээрээс мод чулуу олж аваад тэдэн рүү хайр найргүй шидэж, хэн нь мундаг оносноо гайхуулж эхлэлээ. Тэдний маадгар инээд, бүдүүлэг авирт цочин айсан жараахайнууд ум хумгүй чулууны ан завсраар шургаж нуугдлаа. Тэрхэн зуур ойр орчмын төгөл ой амгалан бус байдалд автаж, харин горхийн ус юу ч болоогүй мэт мэлмэрэн урссаар.

“Ёстой л ойворгон бага нас гэж тэр байх даа ! ” хэмээн Або сэтгэлдээ бодруун “Ай ! Өсөх багын сэтгэл яахаараа эзэрхэг тэрслүү байдаг юм бол доо?”

Цаг хугацаа урсан өнгөрөхийн хэрээр мөнөөх жаалууд сайхан залуус болцгоосон байлаа. Харин тэдний сэтгэл дэх өлөв долов зан нь улам ихсээд байгалийн сайхныг таашаах хүсэл унтарчээ.

Нэгэн зун тэд энэ горхинд анх тор тавьсан юм.

Тэгсээр тэд энэ дондоо улам автан болдогсон бол горхийн бүхий л загас жараахайг торондоо хуу хаман барих хүсэл оволздог боллоо. Хөөрхий загас жараахайнууд харсан зүгтээ ханаран зугатснаас нэг хэсэгтээ л тэдний ул мөр нэгээхэн бээр ч үзэгдэхээ больсон ажээ. Залуус горхийн хайрга чулуу нэг бүрийг эргүүлэн үзээд ганц ч загасны бараа олж хараагүй тул их л гонсгор холдон явж билээ.

Горхийн булингартай ус эргэж цэвэр тунгалаг төрхөндөө ороход, айж бэргэсэн жараахайнууд горхиноос их л харуусангуй байдалтай ийн асууруун:

“Горхи минь ! Саяын залуус саяхан л бидэнтэй тоглож нааддаг байсан гэнэн хонгор жаалууд байсан сан ! Гэтэл хэдий завандаа ийм муухай түрэмгий зан сурчихдаг байна вэ?”

“Жараахайнууд минь ! Дээш өлийгөөд тэнгэрийг нэг харчих ! ” гэчихээд горхи урьдын адил намуухан урссаар байлаа.

Хязгааргүй цэлийх амгалан хөх тэнгэрийн уудам амгалан гэгээн мандлыг харахад, жараахайнуудын айдас эргэлзээ туугдан үгүй болов.

Гэнэт үүлэн чанадаас нисэн ирсэн ганц хээрийн галууны дүрс горхин цээлд тусаад хэд эргэлдэх нь уран бийрийн идэт татлагыг санагдуулна. Тэр ийнхүү горхийн мандалд хэдэн үсэг дурайлган татлачихаад ирсэн лүгээ адил дээш шунган нисэж үүлэн чанадад үзэгдэхгүй алга болов.

“Жараахай минь ! Чи саяын үүлэн чанадаас нисэн ирсэн өнчин галууг харав уу? Тэр тэнгэрийн мандалд ямар сураг чимээ хүргэн ирснийг мэдэж байна уу?”

Жараахайнууд горхийн ийн асуухыг сонсоод, дахин тэнгэр өөд өлийн харахуйд, саяын ганц галуу тэдний дээгүүр эргэлдэн нисэхдээ чухам юуг бичиглэн үлдээсэн болохыг ултай бодолхийлнэ.

Тэгээд жараахайнууд удаж төдөлгүй чухам юу хэлэх гэснийг ойлгожээ.

Тэрхүү баяр жаргал, цэвэр ариуныг бэлгэдэх уран нислэг цээлийн жараахайнуудыг урьдын адил тайван чөлөөтэй амьдралд нь уриалан дуудсан хэрэг байлаа.

Горхийн усан намуухан урссаар л

Горхийн ийн хүүрнэхэд Шидө бүр автаж гүйцээд, харин Або өөрийн эрхгүй толгой өргөн, тэнгэрийн хөх мандлыг харлаа.

“Энэхүү хөх огторгуй миний залуу зандан цагийнхтай эгээ л ижил гүн хөх, цэвэр ариун чигээрээ харагдана. Аяа ! Тэнгэрийн мандал, горхийн цээлд цаг хугацааны туулаад

өнгөрсөн ул мөр үлдээгүй байтал харин миний биед тодоос тод үзэж болохоор байдаг байна шүү”

Ийнхүү бодлогоширон зогсоход Абогийн санаа бодол алсран одож, чихний хажууд сонсогдох горхийн хоржигноон бүдэгрээд ирэв.

“Або чи харж байна уу? Тэнгэрийн мандалд саяхан горхийн өгүүлж байсан өнчин галуу дахин гараад ирлээ.” хэмээн Шидө дуудахад сэхээ орон үзвээс, үнэхээр нэгэн өнчин галуу цэлмэг хөх огторгуйд хэдэнтээ эргэлдсэнээ далавчаа дэвэн нисэн одлоо.

Өнчин галууны нисэн өнгөрсөн өндөр тэнгэрийг ширтэж, горхи жараахай хоёрын хүүрнээг бодолхийлэн зогсохдоо Або идэт бийрийн уран бичиглэл лүгээ адил саяын дүрс чухам ямар мэдээ сургийг авчирсан болохыг мэдэх хүсэл нь оволзоно.

Тэнгэрийн мандалд ганц галуу шувуу нисэн өнгөрөх алийг тэр гэхэв. Тэр болгонд түүний сэтгэл ингэтэл догдлон хөдлөж байсан удаагүй. Саяын галууны нислэг ямар учиртай болохыг сайтар тайлан ухаарч завдаагүй байтал Шидө түүнд горхийн хүүрнэлийг хөрвүүлэн сонсож эхлэжээ.

Цаг хугацаа урсан өнгөрөхийн хэрээр залуус нэг л мэдсэн нас тогтсон эрчүүд болцгоосон байлаа. Тэд горхин дээр буцаж ирэхдээ, загас жараахай барих элдэв зүйлийн арга сурсан

байжээ. Тухайлбал усыг боох, усан цахилгаан утас оруулах, тэр ч байтугай тэсрэх бодис хийж дэлбэлэх гэх мэт. Тэд усны эхээс адаг хүртэл энэ эх захгүй харгислалаа үйлдсээр эцэс сүүлд нь амь голтой зүйл бараг үлдээгээгүй юм.

Горхийн ус урьдын адил намуухан тасралгүй урссаар байвч усан цээлдээ дураар наадах загас жараахайг дахин олж үзэх аргагүй болжээ.

“Тэд нар мөнөөх л хөөрхөн жаалууд байсан атлаа яахаараа тийм харгис муухай зан сурдаг билээ?” хэмээн азаар амьд мэнд үлдсэн тоотой хэдэн жараахай горхиноос шаналангуй асууруун

“Орчлон хорвоогийн аяг араншин орвонгоороо өөрчлөгдөх нь энэ үү? Бидэнтэй л адилхан бусдад хоргүй байсан жаалууд яахаараа цаг хугацааны урсгалыг дагаад өөрийн ариун нандин сэтгэлээ хөсөр хаяна вэ?”

“Мөнх хөх тэнгэрийн уудамд өнчин галууны бидэнд хүргэж ирсэн сураг зангийг санагтун ! ” гэж горхийн ус тайвуухан хариулах ажгуу.

Жараахай горхийн хэлэх үгийг сонсоод толгой өлийлгөн үзэсгэлэнт хөх тэнгэрийг ширтэн харлаа.

Агаар тэнгэрт мөнөөх л өнчин галуу өөрийн биеийн уран бийрээр тодхон бичлэг татлагыг урлана. Шаналалд автаж гүйцсэн жараахайнууд түүний бичиглэлийн гүн нарийн санааг ойлгоод горхийн гүнд шунган сэтгэлийн зовлонгоо

түрхэн атугай ч умартжээ.

Он жил ээжлэн солигдохыг дагалдан хоёр эргийн уянгат мод хавартаа цэцэглэн, намартаа зулгарсаар.Айдас хүйдэст автаж гүйцсэн загас жараахайнуудаас урьд өмнөхтэй адил омог төгөлдөр байдлыг олж харалтгүй болжээ. Нэгэн санчиг буурал настан горхийн хөвөөнд хүрэлцэн ирэв.

Тэрбээр горхийн урсгалыг даган нэлээд явсаны эцэст загас жараахайнууд нүдний гэм болсныг үзэж ихэд гонсойжээ. Бага балчир насандаа жараахайтай хөөцөлдөн тоглож асан жаргалтай үеэ эргэн дурсаж, хэсэг зуур бэдрэн хайсан боловч, ой тойнд нь гүн бат шингэсэн загасан заарцгийн танил дүр, горхийн хөвөөгөөр унгиралтай хөөцөлдөх балчир жаахан жаалуудын төрхийг эргүүлэн сэргээх аргагүй болжээ.

Ийнхүү гансран байх зуур харалган ухааны харгайгаар найз нөхдийн хамт байгаль дэлхийтэйгээ ёс бус харьцаж байсан үйлдлүүд нь нүдэнд нэг нэгээр харагдах шиг болоход хөгшин хүмүүн түүний горыг сая л гүнээ ухамсарлан ойлгов.

Үүнээс хойш өвгөн тунгалаг горхийн загас жараахайнуудын хамгаалагч болон хувираад, эх адгийг өгсөн уруудан бөгцөгнөж явдаг болжээ. Тэр өдөржин горхийн хөвөөг сахин сууж, загас жараахайн амь ахуйн нөхцлийг ажиглан, ялангуяа түрсээ шахах, үржиж өсөх үед нь бүр ч илүү

санаа тавина.

Өвгөн ойр орчмын тосгон суурингуудаар тойрон явж, загасан сүргийг хайрлан хамгаалахын ач тусыг ухуулан таниулсаны хүчинд жил сар өнгөрөх бүр хүмүүсийн ухамсарт гүн бат шингээд, түүнийг дэмжин туслах болжээ.

Хэдэн жил өнгөрөхөд загасан сүргийн бүтэц дахин сэргэж, ёроолынх нь амьдралыг амилуулснаар горхи дахин уйтгарлахаа байжээ. Өвгөн өөрийн үр ач нарын хамт горхи дээр ирж загас жараахайтай наадан тоглуулахын зэрэгцээ байгалийн амь ахуйг хайрлан хамгаалж байх ёстойг зааж сургах болов.

Хүүхдүүдийн гэнэн цайлган инээд хөөр, өвгөний элбэрэл хайр шингэсэн дүр төрх горхийн амьдралыг цалгилуулах боловч жараахайнуудын сэтгэлд шингэсэн айдас эргэлзээ нэг л арилж өгөхгүй тул намуухан дуугаар горхиноос ийн асууруун:

“Үнэхээр ойлгомжгүй нэг зүйл байх юм. Гэнэн цайлган хүүхэд ахуй цагаас, ойворгон залуу үе, хувиа бодсон идэр дунд нас, тэгээд залгуулаад элбэрэл ачлалт өвгөн гээд бүгд л нэг хүн атлаа яахаараа тийм тэс өөр араншин илрэн гардаг билээ?”

Гүн хөх тэнгэр горхийн толь мэт тунгалаг мандал дээр тусахад, нэгэн үзэсгэлэнт дүрс түүний дээгүүр хэдэнтээ эргэлдсэнээ чимээ аниргүйхэн яваад өгөв.

Хээрийн галууны дүрс мандал дээгүүр нь чимээгүй нисэн өнгөрсөний дараа горхи жараахайнуудад хандан:

“Цэлмэг хөх огторгуйгаас хээрийн галууны бидэнд хүргэж ирсэн сураг чимээг сайтар тунгаан бодогтун ! ”

Хоржигнон урсах горхийн чимээ өнө мөнхийн яруу сайхан үлгэрийг хүүрнэсээр. . . . харин ёроолын загас жараахайнууд ус үсчүүлэн хөөцөлдөн тоглосоор байх ажгуу.

Шидөгийн ийн дамжуулан хөрвүүлсэн түүхийг сонсоод, Або тэсгэлгүй доош тонгойн гараараа утган савируулахад, түүний энэхүү аядуу зөөлөн хөдөлгөөнд ч горхийн намуухан зохирол алдагдах шиг санагдана. Хэдэн жараахай түүний гарын хуруунуудыг сониучирхан хазлаж, саваагүй нэг нь алган дээгүүр дамжин хурууны салаагаар зурсхийн өнгөрнө.

Або ийнхүү ямар нэгэн зүйл бодолхийлэн жараахайтай наадаж байтал, чихний үзүүрт нэгэн цээлхэн яруу дуу сонсогдов.

“Горхийн урсгал сайн сайхан зүг рүү хөтлөнө. Загас жараахай аливааг амархан мартах юм. Харин хүн төрөлхтөн ямар хувирамтгай билээ. Үүнээс үүдэн мянган түмэн зовлон амсах боловч загас жараахайнууд, сэтгэлдээ хорслын үр тээхгүй эрх дураараа хөвнөм.”

Тунгалаг горхийн усан тод цээлхэн хоолойгоор ийн дуулах

нь тэртээ алсад дуурсах ажээ.

“Нээрэн ч хувьсамхай зан чанар гэдэг хүн төрөлхтний онцлог юм даа. Хүний санаа сэтгэл хором мөч тутамд хувьсан өөрчлөгдөж байдаг. Баярлаж уурлах баримжаагүй нь загас жараахайтай хэрхэн харьцаж байгаагаас илхэн харагдана. Тухайлбал багадаа тэднээс өөрцгүй наадан тоглож байснаа, тор тавьж хайр найргүй агнана. Тэгснээ эргээд элбэрэл хайрын сэтгэл төрж, тэднийг хайрлан хамгаалах юм. Энэхүү хувьсамтгай зан чанар нь хүмүүсийн хоорондын харилцааг ч нарийн төвөгтэй болгож орхидог. Тийм болохоор цэлмэг огторгуйгаас хээрийн галууны хүргэж ирсэн сураг чимээг горхийн ус, загас жараахайнууд сайтар ойлгох боловч хүмүүс л огт мэдсэн шинжгүй.”

Або ийнхүү хүүрнэхийг чих тавин сонсож байтал холгүйхэн мөнөөх хээрийн галууны үзэсгэлэнт дүрс горхийн мандалд тусахыг өөрийн нүдээр олж үзэв. Шар бүрийн гэрэлд өнчин галуу салхи татуулан өнгөрөх нүд баясгам төрх, Абогийн сэтгэлийн утсыг хөндөж, гайхам сонин мэдрэмж төрүүлсэнд, тэр үнэн сэтгэлээсээ асууруун: “Горхийн ус минь ! Жараахайнууд минь ! Агаар тэнгэрээр элин халин нисэх өнчин галуу чухам ямар сураг чимээ хүргэж ирснийг та бүхэн хэлж өгч болохсон болов уу !”

Нэгэн жараахай горхийн мандлаас под хийтэл үсрэхэд, баруунаа шингэх нарны туяанд зүйргүй үзэсгэлэнтэй

цалин мөнгөн нуман гэрлийг үүсгэв. Жараахай дээгүүр нь эргэлдэн нисэх хээрийн галууны уран хөдөлгөөнийг дууриах гэсэн мэт усны мандлаас дахин үсрэн цойлох нь гайхал төрүүлэм ажээ.

Цаасан шувуу Шидө сэтгэл тэнүүн өгүүлрүүн

“Або гүн хөх огторгуйгаас нисэн ирсэн хээрийн галуу эргэлдэн нисэх тоолондоо нэгэн самгарьд үсэг бичиглэн үлдээдэг болохыг жараахайнууд өгүүлж байна.”

“Самгарьд үсэг гэнэ ээ?” гэж Або гайхширч орхив.

“Тийм ээ ! Хээрийн галууны бидэнд дуулгахаар авчирсан мэдээ нь нэгэн самгарьд үсэг бөгөөд түүний далд санаа нь огторгуй ертөнц эхлэлгүй, мөн төгсгөлгүй гэсэн утгатай юм байна.”

“Жараахайнууд цааш нь, сансар огторгуйн хамгийн гүн нарийн билиг оюун энгүй өргөн уудам эх байгалийн дунд оршдог. Тэрхүү томшгүй олон уул усан судрыг цаглашгүй олон тоот самгарьд үсгээр бичиглэн үлдээсэн байдаг ажээ.”

“Самгарьд үсэг гэдэг чинь чухам юу юм бэ?” гэж Або лавшруулан асуулаа.

“Самгарьд гэдэг үг бол хиргүй ариун гэсэн утгатай юм л даа ! ” гэж цаасан шувуу Шидө тэдний үгийг хөрвүүлэн өгүүлэв.

“Хиргүй ариун гэдэг чинь.” хэмээн Або амандаа бувтнаж байтал гэнэт түүний тархинд оюуны гэрэл гийх

шиг болж их л догдлонгүй ийн асуулаа

“Чиний хэдэн мянган жилийн турш хувиралгүй урсах намуухан төрх болон тасралтгүй эгшиглэх яруу дуу мөн биз дээ?”

Горхийн усан урьдын адил намуухан хоржигнон урссаар лАбо тунгалаг горхи дахин ямар нарийн нандин нууцсыг хүүрнэх бол хэмээн чих тавин чагнаж байтал цаасан шувуу Шидө горхиноос ийн асуухыг сонсжээ.

“Тэгэхээр хамгийн агуу том билиг билгүүний судар гэдэг бол хүний гараар бичиг үсгээр тэмдэглэн үлдээсэн нь бус, тэрхүү нандин судрыг хүн болгон ч хараад уншиж ойлгодог юм биш гэсэн үг үү? Тэгвэл тэр судар чухам хаана байдаг, ямархуу хэлбэрээр илрэн гардаг юм бэ?” хэмээн Шидө өөрийн өнгө алагласан хувцсыг дэрвүүлэнгээ ийн асуулаа.

Горхийн амгалан мандал хааяа нэг салхины аясаар унах шарласан навчны тоолонгоор зөөлөн бидэртэнэ.

“Орчлон хорвоогийн түмэн бодис, түмэн үзэгдэл юмс бүгд л аяндаа үүсэн бүрэлдэх нь гэгээн өдрийн нарны тусгал, харанхуй шөнийн түмэн оддын гялбаа, хөх тэнгэрт хөөрөн нисэх галуу лугаа үлгэрлэж болох юм. . . .Тоо томшгүй олон үзэгдэл юмс бүгд цаад утгаараа эх байгалийн цэвэр ариуны илрэл байдаг ажгуу. Энэ үүднээс авч үзэх юм бол орчлон хорвоо үсэг бичиггүй самгарьд хэлний номноос өөрцгүй. Нэжгээд өвс мод, ганц цэцэг ч байгалийн энэхүү

аварга номын уран бичлэгийн нэгээхэн татлага байдаг юм.”
Шиде орчлон хорвоогийн энэхүү сэтгэшгүй гүн нарийн
нууцыг цааш тайлан өгүүлрүүн:

“Тэрхүү үг хэл, үсэг бичиггүй аварга том ном хаа сайгүй
янз бүрийн хэлбэрээр орчлон хорвоод оршихдоо хором
мөчийн төдийд ч алгасралгүй хиргүй ариун самгарьд үсгийг
бичиглэсээр байдаг аж. Энэ ёсыг ойлгож, сэтгэл тавин
шамдсан хүн бүхэн тэр судрыг уншиж ойлгох чадвартай.
Тухайлбал газар хагалж байгаа одос үхэр, салхины
сэрчигнээн, газар бордож буй хөгшин тариачин, сарны гэрэл
дорх мэлхийн вааглаа, их далайн торгон долгис, дээврийн
саравчнаас дуслах бороон дуслуудбүгд л байгалийн
номын уран бичлэгийн татлага зурлага нь байдаг гэж ойлгож
болно !”

Горхийн урсгалын нууцхан шивнээ, орой намрын шүүдрийн
цэнгэг ус амссан хүний сэтгэлийг сэргээдэг лүгээ адил ажээ.
Абогийн сэтгэлийн хүлээс алдуурах шиг болж, өөрийн
оршин буйг умартан, орон зайн цаг хугацааг гэтлэн даваад,
Шидөгийнхөө хамтаар оёоргүй хөх огторгуйн уудамд
хөөрөн, хээрийн галууны нисэн өнгөрсөн ул мөрөөр замнах
мэт ухаан бодол нь алсран хөглөгдлөө. . . .Гэнэт тэртээ
алсаас горхийн хоржигноон улам тодорсоор чихний омгон
дээр шахам цангинаж ийн өгүүлрүүн:

“Тагцхүү цаг хугацааны сорилтод сөхрөлгүй, сэтгэлийн

цэвэр ариун байдлыг алдалгүй хадгалж, амьдралдаа гоо сайхан, билиг оюуны гэрэл гэгээг цацруулж чадсан хүн л сая огторгуйн хөлгөн судрын номын хүрдэнг эргүүлэх боломжтой байдаг. Яагаад гэвэл хиргүй ариун сэтгэл л тэнгэр газрын тэртээгээс бидэнд илгээгдсэн мэдээллийг ойлгож мэдрэх боломжтой юм.”

Огторгуйн мөнгөн голын хөвгүүн болсон тунгалаг горхи эрт балраас нааш өндөр уулс, өргөн талын дундуур сүлжин урсахдаа эрэг дагуух тоо томшгүй олон амьтдыг ундаалж, өдөр шөнийн алинд ч амсхийлгүй, огторгуйн өнө мөнхийн ариун дууллыг түгээж байдаг ажгуу.

Абогийн догдлох сэтгэл горхийн хоржигноон лугаа уусан нэгдээд:

“Жараахай, бяцхан жаалууд, залуус, том хүн, өтөл өвгөн гээд л өөр өөр хэрэгцээг, горхийн усан харамгүй тэгш гүйцэлдүүлж, сайн сайхныг ухааруулж байдаг юм байна. Харин загас жараахай мартамхай, хүмүүс бид ямар ч хувьсамхай юм бэ дээ?

Хэрвээ хүмүүс бид тэнгэрийн мандлаас хээрийн галууны хүргэж ирсэн мэдээллийг ойлгодог бол горхийн усан лугаа адил сайн руу тэмүүлэх билиг билгүүнийг байг гэхэд жараахайнууд шиг өшөө хонзонг мартагнах занд суралцаж чадвал хичнээн сайн билээ. Тэгж чадваас аливаад автан, хувьсан хуйсагнаж байдгаа болихсон доо !”

Жирэлзэн өнгөрөх бодол Абогийн хүүхэд нас, өсвөр залуу үеийг дамжин өнгөрөхөд, туулсан амьдралын чухал сонин үйл хэргүүд усны урсгал мэт тархины гүнээс тасралтгүй ундрэн сэргэсээр байлаа. Тэрээр гэнэт горхийн урсгал жараахайнуудад ийн өгүүлэхийг олж сонсов.

“Жараахайнууд минь ! Хоржигнон урсах горхийн урсгалд эрт балраас уламжлагдан ирсэн мэдээлэл агуулагдаж байдаг юм шүү ! Та бүхэн түмэн бодист зориулан тоглогдож буй энэхүү яруу аялгууг чих талбин сонсох хэрэгтэй. Би уулын хүйтэн булаг, хүрхрээ, мөрний урсгал, далайн давалгаа, бороо шүүдрийн алинд ч хувилсан бай хамаагүй, түүний дуслын чимээ бүхэн орчлонгийн нууц аялгууг дуурсгаж, цаглашгүй гүн нууцыг тайлан хүүрнэж байдаг юм шүү !”

Мэлмэрэн урсах горхийн усан сансар хорвоогийн хамгийн агуу их атлаа хүний сэтгэлийг догдлуулам гүн нарийн нууцыг өгүүлэхэд түүний мянга түмэн долгис Абогийн сэтгэлийн нууранд мяралзсан үзэсгэлэнт яралжуудыг үүсгэсээр байвай.

“Тагцхүү хиргүй ариухан сэтгэл л тэнгэр газрын нарийн нандин хөг аялгууг сонсож, тэр хэрээр тансаг яруухан амьдралын үүдийг нээн орж чаддаг юм.”

Горхийн ус хоржигнон урсахдаа гэгээн яруу эгшгийг үүсгэсэн нь жаргах нарны дор налайх ой шугуй даяар дуурсана.

Або нам гүмхэн бодолд автсаар л.

“Сэтгэлийн гүнээс түмэн бодисын нарийн нандин амин судлыг ажваас л, хүмүүс амьдралын дунд цаг мөч тутам тасралтгүй дуурсан эгшиглэх яруу аялгууг олж сонсож чадна. Хэзээ нэгэн өдөр хүмүүс амь амьдралын угийн жинхэнэ төлөв байдлыг олж үзсэн тэр цагт хосгүй үзэсгэлэнтэй цоо шинэ ертөнц нүднийх нь өмнө тодрон гарах нь ойлгомжтой !”

Мянган долгис намуухан хөөцөлдөх горхийн мандал цаасан шувуу Шидө багваахай цэцэгс битүү ургасан хоёр эргийн агаар дээгүүр зугуухан нисэхийг ягуухан тольдож харуулав. Горхийн урсгал уянгалаг дуу эгшиглүүлсээр хайрга чулуут голдрилоо даган дорно зүгт урссаар байх ажээ.

* * *

Абогийн сэтгэлийн орон тунгалаг горхийн яруу эгшиглэн дундаас зугуухан буцаж ирэхэд, оройн наран алтан шаргал сүйх тэрэг хөлөглөсөөр баруун уулын оройг чиглэн ширүүн довтолгож буй нь харагдав. Тэнгэрийн хаяа тэр чигтээ улайран шарлахад эргэн тойрны ой шугуй үлгэрийн ертөнц мэт өнгө алаглаад, тунгалаг горхи харин ухаа ягаан өнгөөр гялалзана.

Фэнтори хамтлагийн тоглож үзүүлэх дөрөвдэх шөнийн үлгэр жаргах нарны улбар туяан дор үзэгчдийг өөрийн зүг эрхгүй даллан дуудна. Замын турш Шидө Абог шавдуулах

тул хоёулаа аль болох ширүүхэн алхахыг хичээж явлаа.

Хотын захын үтрэмийн хашаанд эргэн ирэхэд үзэгчид аль хэдийн суудлаа эзлэхихээд, урьд хэдэн өдөр үзсэн зүйлийн тухай тав гурваараа халуун яриа өрнүүлнэ.

Або ч мөн урьдын суудалдаа тухлаад, чих дэлсэх хүмүүсийн ярианд сэтгэл хөтлөгдөн, өнөө орой ямар сонирхолтой жүжиг тоглох бол гэж цаасан шувуу Шидэтэйгөө хамт догдлон хүлээж байлаа.

“Эрхэм анд нар аа ! Өдөр шөнийн уулзах заагаар, тухайн өдрийн хамгийн сүүлчийн шаргал туяа тэнгэрийн хаяаны цаагуур далд орох мөчид эрдэнэсийн эрэлчидийн тухай ээлжит жүжиг маань эхлэдэг уламжлалтай билээ !

Өнөө орой ч мөн өөрцгүй эрдэнэсийн эрэлчид маань Са Юнь багшийнхаа хамтаар одот шөнөөр орой намрын хярууг туучин домогт өгүүлдэг амь насны нандин эрдэнийг олохоор бэдрэн явсаар байгаа ажгуу !

Түмэн одод түгсэн тэнгэр газрын энэ чөлөөнд болсон дээрх явдал уран сэтгэмжийн жүжиг, унтах нойрны зүүд, аль эсвэл жинхэнэ болсон явдлын аль нь юм бол? Тэдний эрэл сурал болон яваа мөнөөх эрдэнэ чухам хаана байгаа бол?”

Харуй бүрийн дунд Фухуагийн цээлхэн хоолой ийн дахин цангинав. Тайзны хөшиг зугуухан нээгдлээ.

【ДӨРӨВДӨХ ШӨНӨ】

НАНДИН ЭРДЭНИЙН ГАЙХАМШИГ

НЭГДҮГЭЭР ҮЗЭГДЭЛ

ΔЗЭЛҮҮД УУЛНАА

(Жихүүн хүйтэн шөнө хэдэн хүүхэд зэлүүд уулнаа айж эмээсэн бололтой явцгаана. Тэд болвоос орчлонгийн диваажингаас зам төөрч будилсан хүүхдүүд бөгөөд алсын уулын цаанаас цацрах гэрлийг олж хараад, хуучин нутагтаа эргэн очих итгэл төрөн, тэр зүгийг чиглэн яваа нь энэ ажээ. Уулын ард утаа гарахыг үзээд түр ч атугай амрах газар олдох нь уу хэмээн тэд бодоцгоов.)

Хүүхэд А: (Яриа)

Уулын цаанаас утаа суунаглаж

Улалзах гэрэл гялалзах нь

Бараан үүлс бүрхсэн сэтгэлийг гийгүүлнэ

Бас л ямар газар юм бол

Таван хүслийн гэрэл цацраадаг нь юуны учир вэ?

Хүүхэд Б: (Дуулна)

Хачин чамин хувцас хунар

Хараа булаам өнгө дүрс

Агдлан хүлэх тор мэт

Алжаасан сэтгэлийг эзэмдээд
Харин няцлаа
Харих замаа умартлаа
ХҮҮХДҮҮД: (Нэгэн зэрэг)
Энэ хэдийгээр
Энхжингийн орон маань биш ч гэлээ
Амарч үдлэхэд яахав
Алжаалаа тайлаад авцгаая !
(ХҮҮХДҮҮД утаа суунаглах нэгэн уулын оройг чиглэн
явцгаана. Оддын бүдэг гэгээ хээр талд унтаж байгаа нэгэн
хүний бие дээр тусав. ХҮҮХДҮҮД түүний олж хараад
хурдаа нэмэн алхах үеэр тэдний дээр тэнгэрийн хүмүүн
гарч ирнэ.)
Тэнгэрийн хүмүүн: (Дуулна)
Төгс ариун бодь мэт сэтгэл нь
Төрөхгүй түрдэхгүй нь хорвоод хосгүй
Хааяа нэг салхинаа хийсэх унгирал
Хавийн лаг шаврыг биедээ халдаахгүй

Оройн улбар наранд навчсын үнэр сэнгэнээд
Орчлон хорвоо даяар ариуслын салхи сэвэлзэнэ
Навчнаа тогтсон шүүдэр хаш сувданд хувираад
Намуун харзын ус цэцгийн зүсийг тольдоно

Тэсвэрлэшгүй там хэзээ хоосрохыг мэдвээс
 Тэнцвэр алдан шавартай хутгалдахаа болино
 Их хүслийг гүйцэлдүүлэхээр дахин ирвээс
 Ирэх он жилүүдийг асрын зүүнтээ үдсүгэй

(Хээр талд унтаж байсан хүн яраглан, байн байн гар нь хий
 агаар руу гозолзоно.Хүүхдүүд энэ байдлыг үзээд
 сэмээрхэн ухарч тайзны араар орно.

Аянга нижигнэн дуугарч, унтаж байсан хүн цочин сэрээд
 давхийн босож ирээд, ийш тийш айсан байдалтай ямар нэгэн
 зүйлийг эрж холхино. . .)

Юэгуан Тунз: (Их л айсан байдалтай хашгирна)

Бүх хүмүүс хаашаа алга болчихдог байна вэ? Би яахаараа
 энэ ээрэм талд унтаж байдаг билээ? Үзэсгэлэнт хот, чамин
 тансаг орд харш хаашаа алга болчихов оо? Бүхий л алтан
 өнгөт тэнгэрийн хүмүүс хааччихав?

(Аянга нижигнэсээр гэрэл зугуухан унтрана.)

ХОЁРДУГААР ҮЗЭГДЭЛ

Уулын дээр хулсан сахал цайран цавцайж, эрдэнэсийн
 эрэлчид их л алжаасан бололтой Са Юньгийн удирдлагын
 дор уул давааг хэжин, өлөн зэлмүүнийг тэвчиж, домогт
 өгүүлдэг нандин эрдэнийг хайсаар л.

ДУУЛЫН ХАВЦЛЫН ҮЗЭМЖ

(Хоёр талаараа хадан ханаар хүрээлэгдсэн уулын хавцлын дундуур ширүүн гол урсаж, түүний хажуугаар эрдэнэсийн эрэлчид айж бэргэсэн байдалтай урагшилна. Тэднийг урагшлах тусам гэрэл бүдэгрэн, урдах зам харанхуйлна.)

Са Юнь: (Тайвуухан) Бүгд тайван байцгаа ! Гар гараасаа барилцан, хөлөө ултай сайн гишгэж явбал энэ үер удахгүй намжих нь гарцаагүй !

(Юэгуан Тунз өөрийн хүндлэн хайрладаг Са Юнь багшийг итгэл дүүрэн нүдээр ширтэнгээ, өөрийн ганзага нийлсэн нөхөд рүү байн байн эргэн харах ажээ.)

Юэгуан Тунз: Бүгдээрээ анхааралтай явцгаагаарай ! Урьд харагдаж байгаа тэр уулын оргилд бидний хайж яваа эрдэнэс агуулагдаж байж мэдэх юм. Бид гагцхүү энэхүү өргөн хавцлыг давчих юм бол эрдэнэсийн байгаа газар очиж чадна.

Шавь А: (Айсан байдалтай) Гэвч энэ хавцал явах тусам улам хүйтэн болоод байна шүү дээ !

Шавь Б: (Арагш ухраад) Энэ хавцлын адгийг бид олж үзэх болов уу? Бид арай буцах хэрэгтэй юм биш биз дээ?

Шавь В: Нээрэн тийм шүү ! Бид өлсөж даарч байна гэдэг жигтэйхэн. Цөмөөрөө буцвал дээргүй юу?

(Уулын салхи ширүүсч голын урсгал улам ширүүсэхэд, хад чулууг хаман өнхрүүлэхэд, хүмүүс айж сандран

хашгиралдана.)

Са Юнь: (Тайван хэвээрээ) Бүгдээрээ сэтгэлийн цөвийг үргээн тайван байдлаа хадгалцгаа ! Аль болохоор хадан ханыг дагаж урагшлаарай !

(Уулын үерийн чимээ нүргэлэн шуугьж, хүмүүс бэдрэн урагшилсаар гэрэл унтрана.)

(Шөнийн тэнгэр дор хавцлын хажууд Са Юнь эрдэнэсийн эрэлчдийн хамт түүдэг тойрон сууцгаажээ. Амь өрссөн аюулын ард гарсан тэд айж түгшсэн, алжааж ядарсан байдалтай харагдана. Юэгуан Тунз огторгуйг ширтэн элдвийг бодолхийлнэ.)

Юэгуан Тунз: (Дуулна)

Өтгөн манан хөшилдөөд

Өнөө шөнө хүйтэн байна

Өнчин ганц бие минь

Өндөр уулын хаяа бараадлаа

Асар тэнгэрийн одод харагдахгүй

Анд нөхдийн алхаа сонсогдохгүй

Оройн салхи хормой хотыг хийсгэвч

Огшсон сэтгэлийн бараан үүл сарнихгүй

Шавь А: Сая мөн айхтар байсан шүү ! Уулын үерт том том бул чулуунууд өнхрөөд, ядаж энэ хавцлын харанхуй хүйтнийг яая даа гэмээр байлаа. Тэнгэр баганадсан өндөр хавцал аймшигт араатан мэт дээр сүглийгээд, цаг хугацаа

урсан өнгөрөх атал, түүний адаг харагдахгүй, үнэхээр сэтгэл цөхрөмөөр санагдсан.

Шавь Б: (Их л урвагардуу)Хэлээд яахав. Ядаж тэр уулын ширүүн салхи амьсгаа ч авах аргагүй шахам үлээж байлаа.

Шавь В: Одоо тэр тухай эргээд санах гэхээр дотор жихүүцмээр болж байна.

Юэгуан Тунз: Азаар Са Юнь багш биднийг сэтгэлийн цөвөө арилган, гар гараасаа хөтлөн тайван явцгаа гэснээр бид хадан хавцлын ханыг дагасаар адагт нь хүрч чадлаа.

Шавь Г: (Гар хөлөө ажиглан хараад) Гэвч энэ удаагийн айхтар барцдыг даваад миний бие багагүй шарх сорвитой хоцорлоо.

Хүмүүс: (Шуугилдан) Би ч гэсэн, би ч гэсэн мөн адилхан. (Тэдний дуу зугуухан намсаад хэсэг хугацаа өнгөрсөний дараа нэг хүн босож ирээд. . .)

Шавь А:(Тавгүйрхсэн байдалтай)Бид орчлонгийн хэргийг огоорон эрдэнэсийн эрэлд гараад, уул давааг хэжин, өлөн зэлмүүнийг тэвчиж, хайсаар байвч өнөө хэр ямар ч үр дүн алга. (Нөхөд рүүгээ эргэн хараад) Та бүгдийн царайд алжаал ядаргаа илхэн байна.

Шавь Г: (Айсан байдалтай) Бүгдээрээ буцвал ямар вэ? Буцсан нь дээр байх аа !

Шавь Б: (Гонсгордуу) Тийм шүү ! Са Юнь багш аа, бид нар өдий олон жил хайсан атал хайж буй эрдэнийхээ барааг ч

олж үзсэнгүй. . . . Тийм болохоор буцсан нь л дээр болов уу !

Хүмүүс: (Шуугилдан) Буцъя аа ! Буцъя л даа !

(Юэгуан Тунз тэднийг бачимдсан байдалтай хараад, Са Юнь рүү эргэв. Са Юнь урьдын адил амгалан дүрээрээ гараа дохиж хүмүүсийг дуугүй болголоо.)

Са Юнь: Та бүхэн бүгд тайвуухан миний хэлэхийг сонсоцгоо ! Та нар хар даа ! (Хуруугаараа урагш заагаад) Тэртээд харагдаж байгаа уулын оргилд бидний хайж яваа эрдэнэс байгаа ч юм бил үү? Бид нар тэр их зовлон бэрхшээлийн ард гарчихаад ийм амархан няцаж болохгүй байх аа !

Шавь А: (Маш урвагар) Нээрэн гэж үү дээ? Бид зөндөө олон уул нуруудыг дамжин хайгаад олсон зүйлгүй л буцдаг байсан шүү дээ ! Энэ удаа ч гэсэн тийм зүйл тохиолдохгүй гэхийн баталгаа хаана байна вэ?

Хүмүүс: (Шуугилдаад) Нээрэн шүү ! Дандаа л бүтэлгүйтэж байсан шүү дээ !

Юэгуан Тунз: (Ухасхийн босоод) Бүгдээрээ битгий шуугилдаад бай ! Са Юнь багшийн хэлдэг үнэн шүү ! Бид хамгийн аюултай газрыг туулан өнгөрчихөөд цааш юу болохыг үзэж яагаад болохгүй байх билээ !

Са Юнь: (Тайвуухан) Шөнө орой болжээ. Та нар ч гэсэн их ядарсан байх. Бид өнөө шөнөдөө сайхан амарч хоночихоод маргааш тэр газар очиж яахаа хэлэлцсэн нь дээр.

(Хүмүүс өөд өөдөөсөө харсанаа дурамжхан тус тусын байрыг олж, амрахаар хэвтэцгээв.Юэгуан Тунз ч гэсэн тэдэнтэй хамт унтахаар хэвтлээ. Хүмүүс унтсан хойно Са Юнь босож ирээд түүдэг галаас холдон, ганцаар оддын дор бодлогоширон суулаа.)

Са Юнь: (Дуулна)

Номин ойн амгаланг эвдэн

Номын хонхны дуу нүргэллээ

Ариун номын чанартай энэ хонх

Аршаан булгийн хүйтэн ус мэт

Аху сэтгэлийн мунхгийг угаанам

Алсад нүргэлэх номын хонх

Аядуу зөөлөн салхи адил

Алжааст сэтгэлийн үүлсийг зайлуулнам.

Энэ хонхон чимээ

Энгэр цээж саруулсахад нүргэлдэг

Энэ хонхон чимээ

Эртний улсын цэцэрлэгээс дуурсдаг

Төв яруу хонхон чимээ

Төөрөлдсөн хамаг амьтдыг сэрээнэ

Бодлын жавар үргээх хонхон дуу

Бодь сэтгэлийн замд хөтлөнө

(Са Юнь огторгуйг ширтэн хэсэг зуур бодолхийлсэнээ)

Са Юнь: (Өөртэйгөө ярьж) Тоо томшгүй олон зовлон бэрхшээлийг давж, өнөөдөр бүр амь нас дээсэн дөрөөн дээр дэнжигнээд, энэ хэдэн хүүхдийн зориг нэлээд мохож, эрдэнэсийг үргэлжлүүлэн хайх хүсэл эрмэлзэл нь үгүй болох шиг боллоо. Гэтэл эрдэнэс агуулсан газар маань хажуу дэргэд шахам байж байдаг. Энэ үед тэдний хүслийг болгоох юм бол урьд өмнөх зүтгэл бүгд талаар болох биш үү !

(Энэ үеэр уулын жавар хүүгэн үлээх нь олон хүмүүсийн уйлан хайлах дуутай төстэй сонсогдоход Са Юньгийн сэтгэл өөрийн эрхгүй халаглан өрөвдөв. . .)

Са Юнь: Одоо гагцхүү уран арга хэрэглэн байж л тэдний итгэл сэтгэлийг эргэн сэргээж болох буй за !

(Түүдгийн дэргэд буцаж очоод унтах үед гэрэл зугуухан унтарна. Маргааш өглөө үүр цайхын алдад Юэгуан Тунз босож үзвээс Са Юнь багш нь ганцаараа алсын оргилыг харуулдан суух ажээ.)

Са Юнь: (Инээмсэглээд) Урт шөнө улиран өнгөрлөө. Тааламжтай сайхан нарны туяа тэртээх уулын оройг даван эх газрыг нэлэнхүйд нь гийгүүлж байна.

Юэгуан Тунз: (Гайхширангуй) Хүүе ! Урд талд нэгэн хот балгад байна. (Олон хүмүүс дараалан сэрнэ) Та нар харав уу ! Тэртээх уулын оройд байна шүү дээ !

Са Юнь: Бүгдээрээ хийморьтой байцгаа ! Урд талд маань нэгэн үзэсгэлэнтэй сайхан хот балгад байгаа болохоор тэнд очоод хэд хоног амраад авцгаая ! Түүний дараа та бүхэн буцъя гэсэн хүсэл чинь хэвээр байх юм бол эрдэнэ хайхаа болиод буцаж бололгүй яахав !

(Са Юньгийн заасан зүг харваас нэгэн үзэсгэлэнтэй сайхан хот балгад үүл манан хөшилдөх оргилын дээр сүндэрлэн үзэгдэх ажээ.Тэгээд олон хүмүүсийн итгэл сэргэн Са Юньгийн удирдлагаар хүсэл найдвар төрүүлсэн тэрхүү хотыг чиглэн алхлаа. Хүмүүс эртний улбаа замыг дагалдан цагаан үүлсийн чанадыг бэдрэн урагшлана. Гэнэт оргилын зүгээс бүдэг бадаг яруу хөгжмийн аялгуу галбингын дуу мэт эгшиглэх сонсогдоно. Нарны туяан дор оргилыг ороосон өтгөн үүл манан сарниж өмнөх зам цэлийгээд явчихав.)

Шавь А: (Уужирсан байдалтай) Ямар сайхан цэнгэг агаар вэ?

Шавь Б: (Догдлонгуй) Урьд өмнө үнэртэж байгаагүй анхилуун үнэр байх чинь !

Шавь В: Ямар яруу сонсголонтой хөгжмийн эгшиг вэ? Алив та нар энэ гайхалтай сонин цэцгийг хар даа !

Шавь Г: Ёстой ховор сонин эртний улбаа зам байна даа !

Үүгээр урьд өмнө хүн хар тун ховор явж байсан бололтой.

Юэгуан Тунз: Та нар хар даа, урд талд таван өнгийн гэрэл цацарч байна.

Хүмүүс: (Нэгэн дуугаар) Ваа !

Са Юнь: Тэр бол нэгэн үзэсгэлэнтэй сайхан орд харш байна.

Юэгуан Тунз: Цөмөөрөө хурдан очиж харцгаая !

(Хүмүүс Са Юньг дагалдан явсаар цэцэгсийн далай дунд умбасан үзэсгэлэнт орд харшийг олж харлаа. Тэдний урам зориг эргэн сэргэж урагш хийморь золбоотой алхаж эхлэхэд гэрэл аажмаар унтарна.)

ДҮЗЭСГЭЛЭНТ ОРД ХАРШ

(Олон хүмүүс хотод ороход үгээр илэрхийлэхийн эцэсгүй туйлын баяр жаргал сэтгэлд нь төрөөд, биедээ өмссөн уранхай нооронхой хувцаснууд нь агшны төдийд цоо шинэ гоёмсог өмсгөл болон хувирч, шарх сорви нь ор мөргүй эдгэрчээ. Салхинаа хийсэх навчис биед тогтсон хир тоосыг ариутган гөвж, нүүрэн дэх алжаал ядаргаа ч мөн үгүй болов. Замын турш тэд цэцэг зулаастай бамбалзсан зөөлөн зөргөөр алхлах зуур биеээс алтан гэрэл цацруулсан туйлын цог заль төгс тэнгэрийн хүмүүс үзэсгэлэнт хувцсыг өмсөөд алхах суух буюу тэнгэрээр дүүлэн нисэхийг харж болох ажээ. Хамгийн гайхамшигтай нь долоон эрдэнээр бүтсэн цөөрөмд солонгын өнгийг цацруулсан лянхуа цэцэг дэлгэрч байлаа.)

Юэгуан Тунз: Харав уу ! Мөнхийн гэгээн ариун амийг тээсэн мэт энэ эрдэнийн цөөрмийн лянхуа цэцэгс үзэсгэлэнт

болрын өнгөөр гэрэлтэж байна.

Шавь А: Үзэсгэлэнт гэрэл цацруулсан, үүлэнд тулсан өндөр орд харшуудтай ямар сайхан хот вэ?

Шавь Б: Хүүе, та минь ээ ! Энэ цөөрмийн эрэг дагуух орд харшууд бүгдээрээ долоон зүйл эрдэнэсээр бүтсэн болохыг харж байна уу?

Шавь В: (Их л догдлонгуй) Бид нар арай орчлон хорвоогийн диваажинд хүрээд ирсэн хэрэг биш биз дээ?

Хүмүүс: (Чанга дуугаар уухай хашгиран) Ямар сайхан юм бэ? Энэ лав нөгөө домогт өгүүлдэг эрдэнэсийг агуулсан газар мөн байж таарлаа !

(Хүмүүс Са Юньг дагалдан цөөрмийн эрэг дагуух орд харшуудыг үзэж сонирхоно. Эргэн тойрон болрын өнгөөр гэрэлтэн, цэцэрлэгийн модод бүгд молор, хув зэрэг эрдэнэсээр бүтжээ.Цэнгэг салхи илбэн өнгөрөх бүрт эрдэнийн мод эгшиг яруу дууг үүсгээд, унасан навчис нь агаарт эргэлдэн бүжнэ. Эрдэнэсийн эрэлчид энэ бүхнийг гайхширан ширтэж байлаа. . .)

Са Юнь: (Инээмсэглээд) Энэ газар та бүхний юу санасан есөн хүсэл чинь сэтгэлчлэн бүтэх болно. Тийм болохоор цөмөөрөө энэ газар хэд хоног сайхан амраад авъя ! Харин өнгөрснийг бодож, ирээдүйн хэргийг мөрөөдөхгүй байх хэрэгтэй шүү !

(Энэ үед тэнгэрийн цэцэгс бороо мэт асгарч бахдан баярлах

дуунд гэрэл бүдэгрээд хөгжим намсана.)

ΔХАВЦЛЫН ҮЗЭМЖ

(Харанхуйд цахилгаан цахилж, аянга тасралтгүй нүргэлнэ. Гэрэл хээр унтаж байгаа Юэгуан Тунзын бие дээр тусахад цочин сэрээд, давхийн босож ийш тийш гайхширан харсанаа нааш цааш явж үзнэ.)

Юэгуан Тунз: Бүх хүмүүс хаашаа явчихав аа? Би яахаараа хээр унтаж байдаг билээ? Нөгөө үзэсгэлэнт орд харш, алтан биет тэнгэрийн хүмүүс хааччихдаг байна вэ?

Хүмүүс: (Царай барайлган) Эрдэнийн цөөрөм, эрдэнэсээр бүтсэн модод хааччихав аа? Урьд шөнө дуу бүжиг цалгиж байсан хөлтэй найр яагаад үгүй болчихов? Нөгөө дээгүүр дүүлэн нисдэг тэнгэрийн хүмүүс хаана байна вэ? Долоон эрдэнийн үзэсгэлэнт орд харшаас дуурсах яруу хөгжим яагаад эгшиглэхээ больчихов?

(Са Юнь цог жавхаа төгс дүртэй гарч ирнэ. Юэгуан Тунз болон айж сандарсан хүмүүс түүний зүг очицгоолоо.)

Юэгуан Тунз: (Гайхширангуй) Са Юнь багш аа, яахаараа ийм болоод хувирчихдаг билээ? Нөгөө үзэмжит байдал чинь ор мөргүй алга болчихлоо шүү дээ !

Са Юнь: (Тайван дөлгөөнөөр) Битгий сандарцгаа ! Харамсаж халаглах зүйл юу байх билээ? Үзэгдэх юмс, орон нугууд

гэдэг бүгд хий хоосон зүйл. (Энэ үеэр Юэгуан Тунз гэнэт ямар нэгэн зүйлийг ухаарах шиг болов.) Сая үзээд өнгөрсөн хот балгадыг та бүхний итгэлийг дахин сэргээхийн тулд санаанаас зохион буй болгосон юм. Та бүхэн хэд хоног сайхан амраад, биеийн хүч тэнхээ сэргэсэний дээр, эрдэнэсийн уул ч холгүй харагдаж байгаа. Тийм болохоор саяын үзэж өнгөрсөн зүүд зөн төдийхөн сайхан үзэмжинд сэтгэлээ бүү чилээ. Жинхэнэ долоон зүйл эрдэнэсээр бүтсэн хот балгад өмнөхөн чинь байна. Тэнд очвол бид өдрийн бодол шөнийн зүүд болсон нандин эрдэнэсээ олоод зогсохгүй, хүн болгон зовлонгийн хүлээснээс ангижран, туйлын жаргалыг эдлэх болно.

(Са Юньгийн үг тэнд байгсдын толгой руу тоншоод авах шиг болоход бүгд түмэнтээ ичингүйрч ухааны сүв нээгдэв.)

Юэгуан Тунз: (Сүслэнгүй) Аяа ! Са Юнь багш аа ! Бид тулгарсан сорилтыг давж чадалгүй хариугүй зорьсон хэргээсээ шантран ухрах шахжээ. Ёстой ичгүүртэй хэрэг гэж энэ байх даа !

Шавь А: (Толгой гудайлган) Бид ч үнэхээр мунхаг улс юм даа !

Шавь Б: Са Юнь багш аа, та биднийг дагуулан цаашид эрлээ үргэлжлүүлэгтүн ! Бид амь насны нандин эрдэнэ олохыг маш их хүсэж байна.

Шавь В: (Маш итгэл төгс) Тийм ээ ! Бид цаашид эрлээ

үргэлжлүүлнэ.

Хүмүүс: (Гуйж гувшсан байдалтай) Са Юнь багш аа !

Биднийг дагуулан цаашид эрлээ үргэлжлүүлэгтүн !

(Са Юнь инээмсэглэсээр тайзны голд хүрч ирээд тэнгээр өөд харан сэтгэлийн магтаалаа өргөн дуулна.)

Са Юнь: (Дээш харан)

Угаас хоосон цэцэгсийн түмэн явдалд суралцан

Ус сарны номын оронг байгуулъя

Чанар хоосон ертөнцийг цог төгс болгож

Чандар тоосыг биедээ халдаахгүйг тангараглая

Атгаг муу шулмын цэргийг номхотгож

Ашид мөнхийн Бурханы үйлийг бадруулъя

(Эрдэнэсийн эрэлчид найрал дуу)

Сэрэхгүй зүүдэнд сар жилээр оршивч

Сэхээрч гэгээрэх агшин зуурын хэрэг

Өнчин дэрэнд хаврын зүүдийг үзэхдээ

Өмнөд мөрнөөр мянган газрыг туулавай

(Үүр манхайн цайхад эрдэнэсийн эрэлчид шинэ эрч хүчийг олоод, галбинга шувууны яруу дуунд уулын цаанаас улаан нарны эхний туяа цухуйна.)

Хөшиг хаагдана.

17 23

ХОРИН НЭГНИЙ ӨДӨР

УЛБАР ТУЯА

Орчлон хорвоо анх үүсэхэд эхлээд газрын үр бүрэлдэж, улмаар модны үр буй болоод түүн дээр тулгуурлан бусад амьд биетүүд төрөн гарсан гэдэг. Модны үр газрыг хаван гарч ирэх нь билиг билгүүний гэгээ нээгдэж байгаатай төстэй байдаг.

Орчлонгийн жам ёс хүний үйл ажиллагааны уршгаар эвдэгдэх үед мод өргөн дэлгэр тарьснаар сая түүнийг хуучин горимд нь оруулах боломжтой.

ХҮЖЧИН ЭМГЭН

Або өдөр болгон орноосоо босуут нэг хүж уугиулж, анхилуун үнэрт нь хэсэг зуур бясалган суусны дараа, цай бүрж тааваараа уудаг заншилтай.

Або хүжийн суунаглах утааг харах бүрт харц нь гүн бодлогоширонгуй аястай болж, нүүрэнд нь амирлангуй инээмсэглэл тодрох нь ямар нэгэн сайхан зүйлийг таашааж байгаа лугаа адил харагддаг.

Цаасан шувуу Шидө ч мөн хүжийн суунагласан утаа өрөөн дотор уугихад дуртай бөгөөд учир нь хамаг биеийг нь ариусгах шиг болдог.

“Шидө минь ! Хүж асаах болгонд сэтгэл санаа уужран, хийморь золбоо сэргэх шиг болдог юм ! ” хэмээн Або хэлж байсан удаатай.

Нэгэн хүж үйлдвэрлэдэг хөгшин эмгэн өөрт нь өөрийн бүтээгдхүүнээ авчирч өгдөг гэж Або бас Шидөд ярьсан билээ.

Тэр эмгэн уулын нарсан төглийн дундах жижиг байшиндаа амьдардаг гэсэн.

Нарсан төгөл дэх агар зандан, мушгирмал арц зэрэг анхилуун үнэрт ургамал мянган наст нарсан төглийн шилмүүсний үнэртэй холилдон тансаг сайхан үнэрийг анхилуулах нь

байгаль дэлхий бүтэн жилийн турш хүж уугиулж байгаагаас өөрцгүй хүмүүний сэтгэлийг ариусгах увдистай ажээ.

Хүжчин эмгэн хотын өмнөд хэсгийн төгөл ойн дунд амьдарч, бүтэн жилийн турш хүжний ургамал нүдэж нунтаглан үйлдвэрлэсэн хүж нь хол ойргүй зар нь түгжээ. Абог бүр бага байхад л тийм нэг хүн явдаг байсан, өнөө хэр эмгэн ануухан тэнхлүүн хэвээрээ болохоор түүний тодорхой насыг хэлж мэдэх хүн хавь ойр үгүй.

Хүжчин эмгэн бүтэн жилийн турш аглаг ойд ганцаар амьдардаг хэр нь айж эмээх зүйл үгүй, маш хийморь золбоотой харагддаг. Хүүхдүүд хэд гурваараа хүжчин эмгэний үлгэрийн ертөнцөд зочлох дуртай болохоор нарсан төгөлд балчир жаалуудын инээд хөөрийн дуу тасрана гэж үгүй. Або ч гэсэн бага байхдаа нарсан төгөлд зочлон очих их дуртай байж билээ.

Хүжчин эмгэний гайхалтай сонин түүхийг сонсоод цаасан шувуу Шидө ч тэрхүү алдартай нарсан төгөлд очиж үзмээр санагдах болжээ. Өнөө өглөө хүж уугиулж байхдаа ойрд хүжчин эмгэнийд очоогүй болохыг Або санажээ. Тэгээд тэр Шидөгөө дагуулан хотын өмнөд дүүргийн чанад дахь нарсан төглийг зорив.

Нарсан төгөлд анхилуун үнэр ханхлана. Өглөө нарны туяа мөчир шилмүүсний завсраар тусаж болрын өнгийг цацруулна.

“Ёстой л үлгэрийн орон гэдэг ийм байдаг байх даа !” хэмээн Шидө нарсан төгөлд орж ирүүтээ дуу алдан хашгирав.

Хэдийгээр хөл хөдөлгөөнт хотын дүүргийн ойролцоо ч гэлээ хүжчин эмгэний амьдардаг нарсан төгөл үймээнт орчлонгоос ангид намуухан цэнгэг агаад, ойн зөргөөр алхан орсон хэн ч болов анхилуун агаараар цээж дүүрэн амьсгалж, орчлонгийн тоосноос огоот ангижраад сэтгэл санаа уужран ариусмаар ажгуу.

“Хүүе, энд хөшилдөх манан будангийн дундаас арш хувилгаад гараад ирэх юм биш байгаа даа !” гэж Абогийн мөрөн дээр жаахан хүүхэд мэт суух Шидө чихэнд нь шивэгнэв.

“Би ч багадаа мөн тэгж боддог байж билээ !” хэмээн Або санал нэг байгаагаа илэрхийлэв.

Анхилуун үнэрийг цээж дүүрэн амьсгалсаар Шидө тэр хоёр нэг л мэдсэн төглийн гүн рүү ороод иржээ. Тэнд нэг даруухан модон байшин нүдэнд туслаа.

Хаалганы хоёр талд өнгө нь онгож халцарсан улаан өнгийн хос уянга хаджээ.

“Ургаа модон төглийн үнэр дэлхий дахинаа анхилаг

Угаарт нүүрсний утааг нарны гэрэл халаг”

Або модон хаалгыг нүдэнгээ:

“Хүжчин эмээ ! Хүжчин эмээ !” хэмээн хашгирав.

“Хүжчин эмгэний амьдардаг газар энэ юм биз дээ ! Тэр

чухам ямархуу хүн байдаг юм бол доо?” гэж Або хаалга нүдэж байх зуур Шидө тэсгэлгүй амандаа бувтнав.

Гэвч байшинд хүн байгаа шинжгүй нам гүм оргино. Або дахин хэдэн удаа дуудсан ч хүн гарч ирэхгүй байтал модон хаалга салхинд чихран онгойлоо.

Модон байшин дотроо ихэд саруул, өрөөний гол дунд байгалийн модыг засаж урласан модон ширээ, хэдэн модон сандал тавьжээ. Хананд нэгэн том бүрх малгай өлгөөстэй харагдана. Хаалганы хацавчинд хэдэн хэлхээ ногоон гадил жимс унжуулж, эргэн тойрны хэдэн цонх шил толь шиг гялалзах нь харсан хүний сэтгэлийг уужруулмаар. Гялалзсан модон ширээний дээрх хэдэн урт модон хайрцганы хажуу бөөрөн дээр агар зандан, мушгирмал арц, алтан зул, шалгавар мод. . . . гэсэн бичиг хаджээ. Түүний дотор тухайн түүхий нунтаглаж талхласан нь харагдана. Хажууд нь ороомог хүж, урт нарийхан хүж, хэвтээ хүж зэргийг өрсөн байх аж.

Абогийн сэтгэл их л догдлонгуй ийн тайлбарлав.

“Шидө чи хар даа ! Эдгээр хүжчин эмгэний бүтэн жилийн турш сэтгэлээ гарган түүж бэлдсэн модны шилмүүс, цэцгийн шүүс, модны үртэс зэргийг нарийн нямбай нүдэж бүтээсэн хүжнүүд юм шүү дээ. Зөвхөн өрөөстэй байхдаа л ийм сайхан үнэр ханхлуулж байгаа юм чинь асаастай үедээ анхилуун утаа нь үнэртсэн хүн бүхэнд онгон байгалийн

унаган төрхөөрөө байгаа ойд очсон мэт сэтгэгдэл төрүүлэх нь ойлгомжтой.”

Хүжчин эмгэнийг дурсах болгондоо Абогийн үг ярианд балчир хүүхэд мэт хөнгөн атаархлын өнгө аяс илэрдэг билээ.

“Або чи өөрөө айлын гэрт хамаагүй орж болохгүй гэдэг биш үү?”

“Зүгээр дээ ! Тэр бол жирийн хүмүүсийн тухайд хэлсэн үг байгаа юм. Харин хүжчин эмээ бол анги хүн шүү ! Тэр үүд хаалгаа хэзээ ч түгждэггүй нь хүмүүсийг хэзээ ямагт өөрийнх нь анхилуун үнэрт модон байшинд морилон ирж болно гэсэн санаа. Чи хар даа ! Энэ модон байшинд онцгой сайн чанарын хүжнүүдийг өрж тавьсан атлаа хаалга үүдээ түгжилгүй орхисон байгаа биз дээ ! Гэсэн атлаа энэ модон байшингаас элдэв зүйл хулгайд алдагдсан гэж сонсоогүй л юм даа ! ” Або ийн хэлэх зуур өрөөний энэ тэрүүгээр явж үзнэ.

“Энд ирсэн хүмүүс өөрийн мэдэлгүй сайхан сэтгэлтэн болон хувирдаг ч байж мэдэх юм.” хэмээн эзнийхээ санааг сайтар гадарладаг Шидө өөрийн тайлбарыг хэлэв.

Або инээмсэглэсээр цонхны хажуугийн хушганы модон ширээний хажууд очиж суулаа. Ширээн дээрх чамин хийцтэй эртний модон бойпорноос хүжийн утаа суунаглана.

“Энэ чинь зандан модны хүж байна.” гээд Або нүдээ

анивхийлэнгээ хэллээ.

Або хүжийн үнэрт тааламжтай суугаа байдлыг харангаа
Шидө амандаа ийн бувтнав.

“Жижигхэн хүж ийм чухал үүрэгтэй байдаг нь мөн сонин
юм шүү !”

“Тийм биш гэж үү?” хэмээн агаарт жингэнэсэн дуу
сонсогдлоо.

Шидө дуу гарсан зүгт харвал нэг урт модон хайрцган дотор
нарийхан хүжнүүдийг жирийтэл өржээ.

“Хүжний үүрэг чиний бодож байгаагаас хавьгүй их шүү
гэдгийг би чамд хэлээд өгье л дөө !” гэж нарийн хүж дахин
өгүүлэв.

“Хавьгүй их үүрэгтэй гэнэ ээ?” гээд Шидө тээнэгэлзэнгүй
ханцуйгаа гөвлөө.

“Эс тийм бөгөөс эмээ яалаа гэж хүж хийх гэж тэр их
цаг завьг зарцуулах билээ дээ?” гэж хүж жингэнэсэн
хоолойгоор өгүүлээд

“Би өөрт чинь их энгийн жишээ ярьж өгье л дөө ! Өглөө
болгон эмээ гурван хүж асааж дээд тэнгэртээ мөргөчихөөд,
тэр гурван хүжийг том бодон дотор хатгаж орхидог юм.”

“Том бодон гэнэ ээ?” гэж Шидө нэлээд хачирхав.

“Тэр бодон дотор юу хийдгийг чи мэдэхгүй л биз дээ?” гэж
хүж жаахан зогсосхийснээ “Гадил жимс хадгалдаг юм шүү
дээ !”

“Гадил жимс гэв үү?” гээд Шидө бүр ч гайхаж орхив. Тэгснээ тэр хацавчинд өлгөөстэй байгаа түүхий ногоон гадилуудыг гүйлгэн харлаа.

“Тийм ээ, гадил жимснүүд. Эмээгийн хийсэн хүжнүүд хол ойр алдартайгаас гадна, түүний ургуулсан гадил жимснүүд ч гэсэн амт чанараараа гайхагддаг юм даа. Тэр ямар учиртайг чи мэдэж байна уу?” хэмээн хүж их л маадгар асуулаа.

Уран байгалийн уул усны үзэмжийг үзэхээрээ нэг болсон Шидө модон хайрцагтай хүжнүүд цаанаа л нэг учиртай эд болохыг ойлгоод их л гайхширангуй асууруу:

“Арай Хүж асааснаас үүдэлтэй юм биш биз дээ?”

“Тэгэлгүй яахав. Бодонд хийн болцоо хүлээж байгаа гадил жимснүүдийг өглөө болгон эмээ хүжээр утдаг болохоор онцгой амт чанартай болдог юм.”

“Ёстой сонин хэрэг гээч энэ байна даа ! ” гэж Шидө их л сониучирхан өгүүлээд цааш залгуулан асууруун “Яахаараа хүжинд утагдсан гадил тийм амттай болдог билээ?”

“Энэ бол өвөг дээдсээс уламжлагдан ирсэн билиг ухаан юм л даа ! ” хэмээн хүж бахдан өгүүлээд “Чи хүж асаахад ур чадвар хэрэгтэй байдаг гэдгийг мэдэх үү?” гэж өөдөөс нь сөргүүлэн асуулаа.

“Хүж асаахдаа гал бадартал шатаах хэрэггүй. Тэгвэл хайран сайхан хүжийг гарлагадсан хэрэг болно гэж Або хэлдэг л дээ ! ” гэж Шидө бодлогоширонгуй хариулав.

“Уухайс зүйтэй ! ” гэж хүж их л эелдгээр өгүүлээд “Хүж асаахдаа гал авалцуулахгүй байхаас гадна, хүжийн оч бүрэн шаталт явагдаагүй болохыг илтгэдэг. Чухам тэр бүрэн шаталт явагдахгүй үед үүсэх өвөрмөц гайхалтай анхилуун үнэрийн үрийг хүмүүс тосон хий гэж нэрлэдэг л дээ ! Хүж асаахын цаад мөн чанар нь тэр тосон хийг гарган авч эд юмсаа ариусган утахад байгаа юм шүү дээ ! Эмээ энэ нууцыг мэддэг болохоор хүжээ гадилын бодонд хатгаснаар түүний үр жимс гайхалтай сайхан амттай болдог.”

“Тийм болохоор хүж асааж байх үедээ сэтгэл санаа тайван байвал гал дүрэлзэн шатаад байдаггүй юм.” гэж саяхан л өвгөн судлаач шиг ултай юм ярьж байсан хүжнүүдийн үгний өнгө зөөлрөөд явчихад Шидөгийн сэтгэл ч гэсэн дагаад уясов.

“Хүж асаахад ийм нарийн ур ухаан хэрэгтэй байдаг гэж санасангүй шүү ! ” гэж Шидө шогшроод, хүжнүүдийн үгийг дамжуулан хүүрнэхэд Або бодлогоширонгуй өгүүлрүүн

“Тийм ээ ! Хүж гэдэг бол хүмүүсийг дээд тэнгэртэй холбох гүүр байдаг болохоор аажуу тайвуу, сүслэнгүй хандах ёстой гэж хүжчин эмгэн ярьдаг юм л даа ! ” гэснээ Шидө рүү хандан инээгээд

“Үнэндээ хүжийг гал авалцуулахгүй асаана гэдэг тун амаргүй шүү. Анх надад хүжчин эмгэн зааж сургахад би

арван хэдэн удаа оролдоод чадаагүй юм даг. Харин хэдэн арван жил хүж уугиулсан болохоор одоо ч гайгүй сурсан гэж болно оо.”

“Зөвхөн түүгээр ч зогсохгүй шүү ! ” гэх жингэнэсэн нарийхан дуу агаарт сонсогдов.

Энэ удаа модон бойпорт утаа уугиулан шатах агар зандан хүж ярианд оролцсон нь тэр ажээ.

“Хүж хийх, хүж асаах арга барил чухлаас гадна, асаасан хүжийг өргөнө гэдэг цаанаа хичнээн нарийн учир жанцантай байдгийг битгий мартаарай ! Асаасан хүжний анхилуун үнэр санаа сэтгэлийг уужруулаад зогсохгүй, атгаг нисваанисыг номхотгож өгдгөөрөө аюулт шулмын цэргийг дарж байгаа гэсэн үг юм шүү дээ ! ”

“Ай ! Үнэхээр мундаг юм аа ! ” гэж Шидө амаа олохгүй магтлаа.

Дээд зэргийн агар зандан модыг нунтаглаж хийсэн хүж цааш өгүүлрүүн:

“Хүжийн суунаглах утаа үр жимсний боловсроход тустайгаас гадна, аливаа түмэн бодисын дотоод сэтгэлийг ч ариусгах эрдэмтэй болохоор сэтгэл нь зөөлөрч, хатуу ширүүн араншинг засаж байдаг. Энэ болвоос аливаа хүн нарсан төгөл дэхь хүжчин эмээгийн гэрт оронгуут санаа сэтгэл нь уужран саруулсдагийн цаад учир шалтгаан юм шүү дээ ! ”

“Хүжчин эмээгийн гэрт хүмүүсийн хөл тасардаггүй нь цаагуураа бас л хүжийн утаатай холбоотой байх нь ! ” гэж Шидө шинэ эх газар нээсэн хүн мэт хөөрцөглөн хашгираад:

“Хотын бараг айл өрх болгон сангийн бойпортой байдагт гайхаад байх юм үгүй ажээ.”

“Хэдийгээр хүн болгон шахам хүж асааж мөргөдөг боловч, хүж уугиулахын жинхэнэ учир шалтгаан, тус эрдмийг ойлгодог хүн гэвэл зөвхөн манай хүжчин эмээ л байх шүү !
... ..”

“Хэ хэ ! Хэн миний тухай яриад байна даа?”

Абогийн үг хараахан хэлж дуусаагүй байтал гаднаас эелдэг буянтай ялдамхан дуу хоолой сонсогдов.

Шидө дуу гарсан зүг харваас нэгэн цал буурал толгойтой эмгэн модон хаалгыг түлхэн орж ирлээ.

“Хүжчин эмээ эргээд ирлээ ! ” гэж Або хөөрцөглөн дуу алдав.

Давжаа намхан биетэй, цэвэрхэн даавуу хувцастай хүжчин эмээ харсан хүнд нэг л өөг дулаан сэтгэгдэл төрүүлэх ажээ.

Тийм болохоор Шидө түүнийг харуут л талтай болжээ.

Өрөөсөн мөрөндөө нэгэн хулсан сагс хэлтгий үүрсэн хүжчин эмээ гаднаас хөнгөн шингэн алхласаар орж ирэв.

“Аа, чи байсан юм уу? Залуу минь ! ” гээд хаалгаар орж ирүүтээ Або байхыг үзээд хүжчин эмээгийн нүүрэн дээр тааламжтай ялдамхан инээмсэглэл тодорлоо.

“Хүжчин эмээ та сайн байна уу? Би урилга заллагагүй шулуухан хүрээд ирлээ.” гэсээр наян настай Або түүнийг угтан очих нь хүжчин эмгэний өмнө томоогүй жаахан хүүхдийг санагдуулна.

Тэр хүжчин эмээгийн мөрөндөө үүрсэн сагсыг буулгасны дараа сониучирхан харж, догдлонгуй өгүүлрүүн

“Та өнөө өглөө хаашаа яваад энэ нандин зүйлсийг олж ирээ вэ?”

“Овоо шүү ! Өнөө өглөө жиргэмэл бялзуухай намайг дагуулан арын том уулын гүн рүү аваачиж энэ бүхэнтэй учрууллаа.” гэхэд цал буурал толгойтой хүжчин эмээгийн нүүрэн дээр идрийн жавхаа гялалзаж, тунгалаг гэгээн нүднээс нь билиг оюуны хурц гэгээ цацрах мэт, уулзсан хүнд уужрал ухаарлыг бэлэглэх ажээ. “Энд ирээд хэр зэрэг удав даа?” гэж тэр ялдамхнаар асуулаа.

“Өглөө эрт ирсээн. Биднийг ирэх үед тэр модон бойпортой хүжний дийлэнх шатаад байсан.”

“Хэ хэ ! Чиний хоёр нүд чинь залуу цагийнхаасаа ч илүү хурц гярхай болоо юу даа?” хэмээн хүжчин эмээ инээвхийлэн хэлээд “Би өнөөдөр нээрэн ч маш эрт гарсан шүү. Уран дуут жиргэмэл бялзуухайн дуунд тогтож суугаад байх хэн байх билээ дээ? Мөртлөө тэр өөрт чинь эрдэнэд хүрэх замыг зааж өгөх гээд байхад чинь !” гэх зуур хүжчин эмээ нэг модон хайрцагнаас дугариг хүж гарган асаалаа.

Хүжчин эмээ хүж асаахдаа гал маналзуулахгүйн дээр үйл хөдлөл нь маш уран эвсэг болохыг Шидө олж харав. Хэдийгээр уулын хол замыг туулж ирсэн боловч хүжчин эмээ алжаасан шинж огт үгүй өөрийн түүж ирсэн зүйлсийг хурааж хумихын зэрэгцээ, Аботой инээж хөхрөн ярих нь хажуу дэргэдэх хүндээ тайван амгалан байдлыг бэлэглэнэ.

Тэр нэгэн дугуй хүжийг ширээн дээрх гуулин бойпорт хатгаад, Абог суухыг урьж өгүүлрүүн:

“Чи үнэрлээд үз дээ ! Энэ бол миний шинэ бүтээл байгаа юм” гэв.

“Өө ! ” хэмээн Або хөнгөн уулга алдаад, хүжчин эмгэн лүгээ хамт түүний шинэ бүтээлийг таашааж эхлэв.

Тунгалаг цонхны шилээр туссан нарны гэрэл ханан дээр ойж шаа торгон хөшиг мэт намилзана. Агаарт дүүрэн түгэх анхилуун үнэрийг таашаан суухуйд өрөөнд нам гүмхэн байх ажээ.Абогийн нүдээ анивхийлсэн нүүрэн дээрх он цагийн ул мөр болон үлдсэн үрчлээсүүд тавиран тэнийгээд ирэх шиг Шидөд санагдаж байлаа.

“Ёстой л нэг амирлангуй ертөнц гэж үүнийг хэлэх буй за ! ” хэмээн Шидө эцэст нь тэсгэлгүй уулга алдав.

Тэгж тэгсээр Або тааламжтай сайхан зүүд нойрноос сэрсэн мэт өөдрөг баясгалантай төрхөөр өгүүлрүүн:

“Энэ хүжийн үнэр цэнгэг анхилуунаас гадна үнэр нь агаарт

удаан хадгалагдах юм.” гэв.

“Шинэ хүжээ анх туршиж үзэхэд чи хамт байсан нь тун сайн хэрэг боллоо.” гэж хүжчин эмгэн толгой дохино.

“Өнөөдөр шинэ хүжээ анх туршиж үзсэн хэрэг байх нь ээ ! Тэгвэл бид ч чамгүй олз омогтой яваа юм байна даа ! Анхилуун хүж үнэртээд зогсохгүй, бас хүжний далд үүргийн талаар зохих мэдлэгтэй боллоо. Хүжчин эмээ өнөө хэр тэнхлүүн жавхаатай харагддаг нь цаагуураа хүжний утаатай холбоотой байх шүү ! ” гэж Абогийн мөрөн дээр сууж байсан Шидө хүжчин эмгэнийг нэлээд удаан ажигласны эцэст өөрийнхөө санаа бодлыг илэрхийлэв.

“Тэгэлгүй яахав. Хүжчин эмээгийн амьдралын эрч хүч хэр баргийн хүнийг урдаа гишгүүлэхгүй шүү ! ” хэмээн Або ч толгой дохин зөвшөөрнө.

Шидөтэйгөө хэсэг зуур ийн хүүрнэлдээд толгой өргөн үзвээс хүжчин эмгэн тэднийг инээмсэглэн харж суух тул Шидөг хараахан танилцуулаагүй байгаагаа санаж, нандин эрдэнэ олсон хүүхэд мэт ойрд тохиолдсон гайхалтай сонин зүйлсийн талаар түүнд ярьж өгөв.

“Яалаа гэнэ ээ? Үнэхээр сонин хэрэг байна шүү ! ” гэхэд түүний ярьсан болгон хүжчин эмгэнд их л сонин байгаа бололтой. Тэр Абогийн мөрөн дээр суугаа Шидөг хэсэг зуур сониучирхан ширтлээ.

Хүжийн утаа нэвт шингэсэн энэ орчин Шидөд ч мөн их

таалагдах тул тэр хүжчин эмгэнээс ийн асууруун:

“Энэ хүж яахаараа ийм гайхалтай сайхан үнэртэнэ вэ?”

“Ямар ухаалаг цаасан шувуу вэ?” гэж Шидөгийн баясгалантай төрхийг хараад хүжчин эмээ ч инээд алдаад “Тийм л дээ ! Хүж гэдэг бол чи бидэнтэй адилхан зүрх сэтгэлтэй байдаг юм. Миний хувьд хүж гэгч зүйл байхгүй бол амьдрал нэг л дутуу дундуур санагдах байсан буй за. . . .”

“Өө ! Би одоо ойлголоо ! ” гэж Шидө цасан цагаан өмсгөлөө дэrvүүлээд өгүүлрүүн “Хүж түмэн бодисыг утан ариусгаж, түүний амь насыг төгөлдөржүүлж байдаг хэрэг байх нь ! ”

“Шидө чи сайн хар даа ! ” гэж хүжчин эмээ тааламжтай өгүүлээд “Энэ хүжийн утаа тасралтгүй дээш уугидаг нь хөдөлгөөний эрчим юм шүү дээ ! Сэтгэлд хөдөлгөөний эрчим байсан цагт оюун ухаан, амьдрал тэр чигээрээ эрч хүчээр дүүрээд ирдэг.” гэв.

Энэ үгсийг бодолхийлэх зуур цаасан шувуу Шидө ямар нэгэн зүйлийг ухаарсан мэт ийн асуулаа.

“Хүжчин эмээ таны дундаршгүй их эрч хүч чинь дотоод сэтгэлийн эрчмээс үүдэлтэй хэрэг үү?”

“Шидө минь жинхэнэ уруу дорой байдал гэдэг гадаад өнгө үзэмжтэй төдийлөн холбоогүй харин түүний дотор сэтгэл ямар байгаагаас хамааралтай юм. Сэтгэл нь алжаас залхагт

баригдсан хүн оюун санааны хувьд гундуу, түүний улмаас өвчин эмгэгт өртөмхий байдаг. Харин дотоод сэтгэлийн хүчийг зохистой байлгаж чадваас оргилсон халуун эрч зоригоор халгиж, амьдралын аар саархан асуудалд түүртэхгүй баяр жаргалтай явах боломжтой. Өөдрөг оюун санаа бие махбодийг улам ч эрүүл чийрэг болгож байдаг гэсэн үг л дээ ! ”

“Тийм болохоор хүж асаах тоолонд сэтгэлийн дотоод эрчим өдөөгдөж, саруул оюун эрүүл бие махбодтой байж болох нь ээ ! ” гэж Шидө үгийг нь залгууллаа.

“Тийм л дээ ! Амь нас гэдэг маш гайхамшигтай ! Тэр дундаа сэтгэл бүгдийг удирдаж байдаг. Тийм болохоор тасралтгүй зугуухан уугих хүж бидний сэтгэлийг тасралтгүй, цаг ямагт шинэлэг бай гэж шавдуулж байдаг юм.”

“Тэгвэл хүж өөрөө хаанаас буй болдог юм бэ?” гэж Шидөгийн сониуч зан улам ч ихээр өдөөгдөв бололтой. Тэр хүжчин эмгэний өөрийнх нь амнаас хүжтэй холбоотой өөр олон нандин зүйлсийг сонсьё гэж хүсчээ.

“Ургаа модон төглийн үнэр дэлхий дахинаа анхилаг Угаарт нүүрсний утааг нарны гэрэл халаг ! ” хэмээн хүжчин эмгэн үүдэндээ хадсан хос уянгыг уянгалуулан уншсан нь Шидөгийн асуултанд өгсөн хамгийн бүрэн дүүрэн хариулт болжээ.

“Хүжчин эмээ мөн сайхан уянгалуулан уншиж байна шүү !

” гэж модон ширээн дээр өрөөстэй хүжнүүд нэгэн дуугаар бахдан өгүүлэв.

Анх дотогш орохдоо үүдэнд хадаастай байхыг хараад, одоо хүжчин эмгэн давтан уншиж дээр нь хүжнүүд бахдан дуу алдахыг сонсоод Шидөгийн сониуч зан бүр дээд цэгтээ тулав бололтой:

“Наад шүлэг чинь тэгээд ямар учиртай юм бэ?” хэмээн асуулаа.

“Шидө энэ хорвоо дээр тэнгэр газар үүсэх үед хамгийн түрүүнд буй болсон анхдагч юу болохыг чи мэдэж байна уу?”

Шидө хүжчин эмгэний ийн асуухыг сайтар тунгааж амжаагүй байтал өрөөний булангаас хүнгэнэсэн дуугаар хэн нэгэн:

“Тэр бол мод шүү дээ ! Нарны хөвгүүн байгаа юм. Орчлон хорвоогийн анх үүсэхэд эхлээд газрын үр бүрэлдэж, улмаар модны үр буй болоод түүн дээр тулгуурлан бусад амьд биетүүд төрөн гарсан гэдэг.”

Шидө дуу гарсан зүг рүү эргэн харваас хуван агаруу модны том тайрдсыг усанд сойн орхисон нь ийн ярьсан ажээ. Тэр болвоос мянган оны турш ихийг үзэж, эвдэршгүй хатуу биеийг олсон болохоор бусад хүжнүүд түүнд их л хүндэтгэлтэй хандан дуугүй байцгаана.

Энэ үеэр хүжчин эмгэн өгүүлрүүн:

“Хамаг бүхэн үүслийн төдийхөн байхад модны үр хөрс шороог хаван гарч ирээд тэнгэр газрын билиг билгүүний гэрлийг анх нээсэн гэдэг. Залгуулаад бусад өвс ургамлууд нарны гэрлийн шимийг хүртэн ургаж, дэлхий ертөнцийн өнцөг булан бүхэнд гэгээ гэрлийн амьсгалыг түгээснээр, эх газрыг өвч бүрэн гоёосноор үл барам, бусад түмэн бодисын амьдралд шаардлагатай усыг нөөцлөдөг болжээ. Бодоод үз л дээ ! Хүн төрөлхтөн бүгд л өвс ургамалтай хамт амьсгалдаг биз дээ? Шидө чи бас энэ хорвоогийн жинхэнэ анхилуун үнэр хаанаас үүдэлтэй болохыг сайтар бод доо? ”

“ ” Шидө хэсэг зуур чухам хаанаас гэдгийг бодоод олсонгүй.

“Чи цаасан шувуу болохоор энэ тэрүүгээр хэрэн нисэх боломж хамгаас их байдаг. Эх байгалийн дундаас агаар чамд ямар санагддаг вэ?” гэж хүжчин эмгэн түүнд эвлэгхэн санууллаа.

“Агаар ч цэвэр тунгалаг болохоор үнэхээр сайхан шүү. Бас энд тэнд явж байхад үл мэдэг анхилуун үнэр ханхладаг юм. ” гэж хэлэх зуур Шидө хэд хоногийн өмнө уулын хормойн зүлгэн дээгүүр нисэж явсанаа саналаа.

“Цаасан шувуу Шидө чи тун зөв ярьж байна ! Тэнгэр газрын хоорондох өвс мод, цэцэг ногооны анхилуун үнэр бүхий л агаарт нэвчсэн байдаг юм. Зандан, агаруу, шалгавар модод ч гэсэн хавь ойрын цэцэг модны доторхи

шим шүүсийг өөртөө хураан нэрээд тийм анхилуун сайхан үнэрийг гаргаж байгаа юм шүү дээ ! ”

“Аа тийм бий ! Модны үр хэмээгч хамаг анхилуун үнэрийн эх булаг юм байна шүү дээ ! Тийм болохоор ургаа модон төглийн үнэр дэлхий дахинаа анхилаг гэсэн хэрэг болж таарлаа.” гэхдээ Шидө их л юм ухаарсан шинжтэй харагдана. Тэр цааш залгуулан асууруун:

“Тэгвэл угаарт нүүрсний утааг нарны гэрэл халаг гэдэг чинь юу гэсэн утгатай юм бэ? Сонсоход л ямар ч байсан их яруу сонсогдож байна ! ”

“Модод өвгөрөөд газар өнхрөн унахын цагт би түүнээс модны тос, цэцгийн шүүс, үртэс зэргийг нь ялган авч, янз бүрийн анхилуун хүж хийдэгтэй агаар нэгэн юм л даа. Тэгээд тэр хүжийг асаахад анхилуун сайхан үнэр ханхладаг биз дээ?” гэж хүжчин эмээ инээмсэглэн өгүүлээд цааш нь:

“Өгөр мод өнхрөн унах үеэс эхлэн нүүрсжиж эхлэдэг бөгөөд дээрх шүлэг дэх нарны гэрэл гэдэг нь түүнийг шатаахыг бэлгэдэж байгаа хэрэг. Тэгээд түүнийг асаахад өөр нэгэн амьдралын гэрэл цацардаг болохоор би угаарт нүүрсний утааг нарны гэрэл халаг гэсэн юм.” гэв.

“Эх байгаль гэдэг ийм гайхалтай байдаг ажгуу. Нэг цэцэг бүхэл бүтэн ертөнц, ганц навч гэдэг түүнчлэн ирэгсэн гэдгийн далд учир энд байна шүү дээ.” гэж тэдний яриаг чагнан удтал дуугүй суусан Або өөрийн эрхгүй дуу алдлаа.

“Модны үрийн амьдрал үнэхээр гайхалтай сонин л доо. Тэр газрыг түшиглэн соёолоод усны хүчээр ургаж төлжиж байдаг. Харин галын дөлөнд нүүрс болж, салхины улмаас үнс болон хийсдэг. Тэгээд газар унахаараа хөрсийг тэжээж, улмаар талсжин болор болдог бус уу?” хэмээн ярьж байх зуур хүжчин эмгэн хүжнүүдийн гайхамшигтай сайхан ертөнцөд уусан шингэв үү гэлтэй хэсэг зуур чимээгүй болсноо дахин өгүүлрүүн:

“Тийм болохоор дээрх хос уянга амьдралын өөр нэгэн нууцлаг талыг илтгэн харуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл модны эх бие шатаж нүүрс болон хөрсөнд шингээд, дахин давтан дарагдсаар нөхцөл боломж бүрдээд ирэхийн цагт мөнөөх нүүрс маань талст болон хувирдаг. Анх үйрэмхий, хар өнгөтэй байсан нүүрс газрын гүний өндөр даралт болон халууны хүчинд олон он жилийг элээсээр эцэс сүүлдээ орчлон хорвоогийн хатуу, нүд баясган гялалзах очир алмас эрдэнийн чулуу болдог гэвэл чи үнэмших үү?”

Хүжчин эмээгийн энэ үг Або, Шидө хоёрыг бүр алмайруулж орхив. Хүжчин эмгэн цааш өгүүлрүүн:

“Хүн амьдралын дунд сэтгэлийн гүн дэх билиг оюуны галыг асааж байх учиртайг ойлгох хэрэгтэй. Тэгээд тэр галыг улам өрдөн бадрааж түүний гэрлийг баримжаалан зоримог ураглах аваас амь амьдралын гүн дэх нууцлаг гайхамшигтай атлаа жинхэнэ мөн чанарыг нь олж үзэх боломжтой ! ”

Нүдний өмнө дээш суунаглах хүжийн утааг харж, хүжчин эмээгийн намуухан хүүрнэхийг сонсох зуур Або, Шидө хоёр өөрийн эрхгүй ягуухан бодлын агаарт уусан нэгдэвэй

Харих замдаа өндөрт хөөрөн нисэх Шидө сэтгэл хоргодсон бололтой байн байн эргэж харангаа:

“Хүжчин эмээ ч үнэхээр их эрдэмтэй хүн юм аа ! ” гэж бахдана.

“Хүжчин эмээ хэр баргийн хүний уншиж чадахааргүй байгалийн номыг уншдаг. Гэтэл хүмүүс өөрийн эргэн тойронд байгаа зүйлсийн учрыг мэдэхгүй мөртлөө өөрсдийн таньж мэдэхгүй өөр ертөнцийг эрэлхийлэн зүтгэх юм гэж эмээ өөрөө ярьдаг л даа ! ”

“Өө ! Тэгвэл тэр ёстой ер бусын хүн байх нь ээ ! ”

“Чи бид хоёр ч өнөөдөр хүжсийн ертөнцөд нүд онгойв бололтой.”

Або цаасан шувуу Шидөгөө дагуулан номин хулст төглийг чиглэн алхлаа.

* * *

Хүжчин эмгэнийд бүтэн өдөр байсан Або сэтгэл санаа нь ариусан шинэчлэгдсэн Шидөгөө дагуулсаар нарсан төглийг өнгөрч хотын дүүргийн чанад дахь үтрэмийн талбай дээр хүрэлцэн ирлээ.

“Тэртээх дорно зүгийн уулын оройг хар даа ! ” хэмээн Шидө

гэнэт бахдангуй хашгирлаа.

“Өө, суунаг одон бороо байх шив дээ ! ” гэж Або ч мөн баясалтай өгүүлээд ойрын хэдэн өдрийн турш од мичид түгсэн сайхан орой болж байгааг эргэн саналаа.

“Хачин юм даа ! Шидө чи анзаарав уу? Фэнтори хамтлагийн тоглолт хийсэн шөнө болгон од сарны гэрэл огторгуй тэнгэрийг гийгүүлээстэй байх юм.”

Шидө ч мөн шөнийн үзэсгэлэнтэй тэнгэрийг дээш өлийн хараад “Та нар ч бас жүжиг үздэг юм уу?” хэмээн хөөр баясалтай хашгирлаа.

“Хүн болгон энэ хорвоод анх мэндлэх үед түүний тэнгэрийн өмсгөлд нэгэн хосгүй үнэтэй гэгээн сувд хадгалаастай байдаг гэлцдэг.

Эрхэм үзэгчид ээ ! Өнөө орой тавдахь шөнийн үлгэрийг та бүхэнд толилуулахад бэлэн боллоо.

Өмсгөл доторх гэгээн сувд ! Өмсгөл доторх гэгээн сувд ! Амьдралын элдэв нугачаа бүдрээн дунд өөрийн өмсгөл доторх тэрхүү гэгээн сувдыг зарж үрчихээгүй хүн л урт холын аян замд чиг зүгээ алдан тэнүүчлэхгүй, хамгийн эрхэм баян туйлыг эдлэдэг ажгуу !

Эрхэм үзэгчид ээ ! Харин та бүхэн өөрсдөдөө байгаа тэр гэгээн сувдын тухай бодож байсан удаа бий юу?

Өнөө орой та бүхэнд толилуулах жүжиг магадгүй таны

амьдралд ч тохиолдоод өнгөрсөн хэрэг байхыг хэн мэдэх билээ.

Өнчин өрөөсөн, өлөн зэлмүүхэн тэнүүчлэж явсан хүн хүнд бэрх зовлон зүдгүүрийг даван туулсаны эцэст түүний уранхай хувцсан дотор хорвоод хосгүй үнэтэй гэгээн сувд агуулагдаж байсныг олж мэдэх тэр агшинд орчлон хорвоо тэр аяараа өөрчлөгджээ.

Фухуа хүний сэтгэлийн утсыг хөндсөн энэ оршлыг хэлж байх зуур хөшиг зугуухан нээгдэж цоглог яруухан магтаал дуу тайзны хүрээнээс халин нийт үтрэмийн талбай хүрэлцэн ирсэн хүмүүсийн сэтгэлийн далай дээгүүр дуурсав.

【ТАВДАХЬ ШӨНӨ】

ӨМСГӨЛ ДОТОРХ ГЭГЭЭН СУВД

ΔГИМАЛАЙН НУРУУНЫ ХОРМОЙ

Цасан малгай духдуулсан Гималайн нуруу цэцэг дэлгэрэх
хаврын гурван сард цас мөсөн өмсгөлөө халахад, хавь ойрын
гол горхи үерлэн урсах нь алсаас харахад шар луу эрчлэн
бууж байгаа мэт сүртэй агаад тэнгэрийн сүүн гол чухам
эндээс л эх авдаг болов уу гэлтэй.

Хэрмэл хөвгүүн: (Дуулна)

Дэлгэр хаврын улирал

Дэлхий дэлэгнэх цагаар

Хоног хоногийн урсгалд

Хорсоор байна даа нас минь

Чулуун яндрын хавь ойр

Чуулсан цэцэгс найгалдах нь

Урин сайхан хаврын

Угтал үзэмжийг илтгэнэ.

Угтал үзэмжийг илтгэнэ.

Уудам тэнгэрийг бараалахуйд

Урин хаврын амьсгал дүүрч
Хувьсамхай хаврын гэгээ
Хурууны үзүүрийг дайрав

Усны мандлыг харахуйяа
Улбар нарны үлдэл туяа
Цайрах яралжинд хоргодсоор байна
Цацрах хөөсөнд ч мөн

(Уйтгар зовлонд шаналсан хэрмэл хөвгүүн урин хаврын
үзэмжийг бахдан хэсэг зуур нүүрэнд нь баясал тодорлоо.)

Хэрмэл хөвгүүн: Уул усны үзэмж хичнээн сайхан байна
вэ? Усны мандал хажуу эргийн суврагыг тольдож, хаврын
салхинд анхилуун үнэр шингээд.Гэвч.

(Урин хаврын салхи хэрмэл хөвгүүний биеийн тааламжтай
илбэх боловч түүний сэтгэлийн гүн дэх нисваанисын
үүлийг хөөж тууж чадахгүй ажээ. Тэрбээр нүглээ
наманчлан, буянд сүслэх сэтгэл өвөрлөсөөр мянганы газрын
туулан явахдаа олон жилийн турш уулзаж учраагүй авга
ахыгаа эрэлхийлэн яваа юм.)

Хэрмэл хөвгүүн: (Толгодын орой дээрээс хотын зүг
бараалан харж амандаа ийн өгүүлрүүн) Авга ах Саравасти
хотод суурьшин олон жилийн турш үнэн сэтгэлийн угаас
Бурханыг шүтэж ирсэн. Тэр жил болгоны хавар номын
үйлээр замнагч хүмүүст өглөг хүндлэл үзүүлж,

эрдэмт лам хуврагуудаар орчлон хорвоо болон хүмүүний амьдралын үнэн мөн чанарын тухай ном талбиулдаг. Түүний зэрэгцээ өнчин ядуу хүмүүст өглөг хишгийг харамгүй түгээдэг байсан сан. Харин түүн лүгээ хэзээ дахин учрах бол доо?

ДСАРАВАСТИ ХОТЫН НОМЫН ХУРАЛ

(Саравасти хот болвоос умард Энэтхэгийн том хот бөгөөд хэрмэл хөвгүүн тус балгадад хүрэлцэн ирэх үест хог шороог цэмцийтэл шүүрдэж цэвэрлэсэн хотын гудамжинд номын яруу дуу эгшиглэж, шүхэр дуаз салхинд дэрвээд, нааш цааш зорчих хүмүүсийн царайд баясгалантай инээмсэглэл тодрон. Эрдэнийн дуазыг баримжаалан явсаар тэр удаж төдөлгүй ном тавьж байгаа өргөн талбайд хүрэлцэн ирлээ. Энэ үеэр ном талбиж байгаа өтгөн урт хөмсөгтэй настан буурал судрын үгсийг ийн айлдруун.)

Урт хөмсөгт өвгөн:

Үлгэрлэвээс нэгэн ядуу хүмүүн бээр

Үнэнч найзындаа айлчлан очжээ

Газар даамгүй баян найз нь

Гараа гарган түүнийг дайлжээ.

Хорвоод хосгүй гэгээн сувдыг ч

Хормой хотонд нууцаар зүүгээд

Огт тэр тухай дурсалгүй
 Ор засаад унтуулж гэнэ
 Хоосон ядуу нөгөө найз нь
 Холын улсыг зорин яваад
 Аяга тагш будаагаа л бодсоор
 Амьдрал нь ч олигтой дээшлэсэнгүй ажээ
 Хоёр идэхгүй хоосон хонохгүй
 Хорвоогийн хоногуудыг үдэх болжээ
 Хормойд нь нуусан гэгээн сувд
 Хосгүй үнэтэйг ч мэдэлгүй явжээ.
 Ховорхон сувдыг бэлэглэсэн найз нь
 Хожмын өдөр түүнтэй тааралджээ
 Анзааргагүй найзыгаа тэр зэмлээд
 Алган дээр нь тавьж үзүүлжээ
 Яндашгүй үнэт сувдыг үзээд
 Ядуу эр ихэд баярлав
 Саяар тоологдох эдтэй болж
 Санасан хүсэл нь гүйцэлдэж гэнэ
 Бид нар ч гэсэн түүнээс өөрцгүй буюу.
 (Хэрмэл эр хоёр алгаа хавсран завилж суугаад ном сонсож
 эхлэхэд хэдэн жилийн өмнө тохиолдсон нэгэн явдал түүнд
 өөрийн эрхгүй санагджээ.Түүнчлэн Са Юнь авгынх
 нь цайлган инээмсэглэл түүнд харагдах шиг болж гэнэ.
 Эргэн тойрных нь үзэгдэл юмс аажмаар бүдэгрээд, хэсэг

байзнасны дараа тайзны нэгэн булангаас гэрэл мэлсхийн асахад хэдэн жилийн өмнө болсон нэг үйл явдлыг үзүүлнэ.)

Са Юнь: Зээ дүү минь, чи өнөө орой манай энд хоноглогтун ! Манай энд нэгэн эрдэмт хувраг үйлийн үрийн учир шалтгааны талаар дээдийн номыг хоёр гурван хоногийн хугацаатай талбих тул чи түүнийг сонсох хэрэгтэй !

Хэрмэл хөвгүүн: (Даруухан) Баярлалаа. Авга минь !

(Анх удаа тэдний айлчлаж байгаа хэрмэл хөвгүүн санаа сэтгэлийн байдал жаахан гундуу байсан боловч Са Юнь түүнийг үнэн сэтгэлийн угаас дайлж, сайтар гэдэс гарсаны дээр, дээдийн номын айлдвар сонссоноор чиг зүгээ алдчихаад байсан сэтгэл нь өөг дүүрэн болжээ. Тэгээд тэр цадтал идсэний дараа унтаад өгчээ.)

ДУНТЛАГЫН ӨРӨӨ

(Са Юнь хэрмэл хөвгүүний унтлагын өрөөний хажууд ирвээс хир даг болсон хувцастайгаа их л тааламжтай унтаж байгааг үзээд, сэрээж төвдсөнгүй дотроо ийн бодруун.)

Са Юнь: Би энэ удаа шавь нарынхаа хамтаар гадагш яваад хэзээ эргэж ирэх нь магадгүй. Энэ хүүхэд намайг эргэж ирэхийг хүлээж чадалгүй ийш тийш яваад өгвөл гар дээрээ ганц сохор зоосгүй хүн чинь гудамжаар тэнүүчлэхээс өөр яах билээ? Хэрвээ дэрнийх нь хажууд шинэ хувцас, зоос

мөнгө орхичихоор бас л төдийлөн нэмэргүй юм даа ! Хувцас нь урагдаж, мөнгө барагдахаар бас л бахь байдгаараа болно гэсэн үг биш үү?

(Ийнхүү сайтар бодсоны эцэст тэрбээр өврөөсөө нэгэн эрдэнийн сувд гаргаж ирээд хэрмэл хөвгүүний энгэрт нямбайлан хадаж өгөв. Ийн дуулна.)

Са Юнь: (Дуулна)

Тэнгэрийн үүлс бараантан усны зах харагдахгүй
Тэнүүлч хөвгүүн гагцхүү зүүдэн дундаа амгалан
Харанхуй шөнө хавсрага жиндүүлэхэд
Харихын хүслэн сэтгэлийг шаналгана
Амрах нойр хулжаад орондоо хөрвөөхөд
Арьяабал Бурхан хажууд залрах мэт

Унжлага сувд хувцсанд чинь бий
Унжлага сувд биед чинь буй
Маргааш өдөр гудамжинд харуй бүрийн алдад
Магад өвгөн бодь мод буцах хэрээг харах буй за
(Ийн дуулсаар Са Юнь эрдэнэсийн эрэлчдийн хамтаар алсын аянд гарахад гэрэл аяндаа унтрана.)

ДСАРАВАСТИ ХОТЫН БОДЬ МОДОТ ОЙ

(Ном хурж буй талбайн байдал зугуухан тодроход хэрмэл

хөвгүүн зүүд нойрноосоо сэрж, нүдээ нээгээд ийш тийш
харваас хүмүүс номоо хурсаар байх ажээ. . . . Тэр ямар
нэгэн зүйл бодолхийлэн бодь модот ойгоор нааш цааш
холхино.)

Хэрмэл хөвгүүн: (Дуулна)

Уулыг өгссөн зам тэнгэрийн хаяанд шингээд
Улаачлан өртөөлөх үүлс уулсын толгойг давлаа
Юундаа ч ингэтэл тэнүүчлэнэ вэ
Холыг туулах хөлгүй атлаа
Хорвоогийн энгээр ийнхүү тэнүүчлэх юм

Урьд шөнийн зүүдэнд хүрэл хонх
Уушиг зүрхийг цочоон дуугарсан
Бараан үүлсийн ханзархайгаар
Баахан одод газарт асгарсан
Ажиж сайтар харваас
Алсын гэгээн уулс сэтгэлд оршоод
Ухаарч сайтар сонсвоос
Уулын горхи ном айлдах мэт урснам
(Хэрмэл хөвгүүн буцаж алхсаар ном айлдаж байгаа талбайд
хүрч ирнэ. Са Юнь болон эрдэнэсийн эрэлчид ч мөн хотод
хүрэлцэн ирлээ. Нүдний өмнөх хосгүй төгс байдлыг үзээд,
Юэгуан Тунз тэсгэлгүй баярлав.)
Юэгуан Тунз: (Дуулна)

Мяралзах усан үүлсийн доогуур урсаж
Мянган уулс тасархай замыг бараална
Аясын салхи намжиж бороо зогсоход
Алжаасан шувуу хуучин ойгоо тэмцэв

Үдшийн цахирмаа шувуудын жиргээг анирлахуйд
Үүлгэртсэн аянчин сэтгэлийн үгсийг хүүрнэвэй
Анх гарахад өвс ногоорч байсан
Алаг цэцэг зулгарахуйд буцаж ирэвэй

Урин хаврын зүүд дуусахад үлдэх мөргүй
Уул бие маань унаган түрүү өсөнтөө эргэх мэт
Өдгөө дорнод шивээний удвал цэцэг шарлах нь
Өрнөд цонхны хуучин цэцэрлэгийн явдал

Бадмын навчис яагаад ийн үелнэ билээ
Бас лянхуа юунд ийм үзэсгэлэнтэй ургана вэ?
Өмхий лаг дундаас цухуйн гардаг хэр нь
Өчүүхэн ч тоос биедээ яагаад эс халдаана вэ?

Урсгал ус уул өнгөрмөгц бохирдоно
Уулнаа байхдаа тунгалаг байдлаа хадгална
Цэцэг зулгаравч хавар бахь байдгаараа
Цэлмэг огторгуйд саран гагцаар шинэхэн

(Ийн дуулах зуур олон хүн Са Юньг бүчин энэ тэрийг ярьсаар ном айлдаж байгаа газарт хүрэлцэн ирнэ.)

Шавь А: Са Юнь багш аа, та наашаа ирээд хар даа ! Олон эрдэнийн дуаз салхины аясаар дэрвэх нь хичнээн үзэсгэлэнтэй сайхан харагдана вэ?

Шавь Б: Их л хөлтэй байх чинь ! Ийм олон хүн цуглачихаад ном айлдахыг сүслэн сонсож байна шүү дээ !

Шавь В: Са Юнь багш аа, хот хүрээг ийм сайхан цэвэрлэхжээ. Би ч гэсэн тэдний дунд ороод ном сонсохыг маш их хүсэж байна.

(Са Юнь ч талбайг хүрээлсэн бодь модон төгөлд ирээд тайвуухан ном айлдахыг сонсож эхлэв. Гэнэт нэгэн хүн ном айлдаж байгаа зүгээс гарч ирлээ.)

Хэрмэл хөвгүүн: (Их л баясгалантай) Хүүе, энэ чинь авга ах уу даа !

Са Юнь: (Мөн л баясгалантайгаар урагш ухасхийж) Хүү минь, чи яахаараа энд байж байдаг билээ?

(Тэр хоёр баярлан тэврэлдэхэд, эрдэнэсийн эрэлчид тэднийг бүчин авлаа.)

Юэгуан Тунз: (Гэнэт санасан байдалтай) Хүүе, чи чинь Са Юнь багшийн зээ хүү байх шив дээ ! Хэдэн жилийн өмнө бас л нэг ийм дээдийн номын хурал дээр би чамайг харж байсан юм байна. Хэдийгээр ганц удаа уулзсан ч гэсэн өнөө хэр тодхон санагдаж байна шүү.

Хэрмэл хөвгүүн: (Уясангуй) Тэгэлгүй яахав. Тэр үед би мянган газрын тэртээгээс хамаатнаа бараадаж ирсэн болохоор хийморь сүлдгүй амьтан байсан. Нигүүлсэнгүй сэтгэлт авга ах маань өнчин өрөөсөн намайг өрөвдөж, дэргэдээ байлган авралт лам багш үйлийн үрийн учир шалтгааны тухай дээдийн ном талбихыг соёрхож билээ. Хурлын хамгийн сүүлчийн шөнө би ном сонсож, цадтал хооллочихоод сайхан унтаад өгсөн сөн. Тэр тухай би одоо хэр нь тод санаж явдаг шүү.

Са Юнь: (Их л найртай зөөлнөөр) Тэр өдрийн өглөө би холын аянд явахдаа чамайг сайхан унтаж байхаар сэрээж төвдөлгүй, зарц нартаа сайтар харж хандаж байгаарай гэж захиад үлдээж билээ. Гэвч хожим сонсох нь ээ, чи сэрээд сэмээрхэн яваад өгчихсөн гэдэг. Би ч энэ тэрүүгээр сураг ажиг тавьсан боловч нэмэргүй хоцорсон.

(Са Юнь хэрмэл хөвгүүнийг сайтар сонжин ажиглаж байх зуур эрдэнэсийн эрэлчид хажууд нь хэрмэл хөвгүүний олон жил тэнүүчлэн явах үеийн байдлыг дүрслэн дуулна)

Эрдэнэсийн эрэлчид: (Найрал дуу)

Уулын хөндий чимээгүй дүнсийх нь

Уйссан сэтгэл лүгээ адил

Урт сунасан сүүдэр л

Урагшлах замд нөхөр болно

Үдшийн бүрэнхий
Үг хэлгүй налайж
Чагнаархан сонсоход
Чацат хоёр хөлийн
Алхаа л сонсогдох ажгуу

Өдөр болгон хүрэл хонх
Үдшийн бүрийгээр нүргэн дуугарахад
Уулын хөндийн цууриа түүнийг
Улам ч алсад дамжуулан сонсгоход
Сэтгэлд хурсан үүлс сэмрэн замхаравай

Цээж хэнхдэгийг задгайлан
Цэнгэг горхийг бараадаад
Өвөр зуураа ажиглахуйд
Өнчин ганц хэвээрээ

Урагш сажлахад
Урин салхи
Ханцуй сугалдрагыг
Хажуу тийш хийсгэнэ

Алсын уулын хүрэл хонх
Амгалан шөнө тодхон дуурьсана

Одон саранг дуудан сэрээж

Орчлонгийн хүмүүсийн сэтгэлийг гийгүүлэвэй

(Яруу хөгжмийн аялгуун дор эргэн тойрны гэрэл бүдгэрч эрдэнэсийн эрэлчид далд орно. . . . Нэгэн хурц гэрэл бодь модны үзүүрээс гялалзахад Са Юнь хэрмэл хөвгүүн лүгээ ярилцаж байгаа дүрс тодорно.)

Са Юнь: (Хөөрхийлсөн байдалтай) Чи яахаараа ийм уруу дорой байдалтай харагдана вэ? Эдгээр жилүүдэд юу хийж байв даа?

Хэрмэл хөвгүүн: Авга ах аа, түрүүчийн удаа уулзан салснаас хойш миний сэтгэл зүрхэнд нэгэн нандин зүйл үлдэж хоцорсон мэт санагдах болсон шүү. (Хэсэг зуур бодолхийлнэ.) Хэдийгээр чухам юу гэдгийг эс мэдэх боловч би бага балчир үе шигээ ганцаардан гансрахаа больчихоод байгаа. Сүүлийн хэдэн жил би энэ тэрүүгээр явж амин зуулга залгуулан, амьдрал ахуй амаргүй байдаг боловч, тэр жил дээдийн номын хурал дээр сонссон зүйлс байнга дурсан санагдаж, давтан унших үед сэтгэл маань маш тайван амирлангуй болдог нь гайхалтай.

Са Юнь: (Инээмсэглээд) Уухайс, чи тэгээд чухам юу ойлгож ухаарав даа !

Хэрмэл хөвгүүн: (Толгой гудайлган) Би урьд нь хар багаасаа ачит аав ээжээсээ хагацаж, хаа ч явсан бусдад дээрэлхүүлж байдагтаа ихэд гутардаг байсан юм. Харин одоо надад бүр ч

нандин зүйл байдаг болохыг ойлгож мэдсэн. Бусад хүмүүс намайг гадуурхан дээрэлхэх тусам би улам хатуу чанга болж, мөнөөх нандин зүйлээ олж авахаар шаргуу хичээдэг болсон.

Са Юнь: (Их л нигүүлсэнгүй) Хүү минь, чи номын гүн ёсыг ухаарсан нь илт байна. Гэвч чи одоо болтол би чиний уранхай хувцсанд чинь сэмээрхэн хадаж өгсөн эрдэнийн сувдын нууцыг мэдээгүй нь харамсалтай.

Хэрмэл хөвгүүн: (Гайхширангуй) Эрдэнийн сувд гэнэ ээ? Юун эрдэнийн сувд билээ?

Са Юнь: Тэр жил би алс хол явахдаа чиний унтаж байгаа төрх байдлыг ажиглахад, үзэж туулсан зовлондоо шаналсан бололтой хөмсгөө атируулсан байсан. Тэгээд би чамайг хар багасаа чамгүй зовлон амсаж овоо чанга хатуу зантай болоо юу гэж бодсон юм. Тэр үед би хэзээ эргэж ирэхээ мэдэхгүй болохоор чамайг ар худрагаар хэл чимээгүй яваад өгвөл гар дээрээ ганц сохор зоосгүй хүн чинь гудамж зээлээр л хэсүүчлэнэ дээ? Яадаг билээ гэж бодсон боловч олигтой арга олддоггүй, тэгээд эцэст нь хосгүй үнэт эрдэнийн сувдыг чиний уранхай хувцасны энгэрт хадаж өгсөн юм.

(Хэрмэл хөвгүүн энэ тухай сонсоод их л гайхширан алмайрч орхив.)

Са Юнь: (Дуулна)

Тэнгэрийн үүлс бараантан усны зах харагдахгүй

Тэнүүлч хөвгүүн гагцхүү зүүдэн дундаа амгалан

Харанхуй шөнө хавсрага жиндүүлэхэд
Харихын хүслэн сэтгэлийг шаналгана
Амрах нойр хулжаад орондоо хөрвөөхөд
Арьяабал Бурхан хажууд залрах мэт

Унжлага сувд хувцсанд чинь бий
Унжлага сувд биед чинь буй
Маргааш өдөр гудамжинд харуй бүрийн алдад
Магад өвгөн бодь мод буцах хэрээг харах буй за

(Ийн дуулах үед хэрмэл хөвгүүн ямар зүйлийг ойлгосон
мэт бодолхийлэн байснаа уг дууг дагаж амандаа аялав.)

Хэрмэл хөвгүүн: (Гэнэт сэхээрсэн бололтой) Би сонссон
юм байна. Энэ дууг урьд нь би сонсож байсан юм байна.

Са Юнь: (Уужирсан байдалтай) Хүү минь, чи ашгүй санав
уу? Тэр жил би чиний хувцсанд хадаж өгсөн тэр гэгээн сувд
болвоос үнэлж баршгүй нандин эрдэнэ тул чиний амьдралыг
хэдэн үеэр чинь ч өөрчлөх шидтэй юм шүү.

(Хэрмэл хөвгүүн Са Юний зүг гайхширан ширтэж байх
зуур тайзны арын гэрэл солбин асаж унтраад өвгөн лам
болон эрдэнэсийн эрэлчид ийн дуулна)

Хүмүүс: (Намуухан атлаа хөгжилтэй)

Алтан өнгөт жиргэмэл бялзуухай сэрээрэй

Алив хурдан тоосыг нэвтлэн гараарай

Цогчин дуганы номын хонхыг сонсов уу

Цог төгөлдөр ертөнцийн дунд
 Билгүүн оюунт нэгэн хүмүүн
 Бичигт номын гүн ёсыг тайлан
 Бичил тоосны гүнд нэвтэрч байна.

(Намуухан давтамжтай дуугарах модон загасны нүргээн дунд хэрмэл хөвгүүн хичээнгүйлэн бодолхийлсээр байх ажээ. Нэг тал саран тэнгэрт хөөрөн мандахад, тайзны арын гэрэл зугуухан бүдэгрэнэ. Талбайн энд тэндгүй зулын гэрэл гялалзахад хэрмэл хөвгүүн гэнэт ухаарсан төрх царайд нь илрэв.)

Хэрмэл хөвгүүн: (Маш баясгалантай) Тийм ээ, хувцсанд хадаастай өмсгөл доторх гэгээн сувд ! Хувцсан доторх гэгээн сувд ! Би бүгдийг ойлголоо. Би орчлонгийн гүн ёсыг оночихлоо. (Залгуулаад ийн дуулна)

Үдшийн бүрийн тэнгэр дор
 Өөрийн зүүдийг олж үзэв
 Харуй бүрийн гэгээ тасрахад
 Хавьсан саран сэтгэлийн мэлмийг нээлээ

Агшин зуурт нэжгээд цэцэг навч
 Ааш ялдам инээвхийлж
 Гурван мянган ертөнц ч
 Гуйранч миний зүг
 Гудиггүйхэн инээвхийллээ.

Энэ бүхнийг чи бид л мэднэ
Инээвхийлэх цэцэг навч
Их мянган ертөнц
Зүүрмэглэх нойрны зүүд төдийхөн
Зөршгүй үнэн тэр болой
(Дууны аялгуу зогсоход нүргэлсэн чимээн дор тайзны
гэрэл мэлсхийн тодроно. Ар талын хүмүүс бүгд нэг эгнээ
жагсаад ийн дуулна.)
Хүмүүс: (Найрал дуу)
Тэнгэрийн сар усанд тусах нь уйтай
Тэртээ уулын цаагуур саран далдарлаа

Эрвэлзэх зүүдний зочин энгэрт зүүсэн сувд
Эргэж ирэхийн зуур тоос болон замхарна

Гаднаас бүү эрэгтүн, гаднаас бүү эрэгтүн
Гэртээ дэмий сууж чалчсаар байтал
Гишгүүрт шатны тоорын цэцэгс гурван хувь дэлгэрлээ
(Бөмбөрийн нижигнэсэн дуу талбайн зүгээс дуурьсахад
хүмүүс дуулахаа больж, Са Юнь дээш тэнгэрийг ширтэн
ийн өгүүлнэ)
Са Юнь:
Олон гол далайг чиглэн урсаад
Очсон хойноо тийм гэх тэмдэггүй

Хүмүүний сэтгэл орныг даган хувиравч

Хувирлын эцэст хуучин байрандаа ирнэ

(Тайзны гэрэл нэлэнхүйдээ унтрахад бодь модны дээр
тал саран ёлтойн харагдана. Цаг хугацаа урсан өнгөрсөөр
тал саран төгрөг болохын үест тэнгэрт түмэн одод түгээд
баясгалантай гялалзах ажгуу.)

Хөшиг хаагдана

17 23

ХОРИН ХОЁРНЫ ӨДӨР

САЛХИНЫ БҮЖИГ

Салхины бүжигт орчлон хорвоод эртнээс нааш уламжлан ирсэн урлагийн хамгийн гайхамшигтай сор дээж хадгалагдан үлдсэн гэж домогт өгүүлдэг.

Тэнгэр газрын хооронд уран байгалийн гараар бүтсэн юм бүхэн төгс үзэсгэлэнтэй ажгуу. Буян ба билгүүн хэмээгч бие биедээ нягт уусан шингэснийг ойлгох хэмээн оролдох тусам ор мөргүй болмуй.

АМГАЛАН ЗҮҮДНИЙ АМИРЛАНГУЙ СЭНТИЙ

Шөнө дундын алдад нэгэн машин гудамжаар давхисаар Абогийн амьдардаг номин хулст хадыг чиглэв.

Хулсан төгөлд унтаж байсан жигүүртэн гөрөөс машины дуунд цочин сэрж ийш тийш дэрхийн зугатацгаалаа. Харин төгрөг саран урьдын адил амгалан налайж машин замыг гийгүүлнэ.

“Түг түг !”

Үймцэх чимээнээр Або аль хэдийн сэрээд чийдэнгээ асаачихаад сууж байсан болохоор тодхон хоолойгоор:

“Хэн бэ?” хэмээн асуулаа.

“Аав аа ! Би байна аа !” гэж гадаа ирсэн зочин хариулав.

Абогийн хотод амьдардаг хүү нь шөнө дөлөөр аав дээрээ ирж байгаа нь энэ ажээ.

“Шөнө дөлөөр хүн унтуулахгүй наашаа ирдэг чинь цаанаа ямар нэгэн учиртай байлгүй дээ !”

Нээрэн ч хайртай хүү нь шөнө дөлөөр машин тэрэг хөлөглөн наашаа зорьсоныг бодоход ямар нэгэн учир шалтгаан байх нь тодорхой боловч Або учиргүй сүйд болсонгүй ийн асуулаа.

“Аав аа, мэдээжийн хэрэг маш яаралтай учир шалтгаан гараагүй бол би яалаа гэж ийм яаруу сандруу наашаа зүглэх билээ дээ.” гэхэд залуу хархүүгийн царайд хэдийгээр эмээнгүй байдал илт боловч яарч бачимдсан сэтгэл мөн тодхон

ажээ. Тэр өгүүлрүүн “Би өнөө шөнө танаас нэг тусламж хэрэгтэй болоод ийм яаруу ирлээ. Яагаад гэвэл энэ удаагийн уран бүтээлийн уралдаанд та л оролцохгүй бол бусад хүмүүсийн хувьд санааны гарз болчихоод байна.”

“Энэ удаа бас л амаргүй хэрэг тохиолдоо юу?” гэж Або хүүдээ аяга халуун цай ойртуулах зуур “Чи жаахан амьсгаагаа дарж байгаад тайвуухан ярьж үз ! ” гэлээ.

Аяга халуун цай уугаад жаахан уужрав бололтой залуу хархүү өөрийн шөнө дөлөөр ирсэн хэрэг зоригийг ийн хүүрнэв.

Уг нь Або залуу зандан цагтаа алдартай уран дархан байсан агаад өөрийн мэддэг чаддаг бүхнээ хайртай хүүдээ өвлүүлсэн нь бас л чамгүй уран гартанд тооцогдох болсон юм. Үүнээс өмнө ямар ч хэцүү захиалга байсан тэр торохгүй дор нь бүтээгээд өгдөг. Эцэг шигээ няхуур нямбай, гарын дүй сайтай болохоор хүмүүсийн хийлгэхээр өгсөн болгоныг хурдан шалмагай гүйцэлдүүлсээр ирсэн юм. Харин энэ удаагийн тэмцээний шалгуур маш өндөр болохоор нийслэл хотын хамаг л уран гартнуудыг бажгадуулаад байгаа болохоор тэр ийнхүү эцгийгээ зорихоос өөр аргагүй болжээ.

“Энэ удаагийн уралдааны сэдэв юу юм бэ? Та нар бүгдээрээ хамжаад ч дийлэхгүй байна гэж үү дээ?”

“Энэ удаа үнэхээр амаргүй даваатай тааралдаад байна.

Бүтээж дийлэх нь байтугай юунаас эхлэхээ мэдэхгүй суучихаад байгаа юм ! ”

Хайртай хүүгийнх нь үг түүний сонирхлыг ихэд өдөөсөн болохоор тэр цааш нь анхааралтай сонсож байлаа.

“Энэ удаагийн тэмцээний сэдэв нь амгалан зүүдний амирлангуй сэнтий гэсэн нэртэй юм. Тэмцээнийг зохион байгуулагчид одоо нэгэнт олдохоо болиод удаж байгаа амгалан зүүдний амирлангуй сэнтийг урлах болзол тавьжээ. Домогт өгүүлдгээр тэр сэнтий болвоос хүмүүний гараар бус дээд тэнгэрийн тааллаар бүтсэн, маш гоёмсог үзэмжтэйгээс гадна ур хийцийн хувьд маш үнэ цэнэтэй бүтээл байсан гэдэг.”

Або инээмсэглээд ийн өгүүлрүүн: “Та нарын хувьд ч айхтар хэцүү биш л баймаарсан даа ! Таван жил тутамд болдог энэ тэмцээн ямар анх удаагийнх биш дээ ! ”

“Уг нь ч тийм л дээ ! Энэ удаа нийслэл хотын хамаг л урдаа барьдаг уран гартангууд бүгд л түрүү байг авчих санаатай мэддэг чаддаг бүхнээ шавхаж байгаа боловч
. . хүмүүний гараар бус дээд тэнгэрийн тааллаар бүтсэн эрдэнийн сэнтийг урлаж үнэхээр хүч хүрэхгүй байна. Тийм болохоор бүгдээрээ л баахан шаналсан улс байцгаана.”

Хүү нь нүүрэндээ цайлган инээмсэглэл тодруулаад ийн хэлрүүн:

“Ёстой л гэгээн өдрийн бодол гэгэлгэн шөнийн зүүд гэгч

л болж байх шиг байна. Тэр ч байтугай би нэгэн шөнө их хачин зүүд зүүдлэсэн шүү ! Зүүдэнд үзсэнээр би нэг хүн амьтангүй аглаг ойд явж байтал нэгэн модны дор мөнөөх эрдэнийн сэнтийг олж үзлээ. Тэгээд гайхан сайтар ажиглах гэтэл нойрноос сэрчихсэн. Тэгээд би нөгөөдүүлийгээ дуудаад зүүдэндээ үзсэн эрдэнийн сэнтийг хийх гэж оролдсон л доо ! ”

“Нэгэнт л эх загварыг олсон бол хийхэд амархан биш үү?”

“Харин ч эсрэгээрээ гээч, чухам энд л асуудлын учиг оршиж байгаа юм. Миний зүүдэндээ үзсэн амгалан зүүдний амирлангуй сандал туйлын үзэсгэлэнтэй, орчлон хорвоод өөр жишиж зүйрлэх юм үгүй боловч би түүний чухам ямар хэлбэртэй байсныг санахаа байчихаад байна. Хэдэн ч сарын турш тархиа гашилган бодсон боловч, барьж аваад хийе гэхээр болдоггүй, яваандаа бүр зүүдэндээ үзсэн сэнтийний ерөнхий хэлбэр дүрс ч мартагдах тийшээ хандлаа. Гэтэл тэмцээний товлосон хугацаа дуусах өдөр хоног улам бүр дөтлөөд байгаа болохоор уурлаж бачимдахаас яах билээ. Одоо хагас сарын хугацаанд л хийж амжихгүй бол бусдын элэг доог болоод хоцрох үлдээд байна. Би ямар сайндаа л энэ харанхуй шөнө номин хулст хадыг зорьж байх билээ. Одоо энэ хэцүү асуудлыг гагц та л шийдэж чадах байх ! ”

Хүүгийнхээ ийн хүүрнэж дуусахыг сонсоод Або гүн бодолд автан нааш цааш холхисоор цонхны дэргэд хүрэлцэн ирлээ.

“Чи эхлээд жаахан амарч бай даа ! ”

Бачимдаж гүйцсэн хайртай хүүгээ унтуулсаны дараа Або шөнийн тэнгэрийг ширтэн гүн бодолд автлаа. Саяхан л үймцэн шуугьж байсан араатан жигүүртэнгүүд бүгд амгалан нойрондоо умбасан бололтой гадаа нам гүм байдал ноёлох ажээ. Гагцхүү шөнийн салхи л унтаагүй сэр сэр салхилж, номин хулст төгөлд сарны сонатыг эгшиглүүлэв. Заримдаа дүрсгүй зан нь хөдлөв бололтой хулсан цонхноо өлгөсөн хонхыг зөөлөн жингэнүүлнэ.

Гэнэт Абогийн нүдэнд баярын оч гялалзахыг Шидө олж үзэв. Тэр лав ямар нэгэн уран арга олсон бололтой намуун дуугаар ийн өгүүлэв.

“Шидө тэр амгалан зүүдний эрдэнийн сэнтийг амирлангуй эрдэнийн лянхуа хэмээн нэрлэдэг байсан гэнэ лээ. Тэрхүү хорвоод хосгүй үзэсгэлэн төгөлдөр эрдэнийн сэнтий өдгөө үзэгдэж харагдахааргүй алга болсон гэлцдэг.”

“Өө? Та түүний ямархуу эд байсныг мэддэг байх нь ээ ! ” хэмээн Шидө баярлан дуу алдахдаа, бас ч нэлээд эргэлзэж байгаа бололтой “Нэгэнтээ алдагдаад удаж байгаа юм бол түүнийг сэргээн хийх арга байгаа гэж үү дээ?”

“Санаа зоволтгүй ээ, амьд хүн аргатай гэдэг шүү дээ ! ” гэхэд хийморь золбоо нь сэргэсэн Абогийн царайд нууцлаг атлаа дүрсгүй инээд тодроод “Миний нэгэн сайн анд түүнийг хэрхэн хийхийг мэдэж байгаа нь лавтай. Уран

гартны ертөнцөд түүний мэдэхгүй чадахгүй зүйл гэж ерөөсөө үгүй. Маргааш цөмөөрөө өглөө эрт түүн дээр очицгооё. . . . Мартсанаас эртхэн очоод, эртхэн эргэж ирэхгүй бол оройн сайхан тоглолтоос хоцорч мэдэх юм шүү ! ”

Үүрийн үнэгэн харанхуйгаар эртлэн боссон Або тайван нойрсон байгаа хүү рүүгээ нэг харсанаа, сэрээж төвдөлгүй Шидөгөө аваад гадагш зүглэв.

Үүр манхайн цайхтай уралдан эртэч шувуухайнууд идэш эрэн нисэлдэж, Абогоос айж үргэсэн шинж огт үгүй ажээ. Энэхүү эртэч найз нарыгаа хараад Абогийн хийморь улам ч сэргэв бололтой амандаа дуу аялсан шиг урагш алхлана.

“Або чиний тэр найз чинь чухам хаана амьдардаг юм бэ? Тэр үнэхээр чиний хэлж байгаа мөнөөх амирлангуй эрдэнийн лянхуа сэнтийг хийх аргыг мэднэ гэж үү дээ? ” гэж Шидө өөрийн шөнөжин гайхширч хоносон эргэлзээг палхийтэл хэлж орхив.

“Миний тэр найз аглаг уулын гүнд амьдардаг бөгөөд миний хамгийн итгэлт анд байгаа юм. Чи уулзахаараа сая бүгдийг ойлгох болно.” гэж Або баясгалантай өгүүлээд “Шидө өнөөдөр хоёулаа салхитай хөл нийлүүлэн алхацгаая ! ” гэв.

“Салхитай хөл нийлүүлэн алхъя гэнэ ээ?” хэмээн Шидө салхинд хэд тонгорцоглон эргэснээ инээд алдаад “Тэр

бололгүй яахав. Яагаад гэвэл салхи ч мөн миний хамгийн дотны анд болохоор надад зөндөө олон сонин хачныг дуулгаж байдаг юм.” гэлээ.

“Тийм ээ, салхинд эх байгалийн маш олон мэдээлэл агуулагдаж байдаг. Түүнийг сэтгэл тавин сонсох аваас сая ойлгож ухаарах боломжтой.” гээд Або их л уясангуй цааш өгүүлрүүн:

“Чи бид хоёр орчлон хорвоогийн үг хэлгүй сэтгэлийн дуудлага болон амин судлын лугшилтыг ойлгодог шүү дээ !” гэлээ.

Або ийнхүү үнэн сэтгэлийн үгсийг хүүрнэхэд агаарт салхины аясаар элин халин нисэх Шидө хариуд нь өгүүлрүүн:

“Би өөрийн сонсож дуулсан болгоныг тантай хуваалцаж байна.” гэлээ.

Тэр хоёр ийнхүү ярьсаар явтал нэгэн аглаг уулын гүнд хүрэлцэн иржээ. Энэхүү аглаг уулын буйдхан чөлөөнд зогсоод үзвээс тэнгэр баганадам өндөр моддын үндэс газрыг хаван цухуйсан үзэгдэнэ. Өвгөн нарс голлосон энэхүү ойд хүрэлцэн ирсэн хүнд балар эртний ертөнцөд байгаа мэт гайхалтай мэдрэмж төрөх нь дамжиггүй.

Тийнхүү яван явсаар Або гэнэт алхаагаа сааруулан уулын салхинд нарсан шугуй исгэрэн шуугих чимээг чих тавин сонсож эхлэв.

“Эндхийн салхи их онцгой содон юм аа! Эрт балрын мартагдсан аялгуу эгшиглэж байгаа мэт алсын алсад дуурсан сонсогдож байна. Үнэхээр яруу сонсголонтой юм гээч! ” хэмээн Шидө тэсгэлгүй бахадлаа.

“Хуйлран эрчлэх салхин ! ” хэмээн Або амандаа бувтнаснаа тэргүүн өргөж салхины аясаар шуугин найгах нарсан ойг гүйлгэн харна. . . . Ийнхүү хэсэг зуур чагнаархан ажигласны эцэст нүүрэнд нь инээмсэглэл тодроод, умард зүгийг чиглэн ширүүхэн алхжээ.

Энэхүү зах хязгаар нь үл харагдах балар ойн дунд удтал явахдаа цаад талд нь гарах болов уу гэсэн шүү юм Шидөд бодогдоно. Гэвч удаж төдөлгүй нарны гэрэл мэлсхийн ойн захад гарч иржээ. Гал улаан наран дорно уулын оройд мандаж, нүд гялбам хурц туяа цацруулна.

“Ашгүй яг олоод ирлээ ! ” гэж Або урд талын цавчим өндөр хавцлыг харангаа өгүүлэв. Эндхийн салхи улам ч эрчтэй хуйлрах мэт Шидөд санагдсан тул тэсгэлгүй ийн хашгирлаа.

“Салхи тэр алсын хавцлыг л чиглэж исгэрээд байх юм ! ”

“Тэгвэл хоёулаа ч гэсэн тэр хавцлын зүг явцгаая даа ! ” гэж Або томоогүйхэн өгүүлээд тийш зүглэв.

“Або энэ их өвөрмөц сонин тогтоцтой газар юм аа. Эгээ л эрт балрын хувилгаан арш нарын орон мэт. Чи энэ газрыг яаж олж ирсэн хэрэг вэ?”

“Санамсаргүй тохиолдлоор гэх үү дээ. Би энэ тэрүүгээр явангаа юухан хээхнийг сонирхож явдагийг чи ямар эс мэдэх биш дээ !

Гурван жилийн өмнөх нэгэн өдөр би санамсаргүй энэ уулын хормойд маш ховор гайхалтай мод газар унасан байхыг олж үзэж билээ. Тэгээд түүнийг аваад буцах замдаа нэлээд ядарсан тул нэг мод түшээд жаахан амсхийтэл удалгүй унтаж орхижээ. Гэтэл зүүд нойрон дунд яруу хөгжмийн аялгуу сонсогдохоор зүүдлэж байгаа юм болов уу гээд гайхан сэртэл.Сэртэл ч гэж дээ, өнөө хэр би тэр үед сэрүүн байсан, аль эсвэл зүүдлэсээр байсны алин болохыг хэлж мэддэггүй юм.” хэмээн хэлэх зуур Абогийн дуу улам намуухан болох нь лав өөрийн ой санамжинд гүнээ автсан бололтой цааш өгүүлрүүн:

“Намайг сэрсэний дараа мөнөөх хөгжим нэлээд холдсон боловч чихэн дээр шахам сонсогдох нь ямар учиртайг ойлгож ядан байлаа. Тэгээд би тэр газраа хөдлөлгүй нам гүм нэлээд удаан суусан боловч өөрт гэрэл цахилаад өнгөрөх мэт хурдан санагдаж байв.Өөрөөр хэлбэл тухайн агшинд миний хувьд цаг хугацааны баримжаа бүрэн утгаа алдсан гэсэн үг л дээ !”

“Дараа нь тэгээд юу болсон бэ? Тэр хөгжим хаанаас үүдэлтэй байв.” гэж Шидөгийн сониуч зан улам хөдлөв бололтой асуулаа.

“Би намуун зөөлөн салхины сэвшээнд илбүүлэн суусаар л байв. Бие сэтгэлийн аль аль нь тааламжтай байгаа гэдэг нь өгүүлж барамгүй. Гэнэт сайтар ажиглаваас мөнөөх яруу хөгжим ой шугуйн тэртээгээс дуурсаж байгааг мэдээд тэсгэлгүй баярлан түүнийг баримжаалан алхав. . . . Тэгж явсаар байтал энэ өвгөн нарсан ойд хүрэлцэн ирсэн юм даа. Дараа нь миний сонсдог хөгжмийн аялгуу салхинд найгах нарсан ойн шуугианаас үүдэлтэй болохыг ойлгосон юм.”

“Байгаль эхийн эгшиг дуу орчлон хорвоогийн хамгийн яруу аялгуу байлгүй ч яахав дээ ! ” гэж Шидө шүүрс алдан хэллээ.

“Тэрхүү далайн давалгаа мэт яруу эгшгийг баримжаалан явахдаа би зөндөө олон гайхалтай сонин модны мөчир гишүү олж билээ. Тэр бүхэн маш ховор нандин түүхий эд байсан болохоор миний хувьд энэ газар эрдэнэсийн сан л гэсэн үг! Түүнээс хойш энд хүрэлцэн ирж нарсны шуугихыг сонсонгоо өөрт хэрэгтэй түүхий эд цуглуулах дуртай болсон юм. Бас нарсан шугуйн эгшиглүүлэх айзам хэмнэлийг ч ойлгодог болсон. Нэгэн удаа би салхийг даган явсаар ойн бүр гүнд очсон юм даг. . . . Тэгээд яваад байтал ойн захад хүрээд саяын чи бидний харсан цавчим хавцлыг олж үзсэн билээ. Эндхийн салхи арай л өвөрмөц эгшиг үүсгэхийг мэдрээд түүнийг даган цааш явав. . . . Тэгтэл нэг л мэдсэн энэ гүн урт хавцлын дунд намайг авчирсан юм

даа ! ”

Ийн ярьж явсаар Або Шидө хоёр нэгэн мурийдуу цавчим хавцлын дунд орж явчихав. Давчуухан хавцлын дээгүүр тэнгэр гялалзсан хөх луу эвхрэн үзэгдэнэ.

“Би нарсан ойн дунд ямар ч тэмдэг үлдээлгүй явж үзсэн л дээ. Тэгэхэд хэрвээ салхины аясаар шуугих нарсан шугуйн айзам хэмнэлийг ойлгохгүй хүн бол энэ хавцлыг олж ирнэ гэдэг санасны гарз юм байна лээ ! ” гэж Або өөрийн олж мэдсэнээ Шидөд хүүрнэв.

“Нээрэн ч тэр зах хязгааргүй үргэлжилсэн нарсан шугуйг нэвтлээд наашаа ирнэ гэдэг үнэхээр амаргүй байж таарна л даа ! Үнэн хэрэгтээ салхины аясаар үүссэн нарсан шугуйн давалгаа наашаа хөтлөдөг байх нь ээ. Або чи үнэхээр гайхалтай гярхай хүн байна шүү ! ” гэж Шидө түүнийг бахдан өгүүлэв.

Тэр хоёр ийнхүү ярьж хөөрч явсаар нэг л мэдэхэд цавчим өндөр хавцлын цаад аманд хүрч ирцгээлээ.

Хавцлын цаадахь өгсүүр аман дээр хүрээд дахин хэдэн арав алхваас нүдний өмнө үлгэрийн мэт үзэмж төгөлдөр байдал тодрон харагдав. Ногоорон харагдах уулын хөндий гүн цэнхэр тэнгэртэй залгалдаад, түүний гол дунд ганц том саглагар өвгөн нарс өтгөн мөчир шилмүүсээ дааж ядан сүглийх нь үзэсгэлэнт лянхуа цэцгийн хэлбэрт эрдэнийн

дуаз мэт үзэсгэлэнтэй.

“Пөөх, ямар үзэсгэлэнтэй сайхан хөндий вэ? Энэ өвгөн нарс лав түмэн оныг ардаа үдсэн байх даа ! Саглайж сүглийгээд өргөн хөндийг нэлэнхүйд нь бүрхсэн мэт харагдаж байна шүү ! Ёстой л гайхамшигтай байгалийн үзэмж гэж үүнийг хэлэх байх даа ! ” гэж Шидө нүдний өмнө дурайх үзэмжийг бахдан өгүүлэв.

Або нүүрэндээ инээмсэглэл тодруулсаар хавцлын амаар уруудан, өргөн хөндий рүү орж мөнөөх саглагар том нарс модны дор очлоо.

“Шидө салхи энэ мушгирсан хавцлыг дундуур гарч, өргөн хөндий рүү орохдоо эрчлэн хуйлардаг болохыг чи анзаарав уу? Салхи энэ өвгөн нарс болоод түүнийг бараадан ургасан өтгөн ороонгын навч мөчрөөр оролдон наадахдаа мөнөөх гайхамшигтай хөг аялгууг үүсгэж байгаа хэрэг шүү дээ ! Хорвоод хосгүй уран хөдөлгөөнт бүжиг гэж чухам үүнийг л хэлэх байх ! ” гээд хэдэнтээ урт амьсгаа авахад салхи болон өвгөн нарсны айзам хэмнэлийг мэдрэв үү гэлтэй бие сэтгэл нь тавираад явчихав.

“Бүжиг гэж тун онож нэрлэлээ шүү, Або ! ” хэмээн бахдан хашгирах зуур Шидө өвгөн нарс болон өтгөн ороонго салхины аясаар уян налархай бүжиглэхийг бахдан ширтэв.

“Энэхүү бүжгийн уян налархай хөдөлгөөн үнэхээр нүд баясгаж, сэтгэл сэргээм ажээ. Салхи сэвэлзэн өнгөрөх

тоолонд өвгөн нарсны намилзан хөдлөх нь нэг л уян зөөлөн агаад юу ч гэмээр юм бэ дээАа тийм, амирлангуй налгар ажгуу ! Амирлангуй налгар гэсэн нь оновчтой юм байна. Манай хүүгийн зүүдэнд үзэгдсэн мөнөөх үгээр илэрхийлэхийн аргагүй эрдэнийн сэнтийний тухай би анх сонсохдоо л сэтгэлд нэг л танил гайхамшигтай мэдрэмж төрсөн юм. Урьд шөнө хулсан шугуй салхины аясаар шуугихыг сонсоод, би гэнэт энэ хөндийд байдаг хуучин андыгаа гэнэт саналаа. Ай, үнэхээр гайхалтай ! Амирлангуй налгар. . . .Амирлангуй эрдэнийн лянхуа сэнтий” гэж Або амандаа үглэх зуур баясан хөөрч гар хөлөө гозолзуулна.

“Або чиний надад дурсаад байсан хуучин анд гэдэг чинь энэ өвгөн нарс байсан байх нь ээ ! ” гэж Шидө сая л учрыг ухав бололтой өгүүлэв.

“Хэлээд юүхэв ! Энэ өвгөн нарсыг хэлсэн юм. Би анх тэр нарийн хавцлыг туулан, өргөн хөндийд ирээд энэ өвгөн нарсанд маш их татагдаж билээ. Хавцлын зүгээ ирэх салхи, өвгөн нарс хоёр хоорондоо ямар нэгэн зүйлийг хүүрнэж байгаа мэт санагддаг юм. Хэдийгээр би тэдний чухам юу ярьж байгааг ойлгохгүй боловч чагнаархан сонсох дуртай. Учир нь салхины аясаар мөчир гишүүдийн тоглох яруу аялгуунд миний шар үсний сүвнүүд хүртэл амсхийн тавирах шиг санагддаг гээч ! ”

Або ийн ярих зуур өтгөн ороонгыг ярсаар өвгөн нарсны бүр дэргэд хүрч ирэв.

Або цаасан шувуу Шидөд хандан бахдангуй өгүүлрүүн:

Энэхүү хөгшин ороонгууд ч гэсэн орчлон хорвоогийн хамгийн төгс бүтээлийн нэг яах аргагүй мөн шүү ! Дээд тэнгэрийн тааллаар бүтсэн тэдний уян налархай гадаад үзэмжийн хажууд хамгийн агуу том урлагийн бүтээл ч гэсэн өнгөө алдах байх даа ! Эдгээрийг сайтар ажиглах юм бол цаглашгүй их онгодыг хөглөдөг юм. Би энд ирэх болгондоо урлагийн эрдэнэсийн санд ирсэн мэт ороонгуудын хэлбэр дүрсийг ажиглах дуртай. Ингэж явах зууртаа л би өөрийн мэдэлгүй өвгөн нарстай салж хагацашгүй андын барилдлагатай болсон юм.

“Аанхаан ! ” хэмээн Шидөд салхины намуухан илбээг мэдрэнгээ тааламжтай дуугарав.

“Яагаадыг бүү мэд, Шидө минь ! Манай хүүгийн ярьдаг амгалан зүүдний амирлангуй сэнтийний тухай энэ өвгөн нарс сайн мэдэж байгаа гэж санагдаад байгаа юм. Харин түүний салхитай чухам юу ярьдагийг ойлгодогсон бол мөн сайхан аа ! ”

Або аварга нарсны сүүдэрт суугаад асар тэнгэрийг бараалан, салхины намуухан сэвшээг чагнав. Өвгөн нарсны өтгөн саглагар мөчир гишүүний завсраар ороонго сүлжилдэн зөрсөн нь түүнд амгалан зүүдний амирлангуй сэнтийг

өөрийн эрхгүй санагдуулах тул тэр гүн бодолд дарагдав. . . .

. .

Гэнэт түүний толгойгоо түших гарын тохойг хэн нэгэн хүн нударх шиг санагдав.

“Або ! Або ! Өвгөн нарс чиний санааг ойлгоод ярьж эхлэлээ.” хэмээн гүн бодолд дарагдсан Абод цаасан шувуу Шиде баясгалантай хэлэх дуу сонсогдов.

Исгэрэх салхины аясаар өтгөн мөчир шилмүүс яруу тунгалаг эгшигийг дуурсгав. Або түүнийг сонсоод тэсгэлгүй баярлан ийн асууруун:

“Өвгөн нарс надтай үнэхээр ярьж байна гэж үү дээ? Тэр тэгээд юу гэж байх юм бэ?”

“Таны яриад байгаа мөнөөх амгалан зүүдний амирлангуй сэнтий болвоос үнэхээр хүмүүний гараар хийгдээгүй дээд тэнгэрийн тааллаар бүтсэн хосгүй бүтээл мөн гэж байна.”

“Тэгэхээр түүнийг урлана гэдэг бүтэшгүй мөрөөдөл гэсэн үг үү?” хэмээн Або жаахан гонсгордуу асуулаа.

“Тэр ч үгүй гэнэ ээ. Салхийг наашаа зочлон иртэл жаахан тайван сууж бай гэж байна.”

“Салхийг зочлон иртэл гэнэ ээ?”

Нам гүмхэн ногоорох уулын хөндийг хараа сунган үзэхэд ямар нэгэн гайхамшигтай нууц удахгүй биеллээ олох гэж байгаа мэт сэтгэгдэл түүнд төрөв. Аясын салхийг амьсгаа даран хүлээж суух зуур энэхүү уулын хөндий үнэхээр

үлгэрийн ертөнц мэт Абод санагдаж байлаа. Хөндий дүүрэн сугсрах өвс ногоо амьдлаг өнгөөр гялталзах нь өвгөн нарс лугаа хамт баяр жаргалын магтуу өргөж ч байгаа юм шиг харагдлаа.

Эндхийн хамаг бүхэн зөнгөөрөө ариухан агаад цаанаа ямар нэгэн далдын нууцыг агуулах шиг Абод дотоод хүчний үйлчлэлийг мэдрүүлнэ. Гэвч цаг хугацаа урсан өнгөрсөөр байх тул тэр өөрийн эрхгүй жаахан бачимдаж ирэв. Тэгээд тэр эцэст нь хэд уужуухан амьсгаа аваад өвгөн модыг түшин суутал хэсэг зүүрмэглэж орхисон байлаа.

“Або, салхи ирлээ ! ” хэмээн Шидөгийн хэлэхийг тэр бүрэг бараг ойлгов.

“Өө ! ” гээд Або нүдээ үл мэдэг нээлээ.

Нээрэн ч салхи ажээ. Урин зөөлөн салхи модны оройгоос хэдэн дусал шүүдрийн усыг гөвж түүн дээр унагасан нь нойрыг сэргээх гэсэн бололтой. Бүр сэргээд үзвээс хавийн өвс ногоо бүгд ханаран шуугьж ямар нэгийг хамтдаа өгүүлцгээнэ. Харин модны доорх ороонго өвс, нарыг халхлах өтгөн шилмүүстэй хамтран уян налархай бүжгээ эхлэжээ.

Салхи улам хүчээ аван уулын хөндийн нам гүм байдлыг эвдэж, тэнд буй үзэгдэх юм бүхэн амь орон хөдлөнө. Өвгөн нарнаас эхлээд нэрийг нь үл мэдэх бяцхан цэцэг хүртэл

дохилзон найгаж, өргөн хөндий тэр аяараа бүжиглэж байх шиг. Өвгөн нарс сэтгэл тэнүүн инээж байх шиг Абод санагдлаа.

“Чухам энэ л орчлон хорвоогийн айзам хэмнэл юм шүү дээ !”

Өвгөн нарс ийн хэлж гүйцэхэд түүний уян налархай салаа мөчрүүд салхины аясаар найган ганхах нь их л эвсэг яруу, заримдаа хүчлэн доргих шиг болсноо, эргээд найгалзан ганхаж нүд баясган бүжиглэсээр байх ажээ.

“Өө ! Тэр бүр амь насаа хүртэл салхинд даатгачихжээ.” хэмээн хэлэх зуур Абод өвгөн нарсыг хязгааргүй хүндэтгэн хайрлах сэтгэл төрөв.

Огторгуйн чанадаас ирсэн энэхүү сураг зангийг өвгөн нарс их л сүслэнгүй сонсож, сэтгэлээ дайчлан бүжиглэсээр

“Уухайс.” хэмээн Або ч мөн өөрийн мэдэлгүй салхиар үүссэн яруу эгшгийг сонсон дуу алдахад, нүдний өмнөх хамаг бүхэн амилан дэрвэж, салхинаас сэтгэлийн хүүрнэл, амьдралын эрч хүчийг олж авах ажгуу.

Салхи нэг хэсэг намуухан шивтнэж, тэгснээ исгэрэн шуугиж, хуйлран эрчлэнэ.Тэр тоолонд моддын мөчир шаагилдан сонсохуйд таатай найрал хөгжмийг эгшиглүүлэхэд Або түүнийг тэргүүн өргөн харсаар байлаа.

“Ай !”

Нааш цааш найган ганхах мөчир ороонгын найрал дунд тэр амгалан зүүдний амирлангуй эрдэнийн лянхуа сэнтийг олж харав. Чухам л тэр янз бүрээр хувьсан өөрчлөгдөх мөчрийн найгаан дунд зурсхийн харагдаад өнгөрчээ. Тэр олж харж чадлаа !

Дотоод сэтгэл нь өгүүлж барамгүй догдлол баясалд автан Або модны дор удтал хөшсөн мэт зогссоор л.

Салхи хэзээ намжсаныг ч анзаарах сөхөө үгүй.

Гэнэт чадхийх чимээ гарч, өвгөн модны оройн хэсгээс нэг том гишүү хугаран доош унаж ирлээ. Або түүнийг их л сүслэнгүй газраас өргөн авч үзэв.

Өвгөн нарсны хайрласан мөнөөх гишүүг илж үзэхэд уян хатан чанараа алдаагүй ажээ.

“Харьцуулан төсөөлөх хэрэггүй ! ” гэж Або өөртөө болон Шидөд хандан хэлсэний алийг бүү мэд бүгтхэн өгүүлээд:

“Аливаа амьтай бүхнийг ойлгоё гэвээс өөрийн дотоод сэтгэл рүү өнгийж харахтай адил хандах хэрэгтэй. Тэгж чадваас урин салхи чамд аливаа зүйлсийн далд үнэн дүр төрхийг аяндаа хэлээд өгөх болно.”

Нэг л мэдсэн тэр дэргэдээ байгаа өвгөн нарс болон амирлангуй эрдэнийн лянхуа сэнтий зэргийг ор тас мартаж орхижээ.Гагцхүү саяын унаж ирдэг гишүүний амьдралын тойрог болон өсөж төлжсөн хэмнэлийг л ойлгох гэж хичээж байлаа.

“Эх байгалийн яруу эгшиг дууг шууд сонсвоос, чи тэнгэр газрын хоорондохь хамгийн гайхамшигт урлаг гэж юу болохыг ойлгох болно ! ” Або өөрийн оршин буйг хүртэл мартчихаад байтал гэнэт сэтгэлийн далай дунд өвгөн нарсны өгүүлэн хэлэх дуун гарахыг сонсжээ.

Тэрхэн зуур ухаан санаа нь цэлмэж, огтхон ч эргэлзэж тээнэгэлзэлгүй нарсны гишүүний хэлбэр дүрсийг үндэслэн, улмаар ургуулан бодож эхлэв.

Уулын хөндийн өвгөн нарс исгэрэх салхины аясаар эрт балрын яруу аялгууг дуурсгана.

“Орчлон хорвоогийн хамгийн яруу гайхамшигтай бүтээлүүд бүгд л байгалийн зөн билигийн хүчээр бүтнэ үү гэхээс бус, санаа бодлоо чилээсэн төдийгийн хэрэг биш юм. Энэ гишүүний хэлбэр дүрс хэдэн мянган жилийн турш салхинд найган бүжихдээ бүтэж бүрэлдсэн билээ. Түмэн оны турш бид салхины хүргэж ирсэн сураг зангийг чих талбин анирлаж, түүнтэй ханьсан жаргах зуур бид орчлон хорвоогийн хамгийн эртний төгс урлагийн гайхамшиг гэж юу болохыг ойлгож авсан. Тэр болвоос ханьцашгүй гайхамшигтай тэнгэр газрын бүтээл юм.”

“Үнэхээр ухаан санаанд багтамгүй юм байна шүү ! Домогт өгүүлдэг амгалан зүүдний амирлангуй сэнтий орчлон хорвоод дахин буй болох боломжтой боллоо ! ” гэж байгалийн мутраар урлагдсан амирлангуй сэнтий нүдний

өмнө тодрохыг үзээд Шидө хөхин баясаж дуу алдлаа.

Энэхэн мөчид Абогийн дотоод сэтгэлийн догдлол баясал Цяньтан мөрний оволзох давалгаа мэт хөвсөлзөх нь ямар ч яруу сайхан үгээр илэрхийлсэн түмний нэг хувийг илтгэж чадахааргүй ажээ.

Ийнхүү удтал зогссон хойно Або модны дэргэд маш ойртон их л баясгалантай өгүүлрүүн:

“Өвгөн нарс минь ! Би өөрт тань хэрхэн талархаж буйгаа үгээр илэрхийлэх арга үнэндээ алга даа ! ”

“Би өөрт чинь хэдэн гишүү хаяж өгснөөс өөр юугаар гялайлгасан билээ дээ?” гэж өвгөн нарсны салаа мөчир шаржигнан дуугарах чимээг Шидө түүнд хөрвүүлж өгчээ.

“Чи л өөрөө салхины уран бүжгийн гайхамшгийг ухаарч, өвгөн миний гишүүний уян зөөлөн амин урсгалыг мэдэрч чадсан хэрэг. Хэрвээ амьд байгалийн гоо сайхныг мэдрэх билгийн нүдгүй аваас, чамд хичнээн олон сайхан түүхий эд байлаа ч амгалан зүүдний амирлангуй сэнтийг урлана гэдэг санааны гарз болох юм.”

“Хэрвээ та л надад зааж сургаагүй бол би яахин энэ гишүү мянган оныг ардаа үдэх зуур бүрэлдэж ирсэн үзэсгэлэнтэй агаад амьд төрхийн нууцыг олж чадах билээ дээ?” гэж Або хоёр гараар аварга модны голыг илбэнгээ өгүүлэв.

“Буян чинь дэлгэрэг ! Буян чинь дэлгэрэг ! ” гэж салхины дунд өвгөн нарс инээн хэлжээ.

Хэдий удсаныг ч бүү мэд, Або амтат зүүднээс сэрж босоод, итгэж ядсан байдалтай амирлангуй сэнтий рүү дөтлөн очих зуур амандаа ийн үглэнэ.

“Энэхүү амгалан зүүдний амирлангуй сэнтий болвоос хосгүй ур ухаан шингэсэн гэдэгт шаардлагад сая дүйцэх буй за. Санаан зоргоор савлан бүжиглэхийн сацуу сэтгэлийн амирлалыг олно гэдэг чухам энэ бус уу?”

“Хүүе, наадхи чинь юу гэсэн утгатай юм бэ?” гэж Шидө их сониучирхан асуулаа.

“Яахав дээ, санаан зоргоороо хувьсан бүжиглэж буй атлаа өөрийн сэтгэлийг амирлуулан жаргаах гэсэн утгатай юм л даа ! Түмэн оны нүүрийг үзсэн өвгөн мөчрүүд чуулан бүтсэний улмаас, дотоод мөн чанар нь хэвээрээ уян налархай байгаа нь хүмүүний биеийн хүсэл таашаалд яв цав нийцэж байгаа хэрэг. Биеийнх нь дулаан, санаа сэтгэлийн байдлыг мэдрэн, тухлан суугчийн хүсэлд нийцсэнээр түүний дагуу хувьсан бүжиглэж байгаагаас өөрцгүй.”

Абогийн хэлсэн ярьсан бүхэн Шидөг бүр хэлэх үггүй болтол гайхшируулж орхив. Тэр их л баясгалантай доош нисэн ирээд нүдний өмнөх амгалан зүүдний амирлангуй сэнтийг бахдан таашааж байснаа тэсгэлгүй түүн дээр сууж, нарсны найгаанд савлан бүжиглэж эхлэв.

“Үнэхээр итгэмээргүй юм аа ! ” хэмээн дуу алдаад Шидө амирлангуй эрдэнийн лянхуа сэнтийний тав тухыг мэдрэх

тутам сэтгэл зүрхээрээ түүнд уусан нэгдээд чөлөөтэй хөнгөн бүжсээр байлаа.

“Ёстой жинхэнэ амирлангуй эрдэнийн лянхуа сэнтий гэгч энэ буюу. Хосгүй гайхамшигтай агаад сэтгэшгүйн туйл гэгч энэ буй за ! Харамсалтай нь энэ хорвоо дээр алдагдчихаад байсан юм.” хэмээн шогшрон зогсож байснаа Або эрт балар цагт тохисон нэгэн явдлыг ийн ярьлаа:

“Анх хүмүүс гайхалтай уран амирлангуй эрдэнийн лянхуа сэнтийг үзээд түүнийг дууриалган хийх гэж хөгшин мөчрүүдийг хайр гамгүй огтчин, хутгаар дууриалган сийлсээр байтал яваандаа мөчир гишүүний уян хатан чанар алдагдах болжээ. Гэвч хүмүүс мөчөөгөө өгөлгүй дууриалган хийх гэж махрах тусам амирлангуй эрдэнийн лянхуа сэнтий тэднээс улам бүр холдсоор эцэс сүүлдээ алга болсон гэдэг юм. ”

“Нээрэн ч өгүүлэхийн эцэсгүй уран гайхамшигтай ажгуу ! ” гэж сэнтий дээр залраад авсан Шидө их л баяр жаргалтай байгаа нь илт өгүүлэв.

Салхинд өвгөн нарсны салаа мөчрүүд шуугих зуур:

“Чи болвоос эх байгалийг сонсож чаддаг уран гартан болохоор энэ ховор тохиолтой учирч, домогт л өгүүлдэг амирлангуй эрдэнийн лянхуа сэнтийг олж харж чадлаа. Энэ бол эрт балраас эдүгээ хүртлэх орчлон хорвоогийн хамгийн дээд ур ухааны охь юм шүү”

Хүний орчлонгийн амьдрал ч мөн үүнээс өөрцгүй шүү дээ ! Гагцхүү төгс билиг оюун л сая жинхэнэ амирлан жаргах гэгч юу байдгийг мэдэрч чаднам. Тийм болохоор өдөр тутам аар саархан хэрэг явдалд түүртэлгүй орчлон хорвоогийн түмэн үзэгдэл орон нугуудыг шууд ажиглаж, учир начрыг нь ойлгож байваас, байгаль дэлхийн хамгийн үзэсгэлэнт долгис болон үг хэлгүй хүүрнэлийг ойлгох боломжтой юм. Өвгөн нарс хайрын шивнээ мэт ийнхүү намуухан шивнэх нь Абогийн сэтгэлийн далай дээгүүр дуурссаар авай.

* * *

Нар жаргахын алдад Або уулын хөндийгөөс амирлангуй эрдэнийн лянхуа сэнтийг гэртээ авчирчээ.

Хайртай хүүгээ үдэж явуулсан хойно, тэр Шидөгийн хамт гэрэл цацруулсан үтрэмийн талбайд хөөр баяртайгаар хүрч ирэв.

“Өнөө оройн тоглолтонд ямар ч байсан амжиж ирлээ шүү ! ” гэж тэр их олзуурхсан байдалтай Шидөд хандан хэллээ.

Урьд өдрүүдээс өөрцгүй үзэсгэлэнт шөнийн тэнгэр дор хөөрч догдлосон хүмүүс суудлаа эзлэн сууцгаав. Хүмүүс энэ тэрийг хөөрөлдөн байх зуур тайзан дээр тэдэнд хэдийн танил болсон хамтлагийн ахлагч дахин гарч ирлээ.

“Эрдэнэс нуусан газар? Чухам ямар нандин эрдэнийг өөртөө агуулсан болоод хүмүүсийг өөрийн зүг татнам бэ? Гэр орон, нутаг нугаа үгүйлэн санагалзах хүмүүс өөрсдийн

гэгээн ариун нутаг орондоо хэрхэн буцаа бол?

Мөнгөн оддын зүүд мэт гэрэл дор, орой болгон тоглогдож байгаа манай жүжиг та бүхэнд амьдралын утга учрын талаар нэгийг бодуулж, хоёрыг санагдуулж байгаа нь лавтай.” хэмээн нам гүмхэн талбайн агаарт Фухуагийн яруу цээлхэн хоолой дуурсаад цааш өгүүлрүүн:

“Дорно дахин болвоос үлгэр домгийн орон !

Дорно дахин болвоос амьдралыг төгөлдүүлждэг газар !

Нэгэн бүтэн жилийн турш цасаар шуурдаг гүн хавцал, өндөр оргилын дунд амь амьдралын сураг зангийг мэдэж болдог гэнэ !

Өнөө орой хамтдаа тэрхүү ариун дагшин агаад үзэсгэлэнтэй газар орноор зочлож, тэрхүү хаант улсын мөнхийн гэгээн ариун амьдралын амтыг мэдэрцгээе

Сэтгэлийн дундах атгаг шулмыг дараад, оройн дээд билиг оюунд хүрвээс эрдэнэсийн санд хүрэхэд ойртлоо гэсэн үг !
”

Фухуагийн оршил үгэнд автаж гүйцсэн хүмүүсийн өмнө хөшиг зугуухан нээгдлээ.

【ЗУРГААДАХЬ ШӨНӨ】

ГЭГЭЭН АРИУН ХААНТ УЛС

ΔΕΖΓҮЙ ХЭЭР

(Сартай шөнө эзгүй хээр нутаг орноо тэмцэх хүүхдүүд энэ тэрүүгээр тэнүүчилнэ.)

Хүүхэд А: (Дуулна)

Талын араатан жигүүртэн

Тавьсан торонд орохгүй

Өнчин хэрмэл хөвгүүн

Өөрийн нутгийг зорино

Хүүхэд Б: (Дуулна)

Дэлгэрсэн цэцэг эргээд дэлгэрэх нь

Дэлхий хорвоогийн жам юм

Тоорын хүрээлэн нэгэнт холдоод

Тоотой намрын өдрүүд эхлэлээ

Хүүхэд В: (Дуулна)

Өвөг дээдсийн нутаглан суусан Үйлин газар

Үеийн үест шаналсан хааны үрс минь

Үлгэр зүүдэнд л гардаг хуучин цэцэрлэгийг сонссон уу

(Хүүхдүүд нийлж зогсоод алсын бараа харуулдана.)

Хүүхдүүд: (Найрал дуу)

Ахуй нутгаа мөрөөдөх сэтгэлийг

Алаг зүрхэндээ тээлээ
Замаасаа төөрсөн хааны үрс минь
Замбуулингийн өдөр хоногуудад
Тэнгэрийн хаяан дахь нутгийн сарыг
Тээж л явдаг биз дээ
Толгой гудайн дуугүй зогсоход
Толгодын салхи жихүүн
Хацар дагах халуун нулимс
Лусын дагины унагасан гэгээн сувд мэт
(Хүүхдүүд тэртээ алсыг зорин явахад гэрэл зугуухан
унтарна.)

ДГЭГЭЭН АРИУН УЛС

(Тайзны засал солигдоход хөгжим ч түүнийг даган хувьсаад,
намуухан нууцлаг өнгө аястай эгшиглэнэ.Үүлс
хөшилдөхийн дор, Са Юнь, Юэгуан Тунз, хэрмэл хөвгүүн
болон бусад эрдэнэсийн эрэлчдийг дагуулан нэгэн өндөр
оргил дээр гарч ирээд жилийн турш цас бударсан хавцал
болон үүлэнд тулам өндөр оргилыг ширтэн харна.)

Юэгуан Тунз: Үелсэн олон уулсын дунд үлгэрийн юм шиг
ийм сайхан орон байх юм гэж бодсонгүй шүү !

Са Юнь: (Инээмсэглээд) Дорно дахин бол үлгэр домгийн
орон. Дорно дахин төгс амьдралын орон гэлцдэг биз дээ !

Хэрмэл хөвгүүн: Доош харахад дэлхий ертөнц тэр чигээрээ бидний хөл дор байгаа мэт санагдаж байна шүү. Ёстой орчлонгийн диваажин гэж ийм л газрыг хэлэх байх даа !

Шавь: (Эргэлзэнгүй) Са Юнь багш аа, орчлонд үнэхээр ийм үзэсгэлэнтэй газар орон байдаг юм гэж үү? Энэ арай бас нэг хувилсан орон биш биз дээ?

Са Юнь: (Итгэл төгс) Үнэндээ орчлон хорвоогийн дунд зөндөө олон ариун үзэсгэлэнтэй орон нугууд агуулагдаж байдаг юм шүү дээ ! Яг л бидний эрэл сурал болоод байгаа эрдэнэс нуусан газартай адилхан гурван мянган их мянган ертөнцийн дунд оршсоор байгаа.

Шавь: Энэ тэгээд чухам ямар газар орон юм бэ? Яагаад энэ газар ирэнгүүт миний хамаг шар үсний сүвүүд хүртэл амсхийх шиг болно вэ? Үнэхээр гайхалтай юм аа !

Са Юнь: Энэ бол дорно зүгийн гэгээн ариун орон юм. Дорно зүгийн ертөнцийн хамгийн нууцлаг, гайхамшигтай газар орон гэвээс чухам гэгээн ариун орон болой. Гэгээн ариун улс эрт балраас эдүгээг хүртэл оршиход, тус улсын бичиг цэргийн зуун түшмэд ургах нартай уралдан босоод, эргээр нь бургас хуайс битүү ургасан хунт нуурын эрэг дээр, улсын хааныхаа залран ирэхийг хүлээдэг гэнэм. Энэ уламжлал хэдэн галав дамжин үргэлжилсээр агаад дотоод сэтгэл нь билиг билгүүнээр гэрэлтсэн гэгээн ариун улсын хаан, мандах нарны эхний туяа тусахад амгалан мяралзах нуурын

мандлын голд залраад ард иргэддээ амьдралын үнэний тухай номлож, шулмын цэргийг дарах хүч чадал олгодог ажээ.

Тоо томшгүй олон галвын турш гэгээн ариун улсын иргэд сайд түшмэдээсээ авахуулаад харц борчуул хүртэл бүгд нэгэн сэтгэлээр гэгээн ариун улсын хааны удирдлагаар амьдралын үнэнийг эрэлхийлж ирсэн байна. Тийм болохоор тус улсын хүн ам бүгдээрээ эрхэмсэг хийморь золбоогоор гэрэлтэж, сөөм газар нь хүртэл амирлангуйн баяр жаргалд умбадаг ажээ.

Юэгуан Тунз: (Замхарч байгаа үүлсийг заагаад) Та нар хар даа !

(Тэнгэр зугуухан цэлмэхэд гэгээн ариун улсын байдал тодроно. Хунт нуурын эрэг дээр бичиг цэргийн зуун түшмэд болон ард иргэд бүгд цугларчээ. Өглөө нарны туяа үелсэн уулсыг гийгүүлэхэд, нуурын гол дунд нэгэн алтан лянхуа цэцэг хөвөн гарч ирлээ. Мөнөөх лянхуа цэцгэн сэнтий дээр гэгээн ариун улсын хаан заларсан харагдана.)

Хаан: (Дуулна)

Жихүүн намрын үдээс хойш

Жимээр орон алхлаа

Яг л энэ жимээр

Явж байсан даа ноднин

Хээрийн өвс халиурах нь

Хэзээний танил төрх

Жихүүн намрын үдээс хойш
 Жимээр орон алхлаа
 Явж өнгөрсөн энэ жим
 Яг л танил санагдана
 Сажлах жим
 Салхи бороотой жихүүн
 Салахуйн зүүд бүрэг бараг

Цахилгаант аянга нижигнэхэд
 Цочин босоод үзвээс
 Өнгөрсөн жилийн хээр тал
 Өнөөх салхи бороо
 Өд шиг будрах цасан ширхэг
 Өр зүрхний амраг

Өдгөө хаана байна вэ
 Өнөөдөр хаана байна вэ?

(Ийн дуулах зуур нар өндөрт мандана. Са Юнь өөрийн
 хүмүүсийн хамт хунт нуурын дэргэд хүрэлцэн ирэхэд
 гэгээн ариун улсын иргэд хоёр эгнээ болон жагсаад баяртай
 угтан авна.)

Юэгуан Тунз: Са Юнь багш аа, би яг л зүүдлэж байгаа мэт
 санагдаад байна шүү

(Энэ үеэр нуурын гол дахь алтан лянхуа цэцгээс алтан шаргал гэрэл цацрана.)

Хаан: Са Юнь богд та тогтсон болзоогоо мартаагүй чинь сайн хэрэг байна.

Са Юнь: Та харин үл няцахуйн хичээнгүй сэтгэлийг барьсаар ийм цог төгөлдөр үзэсгэлэнт оронг цогцлоосныг үзээд түмэнтээ ичингүйрч байгаагаа өгүүлэх юун !

Хаан: Чи шавь нарынхаа хамтаар хээрээр гэр хийж, хэцээр дэр болгон түмэн бэрхээс үл шантран явааг чинь би дандаа сэтгэлийн нуурандаа тольдож байдаг билээ. Чиний энэхүү хатуужилт явдал, чин зориг хүслийг л бахдан бишрэх учиртай.

(Энэ үеэр нэгэн жанжин яаран сандран хүрч ирээд)

Жанжин: Хаантанд айлтгах нь, манай хөрш зэргэлдээ харанхуй улсын үхлийн эзэн шулам, угаас хэрцгий догшин зантай болохоор, тэнгэр хүмүүний хилэнг байнга төрүүлдэг билээ. Дээр нь сүүлийн хэдэн жил ган гачиг тохиож, өлсгөлөн тахал дэлгэрсэний улмаас тус улсын хүн ард атаа хорсол алж хядахын хүсэлд автаж, манай хэрүүл тэмцэлгүй амгалан оронд халдахаар зэхэж байдаг болсон. Тэд одоо манай орон руу халдан ирээд байна.

Хаан: Тэднийг өөгшүүлээд байж болохгүй нь бололтой. . . .

. .

Са Юнь: (Толгой дохингоо) Ийм завшаан олон тохиолдохгүй

нь лавтай. Би ч гэсэн шавь нартаа аюулт шулмын цэргийг хэрхэн номхотгодгийг үзүүлээд авъя !

Хаан: (Олны зүг хандан өгүүлрүүн) Би та нарт амьдралын үнэнийг эрэлхийлж, зовлонгийн хүлээснээс алдуурахыг хүсвэл орчлонг огоорч, хэрүүл тэмцлээс хол байх хэрэгтэй гэж байнга сануулдаг билээ. Энэ удаа хорон санаат үхлийн хаан шулмас өршөөлгүй дайны галыг өдөөж байна. Ард иргэд ээ, бидний амьдран оршдог нутаг орон, ариун нандин газар шороо маань бусармаг дайны хөлд талхлагдах ёсгүй ээ ! Та бүхний дундаас хэн чинь цэрэг удирдан дайсныг эвдэх хүсэлтэй байна вэ?

(Олон хүмүүс бүгд нэгэн зэрэг гараа өргөн шуугилдаж)

Хүмүүс: Би хүсэж байна ! Би явмаар байна !

Хаан: Та бүхний дайчин зориг ийм сайн байгаа нь тун олзуурхууштай. Бид нар одоохон жанжин цэргүүдээ илгээн шулмын хааныг буулган авцгаая ! Өглөг, сахил та хоёр зүүн талаас нь мунхагийн балгадыг дайрагтун ! Хүлцэнгүй, хичээнгүй та нар харин баруун замаар нисваанисын хэрмийг дайраарай ! Самади чи эрдэнэсийн эрэлчдийн хамт гол хүчийг удирдан өөрсдийн хотыг хамгаалж бай ! Билгүүн ном, бичигт ном, гэгээн ном, бэлгэсийн ном жанжингууд та нарын дайчин туршлага их болохоор өрлөг жанжингаар томилон гурван замын цэргийг ерөнхийлөн удирдаж, баруун зүүн хоёр жигүүртэй хавсран дайраад харанхуй улсын

цэргүүдийг даран сөнөөгтүн !

Хүмүүс: Харанхуй улсын цэргүүдэд үхлийн цохилт өгцгөөе !

(Ингэснээр гурван замын их цэрэг ард иргэдийн өмнүүр сүр жавхлантай жагсан явж далд ороход гэрэл унтарна.)

АДАЙНЫ ТАЛБАР

(Харанхуйн дунд дайны их хэнгэрэг холоос ойртон сонсогдоно. Гэрэл асахад гэгээн ариун улсын цэргийн хүрээнээ билгүүн ном тэргүүтэй гурван жанжин бусдынхаа хамтаар хэрхэн дайтах тухай хэлэлцэж байх ажээ.)

Хүлцэнгүй: Дайсны цэргийн шулмын увдис хэдийгээр маш их боловч, манай арван найман ертөнцийн шилдэг цэргүүд цугларсан, дайчин зориг их байгаа болохоор тэдэнд дийлэгдэнэ гэж үгүй.

Самади: Хулгайг барихын тулд эхлээд толгойлогчийг олзлох хэрэгтэй гэсэн үг байдаг. Тэр лүгээ адил эхлээд шулмын хааныг бариад авчих юм бол дайсны цэргүүдийн дайралтыг няцааж болохоос гадна, манай талын хохирол ч мөн тэр хэрээр багасах бус уу?

Хичээнгүй: Чи тун зөв ярьж байна. Гэхдээ дайсныхаа хүч чадлыг басамжилж болохгүй. Хэрвээ жаахан л сэрэмж алдах

юм бол дайсандаа олзлогдсон байхыг үгүйсгэх аргагүй шүү.

Билгүүн гурван номын жанжин: Та бүхний арга бодлого тун зүйтэй. Дайсан ямар ч арга чарга хэрэглэлээ гэсэн гагцхүү гүн билгүүнийг баримтлан, аюумшиггүй харин үл няцахуйн сэтгэлээр зоригтой тулалдваас бид аюулт шулмын цэргийн омгийг дарж чадна. (Босож шөнийн байдлыг ажиглан харсанаа, олны зүг хандан) Шөнө орой болсон тул бүгдээрээ ээлжээр харуулд гарч, маш сонор сэрэмжтэй байх хэрэгтэй. Эс бөгөөс дайсны гэнэтийн халдлагад өртөж болзошгүй. Харин бусад нь сайтар унтаж амраад маргаашийн ширүүн тулалдаанд бэлэн байх хэрэгтэй.

Олон жанжингууд: (Мэхэсхийн ёслоод) Мэдлээ !

(Гэрэл унтраад зугуухан үүрийн гэгээ тусахад уулын хөндийд эвэр бүрээн дуун нүргэлж, залгуулаад түмэн морьдын төвөргөөн сонсогдоно. Гэгээн ариун улсын хаан, Са Юнь болон Юэгуан Тунзыг дагуулан өндөр уулын оройд гараад доошоо харж байна.

Уулын дор дайны хэнгэрэг дэлдэж, гэгээн ариун улсын цэргүүд жагсчихаад дайтахад бэлэн болсон харагдана. Энэ үеэр гэгээн ариун улсын хааны хоёр хөмсөгний хоорондохь цагаан үснээс гэрэл цацарч, агаарт эрт балрын яруу эгшигт тэнгэрийн аялгуу дуурсахыг Юэгуан Тунз олж харлаа. . . .
 . . Гурван билгүүн номын жанжин гэгээн ариун улсын их

цэргийн хүрээний өмнө гарч ирээд, гурван тулга хэлбэртэй завилан сууж, нүдээ хагас анивхийлэн, гүн самадиг бясалгана.)

Билгүүн гурван номын жанжин: (Уужуу тайвуухан) Нигүүлслийн ертөнц хязгааргүй, билгүүний далай амгалан хэмээн сонссон билээ. (Гэнэт их л цог жавхаатай ийнхүү дуулна) Шулмын цэрэг сэтгэлийн талбарыг үймүүлэв. Ялангуяа нүд, чих, хамар, хэл, бие, санааны зургаан үүднээ харгалзах хүслийн цэргийн хүч хамгийн их гэнэм. Хэрвээ сэтгэл түүнд автах аваас бодийн зам хаагдана. (Энэ үеэр, өглөг, сахил, хүлцэнгүй, хичээнгүй, самади зэрэг таван жанжингууд дараалан тайзан дээр гарч ирээд, нэгэн зэрэг “Сэтгэлийн амгалан ! Сэтгэлийн амгалан ! Сэтгэлийн амгалан ! ” хэмээн дуулалдана.) Түүнчлэн нирвааны хот балгад эвдэгдэж, Бурхан ном хувраг гурван эрдэнэ ч эвдрэх болой. Улмаар номын хөрөнгө булаагдан одсоноор нисваанисын хүслийн гал тэнгэрийн орныг ч дүүргэнэ.

(Билгүүн гурван номын жанжин лугаа нийлж цог төгөлдөр зургаан барамид болсоны дараа, бусад таван жанжин цоглог хөгжмийн аялгуун дор тайзны таван буланг эзлэн зогсоно.)

Билгүүн гурван номын жанжин: (Нигүүлсэнгүй хоолойгоор дуулна) Миний үзэхүйеэ энэ үймээн самууны уршгаар Бурханы ном доройтож мэдэх тул зургаан барамид хүч хавсран зургаан шулмын цэргийг даран сөнөөх аргыг

хамтдаа хэлэлцэж байна. (Дайны хэнгэргийн нүргээн дунд бусад жанжингууд амирлангуй тайвнаар “Өглөг, сахил, хүлцэнгүй, хичээнгүй, самади, билгүүн” хэмээн аялгуулан уншина.)

(Эвэр бүрээний дуун дор гэгээн ариун улсын цэргүүд дайрч эхлэнэ.)

Зургаан барамид: (Найрал дуу) (Сүрлэг янзтай)

Эхлээд бэлгэ чанарын хоосныг илгээгтүн !

(Гэгээн ариун улсын цэргүүд цээлхэн яруу хоолойгоор ийн уншина: “Хамаг үзэгдэх бүхэн мөн чанарын хувьд бодитой орших нь үгүй. Гагцхүү учир шалтгааны улмаас түр хуран цогцлосон нь тэр болой. . . .”)

Шулмын цэрэг хаана буйг тандъя хэмээвээс, дайсны цэргийн хүрээ таван цогцсын уулнаа оршиж буй.

(Гэгээн ариун улсын цэргүүд үргэлжлүүлэн: “Өнгө, хүртэхүй, бодол, явдал, мэдэл”)

Тэдний тоо найман түм дөрвөн мянгаар тоологдоно.

(Гэгээн ариун улсын цэргүүд: “Нисваанисын тоо ! Нисваанисын тоо ! Нисваанисын тоо !”) Тиймийн тулд арван найман ертөнцийн шилдэг цэргийг цуглуулан (Гэгээн ариун улсын цэргүүд намуухнаар: “Нүд, чих, хамар, хэл, бие, санаа, өнгө, дуу, үнэр, амт, хүртэхүй, арга, сэтгэл, үндэс, тоос, мэдэл. . . .”)

Бэлгэ чанар лугаа учирч их гавьяаг байгуулаад, хүлцэнгүй,

хичээнгүй хоёрыг дайчин жанжингаар сонгон, бэлгэ чанарын
хоосон үнэнийн хотыг хамгаалцгаая !

(Дуу дуулж байх зуур, олон цэргүүд жагсан найман
тогтоосон цэг рүү очиж хүрээ үүсгэн сууна. Яваандаа
зургаан барамид тэдэнтэй нийлэн хот мандлын хүрээг
үүсгэнэ. Хөгжмийн аялгуун дунд тэдний номын уншлага
улам чангарч ирэх бөгөөд, хамгийн өндөрсөх үед гэнэт
тасалдан зогсоно.Эх газар нам гүм агаад тэнгэрийн
амьсгааг анирлан сонсож болохуйц ажээ.)

Зургаан барамид: (Найрал дуу) (Их л нигүүлсэнгүй)

Гагцхүү зургаан шулмын цэргийг дайрсан жанжингууд,
хатуу ширүүн тулалдаан хийж байна.

(Тэнгэрийн хаяаны чанадаас үе үе тэнгэрийн яруу эгшиг
аялгуулж, олон жанжин цэргүүдийг зоригжуулна.)

Гэгээн ариун улсын цэргүүд: (Их найрал дуу) Аливаад хуран
эс үүдэхүйн үнэний гэрэл болох билиг билгүүний олсоны
хүчинд энэхүү дайны эцсийн ялалтыг оллоо.

(Ялгуусан баатарлаг ая эгшиглэхэд, тэнгэрт өнгө өнгийн
гэрлүүд солбицоод, сүүлд нь гурван тод гэрэл билгүүн
гурван номын жанжны бие дээр тусна. Агаарт ялгуусан
аялгуу эгшиглэхэд, билгүүн гурван номын жанжин зугуухан
босож ирээд өмнө зүгийн уулын оройг ширтлээ.)

Билгүүн гурван номын жанжин: (Цог төгөлдөр дуулна)

Би билиг билгүүний хүчээр омогт шулмын цэргийг даран

устгалаа. Нүд өнгийг үзэхгүй, чих дууг сонсохгүй, оюун ухаанаа нэгтгэн, омог төгөлдөр урагшлаад, эгнэгт харин үл няцаж, зургаан шулмын цэргийг бутниргэж чадлаа. Улмаар мунхаг харанхуйн уулыг эвдлэж, нисваанисын модыг огтлож хаялаа. (Амгалан дөлгөөн өгүүлрүүн) Өдгөө бие сэтгэлийн дотор гадна зүйрлэшгүй амирлалыг олж, бодь хутгийн нөгөө эрэгт хүрсэн мэт болов. Шулмын цэрэг бүгд ухарсан гэдгийг би хаан эзэндээ айлтгая даа !

(Тэнгэр үүлгүй цэлмэг харагдана. Тэнгэрийн хаяанаа их бодь хутгийг бэлгэдсэн туг хиур намирч, агаарт тэнгэрийн орны яруу хөгжим эгшиглэн, огторгуйн цэцэгс хурын ус мэт доош буух ажээ.Гэрэл унтарна.)

ДГЭГЭЭН АРИУН УЛСЫН ХУНТ НУУРЫН ЭРЭГ

(Хөхөө өвөл гэгээн ариун улс ногоон өмсгөлөө тайлаагүй, бороо цас холилдон зөөлөн шавшина. Билгүүн гурван номын жанжин хатуу ширүүн тулалдааны ард гарсан цэрэг дайчдаа дагуулан эргэж ирнэ. Гэгээн ариун улсын ард иргэд гудамжны хоёр хажуугаар баяр хөөртэй жагсан ялгуусан алдраа бадруулан эргэж ирсэн тэднийг угтан авлаа. Нуурын мандлын гол дунд алтан лянхуа сэнтий зугуухан хөвөн гарч ирэхэд улсын хаан түүний дээр амгалан дүрээр заларч байх ажээ.)

Гэгээн ариун улсын хаан (Дуулна)
Буртаггүй сэтгэлээс сарны гэгээ цацраад
Бурханы гэрэл улам тодорлоо
Мэлмийн хөмсгийг улам доош дарваас
Миний чихнээ магтаалын үгс хангиналаа
Хосгүй эрдэнийн дугана сэмээрхэн
Хоёр нүдний өмнө тодорлоо

Өдгөө санагтун
Өмнөх ирээдүйд
Өндөр дугана үнс болно
Өнгийн лянхуа ч үзэгдэхгүй бараагүй

Ухаант хүмүүн минь сэрэгтүн
Уудам орчлонд хэн нэгэн Бурхан болвоос
Тэнгэр огторгуй даруй эмтрээд
Тэндээс үерийн ус газарт асгармуй

Ухаант хүмүүн сэрэгтүн
Угаас юм бүхэн баттай бус
Уудам орчлонгийн жам гэвээс
Ургаа цэцэг, навч амирлан жаргамуй

(Ийн дуулж байх зуур Билгүүн гурван номын жанжин

цэргүүдээ удирдан хүрч ирэхэд хотын иргэд тэдний зүг цэцэг шидэн баяр хүргэнэ. Олон жанжин цэргүүд нуурын хөвөөнөө зогсоход Билгүүн гурван номын жанжин хааны өмнө мэхэсхийн ёслоно.)

Билгүүн гурван номын жанжин: Эзэн дээдэс минь, манай цэрэг олны итгэлийг олтгойлон хөсөрдүүлэлгүй, хөнөөлт шулмын ордонг эвдлэн, хэрсэн торыг нь шатаагаад, гурван сансрын орныг үгүй хийн, мунхаг харанхуй улсыг эгнэгт устгаж чадлаа. Түүнчлэн үхлийн хаан шулмасыг баривчлан ирсэнийг та хэрхэн шийтгэхээ болгоон соёорхогтун !

Гэгээн ариун улсын хаан: Та бүхэн ядарсан байх даа ! (Ард иргэддээ хандан)

Энэ удаа шулмын цэргийн омог сүр маш их байсан билээ. Хэрвээ Билгүүн гурван номын жанжин шулмын хаан манай цэргийн сэтгэл санааг самууруулах гэж буйг мэдээд, сахил, самади, билгүүн гурван жанжинг илгээн, шунал, уур мунхаг тэргүүтэн гурван шулмыг барьж аваагүй бол манай цэргүүд бүгд тэдний хорт нөлөөнд автах байлаа !

Алив хүн байна уу? Би өөрийн эрдэнэсийн санг уудлан өөрт буй бүхий л эрдэнэсээр гурван замын цэргүүдээ урамшуулан шагнахаар шийдлээ.

(Олон хүмүүс бүгд уухай хашгиралдан хааны хайрласан эрдэнэсийг өргөнө. Билгүүн гурван номын жанжин хажууд нь инээмсэглэсээр жанжин цэргүүдээ бахдан харж зогсоно.)

Са Юнь: Энэ удаагийн тулалдаанд ялаад эргэн ирэхдээ Билгүүн гурван номын жанжингийн хөмсөгний хооронд ашид харин үл няцахуй болоод гүн самадигийн гэрэл цацарч байх шив !

Гэгээн ариун улсын хаан: (Билгүүн гурван номын жанжинг их л бахдангуй хараад) Хэлээд яахав ! Тэд нар одоо их үйлийг гардан бүтээх итгэлтэй боллоо !

(Энэ мөчид гэгээн ариун улсын хааны үснирээс зүйрлэшгүй хурц билиг билгүүний ариун гэрэл цацран харсан хүмүүсийн нүдийг гялбуулна. Олон хүмүүс бүгд машид цочин гэлмэхэд, билгүүний гэрэл тэдний бие сэтгэлийг нэвт гийгүүлнэ. Ариун гэгээн улсын хаан гараа сунган үснирийн дээрх гэгээн сувдыг авав.)

Гэгээн ариун улсын хаан: (Чанга дуугаар зарлана.) Энэ эрдэнийн сувдыг би үснирийн дунд агуулан, хэр баргийн хүнд үзүүлэлгүй өнө удсан билээ. Эрдэнийн сувдын дотор ариун үзэмжит лянхуа цэцэг агуулагдан буй. Үүнийг тэргүүн гавьяа байгуулсан хүн л сая хүртэх эрхтэй юм. Өдгөө Билгүүн гурван номын жанжин шулмын цэргийг эвдэхэд тэргүүн гавьяа байгуулсан болохоор би энэхүү эрдэнийн сувдыг түүнд хишиг болгон хүртээж байна. Билгүүн гурван номын жанжин чи үүнийг ёс төртэй хүлээн аваад, сайтар хадгалж явах хэрэгтэй.

(Билгүүн гурван номын жанжин газар сөгдөн гэгээн сувдыг

тосон авна. Энэ үед тэнгэрээс тоо томшгүй олон цэцгийн хур бууж, яруу хөгжим эгшиглэнэ.)

Юэгуан Тунз: Са Юнь багш аа, энэхүү ариун дайныг үзсэний дараа бид хэдэн түмэн галвыг дамнасан хий хоосон зүүднээсээ сэрж, хайж яваа эрдэнэсийн барааг олж харах шиг боллоо !

Са Юнь: Хэрвээ та бүхэн энэ удаа үзэж харсан болгоноо сайтар санаж, сэтгэлийн дундахь шулмын цэргийг дарж чадваас оройн дээд билиг билгүүнийг олж, хайж яваа эрдэнэстээ дөтлөлөө гэсэн үг.

(Гэрэл сөөм газар бүхнийг тодхон гийгүүлэхэд, алтан лянхуа сэнтий дээр заларсан гэгээн ариун улсын хаан цээл яруу хоолойгоор ийнхүү дуулна.)

Гэгээн ариун улсын хаан: (Дуулна)

Хөвөх үүлс чи

Хөхрөх ус би

Дээрх огторгуйд чи эргэлдэнэ

Дэлхийн энгээр би урсана

Гэгээн тунгалаг ахуйдаа

Гэрэлт зүсийг чинь

Гэнэ гэнэхэн тольдном

Алтан нарны даль жигүүрээр

Агаар тэнгэрт хөөрөн

Чам лугаа

Асар тэнгэрт уулзан
Амгалан жаргалыг эдлэнэм.

Чи хаврын аянга цахилах бүрт
Чийглэг хурын шим болон бууж
Голын ус намайг тэтгэн
Голдрил даган хамтдаа урсаад
Хоёулаа хорвоогийн уудмаар зугаалнам.
Хөвөх үүлс чи
Хөхрөх ус би
Аяа !
Ингэхээр би бол чи
Эрэгцүүлвээс чи бол би ажгуу.

(Ийнхүү дуулах дуунд, тэнгэрийн цэцэгс хур мэт асгаран,
алтан нарны цацраг байгаль дэлхийг нэлэнхүйд нь
гийгүүлэхэд, нуурын гол дундах лянхуан дэлбээн дээр
туссан шүүдрийн дуслууд гилтгэнэнэ.)
Хөшиг хаагдав.

17 23

ХОРИН ГУРАВДАХЬ ӨДӨР

АЛТНЫ ДАРХАН

Орчлон хорвоогийн хамаг амьтдыг тэгш хайрлана гэдэг гоо үзэсгэлэн буюу. Гоо үзэсгэлэн нь үйл явдлаар батлагдаж байдаг гүн ухаан юм.

Үнэн гоо сайхантай хослон нийлэх үед, чи орчлон хорвоогийн гүн нарийн нууцыг ойлгох бөгөөд, тэр нь зүйрлэвээс хулсан сахал халиурах тал руу хул морь цахилан орох мэт, эс бөгөөс цагаан өмсгөлт уулсын бэлд цас дүүргэсэн цалин мөнгөн аяга тавьсан лугаа адил болой.

АРВАН ЖИН ШИЖИР АЛТ

Номин хулст хадны өглөөний цэнгэг агаар сэтгэл сэргэм тааламжтай. Өнөө өглөө хулсан төглийн зөрөг замаар нэгэн ховор зочин хүрэлцэн иржээ.

Өглөөгүүр хөхөлбөр хүдэн шаа торго мэт намилзаж, хулсан төглийн цэнгэг салхи лугаа муур хулгана болон хөөцөлдөн тоглож байлаа. Ургах наран хулсны үзүүрийг зөөлөн илбэхэд зөрөг зам дээгүүр номин ногоон сүүдэр туяарна.

Або Шиде нар болвоос уг хотын хамгийн эртэч хоёр юм. Тэд өглөө нарны туяан дорх үзэмжит байгалийг хараад хараад ханашгүй мэт санагдана. Або Шидөгөө аваад гадуур гарахаар зэхэж байтал зөрөг замын тэртээгээс нэгэн эрмэг алхаа сонсогджээ.

“Хүүе, өнөөдөр биднээс эрт боссон хүн байдаг байх нь ээ !” гэж Шиде бухимдангуй хэлэв.

“Хэн байдаг билээ?” хэмээн нэг л догдлонгуй бодох зуур Або дороо зогсоод чих тавин хүлээж байлаа.

Удалгүй хүдэн буданг ярсаар хүдэр бадриун биетэй нэг хүн тэднийг чиглэн том том алхлан хүрч ирлээ. Або түүнийг хараад тэсгэлгүй баярлан:

“Энэ чинь Хоосноор дүүлэх нэрт эртний тосгоны хөгшин алтны дархан байх шив дээ !” хэмээн уулга алдав.

Ийн хэлэх зуур Або тэсгэлгүй түүнийг тосон алхаад хөгшин дархны гараас чанга чанга атган, итгэж ядсан байдалтай чанга дуугаар:

“Алтны дархан таныг ингээд хүрээд ирэх юм гэж бодсонгүй шүү ! Аль газрын салхи таныг манай хулсан төглийн зүг аваад ирдэг байна вэ? Арай зүүд биш байгаа даа?” гэнэ.

“Хэ хэ, нээрэн ч удаан уулзсангүй шүү ! ” гэж хөгшин хүмүүн хүрэл хонх мэт баргиа бүдүүн хоолойгоор хэлээд “Дархан гуай таны амьдран суудаг номин хулст хад ч миний төсөөлж байснаас илүү үзэсгэлэнтэй сайхан газар байна шүү ! ” гэв.

Ийнхүү халуун дотно мэнд усаа мэдэлцсэний дараа Або өвгөн алтны дархныг өөрийн сууцандаа урьж оруулав.

Замын турш Або өвгөн дархныг их л хүндэтгэх нь Шидөгийн сониуч занг ихэд хөдөлгөсөн тул тэрхүү эгэлгүй зочныг сайтар сонжин харж явлаа.

Өвгөн алтны дархныг холоос харахад сүрлэг том биетэй атлаа, ойртоод ирсэн хойно цал буурал тэргүүн, хүүхдэрхүү гэнэн цайлган атлаа ухаалаг царай нь дотносож нөхөрлөмөөр элгэмсүү төрхийг илтгэх ажээ.

“Өвгөн дархан болвоос их л сонин хүн юм байна лээ ! ” гэсэн дүгнэлтийг Шидө хожим гаргаж билээ.

Або өвгөн дархныг баруун цонхны ойролцоох тохилог буланд урьж суулгаад нэгэн дэвэр аагтай сайхан цайгаар

дайлав. Хоёр хөгшин өөд өөдөөсөө харж суучихаад тавтай цайлна.

Өвгөн дархан цайгаа ууж дуусчихаад ташаандаа зүүсэн нэгэн жижиг даалин гаргаж, дотроосоо цагаан пансан боодолтой зүйлийг нямбайлан задлаваас бас нэгэн жижиг модон хайрцаг байх ажээ.

Өвгөн алтны дархны ухаалаг хоёр нүднээс ер бусын гэрэл цацрахыг Шидө олж харлаа. Тэр Або руу учиртай нүдээр инээвхийлэн хараад модон хайрцгийг нээлээ.

“Алтан арслан байх шив дээ ! ” модон хайрцагтай алтан арсланг харах үедээ Або дуу алдах нь өвгөн дархантай анх уулзаж байсан үеийн догдлол баяраас огт дутахааргүй ажээ. Або хэр баргийн юман дээр хөл алдаад байх хөнгөн хүн биш боловч өвгөн дархныг үзээд тэгтэл баярлаж байхыг бодоход цаадхи нь их л учиртай хүн бололтой гэж Шидөд санагдаж байлаа. Үнэндээ модон хайрцагнаас мөнөөх сүрлэг уран хийцтэй жижигхэн алтан арслан гарч ирэх үед Шидө ч түүнийг ихэд сониучирхан харж билээ.

Эгээ л амьд юм шиг уран нарийн хийцтэй алтан арслан халдашгүй дархан эрх сүрийг илтгэн харуулахаас гадна хүрхэрч ч мэдэхээр төрх нь зүрх зориг муутайхан нэгнийг нэлээд бэргүүлэхээр ажээ.

“Энэ лав хөгшин дархны уран бүтээл буй за ! Үнэхээр уран

нарийн хийцтэй болохоор хотын алтан эдлэлийн дэлгүүрт байдаг алтан арслантай харьцуулах эд биш байлаа. Энэ алтан арслангийн биенээс амьдлаг гэрэл цацрах нь намайг ч мөн тольдон харж байгаа мэт санагдаж байх чинь ! ” гэж нүдний өмнөх арсланг ажиглах зуур Шидө бодож байв.

Цонхоор тусах нарны хурц туяа алтан арслангийн бие дээр ойгоод нүд гялбам гэрэл цацруулна. Алтан арслан нарны гэрэлд ариуслын угаал үйлдсэн мэт шаргал зогдор нь намиран зөөлөрчээ. Буржгардуу хоёр хөмсөгний дор гал цогтой нүд дүрлийж, хамрын самсаа сархайж, амаа бага зэрэг язайлгасны завсраас хурц хоёр соёо цухуйна. Хоёр чих нь ялимгүй соотойсон нь ямар нэгэн зүйлийг хичээнгүйлэн сонсож байгаа бололтой. Дөрвөн сарвууны хумсыг газарт бат шигтгэн, цээжээ түхийлгэн зогссон нь хамаг биеийн ааг хүч багтаж ядан байгааг илтгэнэ.

“Ямар сүрлэг арслан бэ?” гэж Шидө дотроо бодож байлаа. Алтан арсланд сэтгэл нь гүнээ татагдсан тул тэсэж чадалгүй ийнхүү асуулаа.

“Алтан арслан минь ! Та нар чухам хаанахын ямар гээч газраас ирсэнийг хэлж болохсон болов уу ! ”

“Бид хоёр Хоосноор дүүлэх нэрт эртний тосгоноос ирсэн юм.” гэж алтан арслан хээвнэг хариулахад Шидө өөрийн мэдэлгүй давхийн цочив. Учир нь түүний эрдүү баргил хоолой жинхэнэ арслангаас огт өөрцгүй ажээ.

Уг нь дотроо ярьдаг байгаасай гэж горьдож байсан боловч цагаа тулахаар ийнхүү балмагдан цочдог байна шүү ! Нөгөө талаар тэр арслангийн сүр хүчинд автсан хэрэг л дээ ! Шидө жаахан тайвширч байгаад залгуулан асууруун:

“Хоосноор дүүлэх тосгон гэж хаана байдаг юм бэ? Манай эндээс хэр зэрэг хол вэ? Ямар хүмүүс амьдран суудаг билээ? Төрх байдал нь та хоёртой адилхан ийм этгээд үү?”

Шидөгийн энэхүү олон цувраа асуултыг тайван сонсож дууссаны дараа алтан арслан:

“Хоосноор дүүлэх тосгон болвоос орчлонгийн тоосноос ангид орших балар эртний суурин юм л даа ! Уг тосгон орчлон хорвоод хэр зэрэг удаан оршсоны хэлж чадашгүй нь ! Яагаад гэвэл манай өвөг дээдэс маш аглаг буйд газрыг сонгон тосгоныг байгуулсан болохоор хоёр хөлт хүн байтугай жигүүртэн шувуу ч маш цөөн олж очдог юм. Тийм болохоор манай тосгоныхон үеийн үед орчлон хорвоогоос бүрэн тусгаарлагдмал байдалтай амьдарсаар ирсэн.”

“Тэгэхээр танай Хоосноор дүүлэх тосгон чинь тэгвэл орчлонгоос ангид оршдог нууцлаг диваажин юм биш үү? Жигүүртэн шувууд хүртэл очиж чаддаггүй гэхээр.”

гэж Шидө ямар нэгэн юм бодсон бололтой амандаа бувтнаад

“Тэгвэл үүлс, салхи танай тэрүүгээр зорчдог байлгүй дээ !

Дараа тэднээс та бүхний мэнд амрыг асууж байя ! ”

Тийм нууцлаг тосгон байдгийг мэдсэн Шидө баярласандаа

тэр тухай Абод хөрвүүлэн хэлж өгөх гэтэл цаадхи нь өвгөн дархантай жинхэнэ ам халан хуучлаж суух ажээ. Тэгээд тэр бодлоо өөрчлөн алтан арслангаас ийн асуулаа:

“Танай Хоосноор дүүлэх тосгоныхон гадаад ертөнцтэй холбоо тасраад маш удсан гэж өөрөө хэлсэн шүү дээ ! Гэтэл эд нар яахаараа хоорондоо танилцчихдаг билээ? Тэр хоёр яг л хуучин найзууд мэт дотносон ярьж байгааг харж байна уу?”

“Манай тосгоныхон үеийн үед гадагш гарч байсан нь үгүй. Харин манай эзэн алтны дархан анх удаа л тэр жишгийг зөрчин гадагш гараад танай энд ирж байгаа юм. Харин миний тухайд гэвэл мянган жилийн өмнө маш ховор ерөөл тавилангийн эрхээр тухайн үеийн маш хөл хөгжөөнтэй нэг хотод очиж билээ. Харин энэ удаа би хоёр дахиа тосгоноосоо гарсан нь энэ ! ” гэж алтан арслан урсган хэлээд:

“Танай эзэн уран гартан маш санамсаргүй тохиолдлоор манай Хоосноор дүүлэх тосгонд нэг удаа очсон юмдаг. Тэгээд хөгшин алтны дархантай танилцангуут хуучин андууд шиг ижилдэн дасаад, хэдэн сар өнжин саатсан билээ. Тэгээд салах үедээ хоёр хөгшин салж хагацашгүй андын барилдлага тогтоосон.”

“Уухайс ! Тэгвэл Або танай орчлонгийн диваажинд очиж байсан байх нь ээ ! Ёстой азтай хэрэг байна даа ! ” гэж Шидө атаархангуй дуу алдсанаа нэлээд харууссан

байдалтай өгүүлрүүн:

“Танай тосгонд очиход тийм хэцүү байдаг юм бол Або яахаараа яваад хүрчихдэг билээ? Тэндхийн амьдрал Абод лав их таалагдсан байж таарна. Гэтэл тэр яахаараа буцаад хүрээд ирдэг байна вэ?”

“Магадгүй тийм л ерөөл барилдлагатай байсан юм байлгүй дээ ! Яадаг ч байсан өвгөн уран гартан яваад л очсон юм даа ! Мянган жилийн өмнө нэг бадарчин яваад очсоныг бодоход тийм ч очиж болшгүй газар бас биш шүү !

Өвгөн уран гартан манай тосгоны амьдралд үнэхээр татагдаж байсан гэдэг тухайд чи зөв таалаа. Гагцхүү тэр хүний орчлонд гүйцэлдүүлэх ёстой цөөнгүй хэрэг зориг байсан болохоор нутаг орондоо буцаж ирсэн юм. Тухайн үед өөрт нь харамсалтай байсан боловч арга буюу буцсан юм даг. Түүнээс хойш манай түүгээр дахин үзэгдээгүй. Харин энэ удаа алтны дархан эзэн маань наашаа аялах далимаараа уулзаж байгаа нь энэ.”

Алтан арслангийн ийн өгүүлэхийг сонсох зуур Шидөд өөр нэгэн чухал зүйл санагдсан тул асууруун:

“Яагаад Або та хоёр тэр сүрлэг том биетэй өвгөнийг алтны дархан гэж нэрлээд байгаа юм бэ? Тэгэхээр тэр чамайг урласан хэрэг үү? Түүнээс гадна Або чамайг олж харах үедээ урьд өмнө үзэж хараагүй мэт тэгтлээ догдолдогийн учир юу билээ?”

“Харин чи л ёстой урьд өмнө үзэж харж байгаагүй сониуч цаасан шувуу байна даа ! ” гэж Шидөгийн асуултанд булагдаж гүйцсэн арслан хэлснээ цааш нь:

“Энэ тухай яривал их урт түүх болно л доо ! Гэхдээ чи манай Хоосноор дүүлэх нэрт тосгоны өөр нэгэн өвөрмөц талыг хөндөж орхилоо байна ! ”

“Үнэхээр тийм гэж үү? Тэгвэл тэр тухайгаа хурдан яриад өг л дөө ! ” гэхэд Шидө алтан арслангийн егөөдөлд огтхон ч юм бодсон шинжгүй харин ч улам сониуч зан нь хөдлөв бололтой.

“Байз л даа ! Би одоохон өөрт чинь ярьж өгөх гэж байна.” гэж алтан арслан инээд алдсанаа Шидөгийн сэтгэл жаахан тогтохыг үзээд, ийнхүү хүүрнэж гарлаа. . .

Маш эрт балар цагт орчлон хорвоо дээр нэгэн тосгон оршин байсныг Хоосноор дүүлэх хэмээн нэрийддэг байжээ. Хүмүүсийн газар хагалж, тариа ногоо ургуулах эрдэм тэндээс үүсэлтэй ч гэлцдэг.

Тэрхүү Хоосноор дүүлэх тосгон нь эрт балраас эдүгээд хүртэл орчлон хорвоогийн хамгийн үзэсгэлэнтэй эрдэнийн газарт тооцогддог юм. Тэр тосгонд өнө мөнхөд тутраган чих ногоорч, гэрэл цацарсан өнгийн цэцэгс халиурахаас гадна, номин ногоон төглүүд, тунгалаг ариун гол горхиуд элбэгтэй.Түүнээс гадна энэхүү эрт балрын тосгонд үе дамжин

уламжлагдаж ирсэн арван лан алт байдаг гэнэм.

Эрт балраас инагш тэрхүү арван лан алтыг нэгэн алтны дархан хадгалж, эд юм урласаар иржээ. Тосгоныхноос хэн нэгэн гэрлэж бараалах болвол, алтны дархан алтнаас хайлуулан хөгжмийн зэмсэг, цэцэг мод, жигүүртэн шувуу зэрэг гоёмсог зүйлийг урлаж сүй бэлэг болгон өгнө. Бас хэн нэгэн хүн төрсөн өдрийн насан хутгийн баярыг тэмдэглэх үед, алтан хэнгэрэг, эрдэнийн асар зэрэг урт насыг бэлгэдсэн эд юмсыг урлаж бэлэглэдэг. Түүнээс гадна аль нэг айлд шинээр амь бүл нэмбэл нялх хүүхдэд нь жиргэмэл бялзуухай, лимбэ зэрэг тоглоомыг алтаар урлаж өгөөд баяр дээр баяр нэмдэг юм.

Өөрөөр хэлбэл уг тосгоныхон арван жин алтыг хамтдаа эдлэж хэрэглэдэг гэсэн үг !

Ийнхүү ердийн цагт арван жин алт маань янз бүрийн хэлбэр дүрсэнд хувилж, тосгоныхны гар дээр очих бөгөөд, аль нэгэн айл бэр буулгахад түүнийг дагалдаад алтан хуур, цэцэг модтой болдог. Өөр нэгэн айл мантгар цагаан хүүтэй болох үедээ үүлэн хээт янтай, алтан лимбэ өөрөө л хүрээд ирнэ гэсэн үг.Хэдийгээр айл болгон, тэр ч бүү хэл хүн болгон уг алтыг эзэмших эрхтэй боловч цаад утгаараа нийт тосгоныхны өмч учраас түүнийг тодорхой хугацааны дараа алтны дарханд буцаан өгөх үүрэгтэй. Түүнийг нь авсан дархан өөр нэгэн хүний хэрэгцээний дагуу хүссэн зүйлийг

нь урлаж өгдөг. Арай баян айл бол авсан алтан эдлэлээ нэг хоёр жил гар дээрээ байлгаж болдог бол, ядуувтар нэг нь ганц хоёр сар болгоод л буцаан өгдөг ажээ.

Үе үеийн алтны дархчуул мөнөөх арван жин алтыг хүмүүс зөв шудрага хуваарилж өгөх үүрэг хүлээнэ.

Алтан арслангийн ийн хүүрнэхийг сонсоод Шидөгийн хувьд Хоосноор дүүлэх эртний тосгон улам ч гайхалтай сонин санагдсан тул тэсгэлгүй ийн асуулаа:

“Тэгвэл алтны дархны үүрэг ч үнэхээр их юм байна даа ! Тэгвэл яаж алтны дархан болдог юм бэ?”

“Хоосноор дүүлэх эртний тосгонд алтны дархныг багш шавийн барилдлагаар бэлтгэдэг юм. Тэндхийн алтны дархан хүн өргөн мэдлэгтэй, гоц билиг билгүүнтэй, хүмүүсийн хүссэн зүйлийг хийж өгдөг гарын уртай байхаас гадна, хамгийн гол нь тосгоны хүмүүсийн хүсэл сонирхол юу болохыг ажиглаж мэдэх гярхай зантай байх ёстой. Тэдгээрийн дотроос онцгой чухал нь гэвэл бусдын тусыг хичээж, олон түмэнд үйлчлэе гэсэн чин эрмэлзэлтэй байх учиртай юм.”

“Тэгвэл алтны дархныг хэр баргийн хүн хийнэ гэдэг ч худлаа юм байна даа ! ”

“Тэгэлгүй яахав ! Алтны дархан хүн хурц билиг ухаан, өндөр ур чадвар, ёс суртахууны чанд хүмүүжилтэй байж л сая олны итгэлийг хөсөрдүүлэхгүй авч явж чадна шүү !”

“Чи их оновчтой сайхан тодорхойллоо. Алтны дархныг анх хараад л би олноос онцгой хүн болохыг нь мэдсэн юм.” гэж Шидө хэсэг зуур бодолхийлээд өгүүлэв.

“Хэдэн мянган жилийн турш мөнөөх арван жин алт нэмэгдэх ч үгүй, хасагдах ч үгүй, үе үеийн уран дархчуулын ур ухаан, гарын дүйгээр, түм буман янзаар хувилсаар өнөөг хүрчээ. Заримдаа том, заримдаа жижиг, тэр ч байтугай бүхлээр нь хайлуулаад нэг алтан арслан цутгаж байсан удаа ч бий. Гэвч түүний мөн чанар хэзээ ч хувирахгүй. Үе үеийн дархчуул өөрийн урласан бүтээлийн зургийг хадгалан үлдээдэг болохоор түмээр тоологдох олон болчихсон байгаа.” гэж хэсэг зогсосхийснээ алтан арслан цааш залгуулан өгүүлрүүн:

“Хоосноор дүүлэх эртний тосгоны уран гартангууд арван жин алтыг бүхэлд нь цуглуулаад нэг том алтан арслан цутгах л хамгийн баяр жаргалтай мөч байдаг гэдгийг чи мэдэх үү? Гэвч онцгой учир шалтгаан үгүй л бол тийм боломж гарах нь маш ховор байдаг юм. Танай эзэн өвгөн уран гартан алтан арслан миний дүрийг харахдаа туйлын ихээр баярлаж байсан нь үүнтэй холбоотой юм л даа. Яагаад гэвэл алтан арсланг урлаж бүтээнэ гэдэг хэдэн зуун мянган жилийн туршид ганц нэгхэн л тохиодог ховор завшаан болохоор тэр.”

“Тэр ховор алтан арслан нь чи болж таарах нь ээ !” гээд хорвоод хосгүй нандин эрдэнэ олж үзсэн мэт Шидө амандаа

бувтнаж гарлаа.

“Тийм ээ ! ” гэж урт түүхийг хүүрнэж дууссан алтан арслан Шидөгөөс ийн асууруун:

“Чи одоо алтан арслангийн гадаад төрхийг л ажиглан харж байна. Харин түүний дотоод мөн чанар юу болохыг мэдэж байна уу? Олон жилийн өмнө танай эзэн намайг анх олж харахад би алтан хэнгэрэг, янтай, цэцэгт мод гэх мэт дүртэй байсан.Гэсэн атал миний мөн чанар түүнийг даган хувьссан бил үү?”

“?” Шидө нэг хэсэг юу хэлэхээ мэдэхгүй хэсэг эрэгцүүлэн бодсон хойно ч бас л таг дуугүй байсаар байлаа.

Алтан арслан ийнхүү Шидөд Хоосноор дүүлэх эртний тосгоны тухай элдвийг хүүрнэж байх зуур, Або ч өвгөн алтны дархан лугаа баяр хөөртэй хуучлан суужээ.

“Түрүүчийн удаа би танай тосгоноор очоод ирсэн цагаас хойш байнга л тэдхийн байдлыг зүүдлэх болсон шүү ! Гэхдээ дахин уулзах боломж олдохгүй биз дээ гэж бодож байтал ашгүй та морилон ирлээ. Ёстой л гайхам сайхан зүүд шиг санагдаж байна. Тан лугаа аагтай сайхан цай хуваан ууж, хууч хөөрөхөөс гадна, арван жин алтаар бүхэлд нь цутгасан арслангийн барааг олж үзэх боломжтой боллоо. Ёстой л гурван төрөлд эс мартагдах тэнгэрийн таалал хэмээх энэ буй за ! ” гэхэд Абогийн ухаалаг царайд нь тэсгэлгүй

баярын оч гялалзана.

Өвгөн алтны дархан ч байн байн толгой дохиход хоёр нүднээс нь гэрэл цацран бүхнийг гийгүүлж байх мэт ажгуу. . . . Тэгээд тэр хоёр модон хайрцган дахь алтан арсланг удтал дуугүй ажиглан суулаа.

“Дархан гуай ! Чухам ямар онцгой учир шалтгааны улмаас энэхүү арван жин алт дахин цуглараад арслан болон цутгагдав аа ! ” гэж Або их л догдлонгуй асуужээ.

“Энэ үнэхээр гайхалтай ховор тохиол юм л даа ! Энэ алтан арслан мянган жилийн өмнө л хорвоод нэг удаа үзэгдэж байсан гэж би түрүүчийн удаа уулзахдаа ярьж байсныг санаж байна уу?”

Ийнхүү яриагаа эхлэхэд өвгөн дархны харц улам ч гүн бодлогоширонгуй болоод дуу нь хүрэл хонх мэт нүргэнэ. Тэр нэг балга цай оочлоод, дуу нь аядуу зөөлөн, оюун санаа нь өөр нэгэн орон зай цаг хугацаа руу явчих мэт санагдав. . . .

Мянган жилийн өмнө өндөр уулын бөглүү хавцалд орших Хоосноор дүүлэх эртний тосгонд нэгэн хэрмэл бадарчин явж очсноос үүдэлтэй ер бусын ховор сонин тохиолдол болжээ.

Тэр үед амьдарч байсан уран дархан анх удаа арван жин алтаар арслан цутгасан юм гэнэ лээ.

Тэрхүү бадарчин эрдэм мэдлэг, хүмүүжил, намба төрхийн

аль алины хувьд хорвоод ховорхон заяах нэгэн байсан агаад, хосгүй нандин амьдралын билиг ухааныг олон түмэнд зааж сургахын төлөө зүтгэдэг хүн байжээ. Тэр тухайн үеийн хаанд маш ховор нандин арга номыг зааж сургаж байх зуур нэгэн шөнө зүүд нойрондоо орчлонгоос тусгаарлагдмал аглаг уулын бөглүү тосгонд орчлонд олдохуйяа бэрх алтан арслан байгаа тухай зүүдлэсэн байна. Тэгээд тэр зүүдний ёр бэлгэсийн дагуу эрэл сурал болон явсаар гайхам үзэсгэлэнтэй Хоосноор дүүлэх эртний тосгоныг олж очоод, хосгүй хурц билгүүний гэрэл болон сүслэнгүй сэтгэлийн хүчээр, тосгоны иргэдийг номондоо оруулахад, тухайн үеийн уран дархан хүмүүсийн гар дээрх бүх алтыг цуглуулж, анх удаа онцгой гайхам ур дүй шаардсан алтан арсланг цутгасан юм гэдэг. Бадарчин тэрхүү алтан арсланг авч хааны ордонд буцан очоод орчлонгийн мянга түмэн үзэгдэл юмсын хувьсал хувирлын цаад мөн чанар болох бодит бэлгэсийг алтан арслангаар жишээлэн тайлбарлахад.хаад ноёдоос авахуулаад харц ард бүгдээр түүнийг сүслэн дагаж, төв хичээнгүй ёсыг сахих болсноор улс орон нь маш урт удаан хугацааны турш амгалан жаргалыг эдлэх болжээ.

Хожим нь бадарчин алтан арсланг мянган боть дээдийн номын хамт Хоосноор дүүлэх эртний тосгонд аваачиж өгсөн нь тэндхийн хүмүүсийн хувьд өнөө ч ам дамжин

яригддаг сайхан домог болон үлджээ. Тэгээд тосгоныхон бүгдээрээ цуглаад тэрхүү дээдийн номын гүн утгыг тайлан номлогч байх юм бол алтан арсланг дахин цутгана гэж андгай тангараг тавьцгаажээ.

Гэвч сүүлийн мянган жилийн турш тийм билиг оюунтан тодрон гараагүй болохоор алтан арсланг үзэх хувь дутсан байна. Харин арван хэдэн жилийн өмнө нэгэн хатуу чанга зоригтой нэг залуу эр түмэн бэрхшээлийг төвөгшөөлгүй эрэл сурал болсоор Хоосноо дүүлэх эртний тосгоныг олж очжээ.

Залуу эр гагцхүү мөнөөх домогт л гардаг мянган боть ховор нандин судрыг хайсаар ирсэн байна.

Тэгээд далай мэт номын чуулган дунд өдөр шөнөгүй шамдан суралцсаар уулын нам гүмхэн тосгонд арван оныг үдэж, улмаар судрын гүн нарийн утгад нэвтэрч, орчлон хорвоо тэнгэр газрын хоорондохь дээдийн билиг билгүүн болох оройн дээд гүн нарийн уран аргыг олж тайлсан байна. Тэгээд хуучин судрын шарласан хуудсан дээрх ойлгохуйяа бэрх гүн нарийн утгыг хүний сэтгэлд нийцтэй догдлом яруу жүжиг болгон найруулсан нь “Долоон шөнийн үлгэр” гэсэн нэртэй амьдралын дээдийн билиг билгүүнийг үзэгчдэд ухааруулдаг юм.

Хамгийн хачирхалтай нь нэгэн шөнө хөгшин алтны дархан сүр хүчээ гайхуулсан алтан арсланг зүүдлэжээ. Удаах өдөр

нь нөгөөх залуу эртэй уулзаж, тосгоны бүхий л хүмүүсийг цуглуулахад, мань залуу өөрийн хосгүй билиг оюун, бусдын тусыг хичээх үзэл болон гайхам уран чадвараараа хүмүүсийн хайр хүндлэлийг гүнээ олсон байна. Тэгээд тосгоныхон өөрсдөдөө байгаа арван жин алт цуглуулан арслан цутгахаар болжээ.

Өөрийн эрхэм хүслийг гүйцэлдүүлэхээр залуу эр уулнаас буун, дахин жирийн амьдралын гүн рүү орсон байна. Харин тосгоныхон түүнд “Долоон шөнийн үлгэр” жүжиг тоглогдож дуусах сүүлчийн өдөр, өвгөн алтны дархнаар алтан арсланг түүнд үзүүлж, баяр хүргэнэ гэдгээ амлажээ. Түүний зэрэгцээ мөнөөх сонирхолтой жүжгийг уулын аглаг эрт балрын тосгонд тоглож үзүүлнэ гэдгийг ч тохирсон байна.

Хөгшин алтны дархны ийн хүүрнэхийг амьсгаа даран чагнаж байхад Абогийн хувьд энэ бүхэн нэг л ухаан санаанд багтамгүй гайхам сонин санагдсаар байлаа.

“Тийм болохоор та өөрийн жишгийг эвдэн, Фэнтори хамтлагийн ахлагч Фухуатай уулзахаар ирсэн юм биз дээ?”

“Тийм ээ ! Олон жилийн турш Фухуагийн үүсгэн байгуулсан Фэнтори хамтлаг Долоон шөнийн үлгэр жүжгийг хот хөдөөгүй аялан тоглож үзэгчдийн халуун талархлыг хүлээгээд буй ! Харин түүний энэ жүжиг

хамгийн сүүлчийн удаа өвгөн уран гартан таны амьдран суудаг энэ хотод тоглогдох юм гэж огт санасангүй шүү ! ”

Өвгөн алтны дархан ийн өгүүлээд Або тэр хоёр баясан инээлдлээ.

Энэ үеэр алтан арсланд мадлагдаж орхисон Шидө дув дуугүйхэн Абогоос тусламж эрэхээр шийдээд байлаа.

“Намайг нүдээр битгий үз, чихээр ч битгий сонс. Мэдэрсэнээр ойлгох хэрэггүй, санаагаар ч бүү төсөөл ! Би бол эрт балраас эдүгээд хүрч ирсэн жинхэнэ бодит бэлгэс байгаа юм. Тайван амгалан байгтун ! Тайван амгалан байгтун ! Чи өөрийн дотор буй жинхэнэ би хэмээгчээр л намайг сая ойлгож чадна. Тэгвэл чи хэзээ нэгэн өдөр би хэмээгч чи, чи хэмээгч би болохыг ойлгоно ! ”

Алтны дархан цагаан пансан буцаан боогоод авч явахын өмнөхөн алтан арслан ийн асууруун:

“Орчлон хорвоо эх дэлхийд чухам хэр зэрэг их алт бий вэ?”

“Тун сонирхолтой асуулт байна шүү ! ” гэж Шидөгийн хөрвүүлэн хэлэхийг сонсоод Або цаад санааг ойлгосон бололтой инээмсэглэлээ.

Өглөө нарны туяан дор алтан шаргал өнгөөр гялалзах тутрагын түрүүг тэр дурсан санав.Түүнчлэн атар хээр талд оройтож ирсэн хэнз цэцэгсийн хүйс алтан шаргал өнгөө гайхуулдгийг ч эргэн саналаа. Мөн талын энгээр алтан шаргалтан халиурах алтан тарианы түрүү нүдэнд

нь харагдах шиг болов. Энэхэн агшинд бидэртэн долгилох горхийн ус, өвгөн нарсны хуй салхитай хуучлан ярьж байсан зэрэг нь чихнээ сонсогдох шиг болов.

Ийнхүү гүн бодолд автан байхад алтан арслангийн хэлсэн үгийн цаад далд санаа түүний орой руу орж ирлээ.

“Намайг нүдээр битгий үз, чихээр ч битгий сонс. Мэдэрсэнээр ойлгох хэрэггүй, санаагаар ч бүү төсөөл”

Гэнэт тутраган чих, зуун цэцэгс, горхийн урсгал, өвгөн нарс. зэрэг мянга түмэн үзэгдэх юмс, бүгд нэг нэгэнгүй сэтгэлийн далайд тодхон дурайн харагдав. Тэд бүгд нийлэн сэтгэлийн утсыг хөндөн, уран нарийн тод цээлхэн бодлын аялгууг хөглөнө.

“Орчлон хорвоо гэдэг тэр чигээрээ алтан эрдэнэ, газар сайгүй хиргүй ариухан амин булгийн өнгө гийж байдаг ажгуу !” хэмээн Або өөрийн мэдэлгүй бахдан шогширов.

Тэр инээмсэглээд энэ бүхэнд гайхаж хоцорсон цаасан шувуу Шидөгөө цэлмэг огторгуйн энд тавьж явуулаад, хөх тэнгэрийн хамт алтан арслангийн асуултын хариултыг эрэг хэмээн боджээ.

Үдээс хойш голын далайтай нийлэх хэсэг дээр хүрч ирлээ.

Уулын хормойгоор зэгс халиурч, эрэг дагуу мөлгөр хайрга чулуу хөглөрнө. Тослог ногоон зүлэг болон үүлс баганадсан өндөр оргил бүгд л далайтай нийлэх усны цутгаланд зүсээ

тольдох ажгуу. Түүнээс цаашлаад их далай цэлийж, тэнгэр гүн цэнхэр өнгөө гайхуулна.

Агаарт энэ бүхнийг ажиглан явахад сэтгэл хөөр баяраар бялхах ажээ.

“Або чиний нүд, чих, хамар бас өргөн мөр зэрэг чинь мөнөөх алтан арслантай нэг л адилхан санагдаад байх юм. Түүний учир юу юм бол доо?”

“Магадгүй, тэр алтан арслан чи бид хоёрын сэтгэл зүрхэнд оршдог ч юм бил үү?” хэмээн инээмсэглээд Або цаасан шувууны хувцас өмсгөлийг янзлаж өгөв.

“Дуу хоолой чинь хүртэл алтан арслантай эгээ л адилхан сонсогдож байна шүү ! ” гэж хэлчихээд цаасан шувуу Шидө ойн бяцхан шувуухай мэт Абогийн гар дээрээс тэнгэр огторгуйд дүүлэн нислээ.

Тэр жаргах нартай тэнгэрт чөлөөтэй дураар элин халин ниснэ.

Алсад их далай алтан шаргал өнгөөр цацрах авай.

* * *

Долоо дахь өдрийн орой далайн эргээр нисэж явсан Шидө жаргах наран асар том галт бөмбөр агаарт өлгөчихсөн мэт ер бусын дугариг улаан байхыг олж мэдэв.

“Өнөөдөр намрын хугас болж байгаа юм байна шүү дээ ! ” гэж амандаа бувтнах зуур Або ч мөн тэрхүү үзэмжийг олж харлаа.

Орой нарны улбар туяа алтан арслангийн энэрэл билгүүн нэвт шингэсэн үгсийг авч одох үест, номин ногоон хулсан төглийн дээгүүр гэгээн саран хөөрөн мандав.

Хүмүүсийн хүсэн хүлээсэн намуухан орой болдгоороо болов. Үтрэмийн талбайг гэгээн саран нэлэнхүйд нь гийгүүлнэ. Або хуучин суудалдаа тухлаад хөнгөн дэвүүрээр сэвэхэд, өвөр дээр нь суугаа Шидө хүсэн хүлээхийн баяр жаргалд умбах ажээ.

Лимбэ хөгжмийн яруу аялгуун дор цайвар шаргал өмсгөлтэй танил дүр төрх тайзан дээр гарч ирлээ. Түүний төрөлхийн бужгардуу үс нь сарны гэрэл дор их далайн мяралзаа тасралтгүй мөнхийн үнэнийг хүүрнэж байдгийг өөрийн эрхгүй санагдуулна.

“Би нэгэн мянган жилийн настай эрт балрын тосгонд билиг оюун нэвт шингэсэн ийм нэгэн домгийг олж сонсож билээ. Орчлон анх үүсээд наран баруунаа хэлбийх үест сансар огторгуйд нэгэн мэргэн ухаантнууд чуулсан эрт балрын тосгон буй болжээ. Тэр тосгоныхон ургах нартай уралдан ажиллаж, нар жаргах үед амран өөрсдөд ноогдох эрдэнийн газрыг арчилж торддог байж гэнэ. Харин жил бүрийн есөн сарын 17-ны өдөр гартаа барьсан анжис, зээтүүг орхин, чин сүжгээр долоон шөнийн сэтгэлийн бясалгал ариуслыг үйлдэн, намрын хугастай золгодог гэнэм. Хаврын хугас болохын цагт ч мөн энэ мэт үйлдэх болой !

Бид анх энд уулзан золгосноос хойш долоон сайхан оройг ардаа орхих гэж байна. 17-ны өдрөөс 23-ныг дуустал бид хамтдаа амьдралын нандин эрдэнийг эрэлхийлсээр байгаа билээ.”

Эрдэнийн модот уулын гацаанд орж хэрмэл хаан хөвгүүнийг өрөвдөж, уулын хөндийн өвс мододтой уулзан, хувилсан хотын сайхан зүүднээс цочин сэрэхдээ та хувцсандаа нуулттай гэгээн сувдыг эргэж санасан буй за ! Гэгээн ариун улсад болсон сүрт тулалдааны дараа та эрэл сурал болж байгаа эрдэнэс таны сэтгэлийн гүнд нуугдаж байдгийг мэдсэн үү?

Эргээд бодоход хүний амьдрал гэгч нэг л том жүжиг байдгийг бид тэр болгон мэддэггүй ажээ.

Өнөө орой цөмөөрөө амьдралын их мөрний эх рүү өгсөж, орчлон хорвоо хүний амьдралын нандин эрдэнэ чухам хаанаас эхлэлтэй байдгийг үзэцгээе !

【ДОЛОО ДАХЬ ШӨНӨ】 ОТОЧИЙН ХААН СЯНХӨ

НЭГДҮГЭЭР ҮЗЭГДЭЛ

ДОРЧЛОНГИЙН ЧАНАДЫН ДИВААЖИН

(Үүлс хөшилдөх алсад орчлонгийн чанад дахь диваажингийн бараа бүрэлзэн харагдана. Хүүхдүүд алсаас түүний барааг олж хараад баярлалдан гүйлдэнэ. . . . Тэдний дээрээс гурван тэнгэрийн хүмүүн инээмсэглэн дагаж ниснэ.)

Тэнгэрийн хүмүүн:

Улаан тоор будангуйрч

Утас шиг зам хөвөрнө

Нуугдмал тоорын цэцэрлэгийн агуйд

Нууцлаг зөнчийг оршуулжээ.

Эрдэнэсийн зургийг тэр үлдээсэн юм

Эрэлхэг хааны ач нар, эцэст нь

Эртний хуяг дуулгаа өмсөөд

Их л догдлон чичирсэн хуруугаар

Илд бамбайг газраас аваад

Эрс шийдэмгий

Эргэж харих замдаа шуударлаа.

(Тэнгэрийн хаяанаас уухайлах дуу гарч хүүхдүүдийн

итгэлийг бадраана.)

ХҮҮХДҮҮД:(Найрал дуу)

Очир эрдэнийн хаан илд

Огтоос эвдрэхгүй бөх

Цавчих ир нь хэнд ч дийлдэхгүй

Цацрах гэрэл нь харанхуйг гийгүүлнэ

(ХҮҮХДҮҮД маш баяртайгаар орчлонгийн чанад дахь
диваажинг чиглэн гүйлдэнэ.)

Тэнгэрийн хүмүүс: (Найрал дуу)

Аясын салхи хулсан шугуйг найгуулж

Аянчин шувуу тэнгэрийн энгээр нисэлдэнэ

ХҮҮХЭД А: (Дуулна)

Аяа !

Сэтгэлд хургасан төөрөгдлийн мананг

Сэмлэн ярж чадлаа би

Хөхөлбөр уулсыг ороон явахад

Хөвөх үүлс хөлийн дор хөглөрнө

Хаа сайгүй гүйлсийн цэцэгт эртний зам

Харваас хөлийн өлмий дор байжээ.

Алсад хөврөх тэр замын үзүүрт

Алтан ганжирт эртний хааны ордон байна

Хаалганы хажуугийн хос алтан арслан

Хоёр нүдэндээ гучин хоёр бэлгэсийг эргэлдүүлнэ

Тэртээх мянган жилийн өмнө гарч одоод

Тэнүүчлэн яваа хааны ачийг үгүйлнэ.
 Тэнгэрийн хүмүүн:
 Зах хязгааргүй энэ хорвоод
 Замын хүзүү урт гэдэг
 Хол ойрын сүсэгтэн олон
 Хосгүй нас буяныг тэтгэдэг
 (Диваажингийн гэрэл тодрон харагдана)
 Хүүхэд Б: (Яриа)
 Энэ болвоос далай дээрх Гандирсын балгад биш
 Эрт урьдын яруу сайхан домог ч бас биш
 Эцэг өвгөдийн жинхэнэ хуучин нутаг энд буй
 Энэхүү ордны ваарнаас сарны туяа өөрөө цацрана.
 Он цагийн урсгалд шүрэн мод нь хэзээ ч зулгарахгүй
 Оройн дээд амь нас энд үргэлжлэн
 Давруу таван хүслийн балт илдийг
 Далдаас далд хадгалан буй
 Тэнгэрийн хүмүүн: (Найрал дуу)
 Хар бараан хувцсыг шавар дотор булваас
 Хараа булаам лянхуа чамтай хамт ирмүй
 Цацрах гэрэлд тэмүүлж тоос тортгоос хагацвал
 Цагаан лянхуа дэлгэрэн Бурханы нүүрийг үзэх буй
 (Хүүхдүүдийн баяр хөөртэй царайд, гүн бодол тодроно.
 Тэд нар диваажингийн уулсын хормой дахь тоост орчлонг
 ажиглан харна.)

Хүүхэд В: (Яриа)

Халуун нарны илч гэрэл хаа сайгүй гийгүүлж гурван мянган их мянган ертөнцийн хумхид тусахад, ширхэг хумхи болгоноос мянган төрлийн ариун лянхуа дэлгэрлээ. Харин би хуруун дээрх алтан лянхуаг ажиглан, таван хорт ертөнцөд шигдсэн Түүнчлэн ирэгчийн садангуудыг эргэн дурсав. Аяа, энэхүү ариун оронд яавал би удаан орших билээ?

Тэнгэрийн хүмүүн: (Найрал дуу)

Тэнгэрийн шүүдэр өнөө шөнө цайрна

Тэргэл саран төрсөн нутгийн гэгээ

Харсаар байтал хавар дахиад л өнгөрөх нь

Харьж буцах өдөр хэзээ ирэх бол доо !

(Хуучин цэцэрлэгийг олсоны дараа хүүхдүүд шийдмэг зоригтойгоор ариун нутаг орноос гарч явав)

Хүүхдүүд: (Яриа) Түүнчлэн ирэгчийн садан болох цог төгөлдөр чин сүжгийг өвөрлөв. Түүнчлэн ирэгчийн алхам алхмаар урагшлан одсон зам далайн хөвөө, уулын хөндий, салаа зам, харанхуй шөнө гээд хаа сайгүй дурайнам. Галвын гашуун зовлон болоод аюулт тамын дунд ч сэтгэл хөдлөм нигүүлсэнгүй агаад жинхэнэ үнэн эртний хааны ордны үлгэрийг дахин дахин өгүүлсээр байна.

Тэнгэрийн хүмүүн: (Найрал дуу)

Цэцэг дэлгэрэн эргээд зулгарахад лянхуан мандал үзэгдээд

Цэцэг зулгаран лянхуан хүчээр уран арга бүрэлдэв

Үг хэлгүй энэхүү аргыг хэн ойлгож ухаад
Үйл явдлаа болгон лянхуан хөлгөнөөр замнах вэ
(Энэ үеэр агаар тэнгэрээс нүргэлсэн сүрт дуу сонсогдон
хүүхдүүдийг гүнээ бахдан магтана.)
Тэнгэрийн дуу:
Амгалан уулын хаалга бат бэх
Авралт Бурханы ном ашид дэлгэрнэ
Арвин олон лус савдаг болоод
Амирлангуй хуврагууд дээдийн номыг хамгаална
(Агаарт хүрэл хонхны дуу нэгэнтээ дуурсахад гэрэл унтарч,
суунаг одон бороо гялалзана.)

ХОЁРДУГААР ҮЗЭГДЭЛ

Тоо томшгүй олон галвын өмнө унжгар уд алтан долгисыг
шүргэсэн Ганга мөрний умард эрэг дээр Отчийн хаан Сяньхө
нэрт нэгэн хүмүүн амьдардаг байжээ. Энэхүү отчийн хаан
залуу зандан цагаасаа эхлэн янз бүрийн өвс ургамлуудыг
судласаар мэдэхгүй зүйл гэж үгүй болж гэнэ. Тэрбээр
Ганга мөрний эх адгийг өгсөн уруудан явж, сонин хачин өвс
ургамлуудыг түүж цуглуулан, онцлогийг нь тохируулан
эмэнд оруулдаг байжээ. Отчийн хаан эм бэлдэх нэгэн
цэцгийн хүрээлэн бүхий жижиг модон байшинтай юмсанж.

Ой доторх модон байшингаас нэг сум харвахын зайтай газар хэдэн өндөр цавчим хавцал хад байдгийн орой дээрээс аварга могойн хэлбэрт асар том хүрхрээ доош урсжээ. Хэдэн мянган тохой өндөр хавцал хадан дээрээс доош сүртэй буух хүрхрээний ус шуугьж, салхи модон байшингийн орой дээрх зузаан навчсыг сэрчигнүүлэх нь үе үе нуугих дун лавайн дууг эрхгүй санагдуулна.

Тэрхүү модон байшинд ямар эм хадгалагдан байдаг юм бол? Тосгоны иргэд үхэшгүй мөнхийн рашаан байх гэдэг бол, отчийн хүүхдүүд харин рид хувилгааны шидэт үрэл гэлцдэг байлаа.

ДГАНГА МӨРНИЙ ЭРЭГ

(Харуй бүрийн алдад цасан шуурга шуурахад жигүүртэн шувуудын бараа үзэгдэхээ болиод, мөрний эргийн тэртээгээс морин төвөргөөн сонсогдов. Нэг том биетэй эр их л яаруу довтолгон ирэх ажээ.)

Том эр: Отчийн хаан минь, манай дорно зүгийн отчийн улсад халдварт өвчин дэлгэрээд дийлдэх янзгүй тул манай хаан таныг залаад ир гэж явууллаа.

Отчийн хаан Сянхө: Бүү яарагтун ! Би энэ хавийн ажил төрлөө захиж үлдээсний дараа хамт хөдлөхөд оройтох юу байх билээ !

(Отчийн хаан бүхий л хүүхдүүдээ цуглуулаад яах ийхийг захиж байна.)

Отчийн хаан Сянхө: Хүүхдүүд минь би хол явах хэрэгтэй болчихлоо. Хоёр гурав хоноод л ирэх болов уу ! Намайг байхгүй хойгуур та бүхэн ой доторх цэцгийн хүрээлэнт модон байшинд дураараа орж болохгүй шүү !

Хүүхдүүд: (Нэгэн дуугаар) Аав аа, та санаа амар байгтун ! Бид тийш нэг ч алхам зүглэхгүй.

(Отчийн хаан нөгөө эрийг дагалдан явахдаа нэг юм хэлэх гэсэн бололтой байн байн эргэж харсаар одлоо.)

ДЦЭЦГИЙН ХҮРЭЭЛЭНТ МОДОН БАЙШИН

Ойн чөлөөний нэгэн буланд хүүхдүүд цуглачихаад ямар нэгэн зүйлийг зөвлөлдөнө.

Том ах: Арайхийж нэг ийм сайхан боломж гардаг байна шүү ! Би модон байшинд орж чухам юу байдгийг үзэхээр шийдлээ !

Хоёрдугаар ах: Би ч гэсэн өдий олон жил хүлээсэн болохоор үхэшгүй мөнхийн рашаан, рид хувилгааны шидэт үрлийн алин болохыг үзмээр байна.

Отгон дүү: (Баярлаж цовхчин) Би ч гэсэн бас үзмээр байна !

(Хүүхдүүд модон байшингийн гадна талаас чамгүй их

ажиглаж байсан боловч дотор нэвтрэх боломж огт гардаггүй байжээ. Харин энэ удаа бүгдээрээ яадаг ч байсан дотогш орохоор шийдэв. Сарны гэрэл хавь ойрыг гийгүүлэхэд хүүхдүүд сэмээрхэн алхсаар модон байшингийн дэргэд хүрэлцэн ирлээ. Сандарч догдлохын эрхээр зүрх нь амаар гарчих гэж байгаа мэт булгилан цохилно. Дотор ороод үзвээс эмийн өвс ургамлууд, зуух, лонх, эрэгнэг зэрэг л байх ажээ.

Отгон дүү:(Дэггүй байдалтай) Хэн түрүүлж олохоо үзэцгээе ! Би хамгийн нууцлаг газарт эхлэж хайна аа !

(Отгон дүү нь ингэж хэлчихээд хөшигний араар гүйн ороход бусад хоёр нь ч дагалдав. Хөшгин дээр хүүхдүүдийн юм хумыг онгичин сандаачиж байгаа сүүдэр тусч, хөгжилдөн инээлдэх дуу гарна. Сар бүр өндөрт хөөрөн мандана.)

Бүгд: (Урам хугарсан байдалтай) Энд юу ч байдаггүй юм байна шүү дээ ! Ядаж ганц олигтой тэжээхүй ухааны ном ч олж үзсэнгүй.

(Гэнэт хөшигний цаанаас бага дүүгийнх нь баясгалантай дуу гарна.)

Отгон дүү: Би олчихлоо ! (Бүгдээрээ ум хумгүй тийш гүйлдэв.) Би энэ усан болор бумбыг олох үеэр таган дээр нь зузаан тоос тогтсон байхыг ханцуйгаар шудраад, жаахан завсар гарган үнэрлэтэл, ер бусын сайхан үнэр гарч

мансуурмаар болж ирлээ. Тэгээд тэнгэрт дүүлэн нисмээр мэт болж, нүдэнд зөндөө олон тэнгэрийн дагинас харагдаж байна.

(Бүгдээрээ түрүүлж үзэхээр булаалдана.)

Бүгдээрээ: (Шуугилдан) Алив би үзээдэхье ! Дотор нь үрлэн болон талхан эмийн аль алин нь алга. Ердийн л нэг болор бумба байна шүү дээ !

Том ах: Битгий маргалдаад бай ! Осолтой зүйл ч байж мэдэх юм шүү !

(Түүнийг ийн хэлж дуусаагүй байтал дүү нар нь тагийг бүрэн нээж орхив. Агшин зуурын төдийд анхилуун үнэр нэлэнхүйдээ тархлаа. Хөшигний араас нэгэн утаа тайзны голыг чиглэн суунаглав. Тэрхэн мөчид хүүхдүүдийн зарим нь газар өнхрөн, өөр нэг нь дэмий балай юм донгосч, ухаан санаа нь самуурсан байдалтай байх бол, бусад нь модон хөшөө мэт хөшиж орхижээ.Тэгээд бүгд үхэдхийн унахад гэрэл аажмаар унтрана. Агаарт хэдэн ширхэг суунаг од зурсхийн өнгөрнө.)

(Өрөөний баруун цонхны дэн асаж отчийн хаан эргэж ирлээ.)
Отчийн хаан Сянхө: (Толгой сэгсрэн санаа алдаад) Ай ! Би уг нь зориуд наашаа эртлэн гарсан юмсан. Гэтэл энэ гэнэн томоогүй хүүхдүүд дэмий бодолд автан, миний захиж хэлснээс гажаад, гүн хордлогод орж мансууран нойрсоцгоож орхижээ.

(Отчийн хаан богцноосоо нэг шилтэй ерөндөг гарган хүүхдүүдэд уулгав. Хүүхдүүд зугуухан сэргэж эхлэв. Арай гайгүй хордсон хүүхдүүдийн ухаан санаа нь хэвийн гайгүй байдалтай бол хүндхэн хордсон нэг нь бас л орон гаран байдалтай байх ажээ. Тэр дундаа том ах, хоёрдугаар ах болон отгон дүүгийн байдал ихэд ноцтой байгаа харагдана. Тэр ч байтугай эцгийн өгсөн ерөндгийг уухгүй хэмээн дургүйцэх ажээ.)

Отчийн хаан Сянхө: Ай ! Энэ гурав маш гүн хордчихоод, түүнийгээ ойлгохгүй байгаа бол өөр арга чарга хэрэглэхээс дээ !

(Харуй бүрийн алдад отчийн хаан өрөөний дөрвөн хэсэг газар дэнлүү асаалаа. Шөнийн харанхуй нөмрөн ирэхэд отчийн хаан баруун цонхны харалдаа гүн бясалгалд орон суугаад үүр цайлган, маргааш өдрийн ургахын улаан нартай золгожээ. . . . Тайз эргэж тайзны засал өөрчлөгдөхөд Ганга мөрөн намуухан долгис шидлэн шуугин урсах ажээ.)

ДГАНГА МӨРНИЙ ҮЗЭМЖ

Шувууд шулганалдах Ганга мөрний эрэг дээр цагаан, хөх, шар, хар өмсгөлтэй дүр байдал ихэмсэг дөрвөн настан гарч ирлээ.

Отчийн хаан Сянхө тэдэнтэй алга хавсран мэнд усаа

мэдэлцсэн хойно холдон явав. Ой дотор өнгийн цэцэгс алаглан, нарны туяа навчсийн завсар зайгаар нэвт тусна. Гэрэл сүүдрийн солбицол дунд зөндөө олон гэгээн толь янз бүрийн өнцгөөс дөрвөн настангийн дээр тусахад, тэд Номхруулагч хотын эзэн, Эрдэнийн модот гацааны эзэн, Са Юнь богд, Гэгээн ариун улсын хаан нар болох нь тодрон харагдана. Тэр дөрөв ойн гүн рүү орцгооход гэрэл унтарна.

(Мөнгөн сартай намрын орой хааяа нэгхэн шувуудын жиргээ сонсогдохыг эс тооцвол, нэвсгэр ой нам гүм дүнсийх ажээ. Гэнэт том модны араас том ах(Хэрмэл хунтайз), бага ах (Хэрмэл хөвгүүн), отгон дүү (Юэгуан Тунз) нар олон хүүхдүүдийн хамт гарч ирнэ. Тэд замаас төөрсөн бололтой ийш тийш зүг чиггүй явцгаах ажээ. Улмаар тэд ийш тийш тарж одоход ойн чөлөөнд хүнгүй эль хуль болов. Навчис уйтай хийсэхэд, цас лавсан орж эхлэлээ. Ойн чөлөөнд нэг бяцхан хүү гарч ирнэ. . .)

Бяцхан хүү: (Цангинасан хоолойгоор дуулна.)

Ачлалт эзний гараас хэзээ нисэн холдлоо доо

Аясын салхийг даган чиггүй явдаг боллоо

Хөвөн дүүлсээр

Хөвсгөр үүлстэй хамт бүжиглэн

Бяцхан шувуухайнуудтай хөөцөлдөж

Бас хөлөө амраахаа мартахгүй

Хөрс хагалах тариачин эрийг харж
 Хөгшин одос анжис чирэхийг үзсээр
 Алтан нар гийсэн энэ өдөр
 Абогийн хулст шугуйд хүрч ирэхэд
 Шинэ эзэн Або намайг
 Шив шинэхэн хувцсаар гоёод
 Цаасан шувуу Шидө хэмээх нэр өглөө
 (Бяцхан жаал доогуур нисэн өнгөрөх жиргэмэл бялзуухайтай
 хөөцөлдөн одоход гэрэл зугуухан унтарна.)

ДЦЭЦГИЙН ХҮРЭЭЛЭНТ МОДОН БАЙШИН

(Горхийн усан хоржигнон урсаж, Са Юнь Юэгуан Тунз, Хэрмэл хөвгүүн болон бусад эрдэнэсийн эрэлчдийг дагуулан тайзан дээр гарч ирнэ.)

Са Юнь: Ганга мөрний энэхүү умард эрэг дээр отчийн хаан
 Сянхө нэрт нэгэн хүмүүн амьдардаг юм. Тэр бид хоёр нэгэн
 эртний хааны ордонд цуг өссөн билээ. Тэр хар бага насандаа
 отчийн эрдмийн оргилд нь гарна гэж андгай тангараг
 тавьсан болохоор залуу наснаасаа эхлэн янз бүрийн өвс
 ургамлыг судласаар өдгөө тэжээхүй ухааны тал дээр өмнө
 нь гишгэх хүн үгүй болсон юм. Тэр энэхүү ойн чөлөөн
 дэх модон байшинд амьдран суугаа. Модон байшин нь их л
 нууцлаг болохоор хавь ойрын зуун газрын хүмүүн цэцгийн

хүрээлэнгийнх нь хашаанд ч орж үзээгүй гэлцдэг. Харин өнөөдөр би та бүхнийг дагуулан тэрхүү нууцлаг модон байшинд оруулъя.

(Олон хүмүүс бүгд модон байшингийн өмнө хүрэлцэн ирэв. Асар өндөр хавцал хадан дээрээс доош хүржигнэн буух аварга хүрхрээзэрэг тэндхийн юм бүхэн Юэгуан Тунзийн хувьд нэг л танил мэт санагдана.)

Юэгуан Тунз: (Амандаа бувтнан) Энэ хавийн газар орон яахаараа надад нэг л танил дотно санагддаг билээ?

(Цэцгийн хүрээлэнгийн эргэн тойрны хашааг гавлын ясан хэлбэрт тоосгоор барьжээ. Гавлын ясны нүдийг улаан ногоон өнгөөр будсан харагдана.Тэр нь сарны гэрлийн дор өөр өөр өнгөөр солигдоно. Цэцгийн хүрээлэнгийн дундаас баргил бүдүүн хоолойгоор дуулах сонсогдоно.)

Отчийн хаан Сянхө: (Дуулна)

Өөрийг чинь гэгээн зүүдтэй учруулахыг

Үнэхээр их хүсэж байна

Үүлгэр зүүдэнд судар уншиж

Үнэгэн харанхуйгаар

Үүрийн хонх дэлдэхийг сонсгох юмсан.

Намуухан зүүдэндээ бясалган сууж

Намрын шөнийн жирхрээг хамт сонсохсон.

Эрт балрын өр зөөлөн сэтгэлийг минь мэдэх үү

Эдүгээ чиний хичээнгүй занд хувилсан шүү дээ
 Өдөн дэрний хажууд тавиастай
 Үхэр чулуу хөх өнгөтэй
 Өдгөө өмнийн цэнхэр далай болон хувилаад
 Өдөр шөнийн турш тасалдалгүй
 Өндөр давалгаа шидлэж байна
 Өөрийг чинь гэгээн зүүдтэй учруулахыг
 Үнэхээр их хүсэж байна

(Ийн дуулж байх зуур Са Юнь нар хүрэлцэн ирэв.)

Са Юнь: Ха ха ! Олон жил уулзаагүй анд минь чи орой
 намрын шөнө шүлэг дуулал хайлсан шиг сууж байгаа нь яг л
 хуучнаараа шив дээ !

Отчийн хаан Сянхө: Харин чи ёстой цагаа олж ирэх шив !

Са Юнь: Хэлээд яахав. Орчлонгийн тоосонд төөрөлдсөн
 хүүхдүүдийг аль болох эртхэн шиг амьдралын нандин
 эрдэнэтэй учруулах гээд л наашаа дагуулан ирлээ шүү дээ !

(Сянхө оточ Юэгуан Тунз, Хэрмэл хөвгүүн болон
 эрдэнэсийн эрэлчин бусад хүмүүсийг энэрэнгүй харцаар
 тойруулан хараад ийн өгүүлрүүн)

Отчийн хаан Сянхө: Ойрдоо их ядарцгаасан байлгүй дээ !

Юэгуан Тунз: (Хэсэг зуур эргэлзсэнээ зоригоо чангалан
 өгүүлрүүн) Тантай би хаа нэгтэй уулзаж байсан мэт царай
 тань нэг л танил санагдаад байх чинь !

Отчийн хаан Сянхө: (Инээвхийлээд) Би ихэнх цагаа энэ нам гүмхэн ойн чөлөөн дэх модон байшиндаа өнгөрөөдөг хүн шүү дээ

(Тэр хоёр ийн ярилцаж байх зуур хэрмэл хөвгүүн болон эрдэнэсийн эрэлчид ийш тийш сониучирхан харж байлаа.)

Шавь А: Энэ модон байшингийн эргэн тойронд сонин хачин өвс цэцгийг тариалсан нь цээж тэнийм анхилуун үнэрийг тархаах ажээ !

Шавь Б: Тийм байна шүү ! Гэхдээ Са Юнь багш л наашаа дагуулж ирээгүй бол би ийшээ ганц алхам зүглэж зүрхлэхээргүй юм байна.

Шавь В: Үнэхээр тийм ! Энэ гавлын ясаар босгосон хашаанаас элдэв өнгийн гэрэл анивчиж байгаа нь бүр ч аймшигтай юм гээч !

Юэгуан Тунз: Отчийн хаан гавлын ясан тоосгоор хашаагаа босгосон нь хүмүүсийг наашаа ойртуулахгүй гэсэн утгатай юм уу? (Бухимдангуй янзтай) Чухам ямар учиртай юм бэ?

Отчийн хаан Сянхө: “Эмийг зөв хэрэглэвэл амьдарна, буруу хэрэглэвэл үхнэ гэдэг шүү дээ. Өөрөөр хэлбэл учрыг нь ойлгохгүй хүнд бол мөнхийн рашаан ч гэсэн хор болон хувирна. Тийм болохоор би энэ тал дээр хашир байлгүй горьгүй. Тэгээд ч би гэр дүүрэн юмны учир ойлгохгүй хүүхдүүдтэй хүн.”

(Отчийн хаан ийн ярьж байтал эрдэнийн модон гацааны эзэн

хүүхдүүдээ дагуулан, номхруулагч хотын эзэн хэрмэл хунтайзийн хамт хүрэлцэн ирнэ.)

Юэгуан Тунз: (Баяртайгаар) Харав уу ! Эрдэнийн модот гацааны эзэн болон номхруулагч хотын эзэн нар бүгд хүрээд ирлээ шүү дээ !

Са Юнь: Эртний хааны ордны анд нөхөд бүгдээрээ нэг дор цугларах шив дээ ! Энэ удаа бидэнд өөрийн хорвоод хосгүй анагаах эрдмийг үзүүлэх юм байгаа биз дээ !

Эрдэнийн модот гацааны эзэн: Тэгэх байлгүй дээ ! Би хүүхдүүддээ том цагаан үхэр тэргийг бэлэглэсэн цагаас хойш тэд дээдийн билиг билгүүн болоод магад гарахуйн орныг хүсэмжлэх болсон тул би эднийгээ дагуулсаар тэртээ холы замыг туулан ирлээ !

Номхруулагч хотын эзэн: Одоо хүмүүс бүгдээрээ отчийн хаан Сяньхө хорвоо дэлхийн хамаг амьтдыг авран гэтэлгэхийн тулд цаглашгүй агуу зоригийг барьж, их үйлээр замнан оройн дээд билиг билгүүнийг олсон гэдгийг мэддэг болсон. Чухам магад гарахуйн орныг эрэлхийлж буй хүн болгон отчийн хаан дээр ирвээс зохилтой.

Хэрмэл хөвгүүн: Отчийн хаан минь, нааш ирэх замд тосгоны хүмүүс таны модонд байшинд мөнхийн хутгийг олгох шидэт рашаан байгаа гэлцэх юм. Тэр үнэн үү?

Хэрмэл хөвгүүн: Зарим хүмүүс болохоор рид хувилгаантай болгодог шидэт үрэл байгаа ч гэлцэх юм байна

лээ шүү дээ !

Юэгуан Тунз: Тэгвэл чухам юу байгаа юм бэ?

Хүмүүс: (Шуугилдан) Чухам ямар шидтэй эм байгаа юм бэ? (Отчийн хаан Сянхө дуугүй инээвхийлэн байх зуур морин төвөргөөн сонсогдоно. Хүрэн ороонгын цэцэгт зүүн хаалгын төмөр хаалганы гинжийг торжигнуулах чимээ гарлаа. Отчийн хаан нууц дохио болохыг мэдээд хаалгыг тайлж өгвөөс, гаднаас ирэгч хүмүүний царай шаналангуй харагдах нь хүнд өвчинд баригдсан нь илт. Тэр хүн отчийн хаанд их л хүндэтгэлтэй мэхийн ёслов.)

Танихгүй хүн: Отчийн хаан минь, болохоо байлаа шүү ! Дорно зүгийн отчийн улсад дахин халдварт өвчин дэгдлээ. Энэ удаа маш ноцтой байгаа болохоор Ганга мөрний өвс ургамлууд хүртэл хатаж үхээд байна. Хаан эзэн намайг зарлагаар явуулж, таныг маш хурдан залж ирнэ үү гэсэн юм ! Жаахан л хожимдох аваас найдлагагүй боллоо гэсэн үг !

Хэрмэл хөвгүүн: Энэ чинь юу болоод байна вэ?

(Хүмүүс бүгд гайхан өөд өөдөөсөө харахад, Сянхө оточ толгой сэгсрэн санаа алдлаа.)

Отчийн хаан Сянхө: Ай ! Тэр дорно зүгийн отчийн улсад хүмүүс үе уламжлан хорвоо дэлхийн хамаг өвс ургамал бүгд анагаах эрдэмтэй гэсэн мухар сүсэг автаад байгаа юм.

Са Юнь: (Зовнингуй) Та тэр хүмүүст эм хүнийг эдгээж чадна, алж ч чадна шүү гэж анхааруулан хэлдэг биз дээ?

Отчийн хаан Сянхө: (Харуусангуй) Тэд нар анхааран хүлээж авахгүй байгаа болохоор л өвчин байн байн дэгдээд байгаа юм л даа !

Номхруулагч хотын эзэн: Наад өвс ургамал бүхэн анагаах эрдэмтэй гэдэг буруу үзэл чинь ямар айхтар билээ. Тэр олон өвсийг хамаагүй хэрэглэвэл дийлдэшгүй хор болох бус уу !

Отчийн хаан Сянхө: Тэгэлгүй яахав. Наадхид чинь л би зовниод байгаа юм. Гэвч тэднийг харсаар байж яахин үхүүлж болох билээ ! Тийм болохоор би нэг удаа тийшээ очоод ирсэн юм. Харин энэ удаа тун амаргүй хэрэг болсон бололтой. Тийм болохоор та гуравтай цуг явалгүй горьгүй.

Са Юнь: Өөртэй чинь хамт явалгүй яахав. (Эрдэнэсийн эрэлчид рүү хараад) Харин энэ хүүхдүүд яах болж байна вэ?

Отчийн хаан Сянхө: Би наадуулд чинь нэг илүү байшингаа гаргаж өгье. Далимаар нь миний хүүхдүүдийг харж байг ! Харин цэцгийн хүрээлэнт модон байшинд яасан ч хамаагүй орж болохгүй шүү гэдгийг хатуу анхаарваас зохино !

(Ахмадууд толгой дохин зөвшөөрөөд хэсэг зөвлөлдсөний эцэст Номхруулагч хотын эзэн хэрмэл хунтайз руу хандлаа.)

Номхруулагч хотын эзэн: Биднийг байхгүй хойгуур чи л энд хамгийн ахмад нь болохоор учир мэдэхгүй хүүхдүүдийг эм тан руу хамаагүй ойртуулж болохгүй шүү ! Эс бөгөөс том осол гарч мэднэ.

Хэрмэл хунтайз: Ойлголоо. Та санаа амар байж болно.

ДОТЧИЙН ХААН СЯНХӨГИЙН ГЭР

(Отчийн хаан Сянхөгийн хүүхдүүд бүгд нэг дор цуглараад ямар нэгэн зүйлийг нууцхан шивнэлдэн байхыг үзээд Хэрмэл хунтайз сэмээрхэн очиж чагнана.)

Хүүхэд А: (Догдлонгуй) Аавын байшин тийм нууцлаг болохоор дотогш орж үзмээр байна.

Хүүхэд Б: Тийм шүү ! Бүгд дотогш ороод аавын байшинд үхэшгүй мөнхийн рашаан, рид хувилгааны шидэт үрлийн чухам аль нь байдгийг үзье !

Хүүхэд В: Аав энэ удаа алс хол явсан болохоор бидэнд маш ховор боломж олдож байна.

Хэрмэл хунтайз: (Сандрангуй) Тэгж болохгүй ээ ! Аав чинь алс хол явахдаа биднийг дотогшоо хамаагүй орж болохгүй шүү гэж захисан. Эс бөгөөс айхтар осол цалгар гарна гэсэн юм.

Хүүхэд А: (Эрхлэнгүй) Бид нар дотогш ороод элдэв юм оролдож идэхгүй учраас ах та санаа зоволтгүй.

Хүүхэд Б: (Дүрсгүйдүү янзтай) Тэгээд хордлоо ч гэсэн аавд анагаах ерөндөг нь байгаа шүү дээ !

Хүүхэд В: Тийм шүү ! Бид нар дотогш ороод болгоомжтой байж чадах юм бол элдэв асуудал гарахгүй нь лавтай.

Бүгд: (Орилолдон) Тийм шүү ! Ямар ч осол гарахгүй дээ !

Хэрмэл хунтайз: Яадаг юм билээ.(Эргэлзэнэ)

(Хүүхдүүдийн орилолдох тусам Хэрмэл хунтайзийн сэтгэл үймэрнэ. Энэ үед хажууд нь дуугүй зогсож байсан хэрмэл хөвгүүн ам нээлээ.)

Хэрмэл хөвгүүн: Үнэндээ тэр модон байшинд юу байдгийг би ч гэсэн үзэхийг маш их хүсэж байна. Гэвч отчийн хаан Сянхө хамаг амьтны тусын тулд өөрт байгаа бүхнээ өгөөмөр сэтгэлийн үүднээс өглөг болгон өргөхдөө гудайдаггүй хүн. Гэсэн атал тэр модон байшинд хамаагүй орж болохгүй гэж захидаг нь нэг л учиртай. Тийм болохоор орохгүй байсан нь дээр байх аа !

Хэрмэл хунтайз: Тийм шүү ! Отчийн хаан Сянхө явахаасаа өмнө бидэнд бие сэтгэлээ сайтар захирч байгаарай гэж хэлж байсан биш үү ! Тийм болохоор бид тэднийг иртэл томоотой хүлээж байсан нь дээр !

(Хүүхдүүд бүгд урвайцгаан ор руугаа явлаа. Хэрмэл хөвгүүн бүх лаануудыг үлээн унтраав.)

(Шөнө төгрөг сарны гэрэл Юэгуан Тунзийн нүүрэн дээр тусав. Тэр зугуухан сэрээд ийш тийш харна. . .)

Юэгуан Тунз: (Цочин) Бүгдээрээ бушуухан сэрцгээгээрэй ! Нөгөөдүүл чинь бүгд алга болчихсон байна.

(Хэрмэл хунтайз, хэрмэл хөвгүүн нар ч босон энэ тэрүүгээр хайцгаалаа.)

Юэгуан Тунз: (Хаалгаар гаран газар руу заагаад) Та нар хар даа !

Хэрмэл хунтайз: (Дуу алдан) Энэ олон жижиг хөлийн мөр бүгд ойг чиглэн явсан байна шүү дээ ! Арай.

Хэрмэл хөвгүүн: Алив хурдан модон байшинд очиж үзэцгээе !

Юэгуан Тунз: Битгий л элдэв юм болчихсон байгаасай даа !

Хэрмэл хөвгүүн: Хурдан очиж тэднийг аварцгаая !

Хэрмэл хунтайз: Хурдалцгаая !

(Ой дотор адуу янцгаах чимээ сонсогдож, отчийн хаан Сянхө нөгөө гурвын хамт хүрч ирнэ.)

Хэрмэл хунтайз: (Баярлан) Отчийн хаан Сянхө гуай эргээд ирлээ шүү дээ !

Хэрмэл хөвгүүн: (Тэсгэлгүй баярлан) Настангууд ч мөн эргээд ирлээ.

Са Юнь: Чухам юу болоо вэ?

Юэгуан Тунз: (Сандрангуй) Са Юнь багш аа, хүүхдүүд биднийг унтаж байх хойгуур гараад явчихжээ. Тэд лав модон байшинд очсон байх. Чухам юу болсныг мэдэх юм алга.

.

(Сянхө оточ үүнийг сонсоод хэдэн хүрэн өнгөт өвс таслан хүн бүр түүнийг амандаа хийсний дараа ойн гүн рүү

явцгаахад гэрэл унтрана.)

(Гэрэл асахад хүүхдүүдийг гэртээ авчран эмчлэж байх ажээ. Хүүхдүүдийн зарим нь сэргэсэн, нөгөөдүүл нь мансуурсан байдалтай ерөндөг уухгүй хэмээн цааргалж байлаа. Юэгуан Тунз бусад хүмүүсийн хамт тэднийг ятгана. Гэвч нөгөөдүүл нь үгэнд орох янзгүй байв.)

Отчийн хаан Сянхө: (Өрөвдсөн байдалтай) Ай ! Яахаараа нэг л болсон явдал дахин дахин үүсдэг байна вэ?Энэ учир мэдэхгүй хүүхдүүд миний үгэнд оролгүй унтуулдаг хортой эмийг ууж орхижээ. Би тэдэнд ерөндөг уулгаснаар хөнгөн хордсон хүүхдүүд хэд хоногийн дараа гайгүй болно. Харин хүнд хордсон хүүхдүүдийг яаж ч ятгаад ерөндөг уухгүй юм.

Юэгуан Тунз: Тэгэхээр яавал дээр вэ?

Отчийн хаан Сянхө: (Их л нухацтай) Гагцхүү уран арга л хэрэглэхээс өөр замгүй дээ.

Юэгуан Тунз: Ямар арга юм бэ?

(Отчийн хаан Сянхө толгой сэгсрэн хариулалгүй нөгөө гурван настантай нууцаар зөвлөлдсөний эцэст ерөндгийг үлдээчихээд өөрөө богцоо аван гарч одов. Юэгуан Тунз түүний араас харсаар учрыг ойлголгүй хоцров. . . .Гэрэл унтрана.)

ΔΟΙΝ ЗУУН ЦЭЦЭГСИЙН ҮЗЭМЖ

(Ой дотор зуун цэцэгс дэлгэрэн Хэрмэл хөвгүүн, Юэгуан Тунзийн хамтаар мансууран төөрөлдсөн хүүхдүүдийг тоглуулна. Хүүхдүүд эрвээхэйтэй хөөцөлдөн их л баясгалантай байх ажээ.)

Хэрмэл хөвгүүн: Отчийн хаан Сянхө гэрээс гараад хэдэн сар болохдоо сураг ажиг байдаггүй шүү.

Юэгуан Тунз: (Зовнингуй) Эд нар заримдаа гайгүй болох үедээ ерөндгийг ерөөсөө ууж өгөхгүй юм. Яавал дээр юм бол доо !

Хэрмэл хөвгүүн: Сянхө гуай отчийн улс руу явсан гэдгийг л мэдэхээс биш хэзээ ирэх юм бол доо?

(Хэрмэл хунтайз их л гунигтай гарч ирээд хүүхдүүдийг цуглуулахад гурван настан ч хүрч ирнэ.)

Хэрмэл хунтайз: Хүүхдүүд ээ, сая отчийн хаант улсаас элч ирээд жаахан тааруухан мэдээ дуулгалаа. Танай эцэг отчийн хаан тэнд нас эцэслэсэн гэнэ ээ !

(Бүгдээрээ орь дуу тавин уйлцаахад хүүхдүүд ч бүгд цурхиралдлаа.)

Хүүхэд Б: Би аавтайгаа уулзмаар байна. Аав минь яачихав аа !

Хүүхэд А: Аав маань биднийг аварч чадах цорын ганц хүн байсан юм шүү дээ ! Бид нар үүнээс хойш яадаг билээ?

Хүүхдүүд: Аав аа !

Эрдэнийн модот гацааны эзэн: Хүн болгон л отчийн хааны анагаах эрдэм чадал хосгүй гэлцдэг байсан. Тэр амьд сэрүүн байхдаа та бүхний авралын найдлага байсан бол одоо хэн ч та нарыг зовлонгоос гэтэлгэж чадахгүй боллоо. Азаар тэр эндээс явахдаа өөрийн эрдэм чадлыг шавхан үйлдсэн нэг лонхтой эмийг үлдээсэн юм. Хэрвээ та нар цааргалахгүй бол түүнийг уугаад үзэхэд болохгүй нь юу байх билээ.

Хэрмэл хунтайз, хэрмэл хөвгүүн, Юэгуан Тунз: Тийм шүү ! Та нар ерөндгийг уугаад үзэгтүн !

(Эрдэнийн модот гацааны эзэн лонхтой ерөндгийг аваад бүгдэд нь хуваан хүртээв. Бүгд л гашуудангуй гартаа барьсан эмийг харахад төөрөлдсөн сэтгэлд нь итгэл найдварын оч улалзав. Тэдний гөжүүд сэтгэл зөөлрөн нулимсаа дуслуулаад үрлэн эмийг залгицгаав.Гэнэт тайзан дээр үүл манан хөвсөлзөөд, гэгээн ариун улсын хаан алтан лянхуа сэнтий дээрээ залран гарч ирэхэд өглөг, хүлцэнгүй, сахил, хичээнгүй, самади болон билгүүн гурван номын жанжин нар бараа болон явах ажээ.)

Гэгээн ариун улсын хаан:(Чанга дуугаар зарлана)

Арван зүгийн одоо цагийн болон
Нөгчсөн ирээдүй цагийн Бурхад
Их Рид хувилгаанаа оршсоноо
Энэхүү ховор хэрэг тохиолоо

Гэгээн дүрийг минь үзэж
Гэтлэсэн олон эрдэнэт Бурхан лугаа учирсанаар
Агаараар зорчих салхи мэт
Аливаа бүхэн саад тотгоргүй болов

(Ойн дундах мушгирмал арц, өвгөн нарс, наранцэцэг, зангууд
болон ичингүүрт цэцэг бүгд гэрэл цацруулсаар хүрч ирнэ.)

Мушгирмал арц, өвгөн нарс: Алив хурдан наашаа яваарай !
Ариун уст үүл болон рашаан хурын ус бидний хүссэнчлэн
ирж байгаа тул бүгдээрээ бэлэн байцгаая ! Тэдний итгэлийг
хугалж болохгүй

(Хүүхдүүд нүдээ нухлан бүлтийтэл харцгаана. Үүлс
сарнихад алтан лянхуа сэнтий дээр ариун гэгээн улсын
хаанаас гадна, отчийн хаан Сянхө бас заларсан байх ажээ.)

Юэгуан Тунз: Энэ юу болох нь энэ билээ?
Хүүхэд А: Харин тийм ээ, аав байх шив дээ !

Хүүхэд Б: Аав отчийн улсад өөд болсон гээгүй бил үү?

Хүүхэд В: Аяа ! Бид нар бүгд зүүдлэж байгаагаас гарцаагүй байх аа.

(Алтан лянхуа дээр заларсан отчийн хаан Сянхөгөөс энэрэнгүй билгүүний гэрэл цацрана. . .)

Отчийн хаан Сянхө: Хүүхдүүд ээ, энэ бол зүүдний орон бус ! Би та нарыг зориуд орхин уулзахгүй байсан хэрэг биш шүү ! Гагцхүү та нар надад дэндүү эрхлээд, ерөндгийг ууж өгөхгүй байсан тул эцэг чинь арга буюу өөр улс орон руу явсан билээ. Харин одоо та нар ерөндгийг ууж, өвчин чинь илааршаад өөрийн жинхэнэ байх ёстой хэв шинжиндээ орсон тул би та нарынхаа санахын эрхэнд уулзахаар ирж байгаа нь энэ.

(Хүүхдүүд бүгд баярлалдан, отчийн хаан Сянхөгийн өмнө очоод, тэврэх буюу сөгдөцгөөхөд отчийн хаан их л энэрэнгүй нүдээр тэднийг харж, толгойг нь илбэнэ. Тэдний хажууд зогсож байсан Юэгуан Тунз, Хэрмэл хөвгүүн болон Хэрмэл хунтайз нарын нүдэнд уяарлын нулимс гялтганана. Тэдний сэтгэл нь цэлмэн, өөрийн эрхэм дээд угсаа гарал болон гадагш үхэл амьдралын орчлонд хэсүүчлэн явдаг учир шалтгааныг ухан ойлгов. Тэр гурав хүүхдүүдтэй хамт газар сөгдөөд удтал эс босоцгоолоо.)

ΔΤΑС ЦОГЦЛОСОН УУЛЫН НОМЫН ХУРАЛ

(Тэр гурав үүрийн гэгээнээр сая сэхээ орон үзвээс, эртнээс
нааш домог болон яригддаг тас цогцлосон уулын номын
чуулганд хүрэлцэн ирсэн байх ажээ. Хүн тэнгэр болон
богдсын чуулган билиг билгүүний уран аргыг сонсож маш
их баяр жаргалтай байх ажгуу. Сайтар харваас. . .

Са Юнь богд (Зүүн талд)

Эрдэнийн модот гацааны эзэн (Өмнө талд)

Ариун гэгээн улсын хаан (Гол дунд)

Номхруулагч хотын эзэн (Умар талд)

Отчийн хаан Сянхө (Баруун талд) тус тус суугаад гартаа
Фэнтори цэцэг барьсан нь дорно зүгийн нэг түм найман
мянган улсыг даяар гийгүүлнэ.)

Таван Бурхан: (Нэгэн зэрэг дуулна)

Авралт Бурхан болон бүтсэн цагаас

Асар олон галав нугуудыг туулсан нь

Түг түмэн наяд голтиор зогсохгүй

Түүнээс нэн үлэмж асанга хугацаагаар тоологдоно

Ашид дээдийн номыг өгүүлэн номлож

Амьтан бүхэн хэдий тоотон түүнийг

Бурханы зам мөрд оруулсан нь

Бас л тоолшгүй олон галвын хэрэг болой

Нийт хамаг амьтныг гэтэлгэхийн тулд
 Нирваан болон уран аргыг үзүүлэхийн тулд
 Үнэхээр эс түрдэн гэтлэхийн сацуу
 Үргэлж энэ газар ном талбин суунам бөлгөө
 Энэ газар ашид ном талбин суух боловч
 Энгүй их рид хувилгааны хүчээр
 Эгэл бэртэгчин ардын нүдэнд
 Эс үзэгдэвч ойр байх бөлгөө
 Бэртэгчин ард гэтэл намайг нөгцөв хэмээн
 Бэлтгэсэн эдийн зүйлсээр шарилыг тахин
 Ачлал энэрлийг минь дуртхан санаж
 Аврал тусыг хамтад нь одуулмуй.
 Хамаг амьтан ийнхүү дээдлэн шүтэж
 Хатуу сэтгэл нь тэр хэрээр номхрон
 Оройн дээд Бурхан лугаа учрая хэмээн сэтгэвч
 Олдсон амь биеэ гамнахыг эс мэднэм.
 Өдгөө би хуврагийн чуулган лугаа
 Өндөр тас цогцлосон уулнаа суухуй дор
 Ашид энэ газраа нөгцөлгүй залрахын учрыг
 Амьтан бүхэнд өгүүлэн соёрхож байна
 Уран аргын учрыг үзүүлэхийн тулд
 Уулнаа эс нөгцөн суухуй дор
 Бусад зүгийн хамаг амьтан нугууд
 Бурхан намайг дээдлэн шүтэгч байх аваас

Тэдний улсад зочлон очиж
Дээдийн номыг талбих болой.
Эгэл бэртэгчин ард энэ ёсыг ухахгүй
Эдүгээ намайг нөгцөв хэмээн сэтгэнэ
Бурханы таалалд өдгөө үзэхүй бээр
Булт хамаг амьтан нисваанисын далайд живмүй
Амьтан тэдгээрийн нүдэнд эс үзэгдэх нь
Авралт Бурханы ачийг санагалзуулахын тулд болой
Асар хүчит рид хувилгааны хүчээр
Асанга тоот галав нугуудын турш
Адистид шингэсэн Тас цогцлосон уулнаа
Амирлан оршихуйн учир тэр болой
Хамаг амьтан галвын эцэст тохиож
Халуун гал хамаг бүхнийг түймэрдэхэд
Амгалан жаргалангийн энэ л газар үлдэж
Асар олон тэнгэрийн хүмүүсийг багтаамуй.

Тэнгэрийн хүмүүн хутагтын чуулган: (Найрал дуу)
Бурханы лагшин түүнчлэн чанарын орныг дүүргэж
Булт хамаг амьтдын өмнө ашид оршмуй
Аливаа сайн тохиолоор ач тусаа хүргэж
Ашид энэ л газраа Бодь суудалдаа залармуй

Ачлалт Бурхан алтан лянхуан мандал дээр залран

Ариун Тас цогцлосон уулнаа өөрийн тааллыг номлохдоо
Долоон зүйлийн үлгэрийн далд санааг шавь нартаа айлдсан
Дор нь ойлгогч хэн бээр Түүнчлэн ирэгч лүгээ учирмуй

Хумхи нарийн тоосыг ширхэгээр тоолж болмуй
Хувингаар далайн усыг юүлж ч болмуй
Огторгуйг хэмжиж салхийг ч хүлж болмуй
Оройн дээд Бурханы ачийг өгүүлж эс бармуй

(Хоосон огторгуйд ариун цагаан лянхуа Фэнтори үзэгдэв.
Тэрхүү цагаан лянхуа түм буман алтан цацраг сацруулж,
тоо томшгүй олон тоосонцор цэцгийн хүйснээс ялгаран
тархлаа.

Цэцэг бүрэн цоморлигоо нээж гүйцмэгц ер бусын анхилуун
үнэр ханхлав.Гэрэл аажмаар унтрахад, хөшиг
зугуухан доош бууж ирнэ. Харанхуйд дөрвөн зүгт цацрах
лянхуан тоосонцор, анивчих одод мэт гэрэлтэн эргэлдэн
бүжсээр авай.)

— Хөшиг хаагдаж жүжиг төгсөнө.

* * *

“Сүр сар” хэмээн тэнгэр огторгуйд дүүлэн нисэх цаасан
шувууг Або мөн шөнө зүүдэндээ үзжээ.

“Сүр сар” хэмээн Шиде их хийморь золбоотой улам өндөрт
дүүлэн нисэв.

“Ий уу !” хэмээн салхинаа Шидөгийн намуухан гингэнэх дууг сонсоход лимбэний ягуухан эгшигнээс өөрцгүй мэт санагдана.

“Дуугарлаа, дуугаргаж чадлаа шүү !” хэмээн Шидөгийн хасын лимбэ мэт шулуухан бие салхи хөлөглөн дүүлэн нисэхдээ, өөрийн агаарын нэвтрүүлэх сүвээр чихнээ яруу аялгууг дуурсгахдаа дуу алдахыг Або дахин сонслоо. Мөнөөх яруу эгшиг түүний агаарт дураар дүүлэн нисэх их биетэй адилхан алсад чөлөөтэй тархах ажгуу.

Хув эрдэнэ зөөлөн гэрэл цацруулах мэт лимбийн яруу эгшиг, зуун цэцэгс зүүрмэглэх хээр талын энгээр дуурсаж, нарсан төгөлт хөндийд хүрээд, навч мөчрийн шаагиан лугаа уусан нийлэх нь огторгуй дахь орь ганцхан өнчин галууны бүжиг лүгээ өөрцгүй, улам улмаар өөдлөн дэвсээр есөн тэнгэрийн чанадад хүрэвэй. Түүнийг үлгэрлэвээс өглөө нарны гэрэлд шүүдэр гилтгэнүүлэх тутарган түрүү намс намс нахилзан, сэтгэлд нийцтэй хөгжим эгшиглүүлдэгтэй агаар нэгэн ажгуу.

Цаасан шувуу шөнийн агаарт ийнхүү дүүлэн нисэхэд огторгуйн салхины хүч ихсэж намдахыг дагалдаад, биеийн эргэлтийн өнцөг аажим түргэн өөрчлөгдөж, тэр хэрээр төсөөлж л болохуйц яруу аялгууг үүсгэлээ. Энэхүү төгс яруухан аялгуу тэнгэр газрын түмэн бодисын хамтаар чуулсан сэтгэлийн эгшиг гэлтэй, далайн түрлэг мэт

тасралтгүй ундран гарсаар байлаа.

Жаргах нартай талын дээгүүр цаасан шувуу Шидө ийнхүү исгэрэн дуулсаар байлаа.

Абогийн уран гар дэлхий дахинаа мянган жилд ганц тохиох эртний хас лимбийг урлаж чаджээ.

Долоон шөнийн хүлээлтийн явцад Шидөгийн ухаарал эгээрэл улам бүр нэмэгдэхийг үзээд, Або түүний хувцсанд мөнөөх эртний хас лимбийг суулгаж өгснөөр салхины аясаар өөрөө амилан сэтгэлийн гүний яруу эгшгийг үүсгэсэн нь тэр болой. Тэр мөн Шидөгийн эртний хасын лимбэт биед цоо шинэ хувцас хийж өгснөөр, өглөө нарны гэрэлд өдөн хувцас нь гал мэт дүрэлзэн, гэрэлт цагирагийг үүсгээд, өөрөөсөө бүтсэн одон биет бичил огторгуйг үлгэрлэх нь шөнийн тэнгэрт эрдэнийн эрвээхэй мэт харагдах аж. Тэр цагаас хойш номин лимбэт мөнгөн өнгөт цаасан шувуу салхи хөлөглөн бороон бүжиг хийж сурснаар аян замын алсад усан шамрага, ширүүн шуурганаас эс халшрах болжээ. Чингэснээр огторгуйн уул усны дээгүүр чөлөөтэй амгалан зорчихдоо, тэнгэр газрын савслаган дахь яруу уянгат эгшгийг дуурсган, түм буман гэгээн өнгийг цацруулах авай !

Урьд нь Шидө салхины аясанд захирагдсан цаасан биет төдийхөн байсан бол өдгөө сансрын салхи хөлөглөн эгшиг ярууг дуурсгагч жинхэнэ цаасан шувуу болон хувирав.

“Або би чамайг үүрд дурсаж явах болно !” Шидө

хэдийгээр төрөл арилжсан мэт хийморь золбоогоо бадруулах боловч урьдын адил салж ядсан байдал илт харагдана.

“Шидө чи бол миний түм буман жилд учрахуйяа нэн бэрх сэтгэл зүрхний минь анд бөлгөө ! ” хэмээн өөрийнх нь урласан гэрэл цацруулах өдөн өмсгөл жаргах нарны алтан цацраг ойлгохыг харах зуур Або инээмсэглэн өгүүллээ.

Ийнхүү агаар тэнгэрт үзэгдээд өнгөрөх суунаг одон мэт цаасан шувуу Шидө номин хулст хаднаа дахин бараа сураг тасрав.

Орчлонгийн намуухан орой Або огторгуйн төв дунд Шидөгийн дуулах дууг сонсдог болжээ.

Ийнхүү огторгуйн цээлд нэгэн цаасан шувуу сансрын салхины аясаар сүүн голын шөнийн гэрэл дунд өөрийн яруу эгшгийг амилуулан дуурсгасаар л.

Шинэ талын хүн цуврал

17 · 23 ДОЛООН ШӨНИЙН ХҮЛЭЭЛТ

Зохиолч: Юй Си

Эрхлэн гаргасан: Ян Жи Мэй

Орчуулагч: Доржсүрэнгийн Болдбаатар

Пү Ень соёлын хувьцаат бүрэн бус хариуцлагатай компани

Тайбэй хот Гуанфу өмнөд тойруу 390 тоот байрны 3 давхар

Албан утас: (02)27013243~5

Шуудангийн дансны дугаар: 1127811—0

E-mail: ekarasa@seed.net.tw

Бүртгэлийн дугаар: Засгийн газрын хэвлэлийн товчоо 3832

Хариуцлагатай редактор: Дай Сяо Цинь

Эх бэлтгэсэн: Ли Цин Лүнь

2012 он

Зохиолчийн зөвшөөрөлгүй хэвлэж олшруулахыг хориглоно.